



ЗҮЙ ЁСНЫ СОНГУУЛЬ :

*Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын
Хүрээлэнгийн гарын авлага*



ЗҮЙ ЁСНЫ СОНГУУЛЬ :

*Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын
Хүрээлэнгийн гарын авлага*

Зүй ёсны сонгууль:

**Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын
Хүрээлэнгийн гарын авлага**

Зохиогч:

Жесус Орозко-Энрике

Редакторууд:

Айман Аюуб

Эндрю Эллис

Хамтран зохиосон:

Ади Аман

Трейси Кэмпбел

Эвери-Дэвис Робертс

Зоран Докович

Эндрю Эллис

Сергей Кузнецов

Ральф Линднер

Аугустин Лоада

Деки Пема

Жорам Рукамбе

Майко Шимизу

Денис Трюсделл

Доминико Туссинарди

This is a direct translation of the English version of *Electoral Justice: The International IDEA handbook*, published by the International Institute for Electoral Assistance (International IDEA) in 2010. The accuracy of the translated text has not yet been verified by the publisher. In case of doubt, the original English version prevails (ISBN 978-91-85724-96-3).



Цуврал гарын авлага

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгээс гаргасан цуврал гарын авлага олон тооны ардчилсан институциуд болон тэдгээрийн үйл ажиллагааны талаарх харьцуулсан дүн шинжилгээ, мэдээлэл цаашлаад тэдгээрийн мөн чанар, агуулгыг таниулах зорилготой юм. Гарын авлагууд нь сонгуулийн ардчилалын чиглэлээр ажилладаг бодлого боловсруулагчид, улс төрчид, иргэний нийгмийн төлөөлөл болон практикт ажилтнуудад зориулсан болно. Түүнчлэн энэ бүтээлийг онолын судлаачид, ардчилалын чиглэлээр дэмжлэг тусалцаа үзүүлдэг хамтын нийгэмлэг болон бусад сонирхсон хувь хүн, хуулийн этгээд ашиглах боломжтой.

© Ардчилал, Сонгуульд Тусалцааны Олон Улсын Хүрээлэн 2010

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн хэвлэн нийтэлж буй бүтээлүүд нь тухайлсан нэг улс орон болон улс төрийн ашиг сонирхлоос хараат бус байдаг. Энэхүү бүтээлд Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн, түүний Удирдах зөвлөл болон зөвлөлийн гишүүдийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Энэхүү номыг дахин хэвлэх болон орчуулах хүсэлтийг доор дурдагдсан хаягаар илгээнэ үү:

International Institute for Democracy and Electoral Assistance
SE-103 34 Stockholm
Sweden

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн нь өөрийн бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхийг хөхүүлэн дэмждэг тул дахин хэвлэх болон орчуулах зөвшөөрөл хүссэн хүсэлтэд нэн даруй хариу өгөх болно.

График дизайн: Сантангело Дисено
Хавтасны дизайн: Сантангело Дисено
Хавтасны зураг, чимэглэл: © Мариано Валеро
Хэвлэсэн: Булс Графикс компани, Швед улс

Өмнөх үг

Зүй ёсны сонгууль нь ардчилалын хамгийн чухал тулгуур багана бөгөөд үүний хүрээнд сонгуулийн үйл ажиллагааны хууль ёсны байдал болон иргэдийн улс төрийн эрхийг сахин хамгаалж байдаг. Сонгуулийн зүй ёсны тогтолцоо нь оороо ардчилалын үйл ажиллагааг үр дүнтэйгээр үргэлжлүүлж, аливаа улс төрийн мөргөлдөөнийг хүчирхийллийн замаар шийдвэрлэхээс урьдчилан сэргийлж, үүнийг хууль ёсны дагуу шударгаар шийдвэрлэх үндсэн үүргийг хүлээдэг.

Зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь олон төрлийн хуулийн механизмуудыг ашиглан улс төрийн зөрчлийг зөвөөр шийдвэрлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангах баталгаа болох, ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжих боломжийг бүрдүүлдэг. Цаашлаад зүй ёсны сонгуулийн тусламжтайгаар сонгууль зохион байгуулдаг эрх бүхий байгууллага нь хүчирхэг байх хэрэгцээтэй гэдгийг улс төрийн, захиргааны болон шүүхийн байгууллагууд тэгш эрхтэйгээр хамтран ажиллах орчин нөхцөл, тогтолцоог сайжруулах шаардлагатай гэдгийг бататгадаг. Үүний үр дүнд нийгмийн тогтвортой байдлыг баталгаажуулах тодорхой элемент бий болгодог.

Зүй ёсны сонгууль: Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн энэхүү гарын авлага нь захиргааны болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын дунд яригдах, онолын судлаачид болон сонгуулийн байгууллагын ажилтнуудын хоёуланд нь хамаарах прагматик үзэл санаатай хамт Зүй ёсны сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх үзэл баримтлал, зарчмын дүн шинжилгээг хослуулан харуулсан. Түүнчлэн энэхүү гарын авлагад сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой урьдчилан сэргийлэхээс эхлээд эцэслэн хянан шийдвэрлэх хүртэл бүхий л процессыг нарийвчлан тодорхойлсон болно.

Энэхүү гарын авлага нь сонгуулийн холбогдолтой зөрчил, маргаанаас урьдчилан сэргийлэх явцад улс төрийн соёл, иргэний боловсрол ямар ач холбогдолтой болохыг мөн харуулж байгаа. Гэхдээ эдгээр хүчин зүйлс нь зөрчил, маргааныг шийдвэрлэх гол шинж болно.

Үүний зэрэгцээ тус гарын авлага нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх системийг ангилан, эдгээр ангилалд ашигласан бүтэц, зарчим, процедурын баталгааг багтааснаараа зүй

ёсны сонгуулийн тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэ нь ялангуяа сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага өөрийн шийдвэрээ богино хугацаанд гаргах шаардлагыг бий болгодог. Тиймээс сонгуулийн асуудал хариуцсан албан тушаалтнуудын үйл ажиллагаа болон мэргэшсэн байдал нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд чухал үр нөлөөтэй байдаг. Энэхүү сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага үр дүнтэй ажиллах нь сонгуулийн тогтолцоо амжилттай, тасралтгүй байх гол хүчин зүйл болдог.

Энэхүү гарын авлага нь иргэний хувьд зүй ёсны сонгуулийг зохион байгуулах байгууллагуудын үүрэг хариуцлагыг хуулиар тогтоохын ач холбогдлыг тодорхойлсон. Гарын авлагад хууль ёсны байх гол хувьсал өөрчлөлтийг дурдсан жишээлбэл, сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүн болон тогтолцоог тодорхойлоход улс төрийн зөвшилцлийн ач холбогдол, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдлын ач холбогдол зэрэгт уншигчдын анхаарлыг хандуулсан.

Гарын авлагад мөн сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх байгууллага нь байнгын үйл ажиллагаатай байх, мөн түүний хууль ёсны хүчин зүйлийг дурдсан. Уг үйл ажиллагааны зардал болон түүний тогтвортой байдлыг хангахад санхүүгийн хувьд хүндрэлтэй байж болох ч нөгөө талаар муу үйл ажиллагаатай сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь эдгээр зардлаас хамаагүй илүү зардлыг бий болгож болно. Сонгуулийн хүчирхэг, хараат бус байгууллагыг бий болгоход зарцуулах тохиромжтой санхүүжилтийн талаарх улс орнуудын шийдвэр болон аливаа төсвийн чиг үүрэг нь өөрөө ардчиллын үнэт зүйлд оруулж байгаа хөрөнгө оруулалт хэмээн үзэх ёстой. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх этгээдийн гаргах шийдвэр нь тухайн улс орны улс төрийн хөгжилд чухал ач холбогдолтой байдаг. Эдгээр шийдвэрүүд нь сонгуулийн үр дүнг хүчин төгөлдөр гэдгийг баталгаажуулах, өөрчлөх, эсвэл хүчингүй болгох болон иргэний улс төрийн эрхийг хамгаалахад чиглэдэг.

Улс төрийн намууд болон иргэд улс төрийн маргааныг хууль ёсны болон шуурхай шийдвэрлэхийг хүсэж байдаг. Үүнээс үүдэн сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх этгээд тэгш эрх, үг хэлэх эрх чөлөө зөрчигдөх, бусдын сонгуулийн эрхийг хулгайлах, хууль бус санхүүжилт болон бусад ардчилалын үнэт зүйлтэй холбоотой

асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг хүлээнэ.

Эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааны үр дүнд бүтсэн энэхүү гарын авлага нь дэлхийн улс орнуудын сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг шүүх, шүүгчдэд үр дүнгээ өгнө гэдэгт эргэлзэхгүй байна. Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн нь ардчилалын үндсэн элемент болох зүй ёсны сонгуулийн талаарх өөрийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлж, цаашдын судалгааг уншигч Та бүхэндээ үргэлжлүүлэн хүргэж байх болно.



*Мариа дел Кармен Аланис Фигуреа
Мексик улс
Холбооны сонгуулийн шүүхийн
Ерөнхий шүүгч*

Удиртгал

Сонгууль нь ардчилалын нэг амин сүнс юм. Сонгуулийн өөрийн үндсэн мөн чанар болох өрсөлдөөн болон улс төрийн талцлыг бий болгодог, нарийн төвөгтэй ээдрээтэй байдал зэрэг нь түүнийг урвуулан ашиглах, зөрчил үүсэх, хууран мэхлэх, луйвар гаргахад нөлөөлөх эмзэг байдлыг бий болгодог. Үүний зэрэгцээ сонгуулийн үр дүнд хууль ёсны дагуу байгуулагдах Засгийн газар нь бүрэн итгэж болохуйц, үнэнч шударга байдлыг ухамсарлан ажиллаж чадсан тохиолдолд сонгуулийн үндсэн зорилго нь амжилттай хэрэгжих боломжтой байдаг. Ийм учраас сонгуулийн үйл ажиллагаа бүрт байнга гарч байдаг зөрчил, маргаанаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах болон хянан шийдвэрлэх, цаашлаад шаардлагатай тохиолдолд талуудын зөрчигдсөн эрхийг бодит болон тэгш байдалд нь сэргээн тогтоож, хамгаалах үр нөлөөтэй механизм шаардлагатай.

Үр ашигтай бөгөөд үр дүнтэй сонгуулийн зүй ёсны тогтолцоо нь эдгээр зорилтуудыг хамгаалах, хангах суурь үндэс нь юм. Хэдийгээр тэгш болон тэгш бус байдлын ойлголтыг бууруулах, түүнийг зүй ёсоор зохицуулж байгаа хамгийн шилдэг сонгуулийн менежментийг хэрэгжүүлсэн сонгуулийн үйл ажиллагаа бусад этгээдээс үл итгэх байдлыг төрүүлж байдаг.

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн нь сонгуулийн зүй ёсны тогтолцооны талаарх олон улсын хэмжээний анхны гарын авлагыг сонгуулийн зүй ёсны тогтолцооны олон төрлийн механизмуудаас улс орнууд өөрийн улсын үндэсний онцлог, нөхцөл байдалд тохирсон тогтолцоог сонгон авч улмаар сонгуулийн эрхийг хамгаалахад хэрхэн ашигладаг болохыг ойлгуулахын тулд бэлтгэн гаргаж байна.

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн хэрэгжүүлж буй санаачилгууд нь сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг хүчирхийлэл, зөрчил, хямралын учир шалтгааныг судлахад чиглэгддэг. Энэхүү гарын авлага нь ийм төрлийн зөрчил, маргаан гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд техникийн болон хууль зүйн асуудал, бүтэц зохион байгуулалтад анхаарч буй билээ. Тус гарын авлага нь өнөөдөр дэлхий нийтээр хэрэглэж байгаа сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх механизмуудыг танилцуулж, энэхүү сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог хэрхэн ангилдаг, тэдгээрт

баримтлах зарчим, элементүүдийн тухай болон түүний баталгааг зохицуулан журамлах шаардлага байгааг, цаашлаад өнөөгийн зүй ёсны сонгуулийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болон хэрэглэгдэж байгаа сонгуулийн бусад алтернатив тогтолцоог авч үзсэн.

Практик ажилтнуудад туслах зорилгоор энэхүү гарын авлагад сонгуулийн зүй ёсны тогтолцооны жишээг багтаан оруулж энэхүү тогтолцоог сайжруулан хөгжүүлэхэд чиглэсэн нөхцөл байдалд тохируулан хэрэглэж болох олон төрлийн үр ашигтай аргачлалыг судлан гаргасан. Энэхүү гарын авлагыг боловсруулахад зориулан цуглуулсан болон харьцуулсан мэдээллийг цааш улам баяжуулан Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн нэгдсэн онлайн мэдээллийн санд (<http://www.idea.int/uid>) оруулсан бөгөөд мэдээллийн санг ашиглагчид шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой бөгөөд сангийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг цаашид хангахад туслалцаа үзүүлж болно.

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн нь энэхүү гарын авлагад багтаасан мэдээллийг Ардчилал, засаглал, сонгуулийн эх үүсвэрийг бий болгох (BRIDGE) сургалтын хөтөлбөрт багтаан Сонгуулийн мэдээллийн сүлжээгээр (<http://www.aceproject.org>) дамжуулан үргэлжлүүлэн боловсруулахаар ажиллаж байна.



Видар Хелгесен

*Ардчилал, Сонгуульд Туслах Олон
Улсын Хүрээлэнгийн
Ерөнхий нарийн бичгийн дарга*

Талархлын үг

Энэхүү гарын авлагыг бүтээхэд олон тооны байгууллага, хувь хүмүүс өөрийн хувь нэмрээ оруулсан билээ. Менежментийн багийн гишүүд болох Пол Гуерин, Ади Аман, Шана Кайзер, Рушди Никерден нарын туслалцаагүйгээр энэхүү ном хэвлэгдэн гарахгүй байсан. Гол зохиогч, редактор, нийтлэлч нараас гадна бид энэхүү гарын авлагыг боловсруулахад хүчин зүтгэсэн доорх хүмүүст талархлаа илэрхийлэхийг хүсэж байна: Диана Ача-Морфау, Раул Авила, Золт Бартфай, Франческа Бенда, Кристиан Комплак, Пета Доусон, Монхар Сингх Гил, Питер Харрис, Жау Юан Хванг, Сергей Кузнецов, Вишакан Кришнадасан, Ралф Линднер, Исмайл Мохамед, Изабел Рибет, Али Сави, Кейт Салливан, Хосе Томсон, Саумура Тиоулонг, Доменико Туккинарди болон Юрий Цукерман нарт талархаж байна. Айман Аяуб, Анджо Эллис, Маартен Хаалф, Жорам Рукамбе болон Гиллес Сафи нарын олон тооны экспертүүд энэхүү хэвлэлтийг сайжруулахад өөрийн мэдлэг, чадварыг хувь нэмэр болгон оруулсанд талархаж байна.

Манай хэл найруулгын редактор Анджо Милш, техник редактор Эва Жонсон нар болон орчуулагч Чарли Робертс нарт үүргээ амжилттай гүйцэтгэсэнд нь онцгойлон талархал илэрхийлж байна. Мелани Аллен, Эрика Бекман, Виржиниа Баремнди, Ингрид Бакстром-Восе, Лука ли Ружжиеро, Хенрик Доминго, Мария Грачев, Эрик Ррунде, Мелида Хименез, Стина Парсеруд, Надим Марл, Майко Шимизу, Сара Стаино нарын бүрэлдэхүүнтэй судалгаа, туслалцааны баг нь ядрахыг умартан менежментийн багт дэмжлэг үзүүлэн ажиллаж энэхүү гарын авлагыг уншигчдын хүртээл болгосон билээ. Бид мөн Антонио Спинеллид хандан зөвлөн, тусалсанд талархлаа илэрхийлж байна.

Түүнчлэн бид сонгуулийн удирдлагын чиглэлээр бидний судалгаанд цаг гарган оролцож, гарын авлагын өргөтгөл болгон бий болгосон онлайн мэдээллийн санд хувь нэмрээ оруулж, харьцуулсан судалгааны мэдээлэл цуглуулахад гар бие оролцсон дараах байгууллагуудад Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн талархал илэрхийлж байна:

Төв, Зүүн Европын сонгуулийн ажилтнуудын холбоо, Унгар
Сонгуулийн шинэтгэлийн төв, Индонези
Хараат бус сонгуулийн хороо, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс
Африк дахь ардчиллын тогтвортой байдлын төлөө сонгуулийн институт,
Өмнөд Африк
Ардчиллын боловсролын хүрээлэн, Кени
Холбооны сонгуулийн хороо, Мексик

Үндэсний сонгуулийн шүүх, Перу

Ардчилал, засаглал, сонгуулийн эх үүсвэрийн хүрээлэн, Армени.

Мөн Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн хэвлэн нийтлэх баг болох Лиза Хагман, Надиа Хандал Зандер, Люси Смит нарт талархал илэрхийлье.

Агуулга

Өмнөх үг
Удиртгал
Талархлын үг
Товчилсон үг болон хураангуй

Бүлэг 1.Танилцуулга

1. Зүй ёсны сонгуулийн ач холбогдол болон үүрэг роль
2. Зүй ёсны тогтолцооны тохирсон загвар бий болгох хэрэгцээ
3. Зүй ёсны сонгуулийн зорилго: Ардчилал, Сонгуульд Туслах
Олон Улсын Хүрээлэнгийн гарын авлага

Бүлэг 2. Зүй ёсны сонгууль, түүнтэй холбоотой бусад зарчим

1. Зүй ёсны сонгуулийн ойлголт
2. Сонгуулийн эрхийг хангах нь
 - а) Сонгуулийн эрх гэж юу болох, хэрхэн үүсдэг?
 - б) Сонгуулийн эрхийг хамгаалах арга замууд
3. Зүй ёсны сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн үе шат

Бүлэг 3. Сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх

1. Танилцуулга
2. Зохистой эрх зүйн тогтолцоо
3. Улс төрийн соёл болон иргэний боловсролыг дээшлүүлэх
4. Сонгуулийг зохион байгуулах эрх бүхий байгууллага болон Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын бүрэлдэхүүн дэх улс төрийн зөвшилцөл
5. Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага болон Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагаа: Мэргэшсэн байдал, үйл ажиллагааны хараат бус байдал, ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх үүрэг
6. Сонгуулийн ёс зүйн дүрэм

Бүлэг 4. Сонгуулийн маргаан шийдвэрлэх механизмууд

1. Танилцуулга
2. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх журам: үр дүнг хүчингүй болгох, өөрчлөх, зөрчил гарсныг хүлээн зөвшөөрөх
3. Сонгуулийн хариуцлага тооцох журам: шийтгэл ногдуулах талаар
 - а) Эрүүгийн хууль дахь сонгуультай холбоотой заалтууд
 - б) Сонгуулийн гэмт хэрэг болон зөрчлийг ангилах шалгуур
 - в) Сонгуулийн холбогдолтой гэмт хэргийн жишээ
 - г) Сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага
 - д) Сонгуулийн зөрчилд ногдуулах захиргааны хариуцлага
 - е) Зөрчил гаргасан хувь хүн, хуулийн этгээдийн ангилал болон сонгуулийн холбогдолтой захиргааны хариуцлага
 - ё) Улс орнуудад сонгуулийн зөрчлийг зохицуулах нь
 - ж) Бусад хууль зүйн арга хэрэгсэл

Бүлэг 5. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны ерөнхий ангилал

1. Танилцуулга
2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилах шалгуур
3. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны өөрчлөлт
 - а) Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хууль тогтоох байгууллага эсхүл бусад улс төрийн хүчний эрх мэдлийг баталгаажуулах
 - б) Шүүхийн байгууллагад эрх олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо
 - в) Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагад шүүхийн эрх мэдлийг олгодог Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо
 - г) Түр шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага (ad hoc body)-аар буюу сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлүүлдэг тогтолцоо

Бүлэг 6. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны зарчмууд болон баталгаанууд

1. Танилцуулга
2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо (СМШТ)-г бий болгох чиг хандлага
3. СМШЭ-ийн баримтлах зарчим болон бүтцийн баталгааны загвар
 - а) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдал
 - б) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус, бие даасан байдал
4. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үйл ажиллагааны баталгаа
 - в) Үнэгүй зүй ёсны сонгууль, эсхүл боломжийн зардалтай үйлчилгээ
 - г) Хугацаа
 - д) Өмгөөлөх, сонсох эрх ба due process of law
 - е) Шүүхийн шийдвэр, журмыг цаг хугацаанд нь, бүрэн хэрэгжүүлэх

Бүлэг 7. Сонгуулийн маргаан шийдвэрлэх системийн үндсэн элементүүд

1. Зөрчил, маргааныг шийдвэрлэх төрлүүд
 - а) сонгуулийн маргааныг шийдвэрлэх захиргааны хамааралтай элемент
 - б) Сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүхийн хамааралтай элемент
2. Маргааныг бий болгодог үйлдлүүд
3. Маргаан үүсгэхээр гомдол гаргах
4. Маргаан шийдвэрлэх хугацаа, шийдвэр
5. Нотлох баримт
 - а) Нотлох баримтыг бүрдүүлэх
 - б) Нотолгооны хэлбэр
 - в) Нотлох баримтыг үнэлэх тогтолцоо
6. Сонгуулийн дүнтэй холбоотой маргааны дагуу авах арга хэмжээ
 - а) Ялагчийг өөрчлөх боломжтой сонгуулийн дүнгийн өөрчлөлт
 - б) Сонгуулийг хүчингүйд тооцох
 - в) Нэр дэвшигч зохих шаардлагыг хангаагүйн улмаас санал хураалтыг дахин явуулах

7. Шүүхийн шийдвэр, тогтоол тогтвортой байх, нарийн нягт байх зарчим

БҮЛЭГ 8.Маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх механизм

1. Танилцуулга
2. Сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх аргын хөгжил
3. СМШ аргын хамт байдаг СМШБЖШ байнгын аргууд
 - а) СМШБЖШ процессын гол шат
 - б) СМШБЖШ байнгын аргыг хэрэглэх өргөн туршлагатай улс орнууд
4. Сонгуулийн тусгайлсан зөрчлийг шийдвэрлэх тусгай аргын үүднээс байгуулагдсан СМШЭ-ийн Ad hoc байгууллагууд
 - а) Үндэсний дотоод шийдлийн үүднээс байгуулагдсан СМШЭ-ийн Ad hoc байгууллагууд
 - б) Олон улсын ad hoc СМШЭ-ийн бүтэц



БҮЛЭГ 1

БҮЛЭГ 1

Танилцуулга

1. Зүй ёсны сонгуулийн ач холбогдол болон үүрэг роль

1. Ерөнхийдөө зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь доорх агуулга болон механизмтай холбоотой байдаг:

- Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйлдэл, процедур, шийдвэр нь хуульд нийцэж байх (Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, олон улсын хууль, гэрээ болон тэдгээрийн заалтууд)
- Сонгуулийн эрхийг хамгаалах, сэргээн тогтоох, энэ нь өөрийн сонгуулийн эрх зөрчигдсөн хэмээн үзэж буй этгээд гомдолоо гаргах, түүнийг нь хүлээн авч, хянан хэлэлцэх, шийдвэр гаргах боломжоор хангах.

2. Энэхүү гарын авлагад “зүй ёсны сонгуулийн тогтолцоо хэмээх ойлголт” нь сонгуулийн үйл явц зөрчилгүй байх, сонгуулийн эрхийг хамгаалах арга, механизмуудыг хамруулах болно. Сонгуулийн зүй ёсны байдлын механизмууд нь сонгуулийн маргаан гарахаас урьдчилан сэргийлэх бүх механизм болон институцын аргаар тэдгээрийг шийдэх бүх албан ёсны маргаан шийдвэрлэх механизм болон бусад шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх арга замуудаас бүрдэнэ. Сонгуулийн ажиллагаанд гардаг аливаа зөрчлөөс шалтгаалж маргаан үүсч болно. Сонгуулийн холбогдолтой зөрчил, маргааныг шийдэх арга механизмуудыг доорх байдлаар ангилж ойлгож болно. Үүнд:

- а. сонгуулийн зөрчлийг бий болгодог гэдэг агуулгаар нь уг зөрчлийг хүчингүй болгох, өөрчлөх, зөрчил гарсныг хүлээн

зөвшөөрөх мөн чанарт нь нийцүүлэн арилгах болон түүнээс хамгаалах албан ёсны хамгаалалтын механизм;

б. хариуцлага хүлээлгэх механизм буюу буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, зөрчил гаргасан байгууллага, иргэнд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх механизмууд;

в. Маргалдагч талууд сайн дурын үндсэн дээр сонгон авч хоорондын маргаанаа шийдвэрлүүлдэг шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх арга механизмууд.

3. Үүнтэй холбоотойгоор сонгуулийн тогтолцооны бусад элементүүдийн хамтаар зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь чөлөөтэй, шударга, үнэн зэрэг зүй ёсны сонгуулийн үндсэн баталгааг харуулж, эдгээр нь сонгуулийн хуульд тусгалаа олдог. Энэхүү сонгуулийн зүй ёсны тогтолцоо нь улс төрийн тогтолцооны хууль ёсны болон сонгуулийн ажиллагааны найдвартай байдлыг бий болгох үндэс суурь нь болдог.

4. Ардчилалд зүй ёсны сонгууль нь улс төрийн тогтолцооны тогтвортой байдлыг баталгаажуулах, хуулийг чандлан сахиулахад шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж, цаашлаад ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг. Зүй ёсны сонгуулийн үүрэг нь хэдийгээр шинэ боловч энэ нь ардчилалыг бүхий л хэлбэрээр бий болгох болон тогтооход чухал хүчин зүйл болдог гэж үздэг. Хүснэгт 1.1-д хүчирхэг Зүй ёсны сонгуулийн илрэх хэлбэр болон дутагдалтай байдалтай холбоотой зарим жишээг харуулах болно.

Хүснэгт 1.1 Зүй ёсны сонгуулийг илэрхийлэх зарим асуудлыг хөндсөн зохицуулалтууд

Улс	Жил	Шийдэр гаргасан этгээд	Үр дүн
Ану	2000	Дээд шүүх	Флорида мужийн зарим дүүргийн сонгогчдын саналыг гараар дахин тоолохыг эцэслэн зогсоосон
Испани	2003	Үндсэн хуулийн шүүх	Алан хядах ажиллагаатай холбоотой байж болох тодорхой улс төрийн намуудын хууль бус үйлдлийг зарласан

Украин	2004	Дээд шүүх	Ерөнхийлөгчийн сонгуулийг хүчингүй болгосон
Тайвань	2004	Дээд шүүх	Тайван улсын Дээд шатны шүүхийн (давж заалдах шатны шүүх)-ийн шийдвэрээр сонгуулийн саналын хуудсыг бүхэлд нь дахин тоолох ажиллагааг хүчинтэйд тооцсон
Англи	2005	Европын хүний эрхийн шүүх	Сонгуулийн хуулийн дагуу шоронд ял эдэлж байсан хүн нь Парламентын болон орон нутгийн сонгуульд санал өгөхийг хориглосон байсныг Европын хүний эрхийн шүүх хууль бус хэмээн тогтоосон
Никарагуа	2005	Америкийн орнуудын хүний эрхийн шүүх	Уугуул иргэдийн нутаг дэвсгэрт явагдаж буй орон нутгийн сонгуульд зөвхөн улс төрийн намуудын нэр дэвшигч нар оролцох эрхтэй байсан нь Америкийн хүний эрхийн тунхаглалыг зөрчсөн болохыг тогтоосон
Коста Рика	2006	Сонгуулийн дээд шүүх	Ерөнхийлөгчийн сонгуулийн бүх саналыг гараар дахин тоолохыг хуулиар зааж өгсөн
Мексик	2006	Мексикийн холбооны улсын шүүх эрх мэдлийн салбарын Сонгуулийн шүүх	Санал авах байруудын хагасаас илүү дээр Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр дахин тооллого хийхийг үүрэгдсэн
Турк	2007	Үндсэн хуулийн шүүх	Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг хүчингүй болгосон
Коломбо	2009	Төрийн зөвлөл	Санал тоолоход зөрчил гарснаас үүдэн 2006 оны Сенатын сонгуулийг хүчингүй болгож шинээр тоолох захирамж гаргасан
Тайланд	2007	Үндсэн хуулийн шүүх	Таксин Шинаватрагын намыг (Тай Рак Тай) татан буулгасан
Герман	2008	Үндсэн хуулийн шүүх	Холбооны сонгуулийн хуулийн зарим заалт болох сөрөг саналын жигнэсэн хэмжээ хэмээх заалт нь Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож 2011 оны 6 дугаар сар гэхэд шинээр хуулийн төсөл оруулж ирэхийг хууль тогтоох байгууллагад даалгасан
Молдав	2009	Үндсэн хуулийн шүүх	Парламентын сонгуулийн саналын хуудсыг дахин тоолсон

5. Сонгуулийн үе шатны аль ч хэсэгт асуудал, бэрхшээл гарч болно. Эдгээрийг улс төрийн тогтолцоо сул байгаатай эсвэл сонгуулийн ажиллагааны хангалтгүй болон булхайтай холбон авч үзэх шаардлагагүй бөгөөд харин сонгуулийн тогтолцооны хүчирхэг, бат бөх , ил тод нээлттэй байдлыг шалгах шалгуур гэж авч үзэх нь зүйтэй. Зүй ёсны сонгуулийг ойлгож, түүнийг гүнзгий танин мэдсэнээр сонгуулийн зөрчлийг институцын агуулгаар нь шийдвэрлэх, зогсооход тусалдаг. Иймээс бусад төрлийн цаашид гарч болох зөрчлийг багасгах улмаар тогтвортой байдал болон энх тайвныг бий болгоход хувь нэмэр оруулдаг.

6. Өргөн хэмжээний иж бүрэн арга хэрэгсэл болон механизмууд нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх түүнээс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдөг. Сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн маргаанд зориулсан цорын ганц эсхүл, ид шидийн юм шиг сонгуулийн ажиллагааны загвар гэж байдаггүй учир олон төрлийн аргыг хамтатган ашиглах нь эерэг үр дүнд хүргэдэг.

7. Хүчирхэг зүй ёсны сонгуулийн тогтолцоо үйлчилж байх нь дангаараа чөлөөт, ардчилсан, шударга, үнэн зүй ёсны сонгуулийг явуулах баталгаа болдоггүй боловч зүй ёсны сонгууль байхгүй байснаар зөрчлийг гүнзгийрүүлэх, хурцатгахад нөлөөлдөг. Хэрэв сонгууль нь зохистой, ойлгомжтой болон зөвшилцөлд үндэслэсэн ардчилсан зарчим болон үнэт зүйлсийг хадгалсан эрх зүйн тогтолцоо байхгүй, хэрэв тухайн сонгууль нь зохион байгуулалтгүй, эсхүл тусгайлсан зүй ёсны сонгуулийн тогтолцоог бүрдүүлсэн механизм байхгүй тохиолдлуудад сонгуулийн ажиллагаа нь тухайн үеийн зөрчил, маргааныг хурцатгах цаашлаад зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэлд хүргэж болзошгүйг 2007 оны 12 дугаар сард болсон Кени улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явдлаас харж болно.


8. Зүй ёсны сонгууль нь зөвхөн сонгуулийн холбогдолтой дүрэм журмын хэрэгжилтийг хангах ажиллагааны талаарх асуудал биш. Харин сонгуулийн ажиллагааг удирдан явуулах болон түүний загварыг багтаасан иж бүрэн цогц үйл ажиллагаа бөгөөд бүх оролцогч талуудын үйл ажиллагаанд ч нөлөөлж байдаг. Түүнчлэн сонгуулийн ажиллагааг зохион байгуулахад хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоо нөлөөлөх бөгөөд зүй ёсны сонгуульд нийгэм-соёлын, түүхийн болон улс төрийн нөхцөл байдал нь хүчтэйгээр нөлөөлдөг. Ийм учраас дэлхий нийтэд өөр өөр улс үндэстэн болон бүс нутагт олон төрлийн ялгаатай зүй ёсны сонгуулийн практик болон тогтолцоо хэрэгждэг.

9. Зүй ёсны сонгууль нь техникийн үүднээс үр ашигтайгаар хэрэгжих шаардлагатай. Үүний зэрэгцээ уг тогтолцоо нь үр дүнтэй буюу хараат бус, шударга байх гэсэн утгаараа хууль дээдлэх, ил тод байдал, хүртээмжтэй байдал, тэгш байдал, талуудын оролцоог хангасан байх шаардлагатай. Мөн энэхүү тогтолцоо нь өөрийн үйл ажиллагааны талаар ил тодоор мэдээлэн хуульд зааснаар ажиллаж буйгаа илэрхийлж байх нь чухал. Сонгуулийн үйл явцад ардчилсан зарчмыг хангаж, итгэлцэл бий болсноор л энэхүү механизм нь өөрийн өмнөө тавьсан зорилгыг хангаж чадах юм.

2. Зохистой зүй ёсны сонгуулийн тогтолцооны жишиг, загварыг бий болгох шаардлага

10. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны жишиг, загвар нь аливаа улс үндэстний хувьд хамгийн чухал шийдвэрийн нэг байдаг бөгөөд үүнтэй зэрэгцэн тухайн улсууд өөрийн сонгуулийн дэглэмийг тогтоох болон шинэчилдэг. Тухайлсан улс оронд үндсэн хууль, бусад хууль болон институцын хувьд сонгуулийн ажиллагааны жишиг, загварын нэгдмэл болон түгээмэл хандлагатай байхыг шаарддаг. Үүнийг зүй ёсны сонгуулийн тогтолцоотой холбох нь зүй ёсны сонгуулийн тогтолцооны нэгэн гол бүрэлдэхүүн хэсэг болдог.

Зураг 1.1. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны чухал хүчин зүйлсүүд



11. Зүй ёсны сонгуулийн тогтолцоог байнга эргэн харж, шинэчлэх замаар тухайн тогтолцоо нь өөрийн үүргийг биелүүлж чадаж буй эсэхийг нягтлан шалгаж, шударга, чөлөөт, үнэн зүй ёсны сонгууль хуулийн дагуу явагдахыг баталгаажуулж байх шаардлагатай. Улс төрийн эрх мэдэлд хүрэх гэсэн хүсэл эрмэлзлэл нь зарим тохиолдолд хууль бус арга хэрэглэхэд ч хүргэх тохиолдол элбэг байдаг. Сайтар боловсруулсан зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь доорх хоёр зорилтод хүрэхийн тулд эерэг хандлагыг бий болгох шаардлагатай.

- Гажуудлыг танин мэдэж, урьдчилэн сэргийлэх ,
- Засан залруулах зохистой арга хэрэгслээр хангах болон

гажуудлыг үүсгэгчидтэй хариуцлага тооцох зохистой арга механизмыг бий болгох.

12. Шинээр бий болсон болон хуучин нь шинэчилгдсэн сонгуулийн хуулийн тогтолцооны аль аль нь зүй ёсны сонгуулийн асуудалд түлхүү анхаарал хандуулдаг бөгөөд үүний хүрээнд нэр дэвшүүлэх, кампанит ажил явуулах болон үр дүнг баталгаажуулах гэх мэт сонгуулийн ажиллагааны талуудын оролцох оролцоог хангадаг. Дэлхий нийтээр хуулийн болон институцын хувьд иж бүрэн, нэгдмэл байдлыг тогтоох нь чухал гэдгийг ойлгох явдал нэмэгдэж, цаашлаад зүй ёсны сонгуулийн тогтолцоог сонгуулийн шинэтгэлийн гол элемент гэж ихэнхдээ үздэг. Сонгуульд итгэх итгэл багасах нь сонгогчид сонгуульд ер нь оролцох шаардлага байна уу гэсэн асуулт тавих, сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүйд хүргэж болзошгүй. Үр дүнтэй, цагаа олсон зүй ёсны сонгууль энэхүү сонгуульд үл итгэх байдлыг өөрчлөхөд гол элемент болдог.

13. Анхлан үүсэж байгаа ардчилсан нийгмийн үед сонгуулийн тогтолцоогоо цоо шинээр бий болгох эсхүл хуучин сонгуулийн тогтолцоогоо уламжлан авдаг. Тухайн улсын эрх зүйн, улс төрийн уламжлал, колончлолын ул мөр, онцлог, хөрш орнуудын нөлөөлөл нь үүнд шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Нөлөө бүхий өөр өөр улс төрийн хүчнүүдийн хооронд байгуулсан богино хугацааны гэрээ болон нийгмийн тусгайлсан шаардлагууд нь мөн шийдвэрлэх үүрэгтэй. Том хэмжээний сонгуулийн хямралаас шалтгаалж ардчилалыг тогтооход саад учруулахад хүргэсэн улс төрийн хямрал нь зүй ёсны сонгуулийн тогтолцоог сайжруулах шаардлагыг бий болгодог. Түүнчлэн ардчилсан улс төрийн шинэчлэлийг дэмжиж байгаа талууд зүй ёсны илүү ардчилсан хууль ёсыг тодорхойлохын тулд сонгуулийн эрхийг үр дүнтэйгээр хамгаалах, шударга, чөлөөт, үнэн зүй ёсны байдлыг баталгаажуулах чиглэлээр сонгуулийн тогтолцоог өөрчлөх тухай улс төрийн хөтөлбөртөө тусгахыг оролдож болох юм.

14. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны загвартай холбоотой шийдвэр нь урьдчилан төлөвлөөгүй үр дагаварт хүргэж болно. Тухайлбал, удаан хугацаанд үр ашиггүй байх, зарим тохиолдолд ардчилалын ирээдүйд аюултай нөлөө үзүүлж магадгүй юм. Жишээбэл, шүүхийн хараат бус байдал дутагдалтай, шүүх нь нэр хүнд муутай улс орнуудын хувьд сонгуулийн тогтолцоог нь өөрчилж байна гээд сонгуулийн үр дүнгийн талаарх эцсийн шийдвэрийг гаргах эрхийг шүүхэд олговол эсрэгээрээ энэ нь өмнөх тогтолцооноосоо дордуулсан сонгуулийн тогтолцооны өөрчлөлт болж болзошгүй.

15. Энэхүү гарын авлага нь зүй ёсны сонгуулийн тогтолцооны загварыг танин мэдэхэд чиглэгдэхээс бус хараат бус техникийн шинжээчдийн багийн цорын ганц зүй ёсны хариулттай “хамгийн шилдэг тогтолцоо”-г харуулахыг зориогүй болно. Харин энэ гарын авлагаар сонгуулийн тогтолцооны нэгдмэл хувилбар бүхий загварт анхаарлаа хандуулж байна. Техникийн асуудлуудыг хамруулан, техникийн туслалцааны хүрээнд хариулт өгч байгаа нь чухал хэдий ч олон төрлийн түүхийн болон улс төрийн агуулгад үндэслэн цөөхөн тохиолдох, жишиг, загварыг оруулсан Зүй ёсны сонгуулийн тогтолцоог судалсан харьцуулсан судалгаа нь төгс сонгуулийн тогтолцоо гэж хаана ч байхгүйг харуулж байна. Гэхдээ энэхүү бүтээлээр олон төрлийн сонгуулийн тогтолцооны давуу болон сул талыг судлан, тэдгээрийн чиг хандлагыг олж мэдэх, дүн шинжилгээ хийж нэмэлт элементүүдийг санал болгох, амжилттай хэрэгжсэн туршлага болон практикийг танин мэдэх боломжийг олгож буй болно.

3. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны зорилго: Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн гарын авлага

16. Одоогоор хэрэгжиж буй зүй ёсны сонгуулийн тогтолцоо, түүний үр дагавар болон яаж уг тогтолцоо нь дэлхийн өөр өөр ардчилалын шалгууртай улс орнуудад хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийх үүднээс энэхүү гарын авлагыг гаргасан нь дор дурдсан үндсэн хоёр зорилготой:

а. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, үзэл баримтлалын түвшинд улс төрийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг өрнүүлэх, зүй ёсны сонгуулийн тогтолцоо болон механизмын загвар болон түүний хэрэгжилтийг хангах,

б. Шинээр зүй ёсны сонгуулийн тогтолцоог бий болгох, сонгуулийн тогтолцоогоо шинэчлэн өөрчлөх гэж байгаа Үндсэн хууль боловсруулагчид, улс төрийн болон шүүх эрх мэдлийн институцууд, сонгуулийн болон процессын хууль тогтоомж боловсруулдаг болон хэрэгжүүлдэг этгээдүүдэд мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах боломжийг хангах.

17. Энэхүү гарын авлагыг гаргасан нь дор дурдсан тусгай зорилготой:

- Зүй ёсны сонгуулийн тогтолцооны тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, үүнд суралцахад дэмжлэг үзүүлэх, үүний хүрээнд сонгуулийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх механизмууд болон зөрчил гарсан тохиолдолд түүнийг

- хэрхэн хянан шийдвэрлэх процессыг хамруулсан
- Зүй ёсны сонгуулийн тогтолцооны олон төрлийн орчин үеийн загваруудыг тодорхойлж, тэдгээр нь олон төрлийн байгууллагуудын баталгаа болон олон улсын зарчмын хүрээнд ямар бүтэцтэйгээр хэрхэн хэрэгждэг болохыг нотлох үүрэг, зохицуулалтыг оруулсан
 - Зүй ёсны сонгуулийн тогтолцоог боловсруулах, тогтоох, шинэчлэх, бэхжүүлэх арга замыг эрэлхийлж буй ямар ч этгээд ашиглах боломжтой лавлагаа, ерөнхий бүтцийг гарган өгсөн
 - Сонгуулийн бүх үйлдэл, үйл ажиллагаа, үйл явц болон шийдвэрүүд нь хуульд нийцсэн, ардчилсан зарчим, үнэт зүйлсийн дагуу байх, сонгуулийн эрхийг хамгаалах баталгаа болоход туслах арга хэрэгслээр хангасан.

18. Энэхүү гарын авлага нь зүй ёсны сонгуулийн тогтолцоог шинээр бий болгохоор болон хуучнаа шинэчлэх гэж байгаа аливаа Үндсэн хуулийн болон бусад хуулийн төсөл боловсруулж байгаа этгээд, улс төрийн тохиролцоо хийхийг хүсэж байгаа этгээд, сонгуулийн зөвлөхүүд болон албаны хүмүүст шаардлагатай мэдээлэл өгөх зорилготой. Эцэст нь дурдахад энэхүү гарын авлага нь ихээхэн ээдрээтэй асуудлуудыг тусгасан бөгөөд холбогдох мэргэжлийн болон онолын судалгааны баримт материалуудаас сонгуулийн асуудалтай холбоотой түлхүүр ойлголт, санаануудыг сонгон авч оруулсан. Хэдийгээр энэхүү гарын авлагыг улс төрийн шинэтгэл хийхийг хүссэн ямар ч хүмүүс ашиглах боломжтой боловч энэ гарын авлагаар хууль зүйн үндсэн мөн чанар, зарчмыг агуулсан олон асуудлууд хөндөгдөх учраас хууль зүйн хүнд хэцүү утга агуулгыг заавал оруулах шаардлага байсныг дурдах нь зүйтэй.

19. Зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь сонгуулийн тогтолцооны салшгүй нэг хэсэг нь байдаг. Зүй ёсны сонгуулийн тогтолцоог бүрэн хэмжээгээр үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд сонгуулийн үйл ажиллагаанд тусалдаг арга хэрэгсэл болон сонгуулийн ажиглалтыг зүй ёсны сонгуулийн тогтолцооны чиг үүрэг, бүрэлдэхүүн, загварыг тодорхойлохдоо анхааран үзэж, сонгуулийн үе шатанд тэдгээрийн үйл ажиллагаа болон үйл явцад үнэлгээ хийх шаардлагатай.

20. Энэхүү гарын авлага нь үндэсний түвшний зүй ёсны сонгуулийн тогтолцоонд анхаарлаа хандуулсан. Гэхдээ тухайн нөхцөл байдалд тохирсон хувилбарыг сонгохыг хүсэж байгаа аливаа этгээдэд сонгуулийн үйл явцад гарч болзошгүй сонгуулийн маргаан, зөрчлийг шийдвэрлэх олон төрлийн хувилбаруудыг санал болгож улмаар шууд

болон төлөөллийн ардчилалын аль ч нөхцөлд хамруулж болдог бүх нийтийн санал асуулга болон саналыг эргүүлэн татах санал хураалтын үйл явцыг хамруулан авч үзсэн. Цаашлаад энэхүү гарын авлага нь орон нутгийн болон бүс нутгийн түвшний сонгуулийн ажиллагааны тогтолцоог гаргах гэж байгаа төсөл боловсруулагчдад чухал лавлах болно. Түүнчлэн улс төрийн намын дотоод сонгууль, уламжлалт болон тодорхой олон нийтийн дундах сонгуулийн тогтолцоог боловсруулагчид, үйлдвэрчний эвлэлүүд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн бүлгүүд өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглах боломжтой. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны төрлүүд бүр өөрийн гэсэн онцлогтой байдаг. Үүнтэй холбоотойгоор сонгуулийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон маргаан шийдвэрлэдэг олон төрлийн хувилбарууд нь мөн л үндсэн мөн чанарын хувьд онцлог шинжүүдтэй байх бөгөөд эдгээр нь тухайн улс орны нөхцөл байдлын талаар дүн шинжилгээ хийсэн байхыг шаарддаг.

21. Гарын авлагын 2 дугаар бүлэгт зүй ёсны сонгуулийн ойлголт болон бусад үүнтэй холбоотой зарчим, үзэл баримтлалыг оруулсан. Тухайлбал, сонгуулийн эрх, уг эрхийг хэрхэн хамгаалах талаар, сонгуулийн олон үе шатанд гарч болох хүндрэл бэрхшээлүүд, зүй ёсны сонгуулийн үндсэн элементүүдийг багтаасан. Харин 3 дугаар бүлэгт сонгуулийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон арга замыг хамруулсан бол 4 дүгээр бүлэгт сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх механизмуудын зарчмыг судалсан. Дэлхий нийтээр хэрэглэдэг сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилан 5 дугаар бүлэгт оруулсан. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндсэн зарчим, түүний баталгааг 6 дугаар бүлэгт дүгнэсэн бол дараагийн 7 дугаар бүлэгт сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндсэн шинжүүдийг авч үзсэн. Эцэст нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх олон төрлийн аргуудыг ерөнхий байдлаар дүгнэн оруулсан болно.

Хүснэгт 1.2 Гарын авлагын агуулга, зохион байгуулалт

Үндэсний түвшин							
Сэдэв	Зүй ёсны сонгууль, сонгуулийн эрх, тохиолдож болох бэрхшээлүүд, зүй ёсны сонгуулийн элементүүд	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх аргууд	Сонгуулийн маргаан шийдвэрлэх үндсэн зарчим	Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны дэлхий нийтийн ангилал	Сонгуулийн маргаан шийдвэрлэх зарчим болон баталгаа	Сонгуулийн маргаан шийдвэрлэх үндсэн шинж	Маргаан, шийдвэрлэх алтернатив механизм
Шийдэх			Маргаан шийдвэрлэх албан ёсны процесс	Сонгуулийн холбогдолтой маргааныг шийдвэрлэх			Маргаан шийдвэрлэх албан бус процесс
Арга хэмжээ		Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Засан залруулах болон хариуцлага хүлээлгэх арга хэмжээ			Засан залруулах арга хэмжээ	Сайн дурын арга хэмжээ
Бүлэг	Бүлэг 2	Бүлэг 3	Бүлэг 4	Бүлэг 5	Бүлэг 6	Бүлэг 7	Бүлэг 8

БҮЛЭГ 2

БҮЛЭГ 2

Зүй ёсны сонгууль, түүнтэй холбоотой бусад зарчим

1. Зүй ёсны сонгуулийн ойлголт

22. “Зүй ёсны сонгууль” хэмээх үг хэллэг нь олон төрлийн утга агуулгатай байдаг. Өргөн хүрээнд болон энэхүү гарын авлагын зорилгын хүрээнд авч үзвэл “Зүй ёсны сонгууль” гэдэг нь сонгуулийн бүхий л үйл ажиллагаа, процесс болон сонгуулийн ажиллагаатай холбоотой гарч байгаа аливаа шийдвэр нь тухайн улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцсэн байх, иргэд сонгуулийн эрхээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадаж байхыг хэлдэг. Сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх гэдэгт өөрийн сонгуулийн эрхээ зөрчигдсөн хэмээн үзэж буй аливаа этгээд эрх бүхий байгууллагад сонгуулийн эрхээ хамгаалуулах, сэргээн тогтоолгохоор гомдол гаргах, уг гомдлыг нь хянан шийдвэрлэх, уг шийдвэрийг хүлээн авах, сонсох эрхтэй байхыг хэлдэг байна.

23. Сонгуулийн 3 үе шатанд (сонгуулийн өмнө, сонгуулийн ажиллагааны үеэр, сонгуулийн дараа үүнийг Зураг 2.4-ийн 44-53 дугаар хэсгээс үзнэ үү) сонгуулийн ажиллагааны тухай болон сонгуулийн тухай аливаа шийдвэрүүд нь зүй ёсны сонгуулийн тогтолцоогоор баталгаажин хуулийн дагуу гардаг.

24. Зүй ёсны сонгууль нь сонгуулийн эрх зүйн тогтолцоонд гарч болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонгуулийн хуулийн заалтыг дагаж мөрдөхгүй байх болон уг хуулийн заалтыг зөрчсөнөөс үүдэн гарсан маргааныг хянан шийдвэрлэх гэсэн хоёр утгыг хамруулан авч үздэг. Үүний дагуу сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагууд

нь албан ёсны механизм харин Сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх аргуудыг албан бус механизмууд гэж нэрлэдэг.

25. Зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь тодорхой нэг улс оронд (зарим тохиолдолд орон нутагт эсвэл бүс нутаг болон олон улсын түвшинд ч байж болно) хэрэгждэг механизм бөгөөд гол зорилго нь сонгуулийн үйл ажиллагаа, процедур болон шийдвэр нь хуульд нийцсэн, сонгуулийн эрхийг хамгаалсан, зөрчигдсөн тохиолдолд уг эрхийг сэргээн тогтоох боломжийг бүрэн дүүрэн хангах байдлаар илэрдэг. Зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь хууль дээдлэх ёс болон чөлөөт, шударга, үнэн зүй ёсны сонгуулийн ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх үндсэн баталгаа болдог.

26. Зүй ёсны сонгуулийн тогтолцооны хамгийн чухал зорилго нь сонгуулийн эрхийг бодитоор болон үр дүнтэйгээр хамгаалахад оршдог. Үүнд:

- Парламентийн төлөөлөл, Засгийн газрын албан тушаал нь улс орон даяар, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд сонгох болон сонгогдох эрхийг хэрэгжүүлсний үр дүнд бий болох;
- Бүх нийтийн санал асуулга болон эргүүлэн татах санал хураалтанд шууд болон шууд ардчилалын үйл явц, процедурын утга агуулгын хүрээнд оролцох.

27. Сонгуулийн үйл ажиллагаа, процедур, шийдвэр нь хуульд нийцээгүй, түүнийг зөрчсөн тохиолдолд үүнийг хууль бус үйл ажиллагаа гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд хуулийг зөрчсөн тал болон өөрийн сонгуулийн эрхийг зөрчигдсөн хэмээн үзэж байгаа талуудын хооронд маргаан үүсдэг.

28. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх албан ёсны механизмуудыг хооронд нь ялган зааглах шаардлагатай бөгөөд зарим нь сонгуулийн маргааныг засан залруулах үүрэгтэй байдаг бол зарим нь хариуцлага хүлээлгэх, шийтгэл ноогдуулах үүрэгтэй байдаг. Сонгуулийн хүндрэл бэрхшээлтэй холбоотой (Бүлэг 7-д энэ талаар тодорхой байгаа.) асуудлуудын хувьд ихэнхдээ засан залруулах арга хэмжээг авдаг. Үүний хүрээнд сонгуулийн хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх, зөрчил гарсныг тогтоох, тухайн хууль бус үйлдлээс шалтгаалан зөрчигдсөн сонгуулийн эрхийг хамгаалах болон сэргээн тогтоох зэрэг арга хэмжээг хамруулдаг. Хариуцлага хүлээлгэх чиглэлийн арга хэмжээ нь сонгуулийн зөрчил гаргасан байгууллага, иргэнд хариуцлага хүлээлгэх үүний хүрээнд захиргааны (иргэний) болон иргэний хариуцлага хүлээлгэдэг (үүнийг гарын

авлагын Бүлэг 4-ийн хэсэг 3-аас харж болно). Үүнээс гадна маргаан зөрчил шийдвэрлэх бусад хувилбар, механизмууд байх бөгөөд маргалдагч талууд өөрийн сайн дураар энэхүү механизмыг сонгон авч хэрэгжүүлдэг ба үүнийг шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх механизмууд гэж үздэг. (Бүлэг 8-д энэ талаар дурдсан).

Зураг 2.1 Зүй ёсны сонгуулийн элементүүд



29. Сонгуультай холбоотой зөрчил, маргаан үүссэн тохиолдолд (жишээ нь нэр дэвшигч санал худалдаж авч ялалт байгуулсан бол) зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь албан ёсны сонгуулийн маргаан шийдвэрлэх механизмыг ашиглан тухайн зөрчлөөс үүдэн хохирсон тал нь дор дурдсан байдлаар гомдол гаргах боломжийг бий болгож байдаг. Үүнд:

- а. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад хандахаас өмнө тухайн сонгуулийн үр дүнг хүчингүй болгох, өөр нэр дэвшигчийг ялагчаар зарлахыг хүссэн гомдол, нэхэмжлэл гаргах. Энэхүү гомдол, нэхэмжлэлийг сонгуулийн болон сонгуулийн процессын хуульд заасны дагуу гаргаж, шаардлагатай бол давж заалдах, шүүхэд хандах бөгөөд үүнтэй холбоотой гол шинжүүдийг гарын авлагын Бүлэг 7-гийн 1 дэх хэсэгт дурдсан.
- б. Эрх бүхий этгээдэд хандахаас өмнө гомдлыг хуульд заасны дагуу эрүүгийн гэмт хэрэг үүсгэн мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, сонгууль зохион байгуулах этгээдэд хандах:

I. Шүүхийн шатанд шилжүүлэхээс өмнө гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага нь тухайн сонгуулийн хууль бус үйлдлийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэрэг гэж үзвэл хорих ял

болон торгуулийн ял оногдуулахаар ял төлөвлөж болно. Харин зарим улс орны зүй ёсны сонгуулийн тогтолцоонд сонгуулийн эрх бүхий байгууллага нь тухайн зөрчил маргааныг хэлэлцэн шийдэж, үр дүнг хүчингүй болгох, өөрчлөх тухай урьдчилсан шийдвэрийг гаргаж болдог бөгөөд энэ шийдвэр нь шүүхээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.

II. Зарим орны зүй ёсны сонгуулийн тогтолцоонд сонгуулийг зохион байгуулдаг этгээд нь мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж болдог. Сонгууль зохион байгуулах этгээд сонгуулийн маргааныг авч хэлэлцэх, байцаалт явуулах зэрэг захиргааны хариуцлагын хуульд заасан процедурыг явуулсны дараагаар тухайн улс төрийн нам эсхүл, нэр дэвшигч нь захиргааны зөрчил (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй захиргааны зөрчил) гаргасан тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэх, жишээ нь торгууль ноогдуулж болох бөгөөд уг шийдвэрийг голдуу шүүхийн өмнөх шатанд гомдол гаргах боломжтой байдаг. Харин зарим орны ялангуяа нийтийн эрх зүйн уламжлалт системтэй орнуудын зүй ёсны сонгуулийн тогтолцоонд сонгуулийн зөрчилтэй холбоотой захиргааны хариуцлагыг иргэн, захиргааны болон эрүүгийн шүүхүүд нь ногдуулдаг. Шийтгэлийг тухайн хэргээс шалгаалан иргэний, захиргааны болон эрүүгийн шүүхээр хэлэлцэн ноогдуулдаг ба энэ нь нийтийн эрх зүйн системийн уламжлал бүхий улс орнуудад хэрэгждэг. Энэ тогтолцооны эрүүгийн болон захиргааны хариуцлагыг ялгах боломжгүй байдаг.

30. Иймээс дор дурдсан зүйлсийг ялган ойлгох нь ач холбогдолтой:

- а. Эрх зүйн хамгаалалт (эрхийг хэрэгжүүлэх эсхүл, гэм бурууг арилгах) ыг санал болгох болон хууль бус эрхийн актуудыг тогтоох, хүчингүй болгох, өөрчлөх зорилго бүхий зорилт;
- б. Эрүүгийн шүүхээр шийдвэрлэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болох гэмт хэргийг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх зорилго бүхий сонгуулийн хүрээний захиргааны болон эрүүгийн хариуцлага тодорхойлох ажиллагаа;
- в. Сонгуулийн байгууллага эсхүл захиргааны байгууллагын зүгээс буюу ихэвчлэн иргэний болон захиргааны шүүх хурлаар захиргааны зөрчил (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэх зөрчил)-д хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа

31. Энэхүү гарын авлага нь сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх арга (Бүлэг 3), маргааныг хянан шийдвэрлэх албан ёсны механизм (Бүлэг 4) болон сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх механизмыг (Бүлэг 8) авч үзсэн болно. Гарын авлагын Бүлэг 5, 6 болон Бүлэг 7д өөр өөр эрх зүйн тогтолцоонд

маргааныг шийдвэрлэх механизмуудыг онцлон авч үзсэн бөгөөд сонгуультай холбоотой асуудлыг өргөдөл, гомдол гаргах болон тэдгээрийг шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллагын талаар тусгайлсан лавлагаагаар хангана.

2. Сонгуулийн эрхийг хангах нь


а) Сонгуулийн эрх гэж юу болох, хэрхэн үүсдэг?

32. Сонгуулийн эрх гэдэг нь улс төрийн эрх бөгөөд хүний эрхийн ангилалд хамаардаг. Сонгуулийн эрх нь үндсэн болон суурь зарчим болж хуульд (Үндсэн хууль болон бусад хуульд биеллээ олсон байдаг) тусгагддаг бөгөөд үүний зэрэгцээ олон улсын хүний эрхийн талаарх гэрээ, конвенци болон цөөн тохиолдолд жишиг эрх зүй (шүүхээс тогтоосон президент)-ээс урган гарсан байдаг.

33. Хамгийн чухал олон улсын хүний эрхийн тунхаглал, конвенцуудад сонгуулийн эрхийг тусгасан байдаг бөгөөд уг эрх нь тухайн гэрээ, тунхаг, конвенцуудад нэгдэн орсон зарим улс орнуудын болон бүс нутгийн хүрээнд баталгаажсан байдаг. (Зураг 2.2-ыг үзнэ үү).

34. Аливаа улс орон хүний эрхийн холбогдолтой олон улсын тунхаг, конвенцэд нэгдэн ороогүй байсан ч тэдгээр улс орнууд олон улсын хэмжээнд сонгуулийн эрхийг хангах харилцан зөвшилцсон үүрэгтэй байдаг. Үүнд чөлөөт, шударга, үнэн зүй ёсны сонгууль явуулах талаар олон улсын түвшинд тавигддаг чухал шаардлагыг биелүүлэх үүрэг хамаардаг. Тухайн улс орны хууль ёсны ардчилсан засаглалд хандах хандлага, сонгуулийн ажиллагааны итгэл төрүүлэхүйц байдал зэргээс нь шалтгаалж тухайн улс орны төрийн зүгээс энэхүү харилцан зөвшилцөх үүргээ хэрхэн биелүүлж байгааг олон улсын хэмжээнд ажиглаж, дүгнэлт өгч байдаг.

Зураг 2.2. Сонгуулийн эрхийг заасан олон улсын хүний эрхийн холбогдолтой баримт бичгүүдийн жишээ



* Эдгээр дээр нэмээд бусад бүс нутгийн хэмжээнд хэрэгждэг баримт бичгүүд байж болох бөгөөд жишээ нь, Шинэ Европын төлөөх Парисын 1950 оны конвенц, Америкын хүний эрхийн 1969 оны конвенцын 15, 16 дугаар заалтууд (Эвлэлдэн нэгдэх эрх болон Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө), Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын Копенгагены 1990 оны уулзалтын 5-8 дугаар бүлэг, олон улсын болон Засгийн газар хоорондын гаргасан бусад баримт бичгүүд тухайлбал ОУПХ-ны Чөлөөт, шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтийн тунхаг (1994) болон Харарегийн хамтын нийгэмлэгийн тунхаг (1991) зэрэг багтана.

35. Сонгуулийн үндсэн эрхүүдэд сонгох болон сонгогдох эрх, санал хураалт нь чөлөөтэй, шударга, үнэн зүй ёсны явагдах, сонгуулийн үе шатууд нь бүх нийтийг хамарсан, чөлөөт, нууцаар, шууд сонгох байдлаар явагдах, төрийн байгууллагад тэгш нөхцөлтэйгээр сонгогдох, сонгуульд оролцох зорилгоор улс төрийн байгууллагууд эвсэж, нэгдэх эрхтэй байх (сонгуульд оролцох зорилгоор улс төрийн нам байгуулах, улс төрийн нам, эвсэлд элсэх болон элсэхгүй байх эрх)-тай эрхүүд хамаардаг. Цаашлаад бусад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөтэйгээр хурал, цуглаан зохион байгуулах, өргөдөл гомдол гаргах, улс төр-сонгуулийн асуудлаар мэдээлэл авах эрх зэрэг


олон тооны сонгуулийн эрхүүд байдаг. Ерөнхийдөө сонгуулийн эрх нь чөлөөтэйгээр, шууд сонгогдсон төлөөллөөр дамжуулан төрийн эрхийг барих улс төрийн эрхийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

36. Сонгуулийн эрх нь сонгуулийн асуудалд хамаардаггүй улс төрийн бусад эрхээс ялгаатай байдаг. Жишээ нь:

- Сонгуультай холбоогүй үйл ажиллагаагаар дамжуулан улс төрийн үйл хэрэгт оролцох эрх (жишээ нь төрийн албанд томилогдоход сонгууль явуулах шаардлагагүй);
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөтэйгээр эвлэлдэн нэгдэх, өргөдөл, гомдол гаргах, сонгуулиас бусад улс төрийн асуудлаар мэдээлэл авах эрх;
- Зарим улс орнуудын хууль тогтоомжид улс төрийн бусад эрхүүдийг буюу санал хураалт явуулахгүйгээр газар нутгаа хамгаалах болон түүний байгууллага, тогтолцоог хамгаалах эрхүүдийг тусгасан байдаг.

Зарим улс орнуудад сонгуулийн эрхийг хамгаалах, хангахдаа улс төрийн бусад эрхээс ялгаатайгаар авч үздэг.

Зураг 2.3 Сонгуулийн үндсэн эрхүүд



37. Хэд хэдэн олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд зүй ёсны сонгуулийг бүрдүүлдэг сонгуулийн эрхүүд түүнийг тодорхойлох олон зарчмуудыг дэлгэрүүлэн тодорхойлж, ялангуяа Сонгуулийн маргааны шийдвэрлэх тогтолцоо болох сонгуулийн эрхийн баталгаа болдог, түүнийг хамгаалж, сэргээн тогтоодог эрх, зарчмуудыг судлан оруулсан. Эдгээр зарчмуудад шүүхийн өмнөх шатанд сонгуулийн эрхийг үр дүнтэйгээр шударгаар хамгаалах, хууль ёсны дагуу болон нийтэд ил тодоор шүүхийн ажиллагаа явагдах зэрэг хамаардаг бөгөөд энэ нь сонгуулийн эрхийн хамгаалалт нь бүхий л талаар тэгш байдлын баталгаа болдог.

Мэдээлэл 2.1 Сонгуулийн маргааныг шийдвэрлэх олон улсын үүргүүд

Авери Давис Робертс

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын конвенц болон бүс нутгийн баримт бичгүүдэд Африкын хүний эрхийн тунхаг, Америкын хүний эрхийн конвенц болон Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах Европын конвенц зэрэг нь олон улсын эрх зүйд үндэслэдэг сонгуулийн маргааныг шийдвэрлэх механизмын зарчмуудыг ойлгуулан таниулахад үндсэн суурь нь болдог. Цаашлаад, НҮБ-ын Хүний эрхийн хорооны гаргасан 31, 32 дугаар ерөнхий тайлбар, Венецийн комиссын Сонгуулийн шилдэг туршлага, дүрэм журам болон бусад эх сурвалжууд нь эдгээр зарчмуудыг илүү тодорхой ойлгоход туслана. Хэдийгээр эдгээр баримт бичиг сонгуулийн маргааныг шийдвэрлэх механизмтай холбоотой асуудлыг шууд илэрхийлээгүй харин сонгуулийн эрхийг үр дүнтэйгээр хамгаалах хамгаалалтын арга хэрэгсэл, шүүхийн нээлттэй, шударга байдал зэрэг ерөнхий эрхүүдийг илүү өргөн хүрээнд харуулсан нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх процессын талаарх бидний ойлголтыг гүнзгийрүүлэх болно.

Сонгуулийн бүхий л үйл ажиллагаа нь хуулийг дээдлэх зарчмыг харгалзан үзэж, төр нь сонгуулийн бүхий л үе шатанд хүний эрхийг баталгаажуулж, хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх хамгийн чухал ач холбогдолтой асуудал нь үр дүнтэй хамгаалалтын эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа буюу хуулийн өмнө шударга, нээлттэй болон тэгш байдлаар маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа байдаг.

25 дугаар хэсэгт заасан улс төрийн үйл хэрэгт хүн бүр оролцох эрхийг оролцуулан хүний эрхийн баримт бичгүүдэд тусгалаа олсон сонгуулийн эрхээ үр дүнтэйгээр хамгаалуулах. Энэхүү эрх зүйн хамгаалалтыг хуулиар баталгаажуулсан тохиолдолд заавал хэрэгжих ёстой. Сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн үр дүнтэй хамгаалалтууд нь зөвхөн шүүхээр хамгаалагдахаар хязгаарлагдахгүй харин уг хамгаалалтын механизмын тохиромжтой байдлаар зөрчил, маргааныг бүрэн шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох явдлыг хангасан байх ёстой. Улс орнууд иргэний эрхийг зөрчсөн тохиолдлыг мөрдөн шалгаж, үүнд хамаарах бүхий л захиргааны механизмуудыг бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал, хүний эрхийн комисс зэрэг байгууллагыг байгуулж, уг байгууллага нь эдгээр үүргийг биелүүлэх боломжийг хангаж өгөх. Түүнчлэн төр нь гуравдагч этгээд болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хүний эрхийн зөрчлийг арилгах зохицуулалтыг бий болгох ёстой.

Үүний зэрэгцээ, хүн бүр өөрийн эрхийн талаарх ойлголтыг шударгаар болон олон нийтэд нээлттэй хэлбэрээр мэдэж авах эрхтэй. Хуульд нийцсэн хүний эрхийн талаарх ойлголт хүрээнд хүн бүр хараат бус, бие даасан шүүхийн аль нэг шатанд хандан өөрийн эрхээ хамгаалуулах баталгаа, боломжоор хангагдсан байх шаардлагатай. Шүүх нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байж, хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ шүүхийн хараат бус байдлыг хангах ёстой. Хараат бус байхын тулд шүүгчийн шийдвэр нь хэргийн талуудын аль нэгэнд нь боломж олгох эсхүл, нөгөө талынх нь эрх ашгийг хохироох байдлаар хэргийг шийдвэрлэхээс өмнө тодорхой ойлголттой болсон байх болон нэг талын эрх ашгийг зүй бусаар хамгаалах ёсгүй. Хамгийн чухал нь тухайн шүүх ажиллагаа хараат бус болж байгааг олон нийт ажиглах боломжийг бүрдүүлэх ёстой. Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах шаардлагатай. Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй байдал нь ил тод байдлыг ханган, нийтийн эрх ашгийг хамгаалж байдаг.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй бөгөөд аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр хуулийн хамгаалалтыг тэгш байдлаар хүртэх эрхтэй. Цаашлаад, хүн бүр шалтгаангүй хязгаарлалт, ялгаварлалгүйгээр шүүхэд хандах эрхээ эдэлж, өөрийн эрхээ хамгаалахад тэгш эрхтэй оролцох ёстой.

Түүнчлэн хэн бүхэн мэдээлэл хайх, авах эрхтэй бөгөөд үүний хүрээнд тухайн гомдлыг хэрхэн авч үзэж буй, ямар үр дүн гарч буй, ямар нотлох баримт олоод буй, хууль зүйн ямар үндэслэлийг тогтоосон зэрэг мэдээллийг авах эрхтэй. Тухайн шүүхийн үйл ажиллагаа нь олон нийтэд хаалттай байсан ч гэсэн дээрх асуудлуудаар мэдээлэл авах бүрэн эрхтэй юм.

б) Сонгуулийн эрхийг хамгаалах арга замууд

38. Зарим хуулийн тогтолцоонд сонгуулийн эрх болон улс төрийн бусад эрхүүдийг өөр өөр арга замуудаар хамгаалдаг бөгөөд шалтгаалж эдгээр эрхүүд нь хоорондоо ялгаатай байдаг. Зарим улс орнуудад сонгуулийн эрхийг хамгаалдаг болон сэргээн тогтоодог зүй ёсны сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг механизмуудаас өөр хууль зүйн арга хэрэгсэл болон процедурыг бусад улс төрийн эрхийг хамгаалахдаа хэрэглэдэг. Жишээ нь Өмнөд Африкт сонгуулийн эрхийг хамгаалах байгууллага нь Сонгуулийн шүүх байдаг бол улс төрийн бусад эрхийг хамгаалах үүргийг Дээд шүүхийн мэдэлд өгдөг байна. Зарим улсуудад нэг байгууллага улс төрийн болон сонгуулийн эрхийн аль алийг нь хамгаалдаг. Европын хэд хэдэн оронд жишээ нь Герман болон Испанид эрхийг хамгаалах доод шатны байгууллагууд тухайн асуудал нь улс төрийн эрх үү сонгуулийн эрх үү гэдгээс хамааран нь өөр өөр байж, харин эдгээр эрхийн хоёуланг нь Үндсэн хуулийн шүүхээр эцэслэн хамгаалдаг байна.

39. Сонгуулийн эрхийг хамгаалах зорилгоор сонгуулийн маргааныг шийдвэрлэх өөр өөр тогтолцоог Бүлэг 7-д нарийвчлан дурдсан. Үүнд захиргааны байгууллага, шүүхийн байгууллага, хууль тогтоох байгууллага, олон улсын байгууллага болон түр хугацааны үйл ажиллагаатай, зөвхөн тухайн маргааныг шийдвэрлэх зорилгоор байгуулагддаг байгууллагууд хамаарна.

- Захиргааны байгууллагад сонгууль зохион байгуулах эрх бүхий сонгуулийн ерөнхий, тойргийн, хэсгийн хороо, комисс хамаарна;
- Шүүхийн байгууллагад байнгын ажиллагаатай шүүх, салбар шүүх, бие даасан шүүх, Үндсэн хуулийн шүүх эсвэл уламжлалт гүйцэтгэх болон ердийн шүүх, эрх мэдлээс тусдаа бүтэц бүхий дагнасан сонгуулийн шүүх, захиргааны шүүх хамаарна. Шүүхийн байгууллагын хүрээнд үндсэндээ шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг шүүхүүд л хамаарах бөгөөд энэхүү гарын авлага нь уг шүүхийн байгууллагыг дээрх

- байдлаар нилээд өргөн хүрээнд авч үзсэн;
- Хууль тогтоох байгууллагад хууль тогтоох байгууллага бүхэлдээ хамаарах бөгөөд жишээ нь уг байгууллагын бүрэлдэхүүнд хамаарах байнгын хороо мөн орно;
 - Олон улсын байгууллагад олон улсын болон бүс нутгийн шүүхийг ойлгох бөгөөд Европын хүний эрхийн шүүх, Америкийн хүний эрхийн шүүх зэрэг орж болох бөгөөд эдгээрийн гаргах шийдвэрийг тухайн шүүхийн харъяалалд хамаарах улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй.

Мэдээлэл 2.2 Сонгуулийн эрхийг хамгаалах үүрэг бүхий байгууллагуудын төрөл

- Захиргааны байгууллага
- Шүүхийн байгууллага
- Хууль тогтоох байгууллага
- Олон улсын байгууллага
- Байнгын бус байгууллага

40. Сонгуулийн эрхийг үндсэндээ иргэн бүр эдэлдэг. Зарим улсад уг эрхийг хэрэгжүүлэхийн тулд заавал тухайн улсын иргэн байх эсхүл, улс төр-хууль зүйн нэгдмэл нөхцөлийг хангах үүднээс тухайн сонгуулийн эрхийг эдлэх эрхтэй гэдгээ нотлох шаардлага тавигддаг. Зарим улсууд байнга оршин сууж буй гадаадын иргэдэд сонгуулийн эрхийг олгодог. Жишээ нь Шинэ Зеланд бүх төрлийн сонгуульд оролцох эрхийг гадаадын иргэдэд олгосон байдаг. Бусад улсууд жишээ нь Аргентин, Канад, Уругвайд орон нутгийн сонгуульд гадаадын иргэд оролцох эрхээр хангадаг бол Европын Холбооны гишүүн орнууд Гадаадын иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох 1992 оны Европын конвенцын хүрээнд энэхүү эрхийг мөн олгосон.

41. Хэд хэдэн улс орнуудад Үндсэн хууль болон бусад хуулиндаа сонгуулийн үйл ажиллагаанд жэндэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүд тэгш эрхтэйгээр сонгуульд оролцох, сонгуульд нэрээ дэвшүүлэх боломжийг хангасан тусгайлсан заалтыг оруулсан байдаг. Олон улсын хэд хэдэн баримт бичгүүдээр эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийг хамгаалсан тухайлбал, Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн 1952 оны конвенц, Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлалыг устгах 1979 оны конвенц зэргийг дурдаж болно(Зураг 2.2-ыг үзнэ үү).


42. Аливаа сонгуулийн үйл ажиллагаа, энэ талаарх шийдвэр нь өөрийн эрхийг зөрчиж байна гэж үзэж байгаа ямар этгээд (иргэн, улс төрийн нам, шүүхийн өмнө шатанд эрх нь зөрчигдсөн этгээд гэх мэт) гомдол гаргах эрхтэй байдаг (Бүлэг 7-г харна уу). Зарим улс орны сонгуулийн маргааныг шийдэх тогтолцоонд улс төрийн намууд сонгуулийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд давуу эрхтэйгээр оролцох, харин зарим тогтолцоонд зөвхөн хуулийн этгээд л тодорхой нэг шийдвэрийг эсэргүүцэн (жишээ нь сонгуулийн дүн) гомдол гаргах эрхтэйгээр зохицуулсан байдаг нь бие даан нэр дэвшигчдэд энэхүү эрхийг эдлүүлээгүй байдаг. Зарим улс орнуудад нэр дэвшигчдийг гуравдагч талыг төлөөлсөн хэмээн үзэж тэд зөвхөн өөрийн харьяалагдах улс төрийн намын шийдвэрийг үндэслэн сонгуулийн эрхээ хамгаалахаар гомдол гаргах эрхтэй байдаг.

43. Аливаа хувь хүн, хуулийн этгээд захиргааны эсхүл, шүүхийн журмаар сонгуулийн хуулийн заалт, сонгуулийн үйл ажиллагааны талаарх шийдвэрт гомдол гаргаж, маргаанаа хянан шийдвэрлүүлэх боломжтой байх явдал нь хамгийн шилдэг зүй ёсны сонгуулийн болон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны практик юм. Ингэснээр сонгуулийн маргааныг хараат бусаар хянан шийдвэрлэх шүүхийн өмнөх үр дүнтэй хамгаалалтыг бий болгож, зөрчигдсөн сонгуулийн эрхийг цаг тухайд нь хамгаалах, сэргээн тогтоох боломжийг олгодог (Жишээ нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын 1966 оны конвенц, Америкийн хүний эрхийн 1969 оны конвенц болон Европын хүний эрхийн 1950 оны конвенцээс харж болно). Ямар ч тохиолдолд сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоо нь нэр дэвшигч хувь хүн болон улс төрийн намд хоёуланд нь тэдний сонгуулийн эрхийг зөрчсөн аливаа хуулийн заалт болон шийдвэрүүдэд гомдол гаргах, гомдлоо шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлсэн механизм байх шаардлагатай.

3. Зүй ёсны сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн үе шат

44. Нэгдмэл, үр дүнтэй арга замуудыг бий болгож, хэрэгжүүлсэн зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь зөвхөн сонгуулийн өмнөх, сонгуулийн үеэр, сонгуулийн дараах гэсэн цаг хугацааны гурван үе шатыг хамран хэрэгждэг.

Зураг 2.4 Сонгуулийн үе шат



45. Зүй ёсны сонгуулийн тогтолцоог зөвхөн сонгуулийн үе шатны хамгийн идэвхтэй хэсэг буюу санал хураах өдөрт л анхаарлаа төвлөрүүдэг механизм гэж үзвэл тухайн сонгуулийн ажиллагаа болон үр дүн хууль зүйн дагуу байсан эсэхийг баталгаажуулахтай холбоогүй тул шилдэг арга гэж тооцогдохгүй. Сонгуулийн өмнөх болон дараах үеүүдэд шударга, чөлөөтэй, үнэн зүй ёсны сонгуульд саад болох зөрчлүүд гарч болох боломжтой бөгөөд намуудын сонирхлын улмаас сонгууль будлиантуулах, булхай гаргах зэргээр хууль бус, хууль зөрчсөн үйлдлүүд гарч болно (жишээ нь сонгогчдын бүртгэл, намын санхүүжилт зэрэг асуудлуудтай холбоотой байж болно).

46. Сонгуулийн өмнөх буюу сонгуулийн бэлтгэлийг хангах үед сонгуулийн хуулийн төслийг бэлтгэх, боловсруулах, сонгуулийн ажилтнуудыг сонгох болон сургах, сонгуулийн байгууллагаас

толовлогөөгөө гаргах, гарч буй маргааныг шийдэх зэрэг олон тооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Эдгээр асуудлын зарим нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд хамаарч байдаг, тухайлбал, сонгуулийн хэсэг, тойргийн хил хязгаарыг тогтоох, улс төрийн намуудын бүртгэлийг баталгаажуулах, бүртгэхээс татгалзах эсэх, сонгогчдын бүртгэлийг шинэчлэх, сонгуулийн ажиллагааны тухай мэдээллийг түгээх, иргэний боловсролыг дээшлүүлэх зэрэг асуудал хамаардаг. Мөн улс төрийн намуудын дотоод ардчилалтай нь холбоотой үйл ажиллагааны хүрээнд хамаарах намын дотоод дүрэм, журмыг батлах, намын удирдлага болон нэр дэвшигчдийг сонгох, намын гишүүнээс хасах, хариуцлага тооцох зэрэг үйл ажиллагааг зохицуулах шаардлага гардаг.

47. Сонгуульд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдийг бүртгэх, нэр дэвшигчийн жагсаалт гаргах, сонгуулийн кампанит ажил явуулах, санал хураах байруудыг бэлтгэх, сонгуулийн ажилтнуудыг томилох, ажиглагч нарт гэрчилгээ олгох, санал хураалт явуулах процесс, санал тоолох, сонгуулийн дүнг зарлах болон хэвлэн нийтлэх зэрэг сонгууль явагдах үе шатанд ямар нэгэн зөрчил, маргаан гарч болдог.

48. Сонгуулийн дараах үе шатанд сонгуультай холбоотой гардаг асуудлууд нь дараагийн сонгуулийг сайжруулах, түүний тогтвортой байдлыг хангахад нөлөөлж болно. Жишээ нь, улс төрийн намууд санхүүжилтээ яаж шийдвэрлэсэн, хэрхэн ашигласан, нэр дэвшигчдийн кампанит ажлын зардлын тайланг хянан шалгах, сонгуулийн тойргуудын хамрах хүрээ, хил хязгаарыг хянах зэрэг үйл ажиллагаа байж болно. Зарим улсад тухайн сонгуультай холбоотой шууд ардчиллын төрөлд хамаарах бүх нийтийн санал асуулга болон дахин сонгууль явуулахтай холбоотой үйл ажиллагаа сонгуулийн дараагийн шатанд хийгдэх тохиолдол бий. Өмнөх сонгуулиас авсан сургамж дээрээ үндэслэн сонгуулийн болон түүнтэй холбоотой бусад хуулиудаа шинэчлэх нь сонгуулийн дараа гүйцэтгэх бас нэгэн чухал үйл ажиллагаа байдаг.

49. Сонгуулийн явагдах үед аливаа сонгуулийн үйл явцтай холбоотой шийдвэрийг түргэн шуурхай гаргах, түүнийг хэрэгжүүлэх, чадварлагаар аливаа сонгуулийн зөрчилд хариу өгдөг хангалттай эрх мэдэл, нооц эх үүсвэр, арга хэрэгслийг бүрдүүлсэн үр ашигтай бөгөөд үр дүнтэй зүй ёсны сонгуулийн тогтолцоо байхгүй тохиолдолд сонгуулийн ажиллагаа будлиантаж, сонгуулийн үр дүн хүлээн зөвшөөрөгдөхгүй байх үр дагаварт хүрдэг байна.

50. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрүүл болон шилдэг туршлага нь аливаа сонгуулийн үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэрийг хянах эрх бүхий этгээдийн ажиллах боломжийг хуульд тусгайлан заах явдлаар илэрдэг. Үүнийг зарим олон улсын баримт бичгүүдэд хүний эрхийн үндсэн хэсэг болгон оруулсан байдаг. Энэ нь сонгуулийн өмнөх, сонгуулийн үеэр, сонгуулийн дараахь зэрэг аль ч үе шатанд гарсан аливаа сонгуулийн үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэр нь хяналтанд байх баталгааг хангах зорилготой байдаг. Энэхүү гарын авлагын Бүлэг 7-д энэ асуудлыг илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

51. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн аль ч үе шатанд гардаг сонгуулийн үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэр нь хуульд нийцэж буйг баталгаажуулдаг механизм юм. Ялангуяа сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг сонгуулиас бусад үед үйл ажиллагаа явуулахгүй байх тухай чухал заалтыг хуульд тусгасан тохиолдол байдаг. Энэ тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас өөр байгууллага сонгуулийн өмнөх болон дараах үед гарсан маргааныг шийдвэрлэх шаардлагатай болно. Иймээс сонгуулийн маргаан шийдвэрлэх байнгын ажиллагаатай болон хараат бус байгууллагыг бий болгох нь сайн практиктай сонгуулийн тогтолцоонд тооцогдож болох юм. (Бүлэг 6-г үзнэ үү).

52. Сонгуулийн үйл явц болон гарсан дүнгийн үнэн зөв, тодорхой байдалд олон нийт ихээхэн анхаарлаа хандуулдаг. Үүнтэй уялдан, сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо бүрт сонгуулийн байгууллагаас гаргасан дүрэм, журам, шийдвэрт хуульд заасан хугацаанд гомдол гаргаагүй тохиолдолд түүнд гомдол гаргах эрхгүй бөгөөд уг шийдвэр, журмыг хууль ёсны эсэхийг хянахгүй гэсэн зарчмыг удирдлага болгодог. Үүний үр дүнд сонгуулийн үе шатыг тодорхой болгон эцэслэж, үр дүнд нь нэгдсэн дүгнэлт хийж, дараагийн сонгуулийн шатанд шилжих боломжийг хангадаг. Ингэснээр сонгуулиас хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа ямар нэг шийдвэр, үйл ажиллагааны хүчинтэй эсэх талаар ямар нэгэн маргаан үүсдэггүй. Жишээ нь хэд хэдэн улсад сонгуулийн үеэр гарсан аливаа маргаантай асуудлыг сонгуулийн дүн гарахаас өмнө л гаргаж ирж, шийдвэрлүүлэх ёстой бөгөөд хэрэв тухайн хугацаанд гомдол гаргаагүй бол энэ нь сонгуулийн дүнг хүчингүй болгох үндэслэл болдоггүй ажээ. Энэ зарчим нь тухайн гарч буй зөрчил нь тэр үедээ л хүчинтэй байх бөгөөд энэ талаарх гомдлыг нэн даруй гаргахыг шаарддаг. Сонгуулийн өмнөх үе шатанд гомдол гаргаагүй бол тухайн асуудлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим тохиолдолд дараагийн үе шатанд уг гомдлыг шийдвэрлүүлэх бодит

үндэслэл нөхцөлд л зөвхөн тухайн гомдлыг дараагийн үе шатанд хэлэлцэн шийдвэрлэж болдог.

53. Сонгуулийн үр дүнд байгуулагддаг аливаа төрийн байгууллагууд нь хуульд заасан сонгуулийн хугацаанаас шалтгаалж бүрэн эрх нь эхэлж, дуусгавар болдог учраас сонгуулийн ажиллагааг тасалдуулж болдоггүй, түүнийг нэгэнт эхлүүлсэн бол заавал дуусгах шаардлага байдаг. Үүний үр дүнд сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоонд хэрэглэгддэг нийтлэг зарчим гарч ирдэг. Энэ нь гомдлыг шийдвэрлэхдээ тухайн үйлдэл, үйл ажиллагааны хэрэгжилтийг хүчингүй болгон түдгэлзүүлэхгүй байх зарчим байдаг. Ийм учраас тухайн гомдолтой холбоотой асуудал албан ёсоор шийдэгдэх хүртэл маргаж буй үйл ажиллагаа үргэлжилж болдог. Цаашлаад, аливаа хүчирхийллээс зайлсхийхийн тулд сонгуультай холбоотой гомдлыг богино хугацаанд яаралтай шийдвэрлэх нь эрүүл практикийг бий болгоход чухал үүрэгтэй байдаг.(Бүлэг 7-г үзнэ үү).

БҮЛЭГ 3

БҮЛЭГ 3

Сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх

1. Танилцуулга

54. Сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх, түүнээс зайлсхийх талаарх ойлголт, хэмжүүр нь зүй ёсны сонгуулийн тогтолцоо бүрийг тогтооход чухал үүрэгтэй. “Rule of law” хүндэтгэх зарчмыг хуулийн хэм хэмжээ болгож чадсан тохиолдолд сонгуулийн маргаан багасч үүнийг дагаад сонгуулийн маргаан шийдвэрлэх хэрэгцээ мөн багасдаг.

55. Сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлж болох хэд хэдэн арга байдаг. Тэдний зарим нь зүй ёсны сонгуулийн тогтолцооноос гадуур эх сурвалжаас бий болдог. Зарим нь энэхүү тогтолцооны хүрээнд бий болдог.

Гаднах эх сурвалжаас авч үзвэл:

- Ардчилсан, төлөөлөл бүхий төрийн байгуулалтыг бий болгож, хүний эрхийг хангасан, сонгуулийн процесст зориулсан Үндсэн хуулийн болон бусад хуулийн зохистой тогтолцоог бүрдүүлэн, хэрэгжүүлэх;
- Улс төрийн гол намууд болон иргэний нийгмийн гол төлөөллийн оролцоотойгоор сонгуулийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, шинэчлэх;
- Ардчилсан зарчим, үнэт зүйлсэд тулгуурласан, хуулиар удирдуулах болон хүний эрхийг хүндэтгэсэн улс төрийн соёл болон иргэний боловсролыг дээшлүүлэх;
- Улс төрийн олон намын тогтолцоо болон улс төрийн намуудын дотоод ардчиллыг хөгжүүлэх;

- Төрийн болон улс төрийн түвшинд жэндэрийн болон цөөнхийн оролцоог хангах;
- Сонгуулийн үйл ажиллагаанд тэгш байдлыг хангах, ялангуяа сонгуулийн ажиллагаан дахь санхүүгийн болон хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд энэхүү тэгш байдлыг онцгойлон хангах;
- Иргэний нийгмийн үүрэг ролийг нэмэгдүүлэх, сонгуулийн бүх шатанд мониторинг хийх боломжийг хангах;
- Хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, сонгуулийн ажиглагч, улс төрийн намуудын үйл ажиллагааны талаарх дүрэм, журмыг батлан мөрдүүлэх;
- Мэргэжлийн, байнгын ажиллагаатай, бие даасан, хараат бус сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагыг бүрдүүлэх;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагаар уламжлан сонгуулийн үйл явц, процедурыг батлан гаргаж, олон нийт ашиглах боломжийг бүрдүүлж, даган мөрдөх;

Дотоод эх сурвалжаас:

- Үндсэн хууль болон бусад хууль тогтоомждоо нээлттэй, үр дүнтэй зүй ёсны сонгуулийн тогтолцоонд зориулсан тохиромжтой заалт оруулж, хэрэгжүүлэх;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг нийгмийн идэвхтэй улс төрийн хүчнүүд, тэр дундаа хууль тогтоох байгууллагад төлөөлөл бүхий улс төрийн намуудын өндөр түвшний зөвшилцөлтэйгээр томилох;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагуудын хараат бус, бие даасан байдал болон бусад ардчилсан зарчим, үнэт зүйлсэд үнэнч байх явдлыг хангах;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр нь ил тод байх, уг шийдвэрийг тайлбартайгаар нь нийтэд мэдээлэх боломжийг бүрдүүлэх;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын ажилтнуудад холбогдох сонгуулийн сургалтыг зохион байгуулах;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын ажилтнуудын баримтлах дүрэм, журмыг батлан гаргаж, мөрдүүлэх;
- Сонгууль зохион байгуулах эрх бүхий болон сонгуулийн

маргаан шийдвэрлэх байгууллагад жэндерийн болон цөөнхийн төлөөллийг хангах;

- Саналын хуудсыг хүлээн авах, тоолох болон бүртгэх, аюулгүй байдлыг хангах.

56. Мөн тодорхой зорилготой, мэдрэмжтэй, үр дүнтэй ажиллаж чаддаг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага нь гарч болох зөрчил, маргаанаас урьдчилан сэргийлэхэд ихээхэн чухал үүрэгтэй байдаг. Улс төрийн намуудын төлөөлөл бүхий сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр гарахаас өмнөх шатанд өргөн хүрээний маргаан, мэтгэлцээн ихээхэн өрнөдөг бөгөөд энэ тохиолдолд улс төрийн намуудын эсрэг тэсрэг байр суурийг нэгтгэх, тэнцвэржүүлэх шаардлага үүсдэг.

2. Зохистой эрх зүйн тогтолцоо

57. Нийгэмд бий болдог уламжлал болон бодит нөхцөл байдлаас урган гардаг, нийгэм даяараа хүлээн зөвшөөрсөн ардчилсан зарчим болон үнэт зүйлд үндэслэн баталсан аливаа зүй ёсны сонгуулийн тогтолцоо, механизм нь сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэг.

58. Хэрэв сонгуулийн шинэтгэл нь гол улс төрийн нам, хүчнүүд, нийгмийн гол секторуудын оролцоог бүрэн хангасан тохиолдолд сонгуулийн маргаан цөөн гарах бөгөөд олонхийн зөвшөөрснөөс гадна зөвшилцөлд суурилсан хандлагаар гаргасан аливаа шийдэл нь энэхүү сонгуулийн шинэтгэл үнэн сэтгэлээр хэрэгжих боломжийг бүрдүүлдэг. Үүний дагуу улс төрийн намуудын оролцоог ханган зохион байгуулсан сонгуулийн дүнг тухайн улс төрийн намууд илүүтэйгээр хүлээн зөвшөөрч, сонгуулийн шинэчлэгдсэн тогтолцооны процесст гарах аливаа зөрчил, маргааныг маргаан шийдвэрлэх байгууллагуудын суваг, холбоог ашиглан хялбархнаар шийдвэрлэдэг. Хэдийгээр цөөнх нь олонхидоо захирагдах, олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэх нь ардчилсан зарчмын үндэс, суурь нь боловч сонгуулийн зарчмыг хэрэгжүүлэх тохиолдолд цөөнхийн эрхийг хүндэтгэх нь үндсэн зарчим болдог. Учир нь олонхи нь байнга давуу байдалтай байдаггүй, өнөөгийн олонхи нь ирээдүйд цөөнх болох магадлалтай тул аль аль талынх нь санал, шийдвэрийг харгалзан үзэх нь чухал юм.

59. Зүй ёсны сонгуулийн тогтолцоонд тохирох эрх зүйн орчинг бий болгохын тулд зүй ёсны сонгуулийн тогтолцоог энгийн, тодорхой,

тогтсон хугацаанд хэрэгжих, ойлгоход хялбар, зүй ёсны сонгуулийг бүрэн хэмжээгээр үр дүнтэйгээр хэрэгжүүлэх боломжтой байхаар бүрдүүлэх шаардлагатай. Үүний дагуу өөрийн сонгуулийн эрхээ зөрчигдсөн гэж үзэж байгаа хэн боловч хараат бус, бие даасан сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээдэд хандан үр дүнтэйгээр богино цаг хугацаанд өөрийн эрхийг хамгаалуулах, сэргээн тогтоолгох боломжийг хангах нь зүйтэй юм. Ийм боломжийг бүрдүүлж чадвал сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд итгэх итгэлийг бий болгож, зөрчил, маргаан гарахаас урьдчилан сэргийлэхэд туслана.

3. Улс төрийн соёл, иргэний боловсролыг дээшлүүлэх талаар

60. Улс төрийн соёл, иргэний боловсролыг дээшлүүлэх нь сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэхэд чухал хувь нэмэр оруулдаг гадаад хүчин зүйлийн нэг байдаг. Энэ нь ардчилалын зарчмууд болон үнэт зүйлсийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Эдгээр зарчмуудад “хуулиар удирдуулах”, хүний эрхийг хүндэтгэх болон маргааныг энхийн замаар институцын түвшинд шийдвэрлэх зэрэг зарчмууд хамаардаг. Үнэт зүйлс гэдэгт нь оролцоо, олон ургалч үзэл, тэвчээр, хамтын ажиллагаа, тогтвортой байдал, нийгмийн тайван байдал, төрийн институцын бүтцийг бэхжүүлэх зэрэг асуудлууд хамаардаг.

61. Нийгэм дэх соёлын хандлага нь, сонгуулийн маргаан илүү олон тоогоор гардаг дарангуйлал (захиргаадалт)-ын дэглэмийг өөрчилж, засахад туслалцаа үзүүлдэг. Ардчилсан болон дарангуйлал (захиргаадалт)-ын нийгэмд байдаг хэд хэдэн төрлийн элементүүдийг таних боломжтой бөгөөд тухайлбал, дарангуйлал, захиргаадалтын элементийг агуулсан ардчилал эсхүл, ардчиллын элементийг агуулсан дарангуйлал, захиргаадалтын дэглэм байж болно. Хуулийн хэрэгжилтийг хангах нь чухал болохыг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж чадаагүй, хуулийг зөрчсөн үйлдлийг нийгэм даяараа хүлээн зөвшөөрөхгүй байх тогтолцоог бүрдүүлээгүй улс орнуудын хувьд үр ашигтай бөгөөд үр дүнтэй зүй ёсны сонгуулийн тогтолцоог бий болгоход нилээд хүндрэлтэй байдаг. Энэ тохиолдолд зүй ёсны сонгуулийн тогтолцоо тухайн улс орны эрх зүйн орчин, төрийн байгууллагуудын бүтэцтэй ижил байдаг. Харин практикт энэхүү сонгуулийн тогтолцоо нь тухайн улс орны улс төрийн соёл болон түүхэн нөхцөл байдлаас ялгаатай байх тохиолдол байж болдог.

62. Сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэхийн тулд улс төрийн соёл, ардчиллын rule of law, сонгуулийн хүний эрх, бусад ардчилалын үнэт зүйлсийг дээдлэн, чанд сахин мөрдөх явдлыг хөхүүлэх дэмжих

нь чухал ач холбогдолтойд тооцогддог. Ардчилсан зарчим, үнэт зүйлс дээр суурилсан улс төрийн соёлыг бэхжүүлэх нь зөвхөн улс төрийн лидерүүдийн үүрэг төдийгүй иргэн бүрийн хүлээх үүрэг юм. Мэдээж хэрэг үүнд төрийн байгууллагууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд чухал үүргийг хүлээнэ.

Мэдээлэл 3.1 Бутан улсын сонгуулийн ажиллагаатай танилцсан талаар

Деки Пема

Бутан улсын түүхэнд Парламентын анхны сонгууль 2008 онд болсон юм. Ийм учраас албан ёсоор сонгуулийн кампанит ажил эхлэх хугацааг зарлахаас өмнө тусгайлан "урьдчилан сонгуультай танилцах туршилтын хугацаа"-г тогтоосон бөгөөд энэ хугацаанд улс төрийн намууд, нэр дэвшигчид жинхэнэ сонгуультай адил хэлбэрээр сонгуулийн кампанит ажлыг туршилтын хэлбэрээр явуулсан.

Хэдийгээр албан ёсоор бүртгэгдсэн зөвхөн 2 улс төрийн нам байсан ч энэхүү туршилтын хугацааны үед сонгогч нар буруу ойлгохгүй будилахгүй байх, улс төрийн намуудын бодлогыг эхнээс нь зүй ёсны ойлгох боломжийг бүрдүүлж чадсан сонгуулийн үйл явцын нэг чухал хэсэг болсон. Туршилтын энэ хугацаа нь техникийн хувьд албан ёсны сонгуулийн нэг хэсэг хэмээн тооцогдохгүй байсан ба улс төрийн намуудын дүрэм журам ч албан ёсоор батлагдаагүй байсан юм. Энэхүү асуудлыг шийдэхийн тулд Бутаны сонгуулийн хороо нь олон нийтэд зориулан "Зөвшөөрөгдөх болон үл зөвшөөрөгдөх үйл ажиллагаа" хэмээх баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа, ёс зүйн дүрэм дээр үндэслэн гаргажээ. Энэхүү материалыг Бутаны бүх засаг захиргааны нэгжид тарааж (20 муж, 15 дэд муж болон 205 анхан шатны нэгж), улмаар анхан шатны нэгжийн дарга нар болох Гуп нар тухайн материалын агуулгыг тусгайлан тодорхойлж олон нийтийн хурал дээр нийтэд таниулах үүрэг хүлээжээ.

Санал хураалтын өдөр ойртох тусам өрсөлдөөн улам ширүүсэн үндэслэлгүй хар пиар, цуурхал тарж байсан. Тухайлбал, санал авах хэсэгт нууцаар камер байрлуулсан гэх цуурхал олон нийтийн дунд тархжээ. Үүнтэй холбоотойгоор сонгуулийн комисс нь уг цуурхал үндэслэлгүй болохыг энгийн, ярианы үг хэллэгээр, орон нутгийн хэл дээр тайлбар, товхимол гарган олон нийтэд мэдээлсэн. Энэхүү товхимол нь сонгогчдод тэдний эрхийг дахин баталгаажуулсан, иргэд нууцаар санал өгөх эрхийг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Товхимлыг нийт 250 анхан шатны нэгжийн Гуп нарт тараан, тэд олон нийтэд чангаар уншиж өгөх үүргийг хүлээсэн байна. Мөн сургуулийн хүүхдүүд ч гэсэн өөрийн гэрт буй бичиг үсэггүй хүмүүс болон гэр бүлийн гишүүддээ уншиж өгч байжээ. Олон тооны арга техник хэрэглэн, иргэний боловсролыг дээшлүүлэх бүхий л хэлбэрийг ашигласнаар энэхүү туршилтын хугацаанд сонгуулийг танилцуулах үйл явц нь хүн амын боловсролыг нэмэгдүүлээд зогсохгүй, худал, хуурмаг цуурхлыг дарж, сонгуультай холбоотой маргаан, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж чадсан үйл ажиллагаа болсон.

4. Сонгуулийг зохион байгуулах эрх бүхий байгууллага болон Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын бүрэлдэхүүн дэх улс төрийн зөвшилцөл

63. Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага болон Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлоход улс төрийн нам, хүчнүүдийн зөвшилцөл, ялангуяа эдгээр нам, хүчнүүдээс шийдвэр гаргах явцад оролцож, түүнд хяналт тавих боломжтой байх нь сонгуулийн холбогдолтой маргаан, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Ийм зөвшилцөл нь сонгуулийн ажиллагаа хуульд нийцсэн, найдвартай байдлыг бий

болгосны үндсэн дээр, сонгогчдын нүдэн дээр итгэл үнэмшил төрүүлж улмаар сонгуульд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

64. Бүрэн бус болон саналын зөрүүтэй ашиг сонирхлуудын тэнцвэрт байдлыг хангах нь шударга байдлыг баталгаажуулахтай адилгүй байдаг. Хэдийгээр Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага болон Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын өндөр түвшний гишүүдийг сонгон авч улс төрийн хүчнүүдийн дунд ерөнхий зөвшилцөл хийсэн ч энэ нь өөрөө жишиг болдог. Энэ нь илүүтэй шударга байдлыг амжилттайгаар амьдралд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд зөвхөн бодит хэрэгжилтийг хангадаг албан тушаал эрхэлдэг этгээдээс гаргах шийдвэр нь дор дурдсан шаардлагыг хангасан тохиолдолд түүний шийдвэрт итгэх итгэлийг батгалгаажуулдаг:

- Намын идэвхтэн бус (тухайн албан тушаалд томилогдохоос өмнө тодорхой цаг хугацааны туршид намын идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй);
- Шударга, мэргэшсэн этгээд гэж тооцогдсон этгээд; Хуулийг ардчилсан байдлаар хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй.

Ийм шаардлагад нийцэх албан тушаалтан аливаа улс төрийн хүчнүүдийн зөвшилцлийг тэнцвэржүүлэн ажиллахад тохиромжтой байдаг. Үүнийг ханган ажилласнаар сонгуулийн ажиллагаа хууль ёсны байх түүнд итгэх итгэл нэмэгддэг. Ийм шаардлагыг үндэслэн сонгон авч ажиллуулж байгаа этгээдийн аюулгүй байдал, тодорхой цалин урамшууллыг тухайн албан тушаалд хараат бусаар ажиллах боломжийг бүрдүүлэх хэмжээнд зохицуулж, түүнийг эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан шалгахаас урьдчилан сэргийлсэн халдашгүй эрхийн баталгааг хангах нь чухал байдаг. Тэдгээрийн эрхэлж байгаа албан тушаал нь бусад албан тушаалтай үл нийцэх бөгөөд энэхүү албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа тодорхой хугацаанд өөр улс төрийн албан тушаал эрхлэхгүй байх шаардлагыг ч мөн бий болгох нь зүйтэй байдаг. (Бүлэг 6-г үзнэ үү).

5. Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага болон Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагаа: Мэргэшсэн байдал, үйл ажиллагааны хараат бус байдал, ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх үүрэг

65. Сонгууль зохион байгуулах эрх бүхий сонгуулийн байгууллага нь хараат бус эсхүл, төрийн харьяа эсхүл холимог хэлбэртэй байж болно. Аль ч загварын дагуу зохион байгуулагдсан сонгуулийн

байгууллагын үйл ажиллагаа нь хууль болон ёс зүйн зарчимд нийцсэн цаг хугацааны дотор зохистой байдлаар мэргэшсэн түвшинд сонгуулийг зохион байгуулах шаардлагатай гэдгийг ойлгох нь чухал юм.

66. Мэргэшсэн байдлаар ажиллах нь сонгуулийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтын чиг үүргийг удирдан чиглүүлэх зарчим бөгөөд сонгуулийн процесс нь төрийн үйлчилгээг хангах үндэс нь болдог (Боломжтой эсвэл шаардлагатай үед сонгуулийн асуудлаар мэргэшсэн байх нь чухал). Цаашлаад сонгуулийн байгууллагын ажилтнуудыг сонгон шалгаруулах, ажилд авах, албан тушаал дэвшүүлэх болон өөр ажилд шилжүүлэх талаарх тодорхой дүрэм, журам, холбогдох хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Ингэснээр тэдний ажлын баталгаат байдлыг хангаж, энэ нь зөвхөн сонгуулийн үе шат эсхүл, төрийн эрх мэдэлтнүүд болон улс төрийн ашиг сонирхолтой холбоотойгоор хэрэгжихгүй байх шаардлагатай.

67. Түүнчлэн мэргэшсэн байдал гэдэгт сонгуулийн ажилтан, албан хаагчдыг бүрэн хэмжээгээр сургалтанд хамруулах, тэдний чадавхийг үе шаттайгаар хөгжүүлж, дүрэм, журмаа сахин ажиллах ойлголт хамаарна. Цаашлаад, мэргэшсэн байдал нь сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлтгэл хангах болон түүний талаарх мэдлэгийн түвшинг нэмэгдүүлдэг бөгөөд хувь хүний хариуцлагыг бий болгож, хариуцлага алдсан бол хариуцлагаа хүлээх зарчмыг хангахад тусладаг.

68. Сонгуулийн үйл ажиллагааг гүйцэтгэх нь сонгуулийн бүхий л үе шатанд хэрэгждэг бөгөөд үүнийг зөвхөн тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг гэж ойлгож болохгүй. Тиймээс сонгуулийн холбогдолтой үйл ажиллагаа байнга тасралтгүй явагдах нь түүнд мэргэших, мэргэжилдээ өсөх боломжийг сонгуулийн байгууллагын ажилтнуудад олгодог. Сонгуулийн мэргэшсэн байдлыг бий болгох нь сонгуулийн үйлчилгээг хамгийн оновчтой зохион байгуулахын төлөө ажиллах хүмүүсийг бэлтгэж байдаг.

69. Сонгуулийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хуулийн дагуу, тодорхой, агуулгад чиглэсэн, хараат бус байдал, бие даасан байдлаар явуулах зарчмыг баримталснаар сонгуулийн найдвартай, итгэл хүлээхүйц байгууллагыг бий болгож, сонгуулийн холбогдолтой маргаан гарахаас урьдчилан сэргийлэхэд чухал хувь нэмэр болдог. Сонгуулийн ажиллагааг хараат бусаар зохион байгуулах гэдэг нь сонгуулийн байгууллагын гишүүдийн үйлдэл, үйл ажиллагаа нь

хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд байх, Засгийн газар болон улс төрийн намуудаас хараат бусаар ажиллах нөхцөл бололцоогоор хангагдсан байхыг ойлгоно.

70. Сонгуулийн байгууллага болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь үүргээ хараат бусаар, бие даасан хэлбэрээр, улс төрийн хувьд нам бус байдлаар гүйцэтгэх шаардлагатай. Иймээс эдгээр байгууллага нь өөрийн үйл ажиллагаандаа бусдын итгэл, найдварыг төрүүлэх, нэмэгдүүлэхэд туслах шилдэг туршлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага үүсч байдаг. Сонгуулийн процессыг амжилтанд хүргэхийн тулд оролцогчид нь юуны өмнө сонгуулийг зохион байгуулах болон сонгуулийн үйл ажиллагааны үед гарсан маргааныг шийдвэрлэх эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд итгэх шаардлагатай. Ийм учраас сонгууль зохион байгуулдаг болон сонгуулийн маргааныг шийддэг байгууллагууд нь улс төрийн нам болон Засгийн газраас хараат бус байж, улс төрийн хувьд нэг талыг баримтлахгүй байх нь чухал юм. Хэрэв сонгууль зохион явуулж байгаа этгээд болон сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий этгээдээс аль нэг улс төрийн хүчний талд буюу аль нэгийг илт байдлаар дэмжсэн үйлдэл, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд олон нийтийн зүгээс тэдгээр байгууллагад итгэх итгэл найдвар үгүй болох бөгөөд энэхүү олон нийтийн итгэлийг дахин эерэгээр өөрчлөх, сэргээх нь маш их цаг хугацаа, хүч шаардах хүндрэлтэй асуудал болдог.

71. Улс орон бүрт сонгуулийн байгууллага болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг томилох үед улс төрийн намууд эсхүл, улс төрийн хүчнүүдийн төлөөллөөс сонголт хийх шаардлага гардаг. Хэдийгээр улс төрийн намын төлөөлөл сонгуулийн байгууллагуудад ордог боловч тэдгээр гишүүд нь сонгуультай холбоотой үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргахдаа намын эрх ашгийн үүднээс бус харин төвийг сахисан, хараат бус байдлаар ажиллах ёстой байдаг.

Мэдээлэл 3.2 Буркина Фасо: сонгуулийн процессыг улс төрийн нам хянах талаар

Аугустин Лоада

Буркина Фасо улсын сонгуулийн байгууллага болох Үндэсний хараат бус сонгуулийн комисс нь 15 гишүүнтэй бөгөөд тэдгээр нь Парламент дахь олонхи болсон улс төрийн нам, сөрөг хүчин, иргэний нийгмийн төлөөллөөс бүрддэг. Энэ комисс нь сонгуулийн процесст мониторинг хийх, хянах үүргийг хүлээдэг.

Тус улсын Үндсэн хуулиар чөлөөт, шударга, нууц санал хураалтаар сонгууль явуулахаар зааж, харин бусад сонгуультай холбоотой зохицуулалтыг байнга өөрчлөгдөж байдаг сонгуулийн хуульдаа оруулахаар зохицуулжээ. Улс төрийн нөхцөл байдлаас шалгаалан сонгуулийн хууль нь байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд аль нэг нам нь засгийн эрхийг барих бүрдээ өөрсдийн эрх ашигт нийцүүлэн хуулиа өөрчилдөг байна.

Сонгуулийн холбогдолтой зөрчил, маргааныг хоёр өөр байгууллага шийдвэрлэдэг бөгөөд эдгээр нь Үндсэн хуулийн зөвлөл болон орон нутгийн сонгуультай холбоотой асуудлыг авч хэлэлцдэг захиргааны хэргийн шүүх юм. Үндсэн хуулийн зөвлөл нь тодорхой хугацаагаар томилогдох шүүгч нараас бүрдэх бөгөөд тэргүүн гурван шүүгчийг Буркина Фасо улсын Ерөнхийлөгч нь Хууль зүйн сайдын санал болгосноор, гурван хүнийг Ерөнхийлөгч шууд, үлдэх гурван хүнийг Парламентын дарга томилдог байна. Тухайн гишүүд нь 9 жилийн хугацаагаар томилогдоно.

Эрх баригч намд харьяалагддаг Ерөнхийлөгч (6 гишүүн), Парламентын дарга (3 гишүүн) нар 9 гишүүнийг томилдог нь Үндсэн хуулийн зөвлөлийн хараат бус байдалд тулгарах нэг асуудал болдог байна. Гэхдээ Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүдийг зөвхөн цөөн хэдэн тохиолдолд л эргүүлэн татаж болдог байна. Мөн даргыг нь Ерөнхийлөгч эргүүлэн татах эрхтэй бөгөөд гишүүд нь өөр ажил албан тушаал эрхлэхийг хориглодог ажээ.

Захиргааны хэргийн шүүх нь орон нутгийн сонгуулийн үед гарсан зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Шүүгч нар нь хуулиар өндөр түвшний баталгаагаар хангагдсан байдаг бөгөөд хараат бус байдал, эргүүлэн үл татах зэргийг хангасан байдаг. Бодит байдал дээрээ улс төрийн хүчнүүдийн хөндлөнгийн нөлөө, хээл хахууль, санхүүжилттэй холбоотой асуудлууд, мэргэжлийн ур чадвар, ил тод байдал зэрэгтэй холбоотой асуудал нь шүүхийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлдөг бөгөөд энэ нь Буркина Фасо улсын хууль зүйн салбарт түгээмэл асуудал болоод байна.

Тус улсад сонгуультай холбоотой зөрчил, маргаан маш цөөн гардаг болохыг цохон дурдах хэрэгтэй. Энэ нь боломжит механизмуудыг бүрэн ойлгоогүй, сонгуулийн маргаан шийдэх байгууллагад бусдын зүгээс итгэх итгэл сул байдагтай холбоотой. Улс төрийн олон нам, нэр дэвшигчид нь зөрчил, маргаан шийдвэрлэх байгууллагад хандахаас илүү сонгуулийн луйвар, зөрчил, авлигын асуудлыг хэвлэл мэдээллээр түлхүү гарган нийтэд хүргэх сонирхолтой байдаг.

Түүнчлэн уг захиргааны хэргийн шүүхэд хандахад ч тодорхой хүндрэлүүд тулгардаг нь газар зүйн болон нийгэм-соёлын асуудлуудаас үүддэг. Газар зүйн хувьд алс нутаг дэвсгэрт байх нь сонгуулийн эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг иргэд давж заалдах боломжийг (хэдийгээр үнэ төлбөргүй ч гэсэн) хааж байдаг ажээ.

72. Сонгуулийн байгууллага болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь ардчиллын зарчмууд, үнэт зүйлс, олон улсын баримт бичгүүдэд тодорхойлсон хүний эрхийн заалтуудыг ямар нэгэн улс төрийн нам, нэр дэвшигч, сонгогч, хэвлэл мэдээлэлд давуу байдал бий болгохгүйгээр хангах үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай.

73. Сонгуулийн байгууллага болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь өөрийн шийдвэрийг олон нийтэд ил тодоор байлгах, уг шийдвэрийн талаар тухайн шийдвэрт хамаарах этгээдүүд болон болон олон нийтэд тайлбарлан таниулж байх нь чухал юм. Ингэснээр уг шийдвэрийн улмаас өөрт нь эсрэг нөлөөлөл бий болсон гэж үзэж байгаа аливаа этгээдүүд уг шийдвэрийг гуйвуулан тайлбарлах, сонгуулийн ажиллагааны хууль бусаар нөлөөлөхийг оролдох, улмаар сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сулруулах оролдлогоос урьдчилан сэргийлнэ.

6. Сонгуулийн ёс зүйн дүрэм

74. Сонгуулийн байгууллага болон сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллагуудад дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг тухайн улсын сонгуулийн хууль тогтоомжтой хамт батлан мөрдүүлдэг. Үүнтэй нэгэн адил дүрэм, журмыг улс төрийн намууд ч дотооддоо батлан мөрдүүлдэг бөгөөд сонгуулийн кампанит ажилтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонгуулийн ажиглагч нарт зориулсан ёс зүйн дүрэм, журам болон мэргэжлийн шалгуур байдаг.

75. Олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоод, олон улсын бусад байгууллагууд мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулан мөрдүүлэх замаар шүүхийн болон сонгуулийн үйл ажиллагаанд хараат бус, бусдын итгэл хүлээхүйц байдлыг бий болгох арга замыг байнга эрэлхийлж байдаг. Түүнчлэн сонгуулийн кампанит ажлын үеэр улс төрийн намуудад чиглэсэн, дотоодын болон олон улсын ажиглагчдын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмуудыг даган мөрдүүлдэг. Үүнтэй холбоотойгоор Сонгуулийн ёс зүй, мэргэжлийн байгууллагын дүрэм, Улс төрийн намуудын ардчилсан сонгуулийн кампанит ажлын ёс зүйн дүрэм зэрэг Олон Улсын Ардчилал, Сонгуульд Туслах Хүрээлэнгийн гаргасан баримт бичгүүдийг дурдаж болно.

76. Хэрэв аливаа нэг улс орны сонгуулийн болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагууд нь албан ёсны бичгээр гарсан ёс зүйн дүрэм байхгүй тохиолдолд тухайн байгууллагын гишүүд нь мэргэжлийн ёс зүйг баримталдаггүй гэсэн агуулгыг илэрхийлнэ. Ихэнхдээ Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудаар ийм төрлийн зарчим, үнэт зүйлсийг зааж өгсөн байдаг. Гэсэн хэдий ч сонгуулийн ажиллагааг хариуцаж байгаа этгээдээс энэхүү хуулийн заалтуудыг шууд хэлбэрээр ойлгон, танин мэдэх нь өөрийн үүргийг зохистойгоор хэрэгжүүлэхэд тусална гэдгийг онцолж байна.

77. Сонгуулийн ажиллагааны зарчим, үнэт зүйлсийн агуулга нь ихэнхдээ тодорхой төрийн албаны болон мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд тусгалаа олсон байдаг жишээ нь шүүгчид болон сонгуулийн ажилтнуудын ёс зүйн дүрэм үүнд хамаарч болно (мэдээлэл 3.3-ыг үзнэ үү). Мөн улс төрийн нам, хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн дүрмийг гарган мөрдүүлдэг. Хуулийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд болон төрийн албан хаагчид дор дурдсан шаардлагыг ханган ажиллах шаардлагатай:

- Хүний эрх, нэр хүндийг хүндэтгэх хүсэл эрмэлзлэлтэй байх;
- Мэргэжлийн өндөр ур чадвартай;
- Шударга;
- Үнэнч;
- Нэг талыг үл баримталсан;
- Хараат бус;
- Байгууллагадаа үнэнч;
- Бусдыг хүндлэх;
- Хариуцлагатай ажиллах.

78. Шүүх эрх мэдлийн салбарын ёс зүйн дүрэмд, зарчим үнэт зүйлсийг доорх байдлаар тусгасан байдаг:

- Зүй ёсыг баримтлах;
- Мэргэжлийн хувьд өндөр ур чадвартай, сайн сургалтад хамрагдсан байх;
- Үр дүнтэй ажиллах;
- Шударга;
- Хараат бус;
- Үнэнч;
- Даруу төлөв, хүлээцтэй;
- Нууцыг хадгалах;
- Хичээл зүтгэлтэй;
- Бусдыг болон хамтран ажиллагсдаа хүндэтгэдэг;
- Доод шатны шүүхэд хэлэлцэж буй асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх;
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй тэгш харилцах.

Мэдээлэл 3.3 Мексикийн холбооны улсын шүүх эрх мэдлийн салбарын ёс зүйн дүрэм

Шүүгчид болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдэд дагаж мөрдөх ёс зүйн дүрмийн нэг жишээ нь Мексикийн холбооны улсын Шүүх эрх мэдлийн салбарын ёс зүйн дүрэм юм. Энэхүү дүрэм нь холбооны шүүгчид болон бусад шатны шүүгчдийн мэргэжлийн-ёс зүйн стандартыг хангахад шаардагдах зарчим, дүрэм журам болон хэм хэмжээг агуулсны зэрэгцээ тэдний гүйцэтгэх үүрэг нэг бүрийн ёс зүйн үйлдлийг заасан. Энэхүү журамд Үндсэн хуульд тусгагдсан дараахь үндсэн 5 зарчмыг заасан байдаг. Үүнд:

- a. Хараат бус байдал- нийгмийн аливаа тогтолцооны зүгээс хуулиас гадуур нөлөөлөхийг хориглох, үүнээс татгалзах;
- b. Шударга- шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх зорилгоор хуулиас гадуурх бүх нөлөөллөөс татгалзах;
- c. Объектив- тухайн шүүгчээс өөрөөс нь үүсэн гарч болох хуулиар заагаагүй гадны бусад нөлөөллөөс ангид байх;
- d. Мэргэжлийн ур чадвар- шүүх эрх мэдлийн үүргийг хариуцлагатай, чухалчлан үзэж гүйцэтгэх;
- e. Үр дүн- ёс зүйн дүрэмд дурдсан ёс суртахууны хэм хэмжээг тэргүүн ээлжинд даган мөрдөх.

Мэдээлэл 3.4 Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсын Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх хорооны ажилтнуудын ёс зүйн дүрэм

Энэхүү ёс зүйн дүрмийг Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх хорооны журам, үйл ажиллагааны 2 дугаар заалтын дагуу боловсруулсан болно. Энэхүү журамд дурдагдсан эрх зүйн болон ёс зүйн стандартууд нь Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх хорооны гишүүд болон Ажлын албаны үйл ажиллагааг сонгуулийн үеэр чиглүүлэн, зохицуулах юм. Энэхүү ёс зүйн дүрмийг түгээмэл хэлбэрээр, зүй ёсны удирдлага, сайн дурын үндсэн дээр даган мөрдөх болно. Энэ дүрмийг зөрчсөн тохиолдлыг сонгуулийн үеийн зөрчил хэмээн үзэж сонгуулийн хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ. Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх хорооны гишүүд болон ажилтнууд нь:

- Үндсэн хууль, Сонгуулийн хууль, бусад дүрэм журам, тушаал заавар, процедурыг даган мөрдөж, өөрийн үүргээ хараат бусаар, шударгаар, аль нэг намын талыг барилгүйгээр, улс төрийн хувьд төвийг сахисан байдлаар хэрэгжүүлнэ;
- Үр дүн, чадамж, шударга ёсны стандартад нийцүүлэн ажиллана;
- Бүх боломжоороо хүн бүрийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, эвсэл хөдөлгөөнд нэгдэх суурь эрхийг сонгуулийн бүх үйл явцад хамгаалж, баталгаажуулан ажиллана;
- Сонгуулийн үйл явцад оролцож буй сонгогчид, нэр дэвшигчид, төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, хуулийн этгээд, хувь хүмүүст хүндэтгэлтэй, хараат бус, улс төрийн хувьд төвийг сахисан байдлаар хандана;
- Хорооны зөвшөөрөлгүйгээр хүлээсэн үүрэгт ажилтай нь холбоотой мэдээллийг авахаар ямар нэгэн этгээд, бусад мэдээллийн эх үүсвэртэй олон нийтэд мэдээлэгдээгүй мэдээллийн асуудлаар харилцахгүй.
- Үүргээ биелүүлэх хугацаанаас бусад үед сонгуультай холбоотой баримт бичиг, мэдээллийг удаан хадгалахгүй, Сонгуулийн гомдлын хорооны үйл ажиллагаа дууссан тохиолдолд үйл ажиллагаагаа зогсооно.
- Хувцаслалт, эдэлж хэрэглэж буй зүйл, үйл ажиллагаа, хандлага, үг яриа зэргээрээ ямар нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг илэрхийлж, дэмжихгүй;
- Гүйцэтгэж буй үүрэгт ажлаа шударга, ил тод явуулж, ажиглагч, төлөөлөгч, сонгогчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудтай хамтран ажиллахдаа зөвшөөрөгдөх хэмжээнд хамтран ажиллана;
- Эрхэлж буй албан тушаалаа хувийн эрх ашгийн төлөө ашиглахгүй, ямар нэгэн төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, эрх баригчдаас хуульд зааснаас бусад заавар зөвлөмж авч, хүсэж болохгүй;
- Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх хорооны гүйцэтгэх үүрэгтэй нь холбоотой сонирхлын ямар нэгэн зөрчлийг зарлан мэдээлж, тухайн зөрчил, маргааныг шийдэх бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

- Санал хураалтын нууцлалыг хүндэтгэнэ;
- Хувь хүнтэй холбоотой болон бусад нууц мэдээллийн нууцыг чандлан хадгална;
- Сонгуулийн хууль, журам, дүрэм, Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх хорооны үйл ажиллагаатай холбогдох этгээдийн хүсэлтээр байнга танилцуулан, мэдээлэл өгч Гишүүд нь бүх боломжоороо Сонгуулийн гомдлын хорооны хуралдаанд оролцоно.

Би энэхүү дүрмыг бүрэн уншиж танилцан, ойлгосон бөгөөд дээрх Ёс зүйн дүрмийг чанд даган мөрдөх болно:

Гарын үсэг _____ Огноо _____ 2009

Сонгуулийн гомдлын хорооны гишүүн /Ажилтны нэр
Сонгуулийн гомдлын хорооны гишүүн /Ажилтны гарын үсэг

79. Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн бэлтгэн гаргасан Сонгуулийн ёс зүй, мэргэжлийн удирдлагын дүрмийг тусгайлан дурдах шаардлагатай. Энэхүү баримт бичиг нь сонгуулийн үйл ажиллагааг явуулах боломжит ёс зүйн болон мэргэжлийн дүрмийг агуулсан баримт бичиг юм. Энэ нь сонгуулийн ажилтнуудын үйл ажиллагааг чиглүүлэх зарчмуудыг системчлэх оролдлогын нэг хэсэг юм. Энэхүү ёс зүйн дүрмийг http://www.idea.int/publications/conduct_admin/index.cfm хаягаар үзэж болно. Дүрмийн үндсэн хэсэг нь сонгуулийн менежментийн үндэс суурийг бүрдүүлж, ёс зүйн зарчмуудыг тогтоосны зэрэгцээ эдгээр зарчмуудыг хэрхэн ашиглах тухай дэлгэрэнгүй мэдээлэл, зааварчилгааг багтаасан байдаг. Сонгуулийн үйл ажиллагааг шударга явуулахын тулд сонгуулийн байгууллага нь ёс зүйн суурь зарчмуудыг даган мөрдөх ёстой бөгөөд эдгээр нь (а) хуулийг хүндэтгэх; (б) хараат бус байдал; (в) ил тод байдал; (г) асуудалд хариуцлагатай хандах; болон (д) үйлчилгээнд суурилсан байдал зэргийг хамруулсан.

80. Ардчилсан сонгуульд оролцож буй улс төрийн намуудын кампанит ажлын үеэр баримтлах ёс зүйн дүрмийг мөн Олон Улсын Хүрээлэнгээс бэлтгэн гаргасан бөгөөд энэ баримт бичиг нь улс төрийн намууд болон тэдний дэмжигчид сонгуулийн кампанит ажилдаа баримтлах минимум зарчим, стандартыг боловсруулан гаргасан байдаг. Үндсэндээ эдгээр журмыг сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрч, даган мөрдөж болох бөгөөд цаашдаа хуульчлан хэрэгжүүлж ч болох юм. Улс төрийн намууд хоорондоо тохиролцох замаар зөвшөөрсөн бусад ёс зүйн дүрмийг гаргаж болох бөгөөд энэ нь гуравдагч талын оролцоотойгоор хийгдэж (жишээ нь Намиби улс 1989 оны 9 сард тусгаар тогтнолоо зарласны дараа улс төрийн намууд зөвшилцөлд хүрсэн); намууд цаашид хууль болгон өөрчилнө гэсэн үндэслэлээр үүнийг зөвшилцдөг (1996 онд Сиерра Леонегийн сонгуулийн өмнө гарсан дүрэм нь энэ нөхцөлөөр хийгдсэн боловч

хууль болон батлагдан гарч чадаагүй); эсвэл бие даасан эрх бүхий байгууллага шууд боловсруулан гаргаж тухайн сонгуулийн үйл ажиллагааны үеэр мөрдүүлэн хэрэгжүүлдэг (НҮБ-ын 1992 онд гаргасан сонгуулийн хуулийг Кампучи улсад хэрэглэсэн) тохиолдол байдаг.

81. Мөн НҮБ-аас 2005 орны 10 сарын 27-ны өдөр батлан гаргасан Сонгуулийн олон улсын ажиглагчдад зориулсан ёс зүйн дүрэм буюу Сонгуулийн ажиглалт хийх олон улсын зарчмуудын тунхагийн нэг хэсэг болон гарсан энэхүү баримт бичгийг бас дурдах шаардлагатай. Тус баримт бичгийг Ардчилал Сонгуульд Туслах Хүрээлэн зэрэг олон тооны бүс нутгийн болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр НҮБ бэлтгэн гаргасан.

82. Сонгуулийн холбогдолтой маргаан, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бусад арга зам, арга хэмжээний хүрээнд олон ургалч үзэл бүхий улс төрийн намын системийг бий болгох, намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, жэндэр болон үндэсний цөөнхийн асуудлаар сонгуулийн үйл ажиллагааны оролцоог түлхүү хангах замаар ялгаварлан гадуурхах явдлыг бууруулах, сонгуулийн өрсөлдөөний тэгш байдлыг хангах тэр дундаа хэвлэл мэдээлэл, санхүүжилтын хүрээнд үүнийг сайтар хангах, сонгуулийн ажилтнууд болон зөрчил, маргаан шийдэх байгууллагын ажилтнуудад хангалтай сургалтуудыг явуулах, санал авах, тоолох зэрэг дээр аюулгүй ажиллагааг сайн хангах зэрэг олон арга хэмжээ багтаж болно.

БҮЛЭГ 4

БҮЛЭГ 4

Сонгуулийн маргаан шийдвэрлэх механизмууд

1. Танилцуулга

83. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоо гэдэг нь захиргааны, шүүхийн, хууль тогтоох болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлдэг сонгуулийн үйл ажиллагаа, процедуртай холбоотой маргааныг хүлээн авч, зөрчлийг илрүүлэх, маргааныг шийдвэрлэх бүрэн хэмжээний цогц институцын болон техникийн-эрх зүйн арга зам, механизмыг ойлгоно.

84. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн ажиллагаа шударга явагдах боломжийг баталгаажуулдаг. Маргааныг хянан шийдвэрлэх явцад сонгуулийн маргааныг хянан шалгах, сонгуулийн үйл ажиллагаа болон шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, зөрчил гаргасан болон санаатай хууль бус, буруу үйлдэл хийсэн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг. Тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиас шалтгаалан нэг төрлийн зөрчлийг хоёр төрлийн механизмаар шийдэж болно.

85. Сонгуулийн зөрчилд захиргааны болон эрүүгийн хариуцлагын алиныг хүлээлгэх вэ гэдгийг ялган салгаж ойлгох нь чухал байдаг. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх институцын эсхүл, албан ёсны процедур, ажиллагааг албан бус буюу шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатайгаар авч үздэг. Эдгээрийг 8 дугаар бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

86. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гол зорилго нь тухайн маргаж буй асуудал нь сонгуулийн алдаа, зөрчил мөн эсэхийг

тогтоож, танин мэдэж, улмаар сонгууль (бүх нийтийн санал асуулга) нь хуулийн хүрээнд явагдаж буйг баталгаажуулах, зөрчигдсөн сонгуулийн эрхийг хамгаалах, сэргээн тогтооход чиглэгддэг. Энэ утгаараа сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн ажиллагааг Үндсэн хууль болон бусад хуульд заасан зарчмуудад нийцсэн эсэхийг шууд хэлбэрээр хянан шалгадаг.

87. Түүнчлэн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоор сонгуулийн ажиллагаа нь сонгуулийн үүрэг, хариуцлагын бүтцийг харуулсан эрх зүйн тогтолцооны хүрээнд байгаа эсэхийг баталгаажуулдаг. Хариуцлагыг тодорхойлох процедур нь захиргааны эсхүл, эрүүгийн журмаар болон тухайн зөрчилд ямар төрлийн шийтгэл ногдуулах эсэх (тухай зөрчлийг гэмт хэргийн шинжтэй эсхүл, гэмт хэргийн шинжгүй бол захиргааны хариуцлага ногдуулах) эсэхийг шийдвэрлэдэг. Энэхүү процедур нь ихэвчлэн байцаан шийтгэх ажиллагааны журмаар явагддаг. Энэ ажиллагааны үед сонгуулийн зөрчлийг засаж, сонгуулийн үр дүнг хүчингүй болгодоггүй. Харин уг ажиллагаанд сонгуулийн зөрчил гаргасан, эсхүл ийм зөрчил гаргаагүй гэдгийг шалган тогтоож, сонгуулийн хуульд заасны дагуу захиргааны эсхүл, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг тогтоодог. Ийм учраас энэ сонгуулийг шууд бусаар хянан шалгадаг ажиллагаа гэж үздэг. (Хүснэгт 4.1-ийг харна уу).

Хүснэгт 4.1 Сонгуулийн маргаан шийдвэрлэх систем

Системийн ялгаа	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагаа	Үр дүн	Хяналтын төрөл
Сонгуулийн зөрчил	Засан залруулах	Зөрчлийг арилгах, хүчингүй болгох, зөрчил гарсныг хүлээн зөвшөөрөх	Сонгуулийн эрхийг хамгаалах, сэргээн тогтоох	Шууд
Сонгуулийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох процесс	Хариуцлага тооцох/ шийтгэл хүлээлгэх	Зөрчил гаргасан, сонгуулийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага ногдуулах		Шууд бус

88. Зарим тохиолдолд сонгуулийн зөрчил гэдэгт юу хамаарах тухай сонгуулийн зөрчлийг тодорхойлсон материаллаг болон сонгуулийн зөрчилд ямар хариуцлага (захиргааны болон эрүүгийн) хүлээлгэхийг тодорхойлдог процессын шинжтэй хуулийн зохицуулалтуудыг нэг ижил хуульд тусгасан байдаг. Үүний нэгэн адилаар сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээдүүд эдгээр 2 асуудлыг ижил байдлаар хянан шийдвэрлэдэг. Тухайлбал, сонгуулийн нэг ажилтан сонгуулийн тооллогын дүнг өөрчилсөн нь илэрчээ. Энэ зөрчил нь магадгүй сонгуулийн үр дүнг хүчингүй болгоход нөлөөлж болзошгүй (энэхүү зөрчил нь сонгуулийн дүнд нөлөөлөх үндэслэлтэй гэхдээ энэ үйлдлээр дамжуулан үнэн зүй ёсны үр дүнг танин мэдэх боломжгүй юм), мөн энэхүү сонгуулийн ажилтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин энэ үйлдэлд улс төрийн намын нөлөөлөл орсон гэдгийг маргаан шийдвэрлэсэн сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага, эсхүл захиргааны шүүх тогтоовол уг улс төрийн намд захиргааны журмаар мөнгөн торгууль ногдуулах шийтгэл хүлээлгэх боломжтой.

89. Тодорхой кейс авч үзвэл, Англид Дээд шүүхийн хоёр шүүгч парламентын сонгуулийн үр дүнтэй холбоотой тангарагтны шүүхийн оролцоогүйгээр давж заалдах эрхгүй сонгуулийн маргааныг шийдвэрлэх гэж байна гэж үзье. Энэ тохиолдолд уг шүүгчид юуны өмнө доорх асуудлыг тодорхойлох ёстой. Үүнд:

- а. Өргөн хүрээний авлига эсвэл хууль бус үйл ажиллагаа бодитоор байсан эсэх;
- б. Тухайн авлига болон хууль бус үйлдлийг нэр дэвшигч нь мэдсээр байж, зөвшөөрч, санаатайгаар үйлдсэн гэдэг нь нотлогдсон эсэх.

Дараа нь шүүгчид уг хэргийн талаарх баталгаажуулсан тайлангаа Парламентын дарга, дэд даргад хүргүүлдэг бөгөөд уг тайланд тухайн сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөх эсвэл түүнийг хүчингүй гэж үзэх саналаа тусгадаг. Хэрэв шүүгч нарын санал зөрсөн, өөр өөр гарсан тохиолдолд яагаад ингэж өөр санал гарсан талаар тайлбар, баталгаагаа гаргах бөгөөд энэ тохиолдолд нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог. Хэрэв ялалт байгуулсан нэр дэвшигч нь хувь хүнийхээ хувьд сонгуулийн авлига, хууль бус үйлдэлд буруутай гэдэг нь тогтоогдвол тухайн сонгуулийг хүчингүй хэмээн зарлаж нэр дэвшигчид хариуцлага хүлээлгэх бөгөөд дараагийн сонгуульд оролцох эрхийг нь хасах шийтгэл ч ногдуулж болдог.

2. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх журам: үр дүнг хүчингүй болгох, өөрчлөх, зөрчил гарсныг хүлээн зөвшөөрөх

90. Сонгуулийн тогтолцооны хэрэгжилтийг баталгаажуулах шууд механизм нь эрх зүйн хамгаалалтыг илэрхийлэх, хууль бус болон хуулиар хориглосон үйлдлийн үр дагаврыг хүчингүй болгох, мөн уг хууль бус үйлдлээс бий болсон хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг асуудлыг хамруулан авч үздэг. Ерөнхийд нь авч үзвэл, сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээдээс тухайн сонгуулийн үйл ажиллагаа, шийдвэр нь сонгуулийн зөрчлийг бий болгосон тохиолдолд түүний үр дүнг хүчингүй болгох, батлахаас татгалзах болон өөрчлөх тухай мэдэгдсэнээр хэрэгждэг. Түүнчлэн зарим нөхцөл байдлаас шалтгаалж сонгуулийн зөрчлийг албан ёсоор зөрчил гэж хүлээн зөвшөөрч, түүнийг тухайн үед нь сэргээн засварладаг. Жишээ нь, санал өгөх явцад сонгуулийн ажилтнуудын буруу үйлдлээс шалтгаалж сонгох эрхийг нь эдлүүлээгүй талаарх иргэний гомдлыг хүлээн авч, шийдвэрлээд түүнийг сонгуульд оролцуулсан тохиолдолд тухайн сонгуулийн байгууллагын ажилтны буруутай үйлдлийг тогтоосон хэдий ч энэ нь зөвхөн нэг санал учир сонгуулийн нийт дүнд нөлөөлөхгүй.

91. Сонгуулийн зөрчлийг шийдвэрлэх явцад сонгууль хуульд нийцэж явагдсан, зүй ёсны сонгуулийн хуульд заасны дагуу зүй ёсны дараалалтай явуулах үйл ажиллагааг хамгаалах, сэргээн тогтооход нөлөөлдөг шууд хяналт хэрэгждэг. Иймээс эдгээр нь зүй ёсны сонгуулийн тогтолцооны хамгийн үр дүнтэй хамгаалалт болон зарчим байдаг, гэвч сонгуулийн маргааныг шийдвэрлэхийн хувьд бусад механизмд зүй ёсны байдлаар нөлөө үзүүлэх утга агуулгыг илэрхийлдэггүй. Ийм учраас энэхүү гарын авлагад сонгуулийн маргааныг үүсгэж байдаг олон улс орнуудын олон төрлийн тогтолцоонуудад дүн шинжилгээ хийж тэдгээрийн гол зарчмууд, баталгаанууд болон үндсэн элементүүдийг тусгайлан оруулсан.

92. Сонгуулийн маргаанууд нь сонгуулийн хуультай сонгуулийн тусгайлсан үйл ажиллагаа, шийдвэр нь нийцэж буй эсэхийг зөвхөн баталгаажуулдаггүй. Мөн энэ үйл ажиллагааны явцад сонгуулийн хууль бусад хуульд заасан Үндсэн хуулийн зарчмуудын талаарх шүүхийн дүгнэлтийг баталгаажуулдаг. Ийм төрлийн маргааныг Үндсэн хуулийн маргаан шийдэх эрх бүхий байгууллага шийдвэрлэдэг. Үүнд Үндсэн хуулийн шүүх, зөвлөл эсвэл тухайн улсын дээд шүүх зэрэг зөвхөн сонгуулийн ч бус эрх зүйн салбарын бүхий л ерөнхий асуудлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд багтдаг. Зарим тохиолдолд эдгээр байгууллага нь сонгуулийн маргааныг хянан

шийдвэрлэж Үндсэн хуульд нийцээгүй зарим хуулийн заалтуудыг хүчингүй болгох эрхтэй байдаг. Гэхдээ энэхүү гарын авлага нь сонгуулийн тусгайлсан маргааныг тухайн улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд шүүхээр хянан шийдвэрлэх журмыг тодорхойлсон.

93. Гэхдээ зарим улс орны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой маргаан хуульд нийцсэн эсэхийг шалган тогтоохоос гадна Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг давхар магадлан шалгадаг шүүхийн харъяаллыг тодорхойлж, зарим улс нь үүнийг Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагын харъяалалд багтаасан байдаг. Жишээ нь, Испани улсад Захиргааны хэргийн шүүх нь иймэрхүү Үндсэн хуультай холбоотой асуудлыг Үндсэн хуулийн шүүхэд хандан шийдүүлж болдог. Энэ нь авч хэлэлцэж буй асуудал, шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн эсэх, Үндсэн хуулийн дагуу байна уу гэдгийг тогтоолгон, сонгуулийн дүнд өөрчлөлт оруулах тохиолдол байж болдог. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд Үндсэн хуулийн шүүх ийм төрлийн маргааныг хянан шийдвэрлэдэг бол зарим улс орнуудын хувьд Дээд шүүх ийм эрхтэй байдаг. Зарим оронд сонгуулийн асуудлыг хариуцсан тусгай шүүх байдаг. Жишээ нь Эквадор болон Мексик улсуудад ийм шүүх байдаг. Ийм байдлаар зүй ёсны сонгуулийн тогтолцоо нь сонгууль Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх явдлыг хангах олон талын хамгаалалтыг бий болгодог.

94. Үр нөлөөг нь харгалзахгүйгээр сонгуулийн маргаан нь сонгуулийн ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа, процедур болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой байж болох бөгөөд тухайн маргааныг шийдвэрлэж байгаа байгууллагын шинж чанараас нь шалтгаалж захиргааны, шүүхийн харъяаллын, хууль тогтоох байгууллагын болон олон улсын гэж ангилдаг. Үүнийг гарын авлагын 7 дугаар бүлэгт илүү дэлгэрэнгүй авч үзсэн.

Мэдээлэл 4.1 Сонгуулийн маргааны төрөл

- Захиргааны
- Шүүхийн харьяаллын (шүүхийн харьяалалд хамаарах эсхүл хараат бус байгууллага)
- Хууль тогтоох байгууллагын
- Олон улсын

3. Сонгуулийн хариуцлага тооцох журам: Шийтгэл ногдуулах талаар

95. Сонгуулийн бүхий л ажиллагааны явцад сонгуулийн хуулийг даган мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж ямар нэгэн захиргааны зөрчил, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл гарсан тохиолдолд захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулах журам үйлчилдэг. Энэхүү журмын дагуу ихэнхдээ сонгуулийн зөрчил, алдааг өөрчилж, хүчингүй болгодоггүй, харин ийм зөрчил гаргасан этгээдэд захиргааны болон эрүүгийн шинжтэй хариуцлагын аль нэгийг ногдуулдаг. Ийм байдлаар сонгууль хуульд нийцэж явагдсан гэдгийг шууд бус механизмын баталгааг бүрдүүлдэг. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны тохиолдлуудын үр дүнд сонгуулийн маргаан үүсгэж, улмаар эрүүгийн гэмт хэрэг, захиргааны зөрчил гэсэн шүүхийн шийдвэр гарвал энэ нь сонгуулийн үр дүн болон эрх зүйн хамгаалалтын боломжит зохицуулалт болдог.

96. Сонгуулийн холбогдолтой эрүүгийн гэмт хэрэгт ихэвчлэн эрүүгийн шүүх шийтгэл ногдуулдаг харин зарим улсад жишээ нь Панам улсад тусгайлсан сонгуулийн шүүх ийм төрлийн хариуцлага ногдуулдаг. Зарим зүй ёсны сонгуулийн тогтолцоонд захиргааны хариуцлагыг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага ногдуулдаг бөгөөд эдгээр байгууллага нь шүүхээр маргаан хянан шийдвэрлэхтэй адилаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг бөгөөд ийм ажиллагааг сонгуулийн маргааныг шийдвэрлэх этгээдээс өмнөх ажиллагаа (урьдчилан шийдвэрлэх ажиллагаа) гэж үздэг. Харин зарим улсад зөвхөн шүүх л эдгээр хариуцлагыг ноогдуулах эрхтэй байдаг. Харин нийтийн эрх зүйн системтэй улсуудад эрүүгийн шүүх ерөнхийд нь хэргийг авч үзээд захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулах шаардлагатай эсэхийг ялгахгүйгээр иргэний шүүх, захиргааны шүүх эсхүл, сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий этгээд өөрөө хянан шийдвэрлэх ёстой гэж үзвэл тэдгээр байгууллагад шилжүүлдэг.

97. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд, жишээ нь Англид ялалт байгуулсан нэр дэвшигч нь авилгын хэрэгт буруутай гэж тооцогдсон болон бусад хууль бус үйлдэл хийсэн нь нотлогдсон бол тухайн этгээд гэмт хэрэгт буруутгагдан ял авсан, үгүй эсэхээс үл хамаарч тухайн нэр дэвшигчид хамааралтай сонгуулийн үйл ажиллагаа хүчингүй болдог. Бусад улсад (жишээ нь Киргизстан) сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь эрүүгийн шүүхээс тухайн үйл ажиллагааг гэмт хэрэг гэж тогтоосон тохиолдолд түүнийг сонгуулийн үр дүнд нөлөөлөх эсэхийг шийдвэрлэх мөн сонгуулийн хүчинтэй эсэхийг зарлах эрхтэй байдаг.

98. Сонгуультай холбоотой эрүүгийн гэмт хэрэг, захиргааны зөрчил нь “хууль бус, буруутай үйлдлийн” жишээ байдаг. Өөрөөр хэлбэл тэдгээр нь хориглосон үйл ажиллагаа байдаг бөгөөд үүнд санал худалдан авах, кампанит ажлын зардлыг дээд хэмжээнээс хэтрүүлэх, хуульд заасан үйл ажиллагааг хийхгүй байх буюу кампанит ажлын орлого зарлагыг тайланг мэдээлэхгүй байх зэрэг олон үйлдэл багтана. Үүнд холбогдогч этгээдэд захиргааны эсвэл эрүүгийн хариуцлага ногдуулдаг.

99. Сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, захиргааны зөрчлийг дор дурдсан үндэслэлээр ангилдаг:

- Хамгаалагдаж буй үнэт зүйл болон хууль ёсны ашиг сонирхол: (жишээ нь санал өгөх эрх, сонгуулийн өрсөлдөөний шударга нөхцөл гэх мэт). Эдгээр нь эрүүгийн хуулиар хамгаалагддаг үндсэн гол үнэт зүйлс байдаг.
- Ноогдуулж болох хариуцлагын төрлүүд: Эрүүгийн ноцтой гэмт хэрэг гэж тооцогдсон нөхцөлд ихэвчлэн хорих ялаар шийтгэдэг. Харин сонгуулийн холбогдолтой захиргааны зөрчил үйлдэгдсэн гэж үзвэл эрх чөлөөг хязгаарлахгүйгээр санхүүгийн шинжтэй шийтгэл болох торгууль ногдуулах, улс төрийн намын бүртгэлийг түдгэлзүүлэх, уг бүртгэлээс хасах, нэр дэвшигчийг хүчингүй болгох зэрэг арга хэмжээг авдаг.
- Идэвхтэй субъект болон хариуцах этгээдийн шинж чанар: улс төрийн нам гэх мэт хуулийн этгээдэд ихэнхдээ эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй харин захиргааны хариуцлага хүлээлгэдэг.
- Тодорхой үйлдлийг захиргааны зөрчил эсхүл гэмт хэрэг болохыг тогтоох процедур: захиргааны зөрчил гэдгийг тогтоох ажиллагааг ерөнхийдөө Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага хариуцдаг бол эрүүгийн

гэмт хэргийг шалган тогтоох үүргийг прокурор болон түүнтэй адил бусад эрх бүхий байгууллага хариуцан явуулдаг.

- Сонгуулийн зөрчил, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг тогтоох, хариуцлага тооцон, шийтгэл ногдуулах эрх бүхий байгууллага: Нийтийн эрх зүйн тогтолцоотой бус иргэний эрх зүйн тогтолцоотой улс орнуудад ерөнхийдөө сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага, эсхүл иргэний болон захиргааны шүүх захиргааны хариуцлагыг хүлээлгэдэг харин эрүүгийн шүүх нь эрүүгийн хариуцлага ногдуулдаг.

100. Эдгээр үндсэн ялгаанаас гадна захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам нь зарим ижил төстэй шинж чанартай байдаг. Шийтгэл болон хариуцлага ногдуулахдаа хууль ёсны байх зарчмын цаад агуулга нь (ius puniendi) тухайн гэмт хэрэг болон зөрчилд шийтгэл болон хариуцлага ногдуулаагүй тохиолдолд үүнд хэрэглэсэн хууль нь заавал бичмэл хэлбэртэй байна гэсэн шаардлагыг тавьдаг. Тийм учраас доор дурдсан зарчим эсвэл баталгааг захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ авч үзнэ:

- Эрүүгийн гэмт хэрэг, эсхүл захиргааны зөрчлийг хянан үзэж, тогтоохоос өмнө тухайн гэмт хэрэг зөрчил болон тэдгээрт ногдуулах хариуцлагыг заавал хуулиар заасан байх. Энэ тохиолдолд хуулийг буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй. Сонгуулийг зохион байгуулах эрх бүхий байгууллага болон шүүхийн байгууллага (эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шүүх болон сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллага) сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа тухайн хэргийн бодит нөхцөл байдал болон хэрэг хянан шийдвэрлэх журмыг тодорхойлохдоо ямар ч байдлаар шинээр захиргааны зөрчил, эрүүгийн гэмт хэргийн ангиллыг бий болгох эрхгүй бөгөөд энэ нь хууль тогтоох эрх бүхий байгууллагын онцгой эрх мэдлийн асуудал юм. Захиргааны зөрчил, эрүүгийн гэмт хэргийг болон тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг заасан хуулийн заалт нь тодорхой байдал, объектив байдал хэмээх зарчмыг өөртөө агуулдаг. Ерөнхий болон бодитой шинж байдлыг нь тоймлон хуулиар оруулсан байх шаардлагатай бөгөөд журамласан болон хориглосон үйлдэл, түүнийг зөрчсөн тохиолдолд хуулийн ямар үр дагаварт хүрч болохыг тодорхой нарийвчлан зохицуулсан байх ёстой. Шийтгэл, хариуцлагыг тусгасан хуулийн заалтуудыг шууд байдлаар тайлбарлан, чандлан

хэрэгжүүлэх шаардлагатай. Хуульд нийцсэн байх зарчим нь ямар нэгэн маргаан, эргэлзээгүйгээр хэрэгжих ёстой бөгөөд үүнийг ерөнхийдөө л зөрчсөн байна эсхүл, төсөөтэй байдлаар хэрэглэж болохгүй. Хэрэв үүнийг хэрэглэсэн тохиолдолд цаашид ямар үйлдэлд хариуцлага хүлээлгэх, ямар үйлдэлд хариуцлага хүлээлгэхгүй байх талаар тодорхой бус байдал үүсгэж болзошгүй юм.

101. “Хуулийг төсөөтэй хэрэглэх” ойлголт зарим тохиолдолд гарч ирдэг бөгөөд жишээ нь, Иргэний хуулийн дагуу 14 настай хүүхэд иргэний эрх зүйн гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрх зүйн чадамжтай гэж тооцогдоггүй байхад үүнтэй нэгэн адилаар 13 настай хүүхэдтэй холбоотой хэрэг дээр шууд ийм эрх зүйн чадамжгүй гэж төсөөтэй байдлаар уг хуулийн заалтыг хэрэглэж болдог. Харин эрүүгийн болон захиргааны эрх зүйд иргэний эрх зүй шиг хуулийг төсөөтэй хэрэглэнэ гэсэн ойлголт байдаггүй.

102. Сонгуулийн ажиллагаатай холбоотой эрүүгийн болон захиргааны шийтгэл ноогдуулах тогтолцоонд зарим ялгаа байдаг бөгөөд үүнийг дараахь байдлаар харуулж байна:

а) Эрүүгийн хууль дахь сонгуультай холбоотой заалтууд

103. Эрүүгийн шинжтэй үйлдэл нь эерэг болон сөрөг байж болно: гэмт үйлдэл болон эс үйлдлийн аль аль нь нийгмийн эсрэг буруутай гэж тооцогдсон байдаг. Гэмт хэрэг гэдэг нь хуулиар ял шийтгэл хүлээлгэхээр заасан үйлдлийг хэлнэ. Эрүүгийн шинжтэй үйлдэл гэдэг нь хууль бус болон гэмт үйлдэл гэж хуульд заасан үйлдэл, эс үйлдлийг хэлдэг бөгөөд уг үйлдэлд нэг болон хэд хэдэн эрүүгийн хариуцлагыг ногдуулахаар хуульд заасан байдаг. Төрөөс хууль гарган тухайн үйлдэл, эс үйлдлийг хориглон, үүнийг биелүүлээгүй тохиолдолд буруутай этгээдэд эрх чөлөөг нь хязгаарлах ял шийтгэл ногдуулахаар заадаг. Сонгуулийн холбогдолтой гэмт хэрэгт ногдуулах шийтгэлийг тодорхойлохын хамгийн чухал зорилго нь сонгууль өгөх замаар төрийн үйл хэрэгт оролцох иргэний эрх болон сонгуулийн эрхээ эдлэх замаар хэрэгжих байсан үнэт зүйлс, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтооход оршдог байна.

104. Сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг нь өнөөгийн нийгэмд шинээр бий болж байгаа асуудал (problem) биш юм. Эрт үеэс л төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд болон санал хураалтанд чөлөөтэй оролцоход саад учруулсан үйлдэлд шийтгэл ногдуулахыг чухал гэж үздэг байсан түүхтэй. Жишээ нь, эртний Грекд хоёр удаа санал

өгсөн эсвэл санал худалдан авсан, зарсан этгээдэд цаазаар авах ял оноож байсан бол Ромд “Lex Julia de Ambitu” хэмээх хууль гарган төрийн албанд хууль бусаар сонгогдсон этгээдийг шийтгэдэг байжээ. Энэхүү хуулинд өнөөгийн сонгуулийн луйвар болон санал худалдан авахыг тусгасан нь өнөөг хүртэл хэрэглэсээр байна.

б) Сонгуулийн гэмт хэрэг болон зөрчлийг ангилах шалгуур

105. Сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн талаарх хуулийн зохицуулалтыг үндэсний эрх зүйн тогтолцооны хувьд ямар хуульд хамааруулан авч үзэх талаар хоёр үндсэн бодлого, арга зам байдаг. Эхнийх нь ийм төрлийн гэмт хэргийг эрүүгийн хуулийн зүйл заалт болгон оруулдаг бол нөгөө нэг нь, эрх зүйн тогтолцооны хувьд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх хуулийн зохицуулалтыг сонгуулийн хуульдаа оруулж өгсөн байдаг. Эхний арга замыг баримтлагчид нь сонгуулийн хууль байнга өөрчлөгдөж байдаг тул сонгуультай холбоотой гэмт хэргийн талаарх хуулийн зохицуулалтыг харьцангуй тогтвортой үйлчилдэг эрүүгийн хуульд тусгаж өгөх нь хамгийн зүй ёсны хэмээн үздэг. Бусад нь сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчил нь сонгуулийн байнга өөрчлөгдөж байдаг динамикаас өөр байж болохгүй энэхүү сонгуулийн гэмт хэргийн талаарх тодорхойлолт сонгуулийн ерөнхий зохицуулалтыг тусгасан эрх зүйн орчин өөрчлөгдсөн үед мөн л дагаж өөрчлөгдөх шаардлагатай бөгөөд сонгуулийн хууль болон сонгуулийн хуулийн хариуцлагатай холбоотой заалтууд хоорондоо уялдан тогтмол өөрчлөлт, засварууд орж байдаг нь зүй ёсны гэж үздэг.

106. Сонгуулийн ажиллагаанд оролцогчид нь хуулийн заалтыг буруугаар ашиглах, үг хэллэгийг нь гуйвуулах арга замыг байнга эрэлхийлж байдаг тул эдгээр үйлдлийг хуульд нийцсэн эсэхийг шалгаж байх нь зүйтэй. Зарим тохиолдолд сайн хуулийг ч муу мэтээр ойлгуулах оролдлого давамгайлж болдог бөгөөд ийм үйлдлийг байнга хянаж байх шаардлагатай. Нөгөө талаар ийм тохиолдолд тухайн хуулийн заалт нь хуучирсан, дахин авч үзэх шаардлагатай болохыг илэрхийлж байдаг баримт болдог. Английн сонгуулийн хуульд кампанит ажилд зарцуулах зардлыг хэтэрхий багаар тогтоожээ гэж улс төрийн гол намууд үздэг байна. Үүнтэй холбоотойгоор улс төрийн намууд тухайн хуулийг техникийн хувьд даган мөрдөж буй ч кампанит ажилдаа зарцуулах зардлаа өсгөх арга замыг хайж байдаг. Жишээ нь, сонгуулийн кампанит ажлын үеэр тоног төхөөрөмж худалдан авахад тухайн өндөр үнийг сонгуулийн зардал хэмээн тайлагнадаг байсан бол одоо нам нь тоног төхөөрөмжөө худалдан авсан хэдий ч үүнийг кампанит ажилдаа түрээсэлсэн гэж тухайн

кампанит ажилд харьцангуй бага монго зарцуулсан хэмээн тайлагнах боломжтой болсон байна.

Мэдээлэл 4.2 Сонгуулийн гэмт хэргийн зохицуулалт

- Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт хамааруулах
- Сонгуулийн хуульд хамааруулах

107. Сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг ангилах үндэслэл нь улс болгонд өөр өөр байдаг. Хэд хэдэн улсад гэмт хэргийн буруутанд тухайн гэмт хэргийг үйлдэгч буюу иргэд, сонгуулийн ажилтан, намын удирдлагууд болон бусад этгээдүүдийг оруулах талаар гол анхаарлаа хандуулдаг. Харин зарим хууль ёсны ашиг сонирхол нь хамгаалагдаж байгаа эсэх тухайлбал, сонгох, сонгогдох эрх чөлөө, нэр дэвшигчид тэгш нөхцөлөөр хангагдаж чадаж байгаа эсэхийг анхааран авч үздэг. Сонгуулийн гэмт хэрэг болон зөрчлийн тухай хуулийн зохицуулалтыг оруулсан гэдгээс илүүтэйгээр харин сонгуулийг чөлөөтэй, шударга, үнэн зөвөөр явуулах боломжийг хэрхэн баталгаажуулж, бүрдүүлэхэд тусалж чадсан зохицуулалтууд оруулсан гэдгээс нь шалтгаалж тухайн хуулийн агуулгын шалгуурыг авч үздэг.

108. Улс бүрийн түүхэн болон нийгэм-улс төрийн нөхцөл байдал нь сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийг тодорхойлоход чухал нөлөө үзүүлнэ. Тухайн улсын улс төрийн соёл, сонгуулийн практик нь тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх үү гэдэгт бас нөлөөлдөг. Учир нь тухайн тогтсон улс төрийн соёлд эрх чөлөө, тэгш байдлыг хэрхэн ойлгодог болохоос хамаарч зарим үйлдлийг зөвшөөрөх эсвэл хориглодог. Нэг улс орны хэмжээнд үүнийг ялгаатайгаар, өөр өөрөөр авч үзэх тохиолдол байж болдог.

109. Жишээ нь зарим улсад нэр дэвшигчид болон улс төрийн намууд сонгогчдыг санал авах байр руу зөөсөн бол эрүүгийн хариуцлага ногдуулдаг. Ийм төрлийн хариуцлагыг бодит өрсөлдөөний дагуу сонгууль явагддаггүй улсуудад түгээмэл хэрэглэдэг. Өмнөх засгийн эрх баригч нам нь бусдаасаа аливаа төрлийн хүний нооц болон бусад эх үүсвэр сайтай байдгаас шалтгаалж санал худалдан авах, сонгуулийн үр дүнд нөлөөлөх оролдлогыг нилээд хийдэг байна. Сонгогчдыг зөөвөрлөх нь сонгох эрх чөлөөнд ноцтой хор хохирол учруулдаг үйлдэл гэж үздэг бөгөөд үүнийг мөн л сонгуулийн үр дүнд нөлөөлөх, санал худалдах авах үйлдэлтэй холбоотой гэж үздэг. Харин Английн түүхэнд сонгогчдыг санал авах байр руу тээвэрлэхийг дээрхээс өөрөөр авч үздэг байжээ: хүчтэй намуудын зүгээс харьцангуй ядуу иргэд баячуудын эсрэг зогсох боломжийг

олгодог- энэ хугацаанд тээврийн компанийн эзэд сонгогчдыг санал өгөхөд нь хүргэж өгч тусалдаг байжээ. Үүнийг сонгуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа нэг хэлбэр гэж үзэн сонгуулийн хуулийн дагуу үйлдэлд тооцогддог байсан. Цаашлаад, сонгууль нь илүү нээлттэй явагддаг олон орнуудад сонгогчдыг тээвэрлэхийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд учир нь энэ нь улс төрийн өрсөлдөөний хууль ёсны байдлыг хангадаг нэг хэсэг хэмээн үздэг байна.

в) Сонгуулийн холбогдолтой гэмт хэргийн жишээ

110. Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн байж мэдэх этгээдийн тоонд сонгуулийн ажилтнууд, намын ажилтнууд, нэр дэвшигчид, сонгуулийн бус төрийн ажилтнууд, иргэд байж болно. Хэрэв шашны болон төрийн бус байгууллагын удирдлагууд тэднийг шүтэн бишрэгч болон гишүүд, дэмжигчдийг уриалан дуудах байдлаар сонгуульд нөлөөлж болдог.

111. Хүснэгт 4.2 нь эрх зүйн өөр өөр системтэй улс орнуудад сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг тодорхойлсон жишээг тусган харуулсан.

Хүснэгт 4.2 Эрх зүйн олон төрлийн системд сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг тодорхойлох хэлбэрүүд

Сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг	Үйл ажиллагаа					
	Сонгогч	Сонгуулийн ажилтнууд	Намын ажилтнууд	Намын лидер эсвэл нэр дэвшигч	Төрийн албан хаагч	Бусад
Сонгуулийн луйвар	Хууль зөрчин санал өгөх Нэгээс илүү санал өгөх	Мэдсээр байж сонгогчдын хууль бус үйлдлийг өөгшүүлсэн				Бусдын баримт бичгийг ашиглан санал өгөх
Сонгогчдыг шахан шаардах		Сонгуулийн өдөр болон үр дүнгийн тухай худал мэдээлэл тараах	Сонгуулийн өдөр болон үр дүнгийн тухай худал мэдээлэл тараах		Өөрийн удирдлага дахь хүмүүсээ аль нэг намд санал өгөхийг шаардах	Сонгогчдод бэлэг, мөнгө өгөх замаар худалдан авах, ямар нэгэн амлалт өгөх

					Төрийн албаны заалтыг сонгуульд тодорхой нэг намд санал өгөх нөхцөл болгох	Иргэдэд дарамт үзүүлэх
						Санал хураалтын байранд кампанит ажил явуулах, дарамт шахалт үзүүлэх
						Санал хураалтын байранд кампанит ажил явуулах, дарамт шахалт үзүүлэх
						Сонгуулийн дүнг зөвшөөрсөн хугацаанаас өмнө түгээх
Сонгуулийн үйл явцад саад учруулах		Бусдын санал өгөх эрхийг хязгаарлах	Сонгуулийн баримт бичиг, материалыг өөртөө авч, эзэмших			Бусдын сонгох эрхийг хязгаарлах
		Санал авах ажилд саад учруулах, сонгогчдын итгэлийг хууль бусаар авах, сонгуулийн баримт бичгийг өөрчлөх, санал авах байранд саад хийх				Санал авах ажилд саад учруулах, сонгогчдын итгэлийг хууль бусаар авах, сонгуулийн баримт бичгийг өөрчлөх, санал авах байранд саад хийх
		Санал авах байран дахь улс төрийн намын эрхийг хэтрүүлэн ашиглах	Санал авах хэвийн үйл ажиллагаанд саад учруулах			Санал авах байран дахь улс төрийн намын эрхийг хэтрүүлэн ашиглах
		Саналын хуудсыг битүүмжилсэн хайрцагнаас хууль бусаар авах				Саналын хуудсыг битүүмжилсэн хайрцагнаас хууль бусаар авах

		Сонгуулийн дүн, баримт бичгийг өөрчлөх, цаг хугацаанд нь хүргэхэд саад хийх, хуулиар заасан цагаас өмнө болон хойно нээх				Сонгуулийн дүн, баримт бичгийг өөрчлөх, цаг хугацаанд нь хүргэхэд саад хийх, хуулиар заасан цагаас өмнө болон хойно нээх
		Албан тушаалд нь хамаарах үүргийг биелүүлэхгүй байх				
Сонгогчдын бүртгэлийн эсрэг гэмт хэрэг	Сонгогчдын бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт хийх, солих					Хуурамч баримт бичиг өгөх, сонгогчдын бүртгэлд хуурамч мэдээлэл оруулах замаар сонгогчийн үнэмлэх авах
						Бүртгэлийн баримт бичиг болон сонгогчийн үнэмлэхийг устгах, өөрчлөх,
Кампанит ажлыг хууль бусаар санхүүжүүлэх			Сонгуулийн зардлын талаар худал тайлагнах	Улс төрийн намыг хууль бусаар дэмжих, өөрийн удирдлагад буй хүмүүст нэг улс төрийн нам, нэр дэвшигчид санал өгөхийг шахах, ажлын цагаар кампанит ажилд оролцуулах, хууль бусаар эд хөрөнгө, хөрөнгө санхүү ашиглуулах		

			Хууль бус санхүүжилтыг ашиглах	Хууль бусаар эд хөрөнгө, хөрөнгө санхүү ашиглуулах		
			Төрийн албан хаагчаас өгсөн хууль бус санхүүжилтыг ашиглах			

г) Сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг шийдэх эрх бүхий байгууллага

112. Олон улс орнуудад сонгуультай холбоотой гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаа нь бусад гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаатай ижил хэлбэрээр явагддаг. Прокурор эсвэл үүнтэй дүйцэх албан тушаалтан тухайн гэмт хэргийг мөрдөх, гэмт хэрэгт холбогдогч этгээдийг гэмт хэрэгт буруутай эсэхийг магадлан шалгах улмаар шүүхэд шилжүүлэн, эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт гаргах үүргийг хүлээнэ. Эрүүгийн хэргийн шүүгч нь шүүх хурлыг явуулж тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг нь нотолсон тохиолдолд ихэнхдээ энэ гэмт хэрэгт хорих ял ногдуулдаг. Зарим улсад тангарагтны гаргасан шийдвэрийг мөн харгалзан үзнэ.

113. Зарим улсуудад сонгуулийн асуудлыг хариуцсан прокурор, зарим улсад тусгайлсан байгууллага ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Мексик улсад Сонгуулийн тусгай прокурорын газар байдаг бөгөөд энэ нь Ерөнхий прокурорын харьяанд байдаг. Панам улсад Сонгуулийн гэмт хэргийн ерөнхий прокурорын алба ажилладаг бөгөөд энэ нь хараат бусаар сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

114. Хэдийгээр сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг эрүүгийн шүүх шийддэг ч зарим улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх тусгай байгууллага нь үүнийг мөрдөн шалгах эрхийг эдэлдэг. Жишээ нь Латин Америкын орнууд болох Бразил болон Панам улсад ийм төрлийн байгууллага байдаг.

д) Сонгуулийн зөрчилд ногдуулах захиргааны хариуцлага

115. Сонгуулийн ажиллагаатай холбоотой захиргааны зөрчил гэж гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, тухайн этгээд нь сонгуулийн болон бусад захиргааны хуулиар зохицуулсан сонгуулийн дүрэм, журмыг зөрчсөн буруутай үйлдлийг хэлдэг. Энэ тохиолдолд эрх чөлөөг нь хасахаас бусад шийтгэл ноогдуулдаг. Ийм төрлийн зөрчлийг ихэнхдээ сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэдэг бөгөөд иргэний буюу эх газрын эрх зүйн системтэй орнуудад түгээмэл байдаг.

116. Зүй ёсны сонгуулийн зарим тогтолцоонд захиргааны хариуцлагыг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага ногдуулахаар заасан байдаг бөгөөд энэ байгууллага нь бодит нөхцөл байдал, баримт материал цуглуулах ажиллагааг хийдэг бөгөөд үүнийг маргааныг шийдвэрлэхийн урьдчилсан процесс гэж үздэг. Харин зарим зүй ёсны сонгуулийн тогтолцоонд захиргааны хариуцлагыг зөвхөн шүүх ногдуулдаг. Энэ нь үндсэндээ нийтийн эрх зүйн системтэй улсуудад хэрэглэгддэг бөгөөд эрүүгийн шүүх, иргэний шүүх, захиргааны хэргийн шүүх заримдаа сонгуулийн маргаан шийдвэрлэх тусдаа байгууллага ч хянан шийдвэрлэж болдог.

117. Сонгуулийн холбогдолтой зөрчлүүдийг ихэнхдээ сонгуулийн хуульд заасан байдаг.

е) Зөрчил гаргасан хувь хүн, хуулийн этгээдийн ангилал болон сонгуулийн холбогдолтой захиргааны хариуцлага

118. Бүх иргэн болон хуулийн этгээд- сонгогч, нэр дэвшигч, сонгуулийн ажиглагчид, төрийн албан хаагчид, сонгуулийн ажилтнууд, улс төрийн намын лидерүүд, улс төрийн нам, эвсэл, бүлгүүд, сонгуулийн ажиглагчдын байгууллагууд, шашны болон төрийн бус байгууллагын нөлөө бүхий хүмүүс, хэвлэл мэдээлэл гээд олон байгууллага, хувь хүн сонгуулийн зөрчил гаргах боломжтой байдаг.

119. Сонгуулийн хуулийн хэрэгжилтэд тохирсон эрх зүйн нөхцөл байдлыг тодорхойлон зохицуулах, сонгуулийн холбогдолтой захиргааны зөрчилд тохирсон хариуцлагыг тогтоохын зорилго нь сонгуулийн эрхээ эдлэх замаар хүртэж чаддаг үнэт зүйл болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтооход оршдог.

120. Сонгуулийн хуулийг шууд бусаар хамгаалах захиргааны хариуцлагын зарим жишээ:

- а. Сануулах, эрхийг нь цуцлах, төрийн албанаас эсвэл сонгуулийн тойргоос гаргах;
- б. Сануулах, улс төрийн намын бүртгэлийг цуцлах;
- в. Улс төрийн намд төрөөс өгөх санхүүжилтыг бууруулах;
- г. Улс төрийн намд албан ёсоор хуваарилсан радио, телевизийн цагийг цуцлах;
- д. Албан ёсоор хуваарилсан улс төрийн зар сурталчилгаа болон улс төрийн мэдээллийн талаарх радио, телевизийн цагийг цуцлах;
- е. Нэр дэвшигчийг нь бүртгэхээс түдгэлзэх болон хасах;
- ё. Сонгуулийн ажиглагчийн статусыг цуцлах; эсвэл
- ж. Торгууль бусад санхүүгийн хариуцлага ногдуулах.

ё) Улс орнуудад сонгуулийн зөрчлийг зохицуулах нь

121. Хэд хэдэн улсад мөрддөг сонгуулийн хууль нь доорх зөрчилд захиргааны хариуцлагыг ногдуулахаар заасан байдаг:

- Улс төрийн нам, бүлэг, нэр дэвшигч хуулиар хүлээлгэсэн үүрэг, сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэрийг зөрчих; дэмжигчид нь хууль бус үйлдэл гаргах; санхүүжилтын эх үүсвэрээ хаанаас авсан, хэрхэн ашигласнаа тайлбарлаж чадахгүй байх; хууль бус эх үүсвэрээс бэлэг, хандив авах; хуулиар заасан хязгаараас хэтэрсэн бэлэг, санхүүжилт авах; болон кампанит ажилд зөвшөөрснөөс илүү мөнгө зарцуулах;
- Иргэд болон бусад хувь хүмүүс сонгууль ажиглах журмыг зөрчих;
- Хэвлэл мэдээлэл улс төрийн намын мэдээллийг албан ёсны цагт нь дамжуулахгүй байх эсвэл сонгуулийн ажиллагаатай холбоотой хуулиар тогтоосон мэдээллийн агуулга болон хэмжээг даган мөрдөхгүй байх;
- Сонгуулийн ажилтнууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх; Сонгуулийн ажилтан, төрийн албан хаагч, шашны болон төрийн бус байгууллагын эрх бүхий этгээд саналаа тодорхой нэг намд өгөхийг болон санал өгөхөөс татгалзахыг хууль бусаар уриалах.

122. Хууль даган мөрдөх байдлыг сайжруулахын тулд сонгуулийн хуульд улс төрийн намууд, тэдний удирдагчид, гишүүд, нэр дэвшигчид болон дэмжигч нарт ногдуулах хариуцлагын заалтыг оруулж өгсөн байх шаардлагатай.

123. Санхүүгийн хариуцлага буюу торгууль нь тухайн буруутай үйлдлийг дахин гаргуулахгүй байхаар хангалттай өндөр байх нь зөв. Хэрэв торгуулийн хэмжээг нь билэгдлийн шинжтэй, бага хэмжээгээр тогтоосон тохиолдолд тухайн зөрчлийг гаргаж буй этгээд нь торгууль төлөх, зөрчил гаргахын хоорондын зөрүү төдийлөн ялгаагүй юм байна гэж үзэн торгуулиа төлөөд зөрчил гаргах нь өөрт нь бага зардлаар илүү үр дүнд хүрч болно гэдгийг ямар ч этгээд хялбархнаар тооцох боломжтой юм. Иймээс тухайн үйлдлийн гарах үр дүнгээс илүү өндөр торгуулийн шийтгэлийг тухайн зөрчилд хүлээлгэх зарчмыг баримтлах нь чухал юм. Үүнтэй холбоотойгоор хариуцлага ногдуулах хугацааг тооцоолох мөн чухал асуудал юм. Захиргааны процедур нь хэт удаан үргэлжилж, сонгууль дууссаны дараагаар буюу тухайн зөрчил гаргасан этгээд нь аль хэдийн ялалт байгуулсан хойно шийдвэр гарч, хариуцлага тооцохоор байвал энэ нь хуулийг зөрчөөд бай гэсэн уриалга шиг л болно. Хариуцлага ногдуулах захиргааны хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд нийцэж, ногдуулах хариуцлага нь үйлдэлд нь тохирсон байх журмыг баримтлах нь зүйтэй .

Мэдээлэл 4. Санхүүгийн хариуцлагын үр дүн нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалж өөр өөр байдаг талаар

Франц улсад 2000 оны тэгш байдлын хуулийн хүрээнд сонгуулийн хууль тогтоомждоо эмэгтэйчүүдийн квотыг нэмж оруулжээ. Энэхүү хуулийн заалтад заасан тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлээгүй улс төрийн намуудад торгууль ноогдуулж, төрөөс тэдэнд олгох санхүүжилтыг бууруулах арга хэмжээг авахаар заажээ. Францын зарим улс төрийн намууд үүнийг даган мөрдөлгүйгээр төлөх торгуулийн хэмжээг бага хэмээн үзсэн тул хуульд заасан тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэлгүй, харин торгууль төлсөн байна. Францын гадуур орших нутаг дэвсгэрт ч гэсэн мөн хуулийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Шинэ Каледонд ч хэрэгжсэн байна. Харин Шинэ Каледоны улс төрийн намууд нь Францын намуудаас ядуу тул хуульд заасан тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлжээ. Үүний үр дүнд Шинэ Каледоны хууль тогтоох байгууллагад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн төлөөлөл бараг ижил болсон бөгөөд эмэгтэйчүүд 44.4%-ийг эзэлсэн бол Францад энэ хэмжээ дөнгөж 18.9% байжээ (2010 оны 2 сарын байдлаар). Эндээс харахад нэг нутаг дэвсгэрт тохирох систем нь нөгөө нутаг дэвсгэрт тэр бүр ижил байдлаар хэрэгждэггүй, тохирдоггүй байна.

124. Сонгуулийн хариуцлагыг шүүхийн өмнөх шат болон шүүхийн шатанд ногдуулах боломжтой байх нь чухал юм. Эдгээр сонгуулийн хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллагууд нь хараат бусаар шүүхийн өмнөх шатанд үр дүнтэй эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлж чадсан байх, цаашлаад хүний эрхийг хангасан байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийг хүндэтгэх шаардлагад нийцсэн эсэхийг шалган баталгаажуулдаг.

ж) Бусад хууль зүйн арга хэрэгсэл

125. Цаашлаад, сонгуулийн хуулийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ улс төрийн гэж

хэлж болох зарим төрлийн хариуцлагыг хүлээлгэж болдог. Тодорхой сонгуулийн ажиллагаатай холбоотой ноцтой зөрчлийг хууль тогтоох байгууллага, бусад улс төрийн хурал, чуулган, төрийн өндөр албан тушаалтан тухайлбал, сайд, Засаг дарга, хууль тогтоогч, шүүгч болон сонгууль зохион байгуулах эрх бүхий этгээдээс үйлдсэн бол энэ төрлийн улс төрийн хариуцлагыг ногдуулдаг. Жишээ нь нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудад импичмент буюу өндөр албан тушаалтныг хариуцлага алдсаных нь төлөө буруутгаж шүүхэд дуудах процедурыг хэрэглэдэг уламжлал байдаг. Өөр нэг жишээ нь “juicio político” буюу улс төрийн шүүх бөгөөд үүнийг Латин Америкын хэд хэдэн оронд хэрэглэн хууль тогтоох байгууллагын өндөр албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах, төрийн алба хаших эрхийг тодорхой хугацаагаар хасах зэрэг хариуцлага ногдуулдаг.

126. Дээрхээс гадна иргэний хариуцлага хэмээх ойлголт байдаг. Жишээ нь, Сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээдээс буруу шийдвэр гаргасан, сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын эсвэл шүүхийн алдаатай шийдвэр гарсан болон зүй ёсны сонгуулийн оновчгүй, дутмаг тогтолцоог бүрдүүлсэн зэрэг тохиолдол нь иймэрхүү төрлийн хариуцлагыг ногдуулах үндэслэл болдог. Үүний нэг жишээ бол Америк тив даяар гарсан маргааныг шийдвэрлэдэг Хүний эрхийн шүүх Мексик улсыг гомдол гаргасан иргэнд нөхөн төлбөр (хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал) төлөх шийдвэр гаргасан. Уг иргэний гомдолд Мексик улс 2006 онд баталсан сонгуулийн хуульдаа иргэний сонгуулийн эрхийг хамгаалах үр дүнтэй эрх зүйн хамгаалалт буюу шүүхийн өмнөх шатанд маргаанаа шийдвэрлүүлэх боломжийг хуульчлан зааж өгөөгүй учраас сонгуулийн эрх нь зөрчигдсөн гэж үзжээ. Хүний эрхийн шүүх нь тухайн асуудал нь гомдол гаргасан иргэний сонгуулийн эрхийг зөрчөөгүй гэж үзсэн. Харин шийдвэр гарах үед Мексикийн Үндсэн хуулинд дээр дурдсан өөрчлөлтийг оруулжээ. (Castaceda Gutman vs Mexico, 2008 оны 8 сарын 6-ны Америкын хүний эрхийн шүүх).

Мэдээлэл 4.4 Туршлагаас суралцах нь: Бутан дахь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны өөрчлөлт

Деки Пема

Бутаны сургамжууд

Бутан улсад анх удаа Парламентын сонгууль 2008 онд явагдаж, уг сонгуулийн үнэлгээг "Туршлагаас суралцах нь" хэмээх хөтөлбөрийн хүрээнд хийжээ. Сонгуулийн холбоотой маргааны хувьд тус улс доорх сургамжуудыг авсан байна:

1. Сонгуулийн үеэр гарсан бүхий л гомдлыг Сонгуулийн хороонд гаргаж байжээ. Үүнээс авсан сургамж нь хэрхэн, ямар үндэслэлээр, хэнд хандан гомдол гаргахыг тодорхой заасан журам, процедур гаргах шаардлагатайг харуулсан байна.

2. Электрон санал хураах машиныг санал авах бүх байранд ашигласан бөгөөд энэ нь санал тоолох болон санал өгөхтэй холбоотой гомдол ихээр гарахаас урьдчилан сэргийлсэн байна.

3. Сонгогчдын нэрсийн жагсаалтыг нарийн гаргасан бөгөөд тус жагсаалт дээрх сонгогчын фото зураг болон иргэний баримт бичгийг хавсаргасан байсан нь гомдол гарахаас урьдчилан сэргийлжээ.

4. Олон нийтийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бүх хэвлэл мэдээлэл, харилцаа холбоог ашиглан явуулсан нь сонгуулийн маргаанаас сэргийлж, иргэд тухайн сонгуулийн тогтолцоонд итгэх итгэлийг сэргээсэн байна. (Мэдээлэл 3.1-ийг үзнэ үү).

5. Сонгууль нь хүлээлт болон бодит байдлын хувьд иргэдэд итгэл төрүүлэхүйц байх ёстой бөгөөд үүнтэй холбоотойгоор хэвлэл мэдээлэл нь ил тод байдлыг хангах, сонгогчдод мэдээлэл хүргэхэд чухал үүргийг гүйцэтгэсэн байна.

6. Гарсан зөрчлийн хэр ноцтой гэдгээс шалтгаалан зарим асуудлыг шууд тойргийн түвшинд нь илүү сайн шийдэх боломжтой байв. Энэ нь гомдол, маргаан шийдвэрлэх процедурыг түргэн ажиллуулах боломжоор хангаж, харин сонгуулийн байгууллага илүү ноцтой хэрэг дээр анхаарал хандуулах боломжийг нээн өгчээ.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулах нь

Дээр дурдсан туршлага дээр үндэслэн сонгуулийн маргаан шийдвэрлэх журам, процедурыг дахин эргэн харж илүү үр дүнтэй, ил тод болгосон байна. Энэхүү хийсэн өөрчлөлтийн талаар дээр илүү дэлгэрэнгүй дурдсан бөгөөд эдгээр нь ямар хэргийг аль түвшинд шийдвэл зохистой талаар дэлгэрэнгүй тусгажээ. Мөн уг өөрчлөлт нь гомдлыг бүртгэх, хянан үзэх ажиллагааны талаар илүү системтэй арга замуудыг гарган ирж, хэргийг хэрхэн мөрдөх, шүүх хурлыг хэрхэн зохион байгуулах, шийдвэр гаргах болон давж заалдахтай холбоотой асуудлыг тодруулжээ.

1. Хоёр шатлалт сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага

Сонгуулийн дараа хууль, журамд хийсэн өөрчлөлтөөр хоёр шат бүхий сонгуулийн маргаан шийдэх байгууллагыг сонгуулийн үеэр ажиллуулахаар болжээ. Сонгуулийн маргаан шийдэх төв байгууллага нь үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулан, харин сонгуулийн тойргийн комиссын гишүүд тэр дундаа комиссын нарийн бичгийн дарга нь, хамаарах хэлтсийн дарга нар болон хуульчид бусад түвшинд нь ажилладаг байна. Тойргийн сонгуулийн маргаан шийдэх байгууллага болон тойргийн хорооны дарга нь тухайн тойргийн захиргааны дэд тэргүүн, тойргийн зөвлөлийн нарийн бичгийн дарга болон сонгуулийн хорооны гишүүдийг үнд багтаадаг байна.

2. Гомдолтой холбоотой шийдвэр гаргах тодорхой дүрэм, журам

Сонгуулийн холбогдолтой гомдол гаргах журмаар бүх гомдлыг доорх этгээдүүдэд хандан гаргана:

1. Сонгуулийн ерөнхий хорооны дарга;
2. Сонгуулийн ерөнхий хорооны зохицуулагч;
3. Үндэсний ажиглагчид; эсвэл
4. Сонгуулийн ажилтнууд.

Энэхүү журам нь тухайн үйл явцыг илүү хөнгөн шуурхай, хүртээмжтэй болгох зорилгоор хийгджээ.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга болон зохицуулагч нь гомдол хүлээн авсан тохиолдолд нэн даруй шалган шийдвэрлэх ёстой. Хэрэв ямар нэгэн хэргийг хүлээн авсан тохиолдолд хоёр өдрийн дотор шийдвэр гарсан байх шаардлагатай. Хэрэв тухайн хэргийг шийдэх боломжгүй бол үүнийг төв байгууллага эсвэл маргаан шийдэх байгууллагад хандана.

3. Гомдлыг зохистойгоор танилцуулах, гаргах

Ямар нэгэн үндэслэлгүй гомдлыг хэрэгсэхгүй болгохын тулд ирүүлсэн бүх гомдлыг гарын үсэг зуран хүлээн авч, түүнд ямар хэрэг болох, холбоо барих хаяг зэргийн тодорхой тэмдэглэж авна.

4. Мөрдөн шалгах комисс байгуулах

Сонгуулийн төв байгууллага дээр тусдаа мөрдөн шалгах комиссыг томилон ирсэн хэргүүдийг шалган, үүнээс гарсан үр дүнг маргаан шийдэх байгууллагад хүргүүлдэг. Тойргийн түвшинд тойргийн маргаан шийдэх байгууллага нь тухайн асуудлыг тусгай комиссын шалгалтын дараагаар хянан үзнэ.

5. Сонсгол, шүүх хурлын талаарх илүү дэлгэрэнгүй зохицуулалт

Сонгуулийн дараа тухайн гомдлыг авч хэлэлцэх сонсгол, хуралдааны холбогдолтой үйл явцыг илүү сайжруулсан байна. Үүнийг зохион явуулахад гурав хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд тухайн маргаанд хамаарах талуудын төлөөлөлтэйгээр, тэд өөрийн нотлох баримтыг гарган ирэх байдлаар хэлэлцэх бөгөөд харин талуудын төлөөлөл байхгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгож болно. Шийдвэр гаргахаас өмнө хамгийн дээд тал нь хоёр удаагийн хурал явуулж болно.

6. Шийдвэр гаргалтыг илүү үр дүнтэйгээр зохицуулах

Сонгуулийн дараа хэрэглэх дүрэм, журмуудыг эргэн харж ямар төрлийн зөрчилд торгууль, сануулга, хүчингүй болгох, нэр дэвшигчийн эрхийг хасах, дүнг хүчингүй болгох, хорих, баривчлах, улс төрийн намын бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээг авах болохыг тодорхой заасан нь төв болон тойргийн хэмжээний маргаан шийдэх байгууллага дээр шийдвэр гаргах явдлыг илүү хөнгөвчилж өгсөн байна.

7. Шийдвэрийг тоймлон гаргах болсон

Хэрэв ноцтой бус хэрэг бол цаашид мөрдөн шалгалгүйгээр тойм байдлаар шийдвэр гаргах боломжийг хангаж өгсөн. Ямар нэгэн материаллаг баримт байхгүй тохиолдолд хэргийг хэлэлцээд тухайн хэргийг шийдэх хангалттай нотолгоо байгаа бол шууд тоймлох байдлаар шийдвэр гаргах боломжийг хангасан.

8. Эцсийн, хууль ёсны шийдвэрийн талаар илүү сайжруулсан заалтуудыг оруулсан

Давж заалдах болон давж заалдах хүсэлтээ гаргах үйл явцыг маш нарийн тодорхойлжээ. Жишээ нь Сонгуулийн төв байгууллагад гаргах давж заалдах хүсэлтийг 5 хоногийн дотор гаргах ёстой. Хэрэв энэ хугацаанд давж заалдаагүй бол сонгуулийн байгууллагын гаргасан үндсэн шийдвэрийг эцсийн гэж тооцно.

9. Хэрэг авч хэлэлцэх цаг хугацааны хязгаар

Сонгуулийн төв байгууллага гарсан гомдлыг санал хураах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө шийдсэн байх ёстой. Тойргийн хэмжээнд үүнийг 10-аас доошгүй хоногийн өмнө магадлан шийдсэн байх шаардлагатай. Ингэснээр тухайн маргалдагч талуудад давж заалдах хангалттай хугацааг гарган өгдөг. Зөвхөн сонгуулийн төв хороо нь энэхүү хугацаанаас хойш гарсан гомдлыг хэлэлцэн шийдэх эрхтэй.

10. Бусад байгууллагад шилжүүлэх үүрэг

Сонгуулийн маргаан шийдэх байгууллага нь гарсан гомдлыг шалгаад бусад хууль тогтоомжид хамаарах хэргийг хамаарах байгууллага болох цагдаа, авлигын эсрэг байгууллага болон бусад байгууллагад тухайн холбогдогч этгээд, нэр дэвшигч болон улс төрийн намд ямар арга хэмжээ авч буйгаас үл хамааран шилжүүлэх үүрэгтэй.

11. Сонгуулийн бус хугацаанд гарах гомдол

Сонгуулийн бус хугацаанд гарсан бүх гомдлыг Сонгуулийн төв байгууллагын даргад хандан гаргана. Гомдлыг хүлээн аваад төв байгууллага нь мөрдөн шалгах комисс байгуулан сонгуулийн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулна.

БҮЛЭГ 5

БҮЛЭГ 5

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны ерөнхий ангилал

1. Танилцуулга

127. Сонгуулийн ажиллагаа нь хуулийн дагуу явагдаж, сонгуулийн эрхийг хангах бүрэн дүүрэн төгс хангах арга зам, тогтолцоо гэж байхгүй. Иймээс сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь олон төрөлд хуваагддаг.

128. Улс бүрийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь тухайн улсын түүх, нийгэм-улс төрийн нөхцөл байдал, эрх зүйн уламжлалын ерөнхий үр дүн байдаг. Ийм учраас нэг улсын сургамж, туршлагыг нөгөө улсын өөр нөхцөл байдалд тохируулан шууд хуулбарлан хэрэглэх боломжгүй байдаг. Гэхдээ сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны амжилттай хэрэгжиж чадсан туршлага болон хамгийн сайн практикийн давуу болон сул талуудаас сургамж авах, нэмэлт элементүүдэд дүн шинжилгээ хийх замаар тухайн тогтолцооны тодорхой хандлагуудыг танин мэдэж харьцуулсан байдлаар судлан үзэх шаардлагатай.

129. Олон улсын хүний эрхийн хэд хэдэн гэрээ, конвенцоор хүний үндсэн эрхийг зааж өгсөн бөгөөд хүний зөрчигдсөн эрхийг хараат бус шүүхээс өмнө үр дүнтэйгээр хамгаалах хамгаалалт байх шаардлагатайг тогтоосон. (Мэдээлэл 5.1-ийг үзнэ үү).

Мэдээлэл 5.1 ОУ-ын Парламентын Хорооноос 1994 онд баталсан Чөлөөт, шударга сонгуулийн шалгуурын тухай тунхаглал

Хэсэг 4.9

"Тунхаглалд нэгдэн орсон талууд нь хүний эрхийн зөрчил, сонгуулийн ажиллагаатай холбоотой гомдлыг нэн даруй шүүх, сонгуулийн хороо зэрэг хараат бус, төвийг сахисан эрх бүхий байгууллага үр дүнтэйгээр шийдвэрлэнэ."

130. Даяарчлалын хэтийн төлвийг танин мэдэх, дэлхийн өнөөгийн нөхцөл байдлыг олж мэдэхийн тулд сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоог ангилах нь чухал. Энэхүү ангиллыг хийхдээ хэд хэдэн шалгуурыг авч үздэг.

2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилах шалгуур

131. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлдэг олон төрлийн элементүүдийг судлах бөгөөд хуульд нийцсэн, сонгуулийн эрхийг хангаж байгаа хамгийн шилдэг арга замыг тодорхойлох оролдлого зэрэг нь ангилах шалгуурын нэг аргачлал болох юм. Хамгийн шилдэг арга зам гэж юу болох талаар маргалгүйгээр энэхүү шалгуурыг авч, мэдээллийг системтэйгээр цуглуулан ангиллыг хийдэг.

132. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны төрөл болон ардчилалыг бэхжүүлэх зорилго хоёрын хоорондын дүгнэлт судалгаанаас чухал харилцан хамаарлыг олж тогтоох боломжгүй байдаг. Шинээр ардчилалыг бий болгож байгаа улс орнууд сонгуулийн маргааныг шийдвэрлэх сайн механизм, сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх хамгийн тохиромжтой механизмыг тогтоож цаашлаад, илүү хатуу чанга сонгуулийн хариуцлагын дэглэм, журмыг бий болгоход голлон анхаардаг ч гэсэн сонгуулийн ноцтой маргаан, институцын хэмжээний хямрал гарсаар байдаг. Сонгуулийн маргааныг урьдчилан сэргийлэх механизмыг бага хэмжээгээр тогтоож, сонгуулийн маргаан болон хариуцлага ногдуулах журам нь энгийн, шууд сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог зарим хөгжил нь тогтворжсон бөгөөд ардчилал өндөр түвшинд хүрсэн улс орнууд бий болгосон байдаг ч гэсэн сонгуулийн холбогдолтой маргаан цөөн гардаг байна. Жишээ нь, Скандинавын орнуудад улс төрийн соёл нь сонгуулийн хатуу журам, заавраас илүүтэйгээр аливаа сонгуулийн маргааныг зохицуулдаг байна. Мөн зарим улсуудад сонгуулийн дүн маш ойролцоо гарсан ч гэсэн ийм төрлийн маргааныг хялбархнаар даван гарч байдаг. Ийм нэг жишээ АНУ-ын Ерөнхийлөгчийн 2000 оны сонгууль юм. Сонгуулийн хямралыг даван туулна гэдэг нь тухайн улсын сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх тогтолцоо, бүтцээс зөвхөн хамаарахгүй мөн

улс төрийн тоглогч нарын харилцан зөвшилцөх хүсэл сонирхлоос мөн хамаардаг.

133. Улс орнуудын эрх зүйн уламжлал нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үйл ажиллагаатай холбоотой байдаг. Жишээ нь, Ром-Германы болон иргэний эрх зүйн тогтолцоотой улс орнууд философи-шашны уламжлалтай байдаг. Энэ нь зөвхөн нэг хүчин зүйл байдаггүй. Их Британи болон АНУ нь хоёулаа нийтийн эрх зүйн буюу Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой тул тэдгээрийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд ижил төстэй зүйлс байдаг ч, мөн ялгаатай зүйлс ч олон байдаг. Иргэний эрх зүйн системтэй улсуудад Испани, Итали, Уругвай зэрэг улсуудыг дурдаж болно. Үүний зэрэгцээ өөр өөр системтэй улсуудын хооронд ч гэсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны бүтэц, үйл ажиллагаанд олон тооны төстэй зүйлс байдаг. Жишээ нь АНУ болон Итали; Этиоф, Англи, Пакистан, Тайван, Испани, Индонези, Нигер; Палестин, болон Уругвай зэрэг улсууд нь хэдийгээр өөр өөр төрлийн эрх зүйн тогтолцоотой ч гэсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны бүтэц болон ажиллагаа нь нилээд ижил байдаг. Үүнээс дүгнэхэд сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоог ангилал гол элементүүд нь өөр өөр байдаг.

134. Түүнчлэн зарим ардчилсан орнууд сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооныхоо урьдчилан сэргийлэх механизмд илүү анхаарал хандуулдаг бол зарим нь засан сайжруулах механизмд түлхүү анхаарч зарим нь хариуцлага ногдуулах механизмаа илүүтэйгээр сайжруулахад анхаардаг байна. Сонгон авсан сонгуулийн маргаан шийдвэрлэх механизм болон гарч буй сонгуулийн маргааны тооны хооронд ямар нэгэн харилцан хамаарал байдаггүй. Хэрэв сонгуультай холбоотой маргаан гарсан тохиолдолд маргааныг шийдвэрлэх механизмын тусламжтайгаар уг маргааныг хянан шийдвэрлэх, сонгуулийн дүнг өөрчлөх, хүчингүй болгох, хүлээн зөвшөөрөх зэргээр буруутай үйлдлийг илрүүлж, сонгуулийн эрхийг хамгаалан, сэргээн тогтоодог. Харин нөгөө талаас нь авч үзвэл тухайн тогтолцооны хариуцлагын талаарх журмын дагуу сонгуулийн хууль бус үйлдэл гаргасан буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэж энэ нь жишиг болон хэрэгждэг.

135. Ийм учраас энэхүү гарын авлагаар Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилж байгаа сонгуулийн маргааныг үүсгэдэг үндэслэлийн талаарх журмыг эрэмбэлэсэн. Энэхүү журам нь сонгуулийн ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, сонгуулийн эрхийг хамгаалах болон сэргээн тогтооход нөлөөлөх

шууд хяналтын механизмыг бүрдүүлдэг. Тиймээс энэхүү сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь зүй ёсны сонгуулийн зарчим болон хамгийн үр дүнтэй баталгаа болдог.

136. Гэхдээ сонгуулийн зөрчлүүдийг ангилж болох хэд хэдэн шалгуур байдаг. Ихэнх тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх зөвхөн нэг тогтолцоо гэхэд л хэд хэдэн төрлийн этгээд сонгуулийн маргааныг шийдвэрлэж байдаг (захиргааны, шүүх, хууль тогтоох болон олон улсын). Ангиллын нэг шалгуур нь тухайн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж байгаа байгууллагын шинж чанарыг тодорхойлох байж болно. Энэхүү шалгуур нь тийм ч үр дүнтэй бус, учир нь олон тооны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн маргааныг шийдвэрлэх анхан шатны байгууллага нь ихэнхдээ сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага байдаг. Харин өндөр түвшний байгууллагуудаар нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилахад илүү чухал байж болох юм. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх анхан шатны байгууллагуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Олон улсын хүрээлэнгийн онлайн мэдээллийн сан болох <http://www.idea.int> хаягаар авна уу.

137. Ихэнх сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх байгууллагын үндсэн мөн чанарыг харгалзан ямар түвшинд шийдвэрлэж байгаагаас шалтгаалж сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилдаг өөр нэг шалгуур байдаг. Харамсалтай нь олон төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны талаарх статистик мэдээлэл маш бага байдаг. Мөн нэг сонгуулиас нөгөө сонгуулийн хооронд тэдний гаргаж буй шийдвэрүүд нь өөрчлөгдөж байх магадлал байдаг. Жишээ нь нэг удаагийн сонгуулиар олон тооны зөрчил гарч, энэ талаар шийдвэр гарсан байхад эсрэгээрээ өмнөх сонгуулиар энэ нөхцөл байдал өөр байсан байж болно. Гэвч шүүхээс маргааныг шийдвэрлэсэн өмнөх шийдвэрийн үр дүн өнөөдрийн сонгуулийн ажиллагаатай холбоотой маргааныг шийдвэрлэсэн үр дүнгээс өөр байж болдог. Хэрэв тухайн жил сонгогчдын бүртгэлийн асуудлаар үүссэн маргаан нилээд гарсан байлаа ч гэхэд жишээ авахад уг маргааныг шийдвэрлэх байгууллага нь энэхүү бүртгэлийн асуудалтай шууд холбогдох байгууллага бус уг үйл ажиллагаанаас хараат бус байгууллага байх шаардлага тавигддаг нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хууль ёсны болон найдвартай байдлыг хангахад чухал үүрэгтэй байдаг.

138. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ангилахдаа ямар шалгуур баримталснаас үл хамааран сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллага хараат бус байх нь чухал хүчин

зүйл байдаг. Иймээс сонгуулийн захиргааны байгууллага анхан шатандаа сонгуулийн маргааныг шийдвэрлэхдээ бие даасан, хараат бусаар ажиллах нь чухал байдаг. Жишээ нь Энэтхэг (Дэлхий дээрх хамгийн том ардчилсан улс), Мексик, Өмнөд Африк зэрэг орнуудын сонгуулийн байгууллага байж болно (Сонгуулийн менежментийн бүтэц: Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн гарын авлагыг үзнэ үү). Хараахан өндөр хэмжээнд хараат бус, бие даасан ардчилалыг хөгжүүлж чадаагүй байгаа орнуудын сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага нь ардчилсан шилжилтийн болон түүнийг баталгаажуулах процесст чухал хувь нэмрийг оруулж байдаг. Тэдгээр байгууллага нь хэдийгээр сонгуулийн маргааныг шийдвэрлэх гинжин холбооны үе шатанд эцсийн шийдвэр гаргадаггүй ч гэсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үйл ажиллагаанд томоохон, эерэг хувь нэмрийг оруулж байдаг.

139. Ийм учраас энэхүү гарын авлагаар дэлхийн улс орнуудын сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын ангилалын шалгуурыг эрх зүйн тогтолцоотой нь нийцүүлэн сонгуулийн үр дүнг баталгаажуулах эцсийн шийдвэрийг гаргах байгууллагын мөн чанарыг нь харгалзан гаргасан. Тухайн улс ямар засаглалтай байхаас үл хамааран ардчилсан бүх улсад энэ байгууллага нь сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг. Энэхүү ангиллыг ашиглан сонгуулийн маргаан шийдвэрлэх дэлхийн хэмжээний тогтолцоог дор дурдсан дөрвөн загварт ангилан авч үзэж болно (Мэдээлэл 5.2-ыг үзнэ үү).

Мэдээлэл 5.2 Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны ерөнхий ангилал

- Хууль тогтоох байгууллага
- Шүүх байгууллага
 - Ердийн шүүхүүд
 - Үндсэн хуулийн шүүх
 - Захиргааны хэргийн шүүх
 - Тусгай сонгуулийн шүүх
- Шүүхийн байгууллагын эрх мэдэл бүхий сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага
- Ad hoc Олон улсын оролцоотой эсвэл дотоодын байгууллагуудын оролцоотой байгуулсан түр байгууллага

140. Мэдээж энэ нь цорын ганц ангилал биш бөгөөд энэхүү гарын авлагад эдгээр ангиллыг дор дурдсан таван шинжид үндэслэн авч үзсэн.

141. Нэгдүгээрт, олон улсын хүний эрхийн баримт бичгүүд нь сонгуулийн эрхийг хангах тухай заалтыг агуулсан байдаг. Үүний үр дүнд сонгуультай холбоотой гомдлыг олон улсын байгууллагад

хандан гаргах боломж бүрдэх хэдий ч одоогоор олон улсын ямар нэгэн байгууллага аль нэг орны сонгуулийн үр дүнтэй холбоотойгоор шийдвэр гаргаагүй байна.

142. Хоёрдугаарт, сонгуулийн маргаан шийдвэрлэх зарим тогтолцоонд сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бусад сонгуулийн маргааныг шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай байдаг.

143. Гуравдугаарт, зарим сонгуулийн ажиллагаатай холбоотой маргаан (жишээ нь улс төрийн намуудын сонгуулийн санхүүжилт хаанаас гарч буй, хэрхэн зарцуулж буйг шалгах, сонгуулийн хүчинтэй эсэхийг тогтоох, нэр дэвшигчийг сонгогдсон эсэхийг зарлах эрхгүй байгууллага зарласан зэрэг маргаан)-ыг шүүхээс өөр байгууллага эцэслэн шийдвэрлэдэг практиктай улс орон байдаг. Жишээ нь Итали улсад сонгууль хүчинтэй эсэх дээрх эцсийн шийдвэрийг гаргах, хууль тогтоох байгууллага дахь суудлыг хуваарилах эрхийг Депутатуудын танхим эсвэл Сенат эдэлдэг бол үүнээс өмнө гарсан сонгуультай холбоотой зөрчлийг Дээд шүүхийн харьяа байгууллага болох Үндэсний төв сонгуулийн алба эцэслэн шийддэг. Гэхдээ улс төрийн намуудын санхүүжилттэй холбоотой асуудлуудыг аудитын шүүх хариуцан шийддэг ажээ. Энэхүү гарын авлагад Итали улсыг сонгуулийн холбоотой зөрчил, маргааныг хараат бус захиргааны шүүхэд бус харин хууль тогтоох байгууллагадаа хариуцуулдаг улс хэмээх ангилалд багтаасан.

144. Дөрөвдүгээрт, сонгогчдын бүртгэл, улс төрийн намуудын бүртгэл, тайлан, нэр дэвшигчдийг бүртгэх болон зарлах, сонгуулийн кампанит ажилтай холбоотой маргаан түгээмэл гардаг. Зарим улсад сонгуулийн бүх төрлийн зөрчил, маргааны талаарх эцсийн шийдвэрийг нэг л байгууллага гаргадаг. Жишээ нь Үндсэн хуулийн шүүх эсвэл тусгайлсан сонгуулийн шүүхэд үүнийг хариуцуулдаг. Бусад орнуудад сонгуулийн маргааныг захиргааны байгууллага буюу сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага, шүүхийн байгууллага шийдвэрлэдэг.

145. Тавдугаарт, сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь ерөнхийдөө олон төрлийн маргаан шийдвэрлэх механизмуудаас бүрдэх ба үүнд захиргааны, шүүх эсхүл, хууль тогтоох зэрэг механизмууд хамаардаг. Үүнээс үзвэл сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог захиргааны, шүүхийн, хууль тогтоох гэж ангилж болох ч энэхүү гарын авлагын хувьд ангилалд хууль тогтоох байгууллагыг авч үзэхдээ хууль зүйн шинж чанарын нь хувьд л сонгуулийн

эцсийн шийдвэрийг гаргадаг талаас нь нь зөвхөн тайлбарласан.

146. Хэдийгээр тухайн механизм нь хэзээ ч хэрэглэгдээгүй байсан ч гэсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагыг эцсийн шийдвэр гаргадаг шалгуураар нь ангилан авч үзэж байгаа учраас хэн сонгуулийн маргааны асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрхтэй хууль зүйн этгээд байна гэдгийг нь гол шалгуур болгож энэ гарын авлагад оруулсан. АНУ-ын хувьд хууль тогтоох байгууллагын сонгуулийн талаарх эцсийн шийдвэрийг гаргах эрх бүхий байгууллага нь Төлөөлөгчдийн танхим эсвэл Сенат нь өөрийн гишүүнчлэлийн асуудлыг хариуцдаг, харин Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд Конгресс бол мужуудын хэмжээнд гарсан шийдвэрийг оорчлоход Төлөөлөгчдийн танхим, Сенат хоёр нь зэрэг санал хураалт явуулан шийддэг байна. Хэдийгээр хуульд заасан ч энэхүү үйл явц Ерөнхийлөгчийн 1876 оны сонгуулиас хойш огт тохиолдоогүй юм. Хамгийн түгээмэл тохиолдсон сонгуулийн асуудлуудыг үндсэндээ Дээд шүүх нь шийддэг байна. Үндэсний хэмжээний хууль тогтоох байгууллагын сонгуулийн хувьд маш цөөн асуудлыг л Төлөөлөгчдийн танхим болон Сенатаар шийдүүлж байжээ. Бидний эцсийн шийдвэр гаргаж байгаа шалгуураар ангилсан ангиллын талаас нь авч үзвэл АНУ-ын сонгуулийн маргаан шийдэх тогтолцоо эцсийн шийдвэр гаргах эрхийг шүүх бус харин хууль тогтоох байгууллагад эдлүүлдэг хэмээх ангилалд багтах юм.

147. Үүний нэгэн адилаар ихэнх улс орны Үндсэн хуулинд хууль тогтоох байгууллага нь парламентад сонгогдсон этгээдүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөх зэрэг эрхийг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүний зэрэгцээ мөн л шүүхийн байгууллага нь сонгуулийн холбогдолтой гарсан маргааныг эцсийн байдлаар шийдвэрлэх эрхтэй байхаар Үндсэн хуулиндаа заасан байдаг. Эдгээр улсуудын практик, Үндсэн хуулийн заалтуудыг үндэслэн энэхүү гарын авлага нь сонгуулийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоох байгууллагын эдлэх эрх нь ёс төдий шинжтэй, бодит байдал дээр шүүх сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэж байгааг харуулсан.

3. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны өөрчлөлт

148. Анхны төлөөллийн ардчиллын дэглэм бий болж байхад сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн үр дүнгийн талаарх эцсийн шийдвэрийг хууль тогтоох байгууллага баталгаажуулдаг байсан. 19 дүгээр зууны 3 дахь үеийн сүүлээр сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд шүүхийн байгууллагаар

маргааныг шийдвэрлүүлэх процедур Англид бий болсон бөгөөд, хууль тогтоох байгууллагын сонгуультай холбоотой шийдвэрлэж байсан маргааныг шүүх хянан шийдвэрлэх болжээ. Хэдийгээр зарим улс орнуудад одоог хүртэл хууль тогтоох байгууллага нь сонгуультай холбоотой зарим эцсийн шийдвэрийг гаргадаг эрхтэй хэвээр байгаа ч гэсэн ихэнх улсууд энэхүү эрхийг аажмаар шүүхийн байгууллагад шилжүүлэх болжээ. 20 дугаар зуунд өөр өөр төрлийн ардчилсан дэглэмтэй улс орнуудын шүүхийн байгууллагууд- ердийн шүүхүүд, Үндсэн хуулийн шүүх, захиргааны шүүх эсвэл тусгайлсан сонгуулийн шүүх- энэхүү эрхийг эдлэх болжээ.

149. Ерөнхийд нь авч үзвэл, хууль тогтоох байгууллага сонгуулийн маргаанд оролцдог байсан байдлаас хууль тогтоох байгууллага, захиргааны байгууллага болон шүүхийн байгууллагууд холимог байдлаар энэхүү эрхийг хэрэгжүүлэх болсон цаашлаад шүүхийн байгууллага дангаар хэрэгжүүлэх болсон тухайлбал, байнгын ажиллагаатай шүүх, үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн болон тусгайлсан сонгуулийн шүүх эсхүл эдгээр шүүх хамтран шийдвэрлэдэг болсон зэрэг өөрчлөлтүүд сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд гарчээ.

150. Мэдээж хэрэг, сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь өөр өөр байдаг нь эрх зүйн уламжлалын үр дүн, улс орнуудын хөгжил болон улс төрийн намуудын тусгай шаардлага, тэдгээрийн хоорондын зөвшилцөл зэргээс хамааралтай байдаг. Улс төр, түүхийн ялгаатай нөхцөл байдал бүхий улс орнуудад нэг ижил байдлаар шууд авч хэрэглэх ерөнхий нэг сонгуулийн маргаан шийдвэрлэх загвар, жишгийг тогтоох нь хүндрэлтэй. Гэхдээ харьцуулсан судалгааны тусламжтайгаар сонгуулийн ажиллагааг бүхий л талаас нь сайжруулахыг хүсэж байгаа аливаа оролдлого, сонгуулийн маргаантай холбоотой элементүүдэд дүн шинжилгээ хийх, тэдгээрийн хандлагыг танин мэдэх цаашлаад амжилттай хэрэгжсэн туршлага, сайн практик болон тухайн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны давуу болон сул талыг олж мэдэх боломжийг олгодог.

151. Ерөнхийдөө сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэх хандлага түгээмэл болжээ. Үүний дагуу сонгуулийн маргаан хуулийн дагуу Үндсэн хуулийн зарчимд нийцэж шийдвэрлэж чадах баталгаа болж байна. Ингэснээр сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хууль тогтоох болон улс төрийн хүчнүүд оролцож өргөн хүрээнд хохиролтой шалгуур болон үр дүнг нь тооцохгүйгээр зөвхөн өөрсдийн эрх ашигт нийцсэн улс төрийн зөвшилцөл хийх явдлаас зайлсхийх боломжийг олгож байна. Энэхүү

чиг хандлагаар сонгуулийн эцсийн шийдвэрийг гаргах эрхийг хууль тогтоох байгууллага, эсвэл түүний нэг танхимд олгодог (Жишээ нь АНУ болон Итали) бол, олон төрлийн сонгуулийн маргааныг шүүх шийдвэрлэхээс өмнө хууль тогтоох байгууллага шийддэг нь хууль тогтоох этгээдэд хүндрэлтэй байж болзошгүй бөгөөд шүүхийн шийдвэрээр улс төрийн шийдлийг нь эргүүлэх боломжтой байдаг. Энэ чиг хандлагын бас нэг үзүүлэлт нь сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын зарим гишүүдийг шүүх эрх мэдлийн салбарын байгууллагуудаас сонгон авах шаардлага тавьдаг, эсхүл шүүгчтэй адил шаардлага, журмаар томилдог, эсхүл тэдгээрийн ажиллах нөхцөл нь шүүхийн өндөр түвшний албан тушаалтантай ижил түвшинд байх шаардлагыг тавьдаг.

152. Сонгуулийн ажиллагааг хянах улс төрийн намуудын үүрэг роль ч мөн оорчлогдож байна. Төлөөллийн ардчилалын эхний үед улс төрийн намууд сонгууль зохион байгуулахад (сонгуулийн байгууллагад төлөөлөлтэйгээр) болон сонгуулийн маргааныг шийдвэрлэхэд оролцож, (зөрчил, маргаан шийдэх байгууллагад төлөөлөлтэйгээр) байжээ. Тэдний төлөөлөгчид сонгуулийн санал авах байранд болон сонгуулийн үе шат бүрт зохион байгуулах үүрэгтэйгээр оролцож маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, үүнтэй холбоотой шийдвэрийг гаргахад оролцдог байсан. Энэхүү сонгуулийн ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах идэвхтэй чиг үүрэг нь сонгуулийн эрх бүхий этгээдээр баталгаажсан үйл ажиллагааг хянах болон удирдах чиглэл рүү аажмаар оорчлогдсон. Улмаар зөвхөн санал өгөхөөс бусад асуудал дээр улс төрийн намууд оролцох болсон хэдий ч цөөхөн тогтолцоонд шийдвэр гаргах эрх мэдлийг өөр өөр үе шат болон холбогдох этгээдүүдэд суудал эзлэх боломжийг бүрдүүлэх тал дээр тодорхойлон өгсөн байдаг.

153. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгууль хүчинтэй эсэх талаар эцсийн шийдвэр гаргах болон мөн сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг хууль тогтоох байгууллагад, үүний аль нэг хороонд эсхүл улс төрийн эвсэлд олгосон байдаг. Францын уламжлалаар үүнийг “эрх мэдлийг баталгаажуулах” хэмээн нэрлэдэг бол АНУ-д уламжлалын дагуу “сонгуулийг шалгах болон гэрчлэх” гэж нэрлэдэг байна.

154. Энэ нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны нилээд эртний төрөл юм. Уг тогтолцоо нь анхлан Англид үүссэн Парламентын уламжлалаас үүдэлтэй хэдий ч 1868 онд Британийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь шүүхэд хамааралтай байсан юм. Хэдийгээр анхлан үүсэхдээ хууль тогтоогч нар сонгуулийн эцсийн

дүнг өөрсдөө баталгаажуулдаг байдлаар үүссэн бөгөөд энэ нь Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд ч зарим улс төрийн эвсэлд тухайн сонгуулийн үр дүнг баталгаажуулдаг хэвээр үлджээ (хоёр танхимтай парламентын системд танхимууд хамтран хуралдаж Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг баталгаажуулдаг). Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд улс төрийн эвслийг оролцуулах явдал нь анх Францад үүсэн бий болж, 18 дугаар зуунаас 1958 оны сонгуулийг хүртэл үргэлжилжээ. АНУ-д үүнийг 1787 оны Үндсэн хуулиар бий болгосон. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хууль тогтоох байгууллага эсвэл улс төрийн эвсэл оролцох нь 19 дүгээр зуунаас эхлэн 20 дугаар зууныг дамжин үргэлжилсэн ардчилсан ёсны нэг түгээмэл хэлбэр болсон.

155. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог хууль тогтоох байгууллагад хариуцуулах болсон түүх нь эрх мэдлийг хуваарилах зарчим дээр суурилсан бөгөөд засаглал бүр харилцан хамааралгүй, бие даасан шийдвэр гаргах боломжийг хангах зорилгыг хэрэгжүүлэх үүднээс ийнхүү сонгуулийн маргааныг хууль тогтоох байгууллага хариуцах нь зүйтэй гэж үздэг. Тухайлбал, хууль тогтоох засаглал нь гүйцэтгэх засаглалаас хараат бус байх шаардлагын дагуу ийнхүү хууль тогтоох байгууллагын бие даасан байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Энэ нь шүүх засаглалыг улс төрийн аливаа тэмцэл, маргаантай хугалдуулах, шүүх аливаа хэрэг, маргааныг мэргэжлийн үүднээс хууль ёсны дагуу шийдвэрлэх үндсэн чиг үүрэгт нь хохирол учруулахаас зайлсхийхэд чиглэгддэг байна. Цаашлаад, Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд хууль тогтоох байгууллага голлох үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн үзэл санааг баримтлагчид шүүхийн байгууллагын шийдвэр нь хууль тогтоох байгууллагын шийдвэрээс давуу хүчин чадалтай байх нь ардчилсан бус шинжийг агуулна гэж үздэг байна.

156. Хэдийгээр Үндсэн хууль болон бусад хуульд нийцэн сонгуулийн үйл ажиллагаа явагдах ёстой боловч хууль тогтоох болон улс төрийн эвслээр баталгааждаг сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндсэн шинж нь ямар ч хуулийн механизм болон хуулийн заалт улс төрийн шийдлээр гарсан шийдвэрийг баталгаажуулж чаддаггүй. Харин улс төрийн шалгуур болох ашиг сонирхлын аливаа зөрчлийг шийдвэрлэхдээ оппортунизм (эрх мэдэл, шударга бус давуу талыг олж авах оролдлого-opportunism) болон улс төрийн зөвшилцөлд тулгуурлан шийдвэрлэсэн улс төрийн аливаа шийдвэр нь хуулийн дагуу гарсан аливаа шийдвэрээс давуу эрхтэйгээр хэрэгждэг байна. Ийм шийдвэр нь олонхи болсон улс төрийн хүчний ашиг сонирхолд нийцэн гардаг. Хууль тогтоох байгууллага өөрийн гишүүдийн

сонгуульд нэр дэвшигчийн эрхийг баталгаажуулж, хууль тогтоох байгууллагын сонгуулийг хүчинтэй эсэх асуудлыг шийдвэрлэх үед шийдвэр гаргах эрхээ хэтрүүлсэн зүй бус үйлдлийн сүүлийн жишээ Их Британид 1868 онд, Францад 1958 онд гарчээ. Энэ эрхээ хэтрүүлсэн үйлдэл сонгуулийн маргааны талаарх шийдвэр гаргах эрхийг шүүхэд шилжүүлэхэд нөлөөлөх шалтгаан болжээ.

Мэдээлэл 5.3 Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо: Хууль тогтоох байгууллага эрхээ хэтрүүлсэн үйлдэл 1958 оноос өмнө Францад гарсан талаар

"Францад 1958 оноос сонгуулийн эрхийг баталгаажуулах эрхийг улс төрийн эвсэлд байсныг өөрчилж Үндсэн хуулийн консулд олгожээ. Улс төрийн намуудын эвсэлд энэхүү эрхийг олгож байсан нь урт удаан хугацааны түүхтэй байжээ. Эзэнт гүрний үед төрийн зөвлөлөөс энэхүү эрхийг болиулсан ч гэсэн, тухайн системийг 1814–15 онуудад дахин сэргээн Парламентын танхимд олгож Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын хувьд Үндсэн хуулиар статусыг нь баталгаажуулсан түүхтэй. Гэсэн ч 1940-өөд оны үеэс тухайн хууль тогтоох байгууллагаас энэхүү эрхээ зүй бусаар хэтрүүлэн ашиглах болсон байна. Үүний улмаас Дөрөвдүгээр Бүгд Найрамдах Улсын 1946 оны 10 дугаар сарын 27-ны Үндсэн хуулийн 8 дугаар зүйл дээр Парламентын хоёр танхим нэг бүр нь өөрийн сонгогдсон гишүүдийн эрхийг баталгаажуулах болохыг зааж өгсөн байдаг. Ингэснээр тухайн хуучин системийг нураасан байна. 1946-1958 оны үед эрх барьж байсан улс төрийн намууд хуулийг үл хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулж, тэдний гаргасан шийдвэр нь зөрчилтэй байснаас үүдэн хуулийн хэрэгжилтэд ихээхэн хүндрэл учруулж байжээ. 1946 онд тэд Үндэсний Ассемблейд сонгогдсон этгээдийн эрхийг хүчингүй болгож, тухайн хэрэглэж байсан систем нь 1946 болон 1951 онуудад гадаад нутаг дэвсгэрт болсон сонгуулийн үр дүнд сөргөөр нөлөөлж, олонхи болсон нам нь 1951-болон 1958 онуудад өөрсдийн суудлаа сэргээх боломжийг олгож байжээ. Ийнхүү сонгуулийн үр дүнг баталгаажуулахтай холбоотой асуудлаар өргөн хүрээний хэлэлцүүлэг явагдаж Үндэсний Ассемблейд итгэх итгэлийг сулруулж байжээ.

157. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хууль тогтоох байгууллага болон улс төрийн эвслээс эрхээ хэтрүүлэх явдлыг хязгаарлах зорилгоор сонгуулийн аливаа маргааныг шийдвэрлэх эрхийг нь шүүхэд өгч, харин сонгууль хүчинтэй байдал болон сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх талаарх эцсийн шийдвэр гаргах эрхийг хууль тогтоох байгууллагад үлдээсэн байдаг. Энэ нь ардчилсан зарчмаар сонгогдсон хууль тогтоох байгууллагын гишүүд нь сонгуулийн талаарх эцсийн шийдвэрийг гаргах эрхийг олгож байгааг "rule of law"-тай нийцүүлэх гэсэн оролдлого байсан. Гэвч зарим сонгууль нь ардчилсан мөн чанарт нийцэж байна уу гэдэг нь эргэлзээтэй юм. Практикт хууль тогтоох болон улс төрийн байгууллага нь улс төрийн шийдлийг эргүүлсэн, өөрчилсөн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх хэвийн бус тохиолдол байдаг бөгөөд энэ байдал нь магадгүй улс төрийн төлөөс өгөх шатгаан болж болзошгүй. Эдгээр сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь хууль тогтоох байгууллагын уламжлалт хязгаарлагдмал боломжтой холбоотой шинжийг одоог хүртэл хадгалж байдаг.

158. Зөвхөн хууль тогтоох байгууллага, эсхүл улс төрийн намуудад сонгуулийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой шийдвэр гаргах

онцгой эрхийг олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо өнөөдрийн практикт байдаггүй. Хууль тогтоох байгууллагын болон Ерөнхийлөгчийн сонгуульд энэ тогтолцоог ашигладаг улсууд нь ихэнхдээ холимог байдлаар ашигладаг үүнд (а) сонгуулийн үр дүнг бус сонгуулийн үйл ажиллагаа болон шийдвэрийг шүүх урьдчилан шийдвэрлэдэг (Аргентин болон Бельги улсууд), эсвэл сонгуулийн шийдвэр болон сонгуулийн үр дүнг шүүх шийдвэрлэх (АНУ, Итали, Латви, Литва, харин Дани, Нидерланд, Норвеги, Швейцар үүнд орохгүй); эсвэл (б) сонгуулийн үр дүнгийн талаарх хууль тогтоох байгууллагын шийдвэрийг шүүх хянан үзэх (Германд Үндсэн хуулийн шүүх нь үүнийг хэрэгжүүлдэг). Үүнээс дүгнэхэд хууль тогтоох-шүүх байгууллагын, хууль тогтоох-захиргааны байгууллагын, эсхүл шүүх-хууль тогтоох байгууллагын зэрэг сонгуулийн маргаан шийдвэрлэх холимог тогтолцоо байдаг.

159. АНУ нь хууль тогтоох-шүүх байгууллагын сонгуулийн маргаан шийдвэрлэх холимог тогтолцоотой. Муж улс бүрийн эрх бүхий байгууллагаас гаргасан журмын дагуу зохион байгуулагдсан холбооны сонгуультай холбоотой маргааныг ерөнхийдөө эхлээд муж улсын ердийн шүүх шийдвэрлэж (муж улсын шүүхийн шийдвэрийг Дээд шүүх нь хянан үзэж түүнийг Дээд шүүхээс албан ёсоор мэдэгддэг), дараагийн шатанд Төлөөлөгчдийн танхим эсвэл Сенат хэлэлцэн эцсийн шийдвэрийг гаргадаг. Түүнчлэн АНУ-ын Конгресс нь Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу Ерөнхийлөгчийн сонгуулийн саналыг тоолдог. Төлөөлөгчдийн танхим болон Сенатын олонхийн санал хураалтыг 1887 оны Сонгуулийн хуулийн дагуу явуулан, тухайн муж улсын гаргасан Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнтэй холбоотой шийдвэрийг өөрчилсөн байдаг. Орон нутгийн маргааныг муж улсын шүүхийн шийдвэр гарсны дараа түүнийг шилжүүлдэг.

160. Итали улсад ч нөхцөл байдал үүнтэй төстэй байдаг. Италийн 1948 оны Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд зааснаар парламентын танхим бүр (Төлөөлөгчдийн танхим эсвэл Сенат) өөрийн гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргах эрхийг эдлэх ба үүнтэй холбоотой гарсан аливаа маргааныг давж заалдах шатны шүүхийн нэг хэсэг болох Сонгуулийн төв хороо шалган шийдвэрлэдэг. Давж заалдах шатны шүүх нь тэргүүн шүүгч болон бусад 4 шүүгчээс бүрддэг. Холбогдох танхимын шийдвэрийн эсрэг ямар нэгэн шүүхийн хамгаалалт байдаггүй.

161. Үүний нэгэн адил Литва улсын Үндсэн хуулийн 105, 107 дугаар зүйлийн дагуу Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгчийн сонгууль болон хууль тогтоох байгууллага болох Сеймасын сонгуулийн зөрчилтэй

холбоотой шийдвэрийг гаргаж, Сеймас нь Үндсэн хуулийн шүүхийн гаргасан шийдвэрт үндэслэн эцсийн шийдвэрийг гаргадаг. Латви улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиар сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй Захиргааны хэргийн шүүхийг байгуулсан байдаг. Үндсэн хуулийн дагуу Сейма нь өөрийн гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх дүгнэлт гаргадаг.

162. Швейцарын холбооны улсад Үндэсний зөвлөл болон Муж улсуудын зөвлөл нь өөр өөрийн гишүүдийг сонгох сонгуулийн талаар эцсийн шийдвэрийг гаргадаг. Үүнээс өмнө санал тоолох болон сонгуулийн үр дүнг баталгаажуулахтай холбоотой маргааныг мужууд болох кантонуудын улс төрийн эрх бүхий байгууллага дээр шийдвэрлэдэг.

163. Аргентин (Мэдээлэл 5.4-ийг үзнэ үү) болон Швейцар улсуудаас гадна Бельги, Исланд, Голланд, Норвег улсуудад, мөн зарим социализмаас ардчилсан тогтолцоонд шилжих шилжилтийн үе дээрээ буй Төв болон Зүүн Европын орнуудад хууль тогтоох байгууллага нь өөрийн эрхийг хүлээн зөвшөөрөх тодорхой хугацааг тогтоодог. Хэрэв энэ хугацаанд сонгуулийн бүрэн эрхээ хүлээн зөвшөөрөх талаар ямар нэг шийдвэр гаргаж чадаагүй бол шүүх үүнийг шийдвэрлэдэг байна.

Мэдээлэл 5.4 Аргентин улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх хууль тогтоох-захиргааны байгууллагын холимог тогтолцоо

Аргентин улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх хууль тогтоох-захиргааны гэсэн холимог тогтолцоотой. Хууль тогтоох байгууллагын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнтэй холбоотой аливаа маргааныг үүнд хамруулан авч үздэг байна. Эдгээрээс бусад сонгуулийн үйл ажиллагаа болон шийдвэртэй холбоотой маргааныг Үндэсний сонгуулийн танхим шийдвэрлэх бөгөөд уг танхим нь шүүх эрх мэдлийн салбартаа харьяалагддаг. Сонгуулийн байгууллага буюу өөрийн бүрэлдэхүүнд шүүгч нарыг багтаасан захиргааны шинжтэй хэмээн тооцогдох тус хороо нь сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэсний дараагаар сонгууль хүчинтэй эсэх талаарх эцсийн шийдвэрийг хууль тогтоох байгууллага эсхүл улс төрийн эвсэл гаргадаг ажээ. Үндсэн хуулийн 1994 оны шинэтгэлийн дагуу Үндэсний Конгресс, түүний хоёр танхим нь Ерөнхийлөгчийн болон Дэд Ерөнхийлөгчийн шууд сонгуультай холбоотой зөрчил, маргааныг шийддэг байжээ. Үндэсний конгрессын хоёр танхимын сонгуулийн хувьд Депутатуудын танхим болон Сенат нь өөрийн гишүүдийн эрхийг хүчинтэй эсэхийг баталгаажуулдаг ба харин үүнийг шүүхийн байгууллага хянан үзэх шаардлагатай гэсэн маргаан гарсаар байдаг. Энэ нь Паттигийн хэргээс шалтгаалсан ажээ. (Хэрэг no. 4207/06 CNE, 2006 оны 9 дүгээр сарын 14 – Мэдээлэл 5.5-ыг үзнэ үү).

164. Эдгээр улсуудад сонгууль хүчинтэй эсэхийг баталгаажуулдаг байгууллагуудын шийдвэр гаргах эрх нь улс төрийн шинжтэй байдгаас үл хамааран, сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь чөлөөт, шударга, үнэн зүй ёсны сонгуулийг баталгаажуулж, энэхүү давуу байдал болон байр сууриа улс төрийн өшөө авалт болон улс төрийн тохиролцоонд ашиглахгүй

байх үүргийг хүлээдэг. Шүүхийн болон захиргааны олон төрлийн шинжийг агуулж байгаагаараа дээр дурдсан тогтолцоог сонгуулийн маргаан шийдвэрлэх холимог тогтолцоо гэж үздэг.

Мэдээлэл 5.5 Луис Паттигийн хэрэг: Аргентин

Льюс Патти нь 2005 онд Холбооны депутатын сонгуульд ялалт байгуулсан бөгөөд үүнийг Сонгуулийн хорооноос баталгаажуулсан байна. Гэсэн ч Депутатуудын танхим нь 2006 онд тухайн сонгуулийг хүчингүй болгон, түүнийг ёс суртахууны, шударга байдлын хувьд тэнцэхгүй хэмээн буруутгаж, хууль тогтоох байгууллагад ажиллахад хориг тавьсан байна. Патти нь энэхүү шийдвэрийн эсрэг зарга мэдүүлсэн ч түүний нэхэмжлэлийг шүүх хангаагүй байна. Улмаар Патти нь Үндэсний сонгуулийн шүүхийн танхимд давж заалдан, тухайн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулсан бөгөөд шүүхээс сонгуульд оролцон, өөрийн саналыг өгсөн хүмүүсийн саналыг хүндэтгэн үзэх шаардлагатай гэж үзсэн. Гэтэл үүнийг Конгресс нь өөрийн шийдвэрээр өөрчилж болохгүй хэмээн шийджээ (тухайн сонгогдсон төлөөлөгчийг анархист эсвэл социалист болох, эсвэл хүйсийн болон шашны үндсэн дээр гадуурхаж болохгүй). Дээд шүүхэд 2008 онд (Corte Suprema de Justicia de la Nación) нөгөө тал нь давж заалдсантай холбогдуулан тухайн сонгуулийн шүүх танхимын гаргасан шийдвэрийг баталгаажуулжээ. Депутатуудын танхим нь өөрийн гишүүдийн сонгуулийн үр дүнтэй хамаарах эрхийг өөрөө эдлэх эрхтэй хэмээн эсэргүүцэж, 2006 онд гаргасан шийдвэрээ хамгаалж байжээ. Тухайн үед Дээд шүүх энэхүү хэргийг авч хэлэлцэх үед Льюс Паттиг мөн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдсан хэрэг шийдэгдсэн байсан ч түүнийг шоронгоос суллах шийдвэр гаргаагүйн улмаас Дээд шүүхийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх боломжгүй болжээ.

б) Шүүхийн байгууллагад эрх олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо

165. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг хууль тогтоох болон улс төрийн намуудад олгосноор эрх мэдлээ хэтрүүлэх байдал бий болж байгааг хүлээн зөвшөөрч, эсхүл өөр өөр тогтолцоог нэвтрүүлэх нь сонгуулийн маргааныг Үндсэн хууль болон бусад хуулийг үндэслэн шийдвэрлэх сайн баталгаа болно гэж үзэн олон орнууд сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг гаргах эрхийг шүүхэд олгодог сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог сонгон авч хэрэгжүүлдэг. Энэхүү тогтолцоог анх Их Британид 19 дүгээр зууны сүүлээр хэрэгжүүлснээс хойш уг тогтолцоог дэлхий даяар хэрэглэж эхэлжээ. Энэхүү сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг шүүх, үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн шүүх эсвэл сонгуулийн тусгай шүүхэд олгох тогтолцоог өнөөдөр ардчилсан нийгэмтэй дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэглэх болжээ.

166. Шүүхийн байгууллагад тулгуурладаг сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоог дэмжигчид нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх, баталгаажуулах явдал үнэн хэрэгтээ шүүхийн үндсэн мөн чанарт нийцэх үйл ажиллагаа гэж үздэг. Ийм учраас сонгуулийг чөлөөтэй, шударга, үнэн зүй ёсны болон хүчин төгөлдөр болсныг баталгаажуулахын тулд шүүх сонгуулийн маргааныг шийдвэрлэх

эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэдэг. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийг зөвхөн хууль тогтоох байгууллага болон улс төрийн бүлэг, шүүгчид баталгаажуулдаг байдлаас зайлсхийдэг. Ялангуяа аливаа урьдчилан тохиролцсон парламентын олонхи нь хууль болон зүй ёсыг үл тоомсорлож өөрсдийн улс төрийн болон намын ашиг сонирхлын дагуу үйл ажиллагаа явуулах эрсдэлтэй байдаг. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг шүүх байгууллагад олгосноор Үндсэн хуулийн болон эрх зүйт хуулийн "rule of law"-гийн зарчимд нийцэж цаашлаад улс төрийн зорилго, ашиг сонирхлыг үндэслэн сонгуулийн маргаан шийдвэрлэгддэггүй байхад чиглэгддэг.

167. Энэ тогтолцооны тусламжтайгаар сонгуулийн маргаанд тусгайлан анхаарлаа хандуулдаг улс төрийн намууд, сонгуулийн ажилтнууд болон гуравдагч этгээдүүдийн хандлага болон бодлого, арга барил өөрчлөгддөг. Сонгуулийн маргаан шийдвэрлэхэд институцын арга барилыг илүүд үздэг. Эрх бүхий шүүхийн байгууллага тухайн маргааны талаарх нотолгоо болон нотлох баримтуудыг бүрдүүлж, тэдгээрийн хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрөхүйц болон үндэслэлтэй гэдгийг мэргэшсэн-хууль ёсны байх шаардлагад нийцүүлэн үнэлж, баталгаажуулна. Энэ байдлаас шалтгаалж сонгуулийн маргааныг бодитойгоор, шударгаар болон хуулийн дагуу шийдвэрлэхэд улс төрийн дэмжлэг болон улс төрийн эрхээ шилжүүлэх байдлыг ашиглах нь үр дүнтэй үндэслэл бөгөөд арга барил болж чаддаггүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг үзэл санаа нэмэгдсээр байна. Сонгуулийн хуулийг харилцан уялдаатай болон шинжлэх ухааны үндэслэлтэй гаргах нь сонгуулийн маргаан гарах нөхцөлийг урьдчилан харж түүнийг шийдвэрлэх боломжийг бүрдүүлснээр хуулийн тодорхой байдалд чухал ач холбогдолтой байдаг.

168. Хэдийгээр сонгуулийн маргаан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн ч шүүхийн салбар улс төрийн маргаанд оролцох нь аажмаар шүүхийн үйл ажиллагааны мөн чанар өөрчлөгдөх, шүүхийн салбар аажмаар сулрах, хүчгүй болох үр дүнд хүргэж болзошгүй гэсэн зарим үзэл санаа байдаг. Иймээс зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд ердийн бус шүүхүүдийн чиг үүрэгт сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааг хамруулдаг. Жишээ нь Үндсэн хуулийн шүүх, захиргааны дагнасан шүүхүүд болон сонгуулийн маргаан шийдвэрлэх тусгай шүүхүүдэд энэ эрхийг олгодог.

169. Сонгуулийн маргаан шийдвэрлэх шүүхийн гэх тогтолцоо нь сонгуулийн маргааны талаар эцсийн үр дүн эсхүл эцсийн шийдвэр

гаргаж байгаа гэдгээс шалтгаалж үндсэн 4 хэсэгт хуваагддаг.

Үүнд:

- Шүүхийн салбарын ердийн шүүх;
- Үндсэн хуулийн шүүх эсхүл консул;
- Захиргааны хэргийн дагнасан шүүх;
- Сонгуулийн тусгай шүүх.

(Мэдээлэл 5.2-ыг үзнэ үү).

i) Шүүх салбарын ердийн шүүх

170. Сонгуулийн маргаан шийдвэрлэх шүүхийн гэх тогтолцооны хамгийн тууштай эхний төрөл нь сонгуулийн маргаан, түүний үр дүнгийн талаарх эцсийн шийдвэрийг сонгуулийн асуудлаар тусгайлан мэргэшээгүй ердийн шүүхийн шүүгч эсхүл шүүх шийдвэрлэдэг жишиг юм. Ихэнх тохиолдолд сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэр гаргах эрхийг тухайн улсын Дээд шүүхэд олгодог бөгөөд маргааныг шууд Дээд шүүх хянан шийдвэрлэх, эсхүл доод шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан тохиолдолд энэхүү эрхийг Дээд шүүх хэрэгжүүлдэг.

171. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь 1868 онд (1983 онд шинэтгэл хийсэн) анх Их Британид бий болсон ба Нийтийн танхим дахь олонхийн гаргаж буй хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох зорилгоор анх уг шийдвэрийг гаргасан ажээ. Тухайн үед гарсан эрх зүйн баримт бичгийн дагуу сонгуультай холбоотой маргааныг шийдэх эрхийг Хатан хааны дээд шүүхийн (ротацын журмаар шүүгч нар нь солигдож байдаг) хоёр шүүгчид хариуцуулжээ. Мөн тухайн хоёр шүүгчийн гаргах шийдвэрийг Нийтийн танхим хэлэлцэн баталж Парламентын бүрэн эрхийг хангаж байхаар зааж өгсөн байна. Тухайн сонгогдсон шүүгчид нь Танхимын Спикерт ажлаа тайлагнаж, улмаар нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж байжээ. Хэрэв шүүгч нар тухайн гишүүний суудалд оор нэр дэвшигч томилогдох ёстой хэмээн үзсэн тохиолдолд Танхим нь тэдний шийдвэрийг даган биелүүлэх шат дараалсан арга хэмжээг авдаг байв. Тухайн үед хэдийгээр сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг шүүхийн салбарт шилжүүлсэн ч гэсэн Нийтийн танхим нь өөрийн гишүүнчлэлийн асуудлыг хариуцан шийдэж байжээ.

172. Австрали, Пакистан болон Ямайка гэх мэт Англи хэлтэй Карибын орнууд зэрэг хамтын нөхөрлөлийн орнуудад дээрхээс бага зэрэг ялгаатай оор нэгэн системийг авч хэрэгжүүлжээ. Энэхүү системийн

хүрээнд эцсийн шийдвэрийг сонгуулийн шүүх гаргах бөгөөд энэ шүүхийн шүүгч нар нь эхний хэлэлцүүлэг бүрийн дараагаар ротацын журмаар өөрчлөгддөг байна. Үүнтэй адилаар системийг Канад, Энэтхэг улсад хэрэгжүүлдэг ба үүний хүрээнд хууль тогтоох байгууллагын сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүх явуулдаг байна. Түүнчлэн Энэтхэг улсад Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр гарсан маргааныг Дээд шүүх шууд гардан шийддэг ажээ. Австрали, Канад болон Энэтхэг улсуудад хараат бус, бие даасан Сонгуулийн байгууллага нь сонгуулийн маргаан шийдэх системд гол үүргийг гүйцэтгэдэг.

173. Төв болон Зүүн Европын зарим орнууд дээр дурдсантай адил сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоотой. Жишээ нь Босни Герцеговина, Эстони, Унгар, Польш, Орос болон Серби улсуудад сонгуулийн үр дүнтэй холбоотой гарсан маргааны эцсийн шийдвэрийг Дээд шүүх нь шийдвэрлэдэг ба сонгуулийн өмнөх шатанд гарсан зөрчлүүдийг бие даасан сонгуулийн байгууллага эцэслэн шийддэг байна. Унгар, Орос зэрэг улсуудад сонгуулийн байгууллагын гаргасан зарим шийдвэрийг доод шатны шүүх нь шийдвэрлэдэг байна.

174. Этиоф, Кени, Лесото, Тайван, Уганда улсуудад хууль тогтоох байгууллагын сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг шүүхийн байгууллага гаргадаг. Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан тохиолдолд Дээд шүүх нь тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэдэг байна. Тайван, Уганда улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой маргааныг Дээд шүүх нь шийдвэрлэдэг. Тайванд Ерөнхийлөгчөөс бусад сонгуультай холбоотой бүх асуудлыг захиргааны хэргийн шүүх нь шийдвэрлэдэг уг шүүхийн шийдвэр нь эцсийн байдаг ажээ.

175. Япон, Киргизстан, Өмнөд Солонгос, Узбекистан, Вануату улсуудын хувьд хууль тогтоох байгууллагын сонгуультай холбоотой маргааныг Дээд шүүх нь шийддэг ба Япон, Киргизстан улсуудын Дээд шүүх нь тухайн маргааныг зөвхөн давж заалдах журмаар шийдвэрлэдэг бол Өмнөд Солонгос, Узбекистан, Вануату улсуудын Дээд шүүх нь сонгуулийн маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэдэг байна.

176. Дэлхий нийтээр хамгийн түгээмэл хэрэглэж буй сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо сонгуулийн үр дүнтэй холбоотой эцсийн шийдвэрийг ердийн шүүхээр шийдвэрлүүлдэг тогтолцоо юм. Ийм төрлийн сонгуулийн тогтолцоог сонгон авсан аливаа улс орон шүүх эрх мэдлийн салбарын хараат бус, бие даасан байдлыг юуны түрүүнд хангах шаардлагатай байдаг. Энэ нь ардчилалыг

шинээр бий болгож байгаа болон бэхжүүлж байгаа аливаа улс орнуудад амин чухал ач холбогдолтой юм. Шүүхийн салбарт итгэх итгэл, найдвар султай, тухайн салбар нь хараат бус байдлаа алдсан түүнчлэн гүйцэтгэх болон улс төрийн намын хяналтанд байдаг бол сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд ноцтой хор хохирол учруулах боломжтой байдаг.

ii) Үндсэн хуулийн шүүх болон консул

177. Дэлхийн 1 дүгээр дайнаас хойш (1914-1918) хэрэгжиж эхэлсэн Европын орнуудын олон Үндсэн хууль болон Австрийн 1920 оны загвар Үндсэн хууль нь сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олгосон бөгөөд зарим улсуудад энэхүү Үндсэн хуулийн шүүхийг шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг хэмээн тооцдог байсан бол зарим улсууд уг шүүхийг шүүхийн салбарт хамааруулдаггүй байна.

178. Австри улсад Парламентын сонгуулийн дүнг баталгаажуулах эрхийг 1920 оноос хойш Холбооны үндсэн хуулийн шүүхэд (Verfassungsgerichtshof) олгосон бөгөөд улмаар цаашид амжилттай шинэчлэл хийж ардчилсан зарчмуудыг тусгаж өгчээ (1929 оноос хойшхи бүх нийтийн санал асуулга, 1931 оноос хойш Ерөнхийлөгчийн сонгууль, орон нутгийн сонгууль). Энэхүү шүүхээс үндэсний Конгресс болон орон нутгийн парламентын сонгуулийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар цуцлах, дахин явуулах тухай шийдвэр гаргах эрхтэй байдаг.

179. Герман улс нь мөн ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоотой орнуудад хамаардаг. (Мэдээлэл 5.6-г үзнэ үү). Сонгуулийн дүнг баталгаажуулах эрхийг Бундестагт (Парламентын доод танхим хэмээн тооцогддог) олгосон байдаг. Түүний гаргах шийдвэрийг Холбооны Улсын хэмжээний Үндсэн хуулийн шүүхэд хандан давж заалдаж болдог. Энэ байдлаас харахад шүүхийн-хууль тогтоох байгууллагын аль аль сонгуультай холбоотой асуудлыг шийдвэрлэж болдог хосолмол тогтолцоотой байгаа боловч Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх нь эцсийн шийдвэр гаргаж байгаа учраас уг тогтолцоог шүүхийн систем давамгайлсан гэж хэлж болно.

Мэдээлэл 5.6 Герман улс дахь шүүхийн-хууль тогтоох байгууллагын хосолмол тогтолцоо: гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын сонгуулийн хяналт

Ралф Линднер

Герман улсын Холбооны сонгуулийн үйл ажиллагааг Холбооны сонгуулийн хянагч (Bundeswahlleiter), 16 lander-ийн сонгуулийн хянагч, (Landeswahlleiter) болон бусад хянагч (Kreiswahlleiter) нарын хамтаар хянаж байдаг. Холбооны сонгуулийн хянагч нь уламжлалын дагуу Холбооны статистикийн албаны дарга байх ба түүнийг Холбооны дотоод хэргийн яамнаас томилдог бол бусад хянагч нарыг мужуудын захиргаанаас томилдог. Хянагч нар нь өөрийн нутаг дэвсгэрийн сонгуулийн комиссын даргаар ажилладаг.

Холбооны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог Парламентын хороо (Wahlprüfungsausschuss) эрхлэн явуулж, тус хороонд Бундестагийн 9 гишүүн болон 9 депутат ажилладаг байна. Тухайн хороонд хандан шийдвэрлүүлээгүй ямар нэгэн зөрчлийн хувьд үүнийг зөвлөлдөх хороонд ханддаг байна. Тус хорооны гишүүдийг Парламент дангаараа сонгон, тус хороо нь гарсан бүх гомдлыг авч хэлэлцдэг. Тухайн хороонд Парламент дахь намуудын төлөөлөл багтдаг ажээ. Тус хорооны гаргасан бүх шийдвэрийг Үндсэн хуулийн шүүхэд хандан давж заалдаж болох ч иргэний зүгээс давж заалдах тохиолдолд дор хаяад тухайн нэхэмжлэлийг дэмжсэн 100 гарын үсэг цуглуулсан байх шаардлагатай.

Давж заалдах шатны эцсийн шийдвэр гаргадаг шүүх нь Үндсэн хуулийн шүүх хэдий ч сонгуулийн үйл явцыг гүйцэтгэх засаглал (Сонгуулийн байгууллагаар дамжуулан), Парламент (сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоор дамжуулан) хянаж байдаг. Маргаан шийдвэрлэх ажиллагаа нь хоёр жил хүртэл хугацаанд үргэлжилж болох ба (Хороон дээр нэг жил, Үндсэн хуулийн шүүх дээр нэг жил), зарим тохиолдолд илүү удаан үргэлжилж ч болно. Гомдлыг зөвхөн сонгууль дуусаж, парламент бүрдсэний дараа л гаргаж болох тул сонгуулийн өмнөх үе шатанд гарсан аливаа маргааныг сонгуулийн дараа шийддэг. Хэдийгээр энэхүү тогтолцоог өөрчлөх санал гарсаар байгаа боловч ийм төрлийн өөрчлөлт, шинэтгэл хийгдэх эсэх нь тодорхойгүй байна.

180. Францын Үндсэн хуулийн зөвлөл нь мөн л ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны нэг жишээ юм. Энэ байгууллага 1958 оноос хойш нь Ерөнхийлөгчийн сонгууль болон бүх нийтийн санал асуулгын дүнг баталгаажуулах эрхийг эдэлж ирсэн бөгөөд санал хураалтын дүнг зарлах, гарсан маргааныг шийдэх эрхийг эдэлдэг байна. Францын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь Үндсэн хуулийн болон захиргааны хосолсон төрлийн тогтолцоотой. Захиргааны шүүх нь хараат бус ажиллах бөгөөд Төрийн зөвлөлд харъяалагддаг бөгөөд сонгуулийн бэлтгэл ажлын үеэс эхлэн маргааныг авч хэлэлцэж болно. Үндсэн хуулийн шүүх нь Төрийн зөвлөлийн сонгуулийн бүртгэл, сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг хянан үзсэн тодорхой шийдвэрийн талаарх маргааныг шийдвэрлэдэг. Сонгогчдын бүртгэлтэй холбоотой тодорхой хэргүүд дээр гомдлыг анхан шатны (Tribunal d'instance) шүүхэд хандан шийдвэрлүүлдэг бөгөөд үүний дараагаар давж заалдах шатны шүүхэд мөн хандах боломжтой ба эдгээр шүүхүүд нь хоёулаа шүүхийн салбарт хамаарч, гаргасан шийдвэрүүд нэгэн адил эцсийнх байдаг.

181. Үндсэн хуулийн болон захиргааны шинж чанар бүхий сонгуулийн

маргаан шийдвэрлэх тогтолцоог Испани улсад хэрэглэдэг бөгөөд сонгуультай холбоотой эцсийн шийдвэрийг Үндсэн хуулийн шүүх гаргадаг. Энэ шүүх өмнө нь гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хянан үздэг. Өөр нэгэн жишээ нь Португал бөгөөд сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг Үндсэн хуулийн шүүх нь хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

182. Төв болон Зүүн Европын ардчилсан шилжилтийг хийж буй олон тооны улс орнууд өөрийн Үндсэн хуулийн шүүхэд сонгуулийн үр дүнтэй холбоотой эцсийн шийдвэрийг гаргах эрхийг олгосон байдаг. Эдгээр улсуудын тоонд Болгар, Хорват, Молдав, Монтенегро, Румын, Армени, Словени, Чех, Гүрж, Словак зэрэг улсууд багтах ба эдгээр улсуудын Үндсэн хуулийн шүүх нь шүүх эрх мэдлийн салбарт хамаардаг байна. Индонези, Нигер улсуудад сонгуультай холбоотой маргаан, зөрчлийг Үндсэн хуулийн шүүх нь шийдвэрлэдэг бөгөөд Индонезид энэ шүүх нь шүүх эрх мэдлийн салбартаа хамаардаг.

183. Буркина Фасо, Кампучи, Камерун, Казахстан, Мозамбик улсуудад Үндсэн хуулийн шүүх сонгуулийн асуудлыг эцэслэн шийддэг ч Үндсэн хуулийн шүүхийг шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг хэмээн тооцдоггүй.

iii) Захиргааны хэргийн шүүх

184. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гурав дахь төрөл буюу тийм ч түгээмэл бус ашигладаг төрөл нь сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхийг бие даасан эсвэл шүүх эрх мэдлийн салбарын харьяа захиргааны хэргийн шүүхэд олгодог.

185. Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллалгаа, шийдвэрийн эсрэг гаргасан сонгуулийн маргааныг зарим орнуудад уг маргааныг шийдвэрлэх харьяалал нь захиргааны хэргийн шүүхэд байдаг, мөн тухайн шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бүрэн хангах замаар Францын уламжлалын дагуу захиргааны хэргийн шүүхэд уг маргааныг шийдвэрлэдэг (Төрийн зөвлөл).

186. Захиргааны хэргийн шүүх сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоотой орнуудын жишээнд Колумб улс багтах ба тус улсад ердийн шүүхийн бүтцэд хамаардаггүй хараат бус Төрийн зөвлөл (Consejo de Estado) тухайн асуудлыг хариуцдаг. Өөр нэгэн жишээ нь Финланд улс бөгөөд Захиргааны хэргийн дээд шүүх нь (Korkein Hallinto- Oikeus) мужуудын захиргааны хэргийн шүүхийн (шүүх эрх мэдлийн салбарт хамаарах) гаргасан

шийдвэрийг давж заалдах гомдлыг үндэслэн сонгуулийн хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй байдаг.

Мэдээлэл 5.7 Иргэдийн гаргах гомдол Колумб улсад

Колумб улсад иргэд нь Төрийн зөвлөлд хандан сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргах эрхтэй бөгөөд үүний хүрээнд Сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэртэй холбоотой гомдлыг мөн гаргаж болдог. Тухайн гомдол нь үндэсний хэмжээний сонгуулийн санал тооллого, үр дүнг зарлах, эрхийг баталгаажуулахтай холбоотой байж болно. Төрийн зөвлөл нь сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэрийг цуцлах, өөрчлөх, засах эрх бүхий хараат бус захиргааны хэргийн шүүх юм.

iv) Чиг үүргийн хувьд хараат бус сонгуулийн дагнасан шүүх

187. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн холбогдолтой маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхийг сонгуулийн асуудлыг хариуцсан дагнасан шүүхэд олгосон байдаг ба тухайн шүүх нь чиг үүргийн хувьд хараат бусаар ажиллаж, шүүх салбарын нэг хэсэг байж, эсхүл засаглалын гурван хэлбэрээс хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг.

188. Ийм төрлийн тогтолцоо нь хамгийн анх Уругвай улсад 1924 онд Сонгуулийн шүүх байгуулснаар эхэлсэн түүхтэй. 1925 онд Чили улсын Сонгуулийн баталгаажуулалтын шүүхийг (Tribunal Calificador de Elecciones) тус улсын Үндсэн хуулиар бий болгожээ. Энэ төрлийн сонгуулийн шүүх 20 дугаар зууны туршид хөгжин, улмаар Латин Америкын ихэнх улсуудад байгуулагджээ. Үүнийг Латин Америкын орнуудын зүгээс дэлхий нийтийн улс төрийн шинжлэх ухаан, сонгуулийн хуулийн практикт оруулсан хувь нэмэр хэмээн үзэж болох ба энэ туршлага нь Латин Америкийн бүс нутгийн орнуудад ардчиллыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулсан. Ялангуяа “ардчилалын гурав дахь давалгааны” 1980-1990-ээд оны үеэр хамгийн өндөр үр дүнг үзүүлжээ.

189. Сонгуулийн дагнасан шүүх байгуулсан нь сонгуулийн холбогдолтой шүүхийн шийдвэрийг хамгаалах, өмнө нь хууль тогтоох байгууллагаас энэ эрхийг эдэлж байсныг тусгаарлах, улмаар энэхүү эрхийг Дээд шүүхэд олгох (шүүхийн салбар), улс төрийн нөлөөллийг бууруулах оролдлогын үр дүн байлаа.

190. Дээр дурдсан ангиллын шалгуурууд дээр үндэслэн авч үзвэл энэхүү ангилалд багтаж болох цорын ганц шүүх нь сонгуулийн дагнасан шүүх юм (хараат бусаар эсвэл шүүх эрх мэдлийн салбарын харьяанд байдаг). Энэ шүүх нь сонгуулийн дүнтэй холбоотой бүх асуудлыг эцэслэн шийддэг бөгөөд ямар ч бусад шүүхийн болон үндсэн

хуулийн шүүхийн шатны журмаар энэхүү шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар шийдвэрлэх эрхгүй байдаг байна. Ийм тогтолцоо нь Чили, Доминикан, Эквадор, Мексик, Перу, Албани, Грек, Палестин, Өмнөд Африк, Швед зэрэг улсуудад хэрэгждэг. Албани, Грек, Мексик улсуудын сонгуулийн шүүх нь тухайн улсын шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг байдаг бөгөөд дээр дурдсан бусад улсуудад энэхүү шүүх нь хараат бус байдлаар зохион байгуулагддаг. Гэхдээ энэ тогтолцоотой бүх улсуудын ийм төрлийн шүүх нь хараат бус чиг үүрэгтэй байдаг.

191. Сонгуулийн дагнасан шүүхээс гаргасан шийдвэрийг Үндсэн хуулийн зарчимд тулгуурлан Дээд шүүхэд давж заалдах боломжтой (Бразил, Сальвадор, Гондурас, Парагвай, Панам)-д байдаг. Мөн Үндсэн хуулийн шүүхэд уг сонгуулийн дагнасан шүүхийн шийдвэрийг давж заалддаг шүүхүүд (Боливи, Эквадор)-т байдаг. Түүнчлэн дээрх хоёр төрлийн тогтолцооны аль аль нь (Гватемал)-д байдаг бөгөөд үүнийг сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг шүүх эрх мэдлийн салбартаа хамааруулдаг, эсвэл Үндсэн хуулийн шүүхэд хамааруулдаг гэсэн ангилалд багтана. Энэхүү хэсэгт дурдагдсан сонгуулийн шүүхүүд нь (шүүх эрх мэдлийн салбарт хамаардаг Бразил, Парагвай улсуудаас бусад) хараат бус байдаг.

192. Энэхүү тогтолцоонд багтаагүй нэг төрлийн ангилал нь сонгуультай холбоотой бүхий л эцсийн шийдвэрийг гаргах эрхтэйгээс гадна сонгуулийн ажиллагааг зохион байгуулах, удирдах захиргааны чиглэлийн чиг үүргийг хэрэгжүүлдэг Сонгууль зохион байгуулах эрх бүхий этгээдтэй ижил төрлийн үүргийг хэрэгжүүлдэг сонгуулийн дагнасан шүүх юм. Ийм шүүхтэй орнуудын жишээнд Коста Рика, Никарагуа, Уругвай улсууд хамаарна. Энэ тогтолцооны онцлог нь тусгайлан сонгуулийн шүүх байгуулсан эсэхээс үл хамаардаг. Энэ байгууллага нь сонгууль удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй, үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус байдаг бөгөөд сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг энэ байгууллага баталгаажуулдаг байна.

193. Латин Америкийн олон улсуудад сонгуулийн дагнасан шүүх нь сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэдэг. Энэ бүс нутгийн ихэнх орнуудад сонгуулийн бие даасан, хараат бус байгууллага нь захиргааны, шүүхийн болон зохион байгуулах чиг үүргийг хамт хэрэгжүүлдэг. Харин зарим улсад бие даасан, хараат бус сонгуулийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дагнасан хоёр байгууллага байдаг. Үүний нэг нь сонгуулийг захиргааны талаас нь буюу сонгууль зохион байгуулах, удирдан чиглүүлэх болон хяналт тавих эрх бүхий

захиргааны байгууллага (сонгуулийн хороод), нөгөө нь сонгуулийн холбогдолтой зөрчил, маргаан болон сонгуулийн хорооны шийдвэрийг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага (сонгуулийн шүүх) байдаг. Сонгуультай холбоотой гомдлыг бие даасан, хараат бус сонгуулийн байгууллагад гарган (Чили, Доминикан, Эквадор, Перу), улмаар уг байгууллагын шийдвэрт гомдол гаргахдаа сонгуулийн шүүхэд хандан шийдвэрлүүлдэг тогтолцоотой улсуудыг сонгуулийн маргааныг шууд шүүх нь анхан шатны журмаар хүлээн авч шийдвэрлэдэг тогтолцооноос (Мексик болон Венесуэл) ялгах шаардлагатай байдаг: Латин Америкаас гадна Албани, Грек, Палестин, Өмнөд Африк, Швед зэрэг улсууд нь сүүлийн ангилалд багтдаг.

194. Албани улсад хараат бус сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын гаргасан сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг шүүхийн дээд зөвлөлөөс томилсон 8 шүүгчийн бүрэлдэхүүнтэй сонгуулийн дагнасан шүүх буюу Албаны сонгуулийн коллеж эцэслэн шийдвэрлэдэг. Грек улсад сонгуулийн маргааныг Ердийн шүүхийн салбараас томилогдсон шүүгчдээс бүрдэх Тусгай дээд шүүх (Ανωτάτο Ειδικό Δικαστήριο) шийдвэрлэдэг. Палестинд сонгуулийн маргааныг Дээд шүүхийн санал болгосноор Ерөнхийлөгчийн томилсон 9 шүүгчийн бүрэлдэхүүнтэй Сонгуулийн дагнасан шүүх шийдвэрлэдэг. Өмнөд Африкт 1999 онд байгуулагдсан Сонгуулийн шүүх сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг бол Шведэд Парламентын томилсон 7 гишүүний бүрэлдэхүүнтэй Сонгуулийн хяналтын хороо сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг. Өмнөд Африк, Швед болон Палестины сонгуулийн шүүх нь төрийн аливаа байгууллагаас хараат бусаар, бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг.

195. Зарим орнуудын дагнасан шүүхүүд нь байнгын ажиллагаатай байдаг бөгөөд шүүгчид нь төрийн өндөр албан тушаалтны зэрэглэлд хамаардаг байна. Ийм орны жишээнд дийлэнх Латин Америкын орнууд хамаарна. Харин зарим улс орнуудад сонгуулийн дагнасан шүүх нь зөвхөн сонгуулийн үеэр байгуулагдаж, түр хугацааны шинжтэй үйл ажиллагааг явуулдаг байна. Ийм орнуудад Албани, Чили, Грек ордог бөгөөд тухайн сонгуулийн дагнасан шүүхийн шүүгчдийн албан тушаал хаших хугацааны аюулгүй байдлыг нь хангахын тулд сонгуулийн хэрэг маргааныг шийдвэрлэх үүргээ гүйцэтгээгүй байх үед нь мөн түүний хараат бус байдлыг хамгаалах зохицуулалт хэрэгждэг. Сонгуулийн байнгын ажиллагаатай дагнасан шүүх байх нь мэргэжлийн өндөр түвшинд асуудлыг судлан, энэ салбарын орчин үеийн хөгжил, дэвшилд тулгуурлан энэ төрлийн маргааныг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэртэй бөгөөд сонгуулийн аль ч үе шатанд (эхний болон дараагийн аль

ч үед) маргааныг түргэн шуурхай шийдвэрлэхэд чухал гэж үздэг. Гэхдээ энэ нь маш их зардал өндөртэй байж болох юм. Сонгуулийн холбоотой гомдол, маргаан цөөн гардаг улс орнуудад сонгуулийн байнгын шүүхтэй байх тогтолцоог төдийлөн дэмждэггүй хандлагатай байдаг.

в) Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагад шүүхийн эрх мэдлийг олгодог Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо

196. Энэ төрлийн тогтолцооны хувьд Сонгууль зохион байгуулах эрх бүхий этгээд нь сонгууль удирдан зохион байгуулах болон сонгуулийн ажиллагааны бүхий л захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ сонгуулийн ажиллагааны хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах болон сонгуулийн талаарх маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн адил эрхтэй байдаг.

197. Энэхүү загварыг үндсэндээ Латин Америкын орнуудад авч хэрэгжүүлсэн. Энэ төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоор маргааныг зөвхөн эцэслэн шийдвэрлээд зогсохгүй мөн сонгууль хүчин төгөлдөр эсэх талаар эцсийн шийдвэр гаргадаг бөгөөд уг шийдвэрийг аливаа шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллага хянах эрхгүй байдаг.

198. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг олгодог улс орнуудын хараат бус сонгуулийг зохион байгуулах эрх бүхий этгээдэд Никарагуа улсын Сонгуулийн дээд зөвлөл (Consejo Supremo Electoral), Коста Рика улсын Сонгуулийн дээд шүүх (Tribunal Supremo de Elecciones) болон Уругвай улсын Сонгуулийн шүүх болон Туркын Сонгуулийн дээд зөвлөл (Yüksek Sesim Kurulu Başkanlığı) зэрэг байгууллагуудыг нэрлэж болно. Никарагуа улсын Үндсэн хуулиар Сонгуулийн дээд зөвлөлийг сонгуулийн засаглалыг хэрэгжүүлэх байгууллага гэж заажээ. Коста Рика улсын Үндсэн хуулиар Сонгуулийн дээд шүүхэд энэхүү маргаан шийдвэрлэх эрхийг олгосон байдаг бол Уругвай улсын Үндсэн хуулийн дагуу Сонгуулийн шүүхийг байгуулан, бүтцийг тогтоон түүнийг дөрөв дэх засаглал хэмээн хууль ёсоор заасан байдаг.

199. Энэ бүлэгт жишээ болгон оруулсан зарим улсын сонгуулийн шүүхийн шүүгчид болон гишүүд нь шүүх эрх мэдлийн салбарын шүүгчдийн адил ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдсан байдаг. Тэдгээр нь сонгуулийн үйл ажиллагааг зохион явуулах захиргааны эрх, үүргийг хэрэгжүүлдэг гэдгээрээ хараат бус сонгуулийг зохион байгуулах эрх бүхий этгээд гэдэгт хамаарахын зэрэгцээ мэргэжлийн

талаас нь авч үзвэл шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага гэж авч үзэх боломжтой.

200. Өмнөх хэсэгт дурдсан сонгуулийн дагнасан шүүхтэй харьцуулбал шүүх эрх мэдэл бүхий сонгуулийг зохион байгуулах эрх бүхий этгээд нь сонгуультай хамааралтай шийдвэр гаргадаг бүх байгууллагын үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой маргааныг шийдвэрлэх эрхгүй зөвхөн сонгуулийн доод шатны байгууллагын шийдвэртэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг. Түүнчлэн гаргасан шийдвэрийг нь Дээд шүүх эсвэл Үндсэн хуулийн шүүх хянан үздэг сонгуулийн дагнасан шүүхээс ялгаатай нь шүүх эрх мэдэл бүхий сонгуулийн байгууллагын шийдвэр нь эцсийнх байдаг.

201. Ерөнхийдөө шүүх эрх мэдэл бүхий сонгуулийн байгууллага нь пирамид бүтэцтэй байдаг. Дээд байгууллага нь үндэсний хэмжээнд өндөр түвшний байгууллагадаа төвлөрсөн байдлаар хамаардаг харин бусад дунд түвшний байгууллагууд нь дараагийн шатны байгууллагадаа хамаардаг. Ихэнх тохиолдолд тэдгээр нь нутаг дэвсгэр, засаг захиргаа, улс төр болон сонгуулийн тойрог, хэсгүүдийн зарчмаар хуваагдаж (ихэнхдээ бүсийн, улсын, орон нутгийн, хотын, дүүргийн хэмээдэг) эцсийн шат нь иргэд ирж саналаа өгдөг санал авах байрууд хүртэл үргэлжилдэг.

202. Уругвай улсын тогтолцоог онцгойлон дурдаж байна. Энэ улсад 1997 онд хийгдсэн шинэтгэлээр Сонгуулийн шүүх сонгуультай холбоотой үйл ажиллагаа, процедур болон улс төрийн намуудаас ерөнхийлөгч болон парламентад нэр дэвшигчийг (хоёр сонгууль энэ улс даяар зэрэг явагддаг) сонгох дотоод сонгуулийн шийдвэр цаашлаад улс төрийн намууд удирдлагаа сонгосон шийдвэртэй холбоотой аливаа маргааныг хүртэл хянан шийдвэрлэх зохицуулалтыг оруулжээ. Сонгуулийн шүүх нь үндэсний хэмжээний сонгуулиас гадна улс төрийн намын дотоод сонгуультай холбоотой маргаан, тэдгээрийн дүрэм, журмыг зөрчсөн талаарх гомдлыг хянан үзэж шийдвэр гаргадаг. Уг шүүхийн шийдвэрийг нь давж заалдах боломжгүй байдаг.

203. Латин Америкт сонгуулийг гадны нөлөөлөл ялангуяа төрийн гурван засаглалд хамаарах байгууллагуудын нөлөөллөөс хамгаалах сонирхол нэмэгдэж байгаа. Чөлөөт, шударга, үнэн зүй ёсны сонгуулийн гол баталгаа нь сонгуультай холбоотой асуудал, тэр дундаа сонгуулийн маргаан шийдвэрлэх хараат бус, бие даасан эрх бүхий этгээд болох шүүхтэй адил эрх мэдэл бүхий хараат бус сонгуулийн байгууллага бий болгон сонгуулийн үйл ажиллагааны

явцад гарах аливаа маргааныг шийдвэрлүүлэх явдал гэж олон улс орнууд үздэг.

204. Туркын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар Сонгуулийн дээд хороо нь (Yüksek Seçim Kurulu Başkanlığı) сонгуулийг эхнээс нь дуустал нь шударга, эмх цэгцтэй явуулах бүхий л үүргийг хүлээхээс гадна хууль бус шийдвэрүүдийн талаар гарсан маргааныг мөрдөн шалгах, санал хураалтын үеэр болон дараа гарсан гомдол, маргааныг шийдвэрлэх болон Туркын үндэсний ассемблейд сонгогдох гишүүдийг баталгаажуулдаг. Тус хорооны гаргасан шийдвэрт гомдол гаргадаггүй байна.

205. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг хараат бус сонгуулийн байгууллагад олгож, энэ байгууллага нь нилээд амжилттай бөгөөд үр дүнтэйгээр ажиллаж байгаа тохиолдлын жишээнд Коста Рика болон Уругвай улсууд хамаарна. Эдгээр улсуудад өөрийн гэсэн дагаж мөрдөх хэм хэмжээний тогтолцоог бий болгон, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах гишүүдийн ур чадварыг сайн бүрдүүлжээ. Эдгээр нь өөрийн сонгуулийн маргааны шийдвэрлэх тогтолцоондоо ардчиллыг хэрэгжүүлж, шилдэг туршлагыг бий болгож чадсан жижиг улс орнуудад хамаарна. Тэдний энэхүү амжилтад нөлөөлж буй нэг хүчин зүйл нь тухайн улсуудад улс төрийн соёл нэлээд өргөн хүрээнд нэвтрүүлсэн явдал бөгөөд тэд Латин Америк дахь ардчиллын зарчим болон үнэт зүйлийг бүрдүүлэхийн төлөө хамгийн ихээр хичээл зүтгэл гаргаж буй орнууд юм. Эдгээр орнуудын сонгуулийн шүүхүүд нь олон жилийн туршид үйл ажиллагаа явуулахдаа энэхүү улс төрийн соёлыг бий болгож чаджээ.

206. Хэдийгээр хараат бус байгууллага ч гэсэн эрх мэдлээ урвуулан ашиглаж болзошгүй, ялангуяа энэ байгууллагын шийдвэрт гомдол гаргах боломжгүй учраас сонгуулийн байгууллагад шүүхтэй адил эрх мэдлийг бүрэн хэмжээгээр эдлүүлэх талаар сайтар судлан, нухацтай авч үзэх шаардлагатай. Сонгуулийг зохион байгуулах болон сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх үүргийг зөвхөн нэг байгууллага хэрэгжүүлэх нь өөрөө эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг бүрдүүлдэг. Олон тооны сонгуулийн маргаан сонгуулийн байгууллагын үйл ажиллагаа, процедур, шийдвэрээс үүдэлтэй байдаг учир сонгуулийн маргааныг хууль тогтоох байгууллага шийдвэрлэхээс илүүтэй шүүх шийдвэрлэх нь зүйтэй гэж үздэг үзэл санаанууд байдаг нь мөн л энэхүү тогтолцоог эсэргүүцэж байгаа нэг хэлбэр юм.

207. Гэсэн хэдий ч хараат бус, бие даасан сонгуулийн хороо

нь сонгуулийн ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэхэд боломжтой байгууллага гэж тооцогддог гэж чөлөөт, шударга сонгуулийн шалгуурын тунхаглал (Мэдээлэл 5.1-ийг үзнэ үү)-д дурджээ.

208. Сонгуулийн хороо итгэл, найдвартай ажиллахад олон төрлийн хүчин зүйлүүд нөлөөлж байдаг. Эдгээрийн дундаас ялангуяа энэ байгууллагын гишүүдийг сонгох, томилох тогтолцоо, мөн тэдгээрт хүлээлгэх хариуцлага болон хариуцлага тооцох боломж нь хуулийн дагуу байх явдал юм. Эдгээрийг энэхүү гарын авлагын 6 дугаар бүлэгт дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийж оруулсан. Үр дүнтэй гэж хэлж болох нэг хандлага нь хараат бус сонгуулийг зохион байгуулах эрх бүхий болон шүүхийн байгууллагууд хоёулаа сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхтэй байдаг хосолмол тогтолцоо юм. Энэ тогтолцоогоор маргааныг сонгуулийн байгууллага буюу захиргааны байгууллага эхлэн авч үзэж, тодорхой шийдвэр гаргаад түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл хараат бус шүүхэд хандаж шийдвэрлүүлдэг боломжийг бүрдүүлдэг. Сүүлийн үед бий болж байгаа сонгуулийн хуулийн зарим тогтолцооноос авч үзэхэд сонгуулийн олон маргааныг захиргааны байгууллага шийдвэрлэж улмаар энэ шатандаа уг шийдвэр биелэгдэж байгаа нь шүүхийн ачааллыг бууруулахад нөлөөлж байна. Зарим оронд дагнасан сонгуулийн шүүх байгуулах нь хамгийн оновчтой хувилбар гэж тооцогддог бол зарим оронд санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалж ийм төрлийн шүүх байгуулахад хүндрэлтэй гэж үздэг.

г) Түр шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага (ad hoc body)-аар буюу сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлүүлдэг тогтолцоо

209. Эцэст нь, түр хугацаагаар болон шилжилтийн үед тогтвортой бус үйл ажиллагаа явуулдаг байгууллагаар сонгуулийн маргааныг шийдвэрлүүлдэг сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны /шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлүүлдэг тогтолцооны/ талаар авч үзье. Энэ төрлийн тогтолцоог чөлөөт, шударга болон үнэн зүй ёсны сонгуулийг баталгаажуулах зорилгоор ноцтой зөрчил, мөргөлдөөн болсон улс орнуудад олон улсын байгууллагын санхүүжилтээр зохион байгуулдаг. Жишээ нь 1993 онд Кампучи улсад, 1996 онд Босни Герцеговина улсад, 2008 онд Балба улсад энэ тогтолцоог хэрэгжүүлж байжээ. Ийм төрлийн тогтолцооны нэг чухал шинж нь сонгуулийн маргааныг түр зуурын байгууллага шийдвэрлэх мөн чанарт тулгуурласан байдаг: тухайн улсад тогтвортой, байнгын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо бий болох хүртэл буюу шилжилтийн үед тусгайлсан нэг болон хэд хэдэн

сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлүүлэхэд ашигладаг.

i) Олон улсын оролцоотой байгуулагдсан түр байгууллага

210. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн үйл ажиллагаа, үр дүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэхийн тулд түр байгууллага байгуулдаг. Энэ түр байгууллага нь өөрөө сонгуулийг зохион байгуулах эрхтэй түр байгууллагатай ижил байж болох ч заавал ийм байх шаардлагагүй байж болно. Ийм төрлийн хувилбарыг нэг болон хэд хэдэн олон улсын байгууллагууд санхүүжүүлдэг. Тухайлбал, НҮБ, ЕАБХАБ, Америкын улсуудын холбоо зэрэг байгууллагууд зөрчил, мөргөлдөөний дараах шилжилтийн нөхцөл байдалтай орнуудад ийм төрлийн санхүүжилт үзүүлдэг. Түр байгууллага нь ихэнхдээ олон улсын байгууллагуудаас томилогдсон гишүүдийг оруулдаг. Гол зорилго нь ямар нэгэн бүлэг, салбарыг үл орхигдуулсан чөлөөт, шударга, бодит сонгуулийг явуулахад оршино. Ийм түр байгууллага нь 1993 онд Кампучи, 1996 онд Босни Герцеговина, 2001 онд Зүүн Тимор, 2005 онд Афганистан улсуудад амжилттай ажилласан юм.

ii) Дотоодын үндэсний институц байдлаар байгуулагддаг түр байгууллага

211. Зарим тохиолдолд зарим улс орон өөрийн шилжилтийн үеийн дотоод асуудлаа шийдвэрлэх зорилгоор нэг болон хэд хэдэн онцлог сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх эрх бүхий түр байгууллагыг байгуулдаг. Уг байгууллагыг улс төрийн гол хүчнүүдийн гэрээ хэлэлцээр болон зөвшилцлийн дагуу байгуулдаг. Ийм гэрээ, зөвшилцлийг ноцтой зөрчил, мөргөлдөөний улмаас сонгуулийн байгууллагын чиг үүргийнхээ дагуу ажиллаж чадахгүй болсон болон Үндсэн хуулийг хэрэгжүүлж чадахгүй болсон тохиолдлуудад байгуулдаг. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу шилжилтийн, үндсэн хуулийн эсвэл бусад хуулийн болон мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд байгуулсан эв нэгдлийн гэрээ, хэлэлцээр зэрэгт үндэслэдэг. Ийм байгууллагыг тухайн улсын иргэдийн оролцоотойгоор сонгуулийг шударга, чөлөөтэй, хуулийн дагуу явуулах зорилгоор зохион байгуулдаг.

212. Ийм нөхцөл байдал Балба улсад болсон. Энхийн гэрээ байгуулсны дараагаар Ассемблейн шүүхийг 2006 оны Ассемблейн сонгуулийг зохион явуулахад зориулан байгуулж, тухайн сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэж байжээ. Үүний үр дүнд хоёр

жилийн хугацаатай Ассемблейг байгуулан энэ хугацаанд шинэ Үндсэн хуулийг боловсруулах үүргийг хүлээлгэсэн байна. Эцэст нь тусгайлсан түр шүүхийг Дээд шүүхийн гишүүн гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд үүнтэй хамт сонгууль зохион байгуулах үүрэг бүхий байгууллагыг байгуулан ажиллуулсан.

213. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гол шинж нь түр бөгөөд шилжилтийн шинжтэй байдаг. Түр байгууллага нь тухайн сонгуультай холбоотой маргааныг сонгуулийн үед болон тодорхой үйл ажиллагаа явуулах хугацаандаа шийдвэрлэдэг. Ийм төрлийн байгууллага нь хууль тогтоох, шүүхийн эсхүл захиргааны байгууллагууд байж болох бөгөөд энэ бүлэгт дурдсан асуудлууд мөн хамаарна.

214. Энэ төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн ажиллагаа, үр дүнгээс нь хамааралтайгаар ноцтой зөрчил, мөргөлдөөн үүсэж, үүнээс үүдэн гарсан маргааныг дараа нь тусгайлан шийдэх шаардлага бүхий нөхцөл байдлаас ялгаатай. Үүний жишээнд АНУ-д 1876 онд болсон хэрэг явдал, 2007 онд Кени улсад болсон хэрэг явдал зэрэг багтана. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хуулийг даган мөрдөж, хуулийг дээдлэх нь чухал хэдий ч улс төрийн намуудад сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх тал дээр үүссэн зөрчлийг хуульд нийцүүлэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал байдаг. Энэ тохиолдолд тухайн гарч болох үр дагавар, хүчирхийллээс зайлсхийхийн тулд ийм төрлийн маргааныг шийдвэрлэх шүүхийн бус арга замыг ашиглах нь үр дүнтэй байдаг (Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх арга замыг 8 дугаар бүлгээс харна уу).

БҮЛЭГ 6

БҮЛЭГ 6

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны зарчмууд болон баталгаанууд

1. Танилцуулга

215. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ямар төрлийн тогтолцоог сонгосон гэдгээс үл хамааран тухайн тогтолцоо нь чөлөөт, шударга, үнэн зүй ёсны сонгуулийг явуулахад чиглэгдсэн тодорхой зарчмууд болон баталгаануудыг хангасан байх шаардлагатай. Эдгээр зарчмуудыг сонгуулийн маргааны талаархи анхны шийдвэр гаргахаас эхлүүлээд, сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үе шат бүрт, цаашлаад сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий этгээдээс сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг гаргах хүртэл хэрэглэх шаардлагатай.

216. “Зарчим” гэдэг нь хуулийн зохицуулалт болон түүний салбар, институцын хүрээнд баримтлах дээд хүчин чадалтай ёс зүйн болон улс төрийн үнэт зүйлийг хэлнэ. Энэ нь сонгогчдын хувьд ерөнхийд нь харин сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээдийн хувьд тусгайлан дагаж мөрдөх стандарт болон итгэл, дэмжлэгийг бий болгодог. Энэхүү зарчмуудыг баримталж, хэрэгжүүлснээр зөвхөн хууль ёсны байдал, ёс суртахуун болон улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох төдийгүй мөн тухайн үйл ажиллагаа нь туршлага дээр үндэслэсэн зорьсон зорилгодоо хүрэх магадлалыг нэмэгдүүлж байдаг. Иймээс “Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны зарчмууд” нь хуульд чанд нийцсэн чөлөөт, шударга, үнэн зүй ёсны сонгуулийн баталгаа болоход тусалдаг суурь үнэт зүйлс гэж тодорхойлогддог.

217. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд хоёр үндсэн зарчмыг баримтлах шаардлагатай байдаг. Үүнд шударга, чөлөөт, үнэн зүй ёсны сонгуулийг явуулах болон бүх нийтийн сонгуулийн эрхийг хангах зарчим хамаарна. Үүнээс гадна Үндсэн хуульд захирагдах, хуульд нийцсэн байх, шүүхийн хараат бус байдал, хууль ёсны үйл ажиллагаа болон эрхийг хамгаалах чадварын зарчим зэрэг олон төрлийн эрх зүйн хүрээнд хэрэглэгддэг нийтлэг зарчмууд мөн хамаарна. Цаашлаад, сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны тусгай зарчмууд мөн хамаарна. Тухайлбал, шийдвэр нь эцсийн бөгөөд эргэлт буцалтгүй байх, сонгуулийн дараалсан үе шатууд дахь шийдвэр нь эцсийн байх ёстой. Сонгуулийн тодорхой үе шатууд нь дуусаж байж дараагийн үе шатанд шилждэг байх (жишээлбэл, сонгуулийн бэлтгэл үе шат дуусаад дараагийн үе шат нь эхлэнэ). Өөрөөр хэлбэл, сонгуулийн тухайн үе шат дуусаж, дараагийн үед шилжсэн байхад өмнөх үе шатанд гарсан аливаа үйлдэл, шийдвэрийн талаархи маргааныг дараагийн үе шатанд авч хэлэлцэхгүй байх зарчим юм (жишээлбэл сонгуулийн өдөр болон сонгуулийн дараагийн үе шат зэрэгт хамаарна). Гэхдээ зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үед энэ зарчмыг өөрөөр авч хэрэглэдэг. Жишээ нь сонгуулийн байгууллага нь нэр дэвшигчдийг бүртгэх болон нэр дэвшүүлэхдээ тухайн нэр дэвшигч нь хуульд заасан шаардлагад нийцсэн шалгуурыг хангасан эсэхийг сонгуулийн бэлтгэл үе шатанд нягталдаг. Харин зарим СМШТ-нд ийнхүү нягтлах ажлыг сонгуулийн дараа, сонгуульд ялсан гэдгийг зарлахын өмнө дахин шалгадаг тохиолдол байдаг.

218. “Баталгаа” гэдэг нь хуулиар хамгаалагдаж, хуулиар тогтоосон сонгогчдыг төлөөлөх байгууллагын үнэт зүйлс, эрх болон дэг журмыг баталгаажуулах, сахих, хамгаалах, дэмжих, аюулгүй байдлыг хангах аливаа хуульд нийцсэн хөшүүрэг, арга хэрэгслийг хэлнэ. Энэхүү баталгаагаар сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны бүтцийн болон процедурын хувьд сонгууль нь хуулийн дагуу явагдах мөн шударга, чөлөөтэй болон үнэн зүй ёсны явагдах цаашлаад сонгуулийн эрхийг хамгаалах болон сэргээн тогтоох баталгааг хангаж өгдөг. Энэ утгаараа сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь ардчилал, “эрх зүйт хуулийн” зүй ёсны (rule of law) зарчмыг сахих зэргийг хамарсан баталгааг үндэслэдэг.

219. Үр дүнтэй сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндсэн баталгаа нь хууль бус үйл ажиллагааг хүчингүй болгох, цуцлах, оорчлох болон хүлээн зөвшөөрөх замаар засан залруулах боломжтой эрх зүйн хамгаалалт юм. Бусад механизмуудаар хууль зөрчигчдөд хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагын тогтолцоог

тодорхойлж, уг хариуцлагыг ногдуулдаг. (Зураг 2.1-ийг үзнэ үү). Зүй ёсны зохистой зохион байгуулалтын загвар нь тухайн үнэт зүйлсийг хамгаалах болон түүнийг хэрэгжихэд сайн нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлдэг; тухайлбал, сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь нэгээс дээш гишүүнтэй байснаар энэ байгууллага хараат бусаар, бие даан ажиллах зарчмыг ханган ажиллах боломжтой болдог.

220. Сонгуулийн гомдлыг хүлээн авах анхан шатны байгууллага Сонгууль зохион байгуулах байгууллага байх нь түгээмэл байдаг. Тухайлбал, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай нэр дэвшигч болон улс төрийн намаас гаргасан гомдлыг хүлээн авах анхан шатны байгууллага нь энэ байгууллага байдаг. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоор гомдол шийдвэрлэх сонгуулийн байгууллага эсхүл, дээд түвшний албан тушаалтнаас өмнө захиргааны маргааныг шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн байдаг. Хэрэв улс төрийн нам, нэр дэвшигчдийг татгалзсан нь баталгаажсан, бусад улс төрийн болон нэр дэвшигчээс уг маргааныг эсэргүүцсэн тохиолдолд эрх бүхий дээд түвшний этгээд эсхүл байгууллага нь маргааныг хүлээн авч шийдвэр гаргадаг. Шүүхийн байгууллага-ердийн шүүх, үндсэн хуулийн шүүх, захиргааны шүүх эсхүл, сонгуулийн шүүх энэхүү маргааны талаархи эцсийн шийдвэрийг гаргадаг. Зарим тохиолдолд сонгуулийн маргааныг шүүх хоёр шатаар шийдвэрлэдэг. Тухайлбал, эхлээд ердийн шүүх маргааныг шийдвэрлээд дараа нь үндсэн хуулийн шүүх шийдвэрлэдэг. Харин сонгууль зохион байгуулах байгууллага сонгуулийн маргааныг эхэлж шийдвэрлээд дараагийн шатанд нь шүүх шийдвэрлэдэг тогтолцоо нь түгээмэл байдаг.

221. Үүнтэй нэгэн адилаар, сонгуулийн маргаан шийдвэрлэх олон тогтолцоонд сонгуулийн өдөр сонгуулийн байранд гарсан аливаа хууль бус үйл ажиллагаа болон албан ёсны санал тооллогын үед улс төрийн намууд, эсхүл нэр дэвшигчид нөлөөлөхийг оролдсон зөрчил, түүнтэй холбоотой маргааныг сонгууль зохион байгуулах дээд түвшний байгууллага нь шийдвэрлэдэг. Энэ байгууллага нь ерөнхийдөө хууль бус үйл ажиллагааг залруулах эрхтэй байдаг. Зарим төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн албан ёсны дүнгийн талаар гомдолтой байгаа улс төрийн намууд болон нэр дэвшигчдээс шүүх (ердийн шүүх, Үндсэн хуулийн шүүх, захиргааны болон сонгуулийн шүүх)-д хандах эрхийг нь хангасан байдаг. Ийм тогтолцооны хувьд сонгуулийн маргааныг анхан шатны журмаар ердийн эсхүл, сонгуулийн шүүх хянан шийдвэрлэж харин Үндсэн хуулийн шүүх нь уг маргааныг давж заалдах журмаар хянан шийдвэрлэж, түүний шийдвэр эцсийн байдаг. Харин зарим төрлийн

сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хувьд хууль тогтоох байгууллага нь сонгуулийн дүнг хүчинтэй эсэх болон түүний дүнгийн талаарх маргааны эцсийн шийдвэрийг гаргадаг.

222. Зарим төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хувьд хэд хэдэн сонгуулийн маргааныг хэд хэдэн арга, механизмаар шийдвэрлэдэг ч тохиолдол нийтлэг байдаг. Үүнд: Сонгуулийг зохион байгуулах эрх бүхий этгээд, шүүх, цөөхөн тохиолдолд хууль тогтоох байгууллага шийдвэрлэдэг. Хэдийгээр улс орнуудын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонууд нь өөр өөр төрлийн арга механизмаар маргааныг шийдвэрлэдэг ч гэсэн сонгуулийн бүхий л үйл ажиллагаа, процедур болон шийдвэр нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх зарчмыг хангахын тулд сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны “зарчим” болон “баталгаа”-тай уялдсан байх шаардлагатай.

223. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны “зарчмууд” болон “баталгаанууд” нь “эрх зүйт хууль”-ийн дагуу Үндсэн хуулийн ардчиллын үндсэн шинж чанарт нийцсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог харгалзан үздэг. Энэ зарчим, баталгаануудын зорилго нь олон улсын үүрэг, стандарт, “шилдэг туршлага” болон хамгийн бага нөхцөлийг шаардсан шалгуурыг бий болгож байгаагаар тодорхойлогддог. Эдгээр зарчим, баталгааг тодорхойлж байгаа нь бусад туршлага болон практикийг хориглох зорилгогүй харин сонгууль нь чөлөөтэй, шударга, үнэн бөгөөд хуулийн дагуу явагдах нөхцөлийг бэхжүүлэх зорилготой.

224. Сонгуулийн үйл явцад оролцож байгаа иргэд, нэр дэвшигчид, улс төрийн намууд, хэвлэл мэдээлэл, эрх баригчид бүгд сонгуулийн хуулийг өөрсдийн үүрэгт нийцүүлэн сайн дураар даган мөрддөг. Гэсэн хэдий ч сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн хуулийг зөрчсөн аливаа тохиолдол болон сонгуулийн хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь баталгаажуулах шаардлагыг бий болгодог. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн үйл ажиллагаа, процедур болон шийдвэрүүд хуульд нийцсэн байхад дэмжлэг үзүүлдэг чухал хэлбэрийг баталгаажуулдаг.

225. Сонгуулийн маргааныг хууль ёсны дагуу шийдвэрлэгдэх баталгааг бий болгох зорилготой арга хэмжээний дотор бүтцийн болон процедурын баталгаануудыг дурдаж болно. Бүтцийн баталгаануудад СМШЭ-дүүдийн төвийг сахисан, хараат бус болон бие даасан байдлыг баталгаажуулах (жишээ нь гишүүдийг нь сонгох, томилж процедур) зэрэг хамаардаг. Процедурын баталгаа

нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үр дүн болон үр ашгийг баталгаажуулж, цаашлаад зүй ёсны сонгуулийн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлж сонгуулийн маргааныг шийдвэрлэх хөшүүргийг хангахад туслах хууль зүйн арга хэмжээ болдог. (жишээ нь зүй ёсны сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлэх болон түүний үр дүнтэй баталгааг бий болгодог).

2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо (СМШТ)-г бий болгох чиг хандлага

226. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог бий болгосон анхны ардчилсан дэглэмд сонгуулийг баталгаажуулах эцсийн шийдвэрийг хууль тогтоох байгууллага өөрөө гаргах эрхтэй байсан. Гэсэн хэдий ч 19 дүгээр зууны сүүлийн 30 гаруй жилд сонгуулийн маргааныг шүүх шийдвэрлэдэг сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо Их Британид бий болсон. Үүний хүрээнд парламентын сонгуультай холбоотой маргааныг ердийн шүүх шийдвэрлэх болсон (171 дүгээр хэсгийг үзнэ үү). Улмаар 20 дугаар зуунд сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг шүүх эрх мэдлийн байгууллагад (анхан шатны, Үндсэн хуулийн, захиргааны хэргийн болон тусгайлсан сонгуулийн шүүхүүдэд) шилжүүлсэн байдаг. Мөн шүүхтэй адил эрхтэй СЗББ-д болон шилжилтийн үеийн түр ажиллагаатай байгууллагад ийм эрхийг шилжүүлж эхэлсэн байдаг. Ерөнхийдөө сонгуулийн маргааныг шүүх шийдвэрлэх хандлага зонхилж байна.

227. Шүүхээс сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийнхээ дагуу уг маргааны талаар эцсийн шийдвэр гаргах албан ёсны эрхийг шүүх эдэлж болдог. Хэдийгээр сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг хууль тогтоох болон улс төрийн байгууллагууд гаргах эрхтэйгээр зарим тогтолцоонд байдаг ч тухайн маргааны хувьд эцсийн шийдвэрийг шүүх л гаргадаг. Үүнд сонгуулийн дүнтэй холбоотойгоос гадна сонгуулийн бэлтгэл үе шатны үеэр гарсан маргаан мөн хамаарна. Түүнчлэн улс төрийн намуудын дотоод үйл ажиллагаанд хамаарах удирдлага болон нэр дэвшигчийг сонгох, дотоодын дэг журмыг тогтоох зэрэг асуудлаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэх эрхтэй улс орнуудын тоо өсөж байгаа. Үүний жишээнд Аргентин, Болив, Коста Рика, Герман, Мехсик, Пурто Рико, Испани болон АНУ орно. Сонгуулийн маргааныг шүүх шийдвэрлэдэг тогтолцооны өөр нэгэн үзүүлэлт нь сонгуулийг зохион байгуулдаг болон түүнд хяналт тавих эрхтэй байгууллагуудад шүүхтэй адил хянан шийдвэрлэх эрх мэдэл олгож, улмаар эдгээр байгууллагын албан хаагчид нь шүүгчтэй адил арга замаар томилогдож, шүүгчтэй адил шаардлага болон баталгаагаар хангагдаж шүүгчтэй адил

өндөр түвшинд ажилладаг байна. Шүүхэд суурилсан сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хандлага нь 20 дугаар зууны эхэнд ялангуяа нийтийн эрх зүйн системтэй орнуудад сонгуулийн маргааныг ердийн шүүх шийдвэрлэх болжээ. Улмаар уг хандлагыг өөр эрх зүйн системтэй орнууд цаашлаад дэлхий нийтээр өөрийн тогтолцоондоо авч хэрэгжүүлсэн байдаг. Дэлхийн 1 болон 2 дугаар дайны дараагаар сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олгох явдал түгээмэл болсон үүнд Европ тивийн хэд хэдэн орон, Ази болон Африкын орнууд хамаарна. 20 дугаар зууны сүүлийн үе буюу ардчиллын гурав дахь давалгаанаас хойш хугацаанд сонгуулийн дагнасан шүүхээр сонгуулийн маргааныг шийдвэрлэх нь түгээмэл болсон. Үүнийг Латин Америк, Африк, Ази болон Европын зарим орнуудын жишээнээс харж болно .

228. Шүүхийн үйл ажиллагаанд суурилсан сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хүний эрхийн үр дүнтэй хамгаалалт байдаг. Энэ нь хараат бус, бие даасан болон хуулиар өмнө нь тогтоосон баталгаанд үндэслэгддэг бөгөөд олон улсын хүний эрхийн холбогдолтой хэд хэдэн баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг. (Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын 1966 оны гэрээ, заалт 2(3)(а) and 14(1) дурдагдсан заалтуудад нийцүүлэн, зохистой баталгааг хангах боломжийг бий болгожээ).

229. Шүүхийн үйл ажиллагаанд суурилсан сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндэслэл нь сонгуулийн маргааныг Үндсэн хууль болон бусад хуульд заасан зарчмын үндсэн дээр хуульд нийцүүлэн шийдвэрлэхэд оршино. Сонгуулийн маргааныг улс төрөөс ангид байдлаар шийдвэрлэх ёстой байдаг. Энэ талаар хууль тогтоох байгууллага болон улс төрийн байгууллага сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхтэй байдаг СМШТ-нд илүүтэй яригддаг. Мөн улс төрийн нам, сонгуулийн ажилтнууд болон бусад гуравдагч талуудын хандлагаас ихээхэн хамаардаг болохыг харьцуулсан эрх зүйн туршлага харуулсан байдаг. Ийм төрлийн тогтолцоог үндсэн утга агуулгаар нь авч үзвэл тухайн маргаанд холбоотой бодит нөхцөл байдал, нотолгоо болон нотлох баримтыг хуулийн-мэргэжлийн шаардлагад нийцүүлэн боломжит байдлаар шүүхэд гаргаж өгдөг.

230. Улс төрийн асуудлыг шийдвэрлэх шүүхийн ажиллагаа нь улс төрийн үйл ажиллагаатай адил биш харин энэ ажиллагаа нь улс төрийн шалгуурт суурилдаг. (Улс төрийн үйл ажиллагааны нэг жишээ нь зарим төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд улс төрийн байгууллагууд эсхүл, хууль тогтоох байгууллагууд нь сонгуульд

оролцох гишүүдээ баталгаажуулж, тэдний талаар дүгнэлтийг гаргаж байдаг.) Эдгээр хоёр ойлголтын талаар маш тодорхой зааг ялгааг бий болгох шаардлагатай. Бодит байдал дээр сонгуулийн маргаан нь улс төрийн асуудал байдаг. Иймд сонгуулийн маргааны талаар гарах шүүхийн шийдвэр нь улс төрийн бодлого, ашиг сонирхол болон зорилгод үндэслэж гардаг. Уг шийдвэр нь хуульд нийцсэн байх ёстой. Энэ утгаараа эрх мэдэл нь учир шалтгаанаас үүдэлтэй харин учир шалтгаан эрх мэдлийг үүсгэдэггүй. Ийм учраас сүүлийн үед хуулийн аргументын суурь ач холбогдол онол болон практикийн хоёуланд нь хөгжиж байна. Тухайлбал, шүүхээр сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь илүүтэй хөгжиж байна. СМШЭ-ийн ач холбогдол нь сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий этгээдийн шийдвэр олон нийтийн хатуу хяналтанд байхыг ойлгоно. СМШТ-ны найдвартай байдал нь сонгуулийн шийдвэрийн бат бөх суурь болон үндэслэлээс хамаардаг.

231. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гүйцэтгэдэг хяналт, ялангуяа шүүхийн хяналт нь улс төрийн хяналтаас ялгаатай хэд хэдэн шинжтэй.

- Энэ нь бодит үндэслэлтэй бөгөөд хяналтын стандарт нь урьдчилан тогтоосон хэм хэмжээгээр тогтоогддог харин уг хяналтыг хийж байдаг байгууллага нь өөрөө тогтоодоггүй.
- Хууль зүйн үндэслэлд суурилдаг харин улс төрийн үндэслэлд суурилахгүй.
- Энэ талаарх шийдвэрийг заавал даган мөрдөх шаардлагатай байдаг. сонгуулийн маргаан шийдвэрлэх шүүх тогтолцооны үед тухайн маргаан хэзээ гарсан байхаас үл хамааран шүүхийн хяналт үйлчилж байх ёстой.
Хараат бус бөгөөд бие даасан этгээд маргааныг шийдвэрлэх эрхтэй байхаар зааж, эрх зүйн маргааныг шийдвэрлэх тусгайлсан техникийн чадавхитай байх шаардлагатай.

232. Шүүхийн журмаар сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн маргааныг гурваас доошгүй шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх шаардлагатай байдаг (шүүхийн анхан болон эцсийн шатанд аль алинд нь энэ хамааралтай). Ялангуяа сонгуулийн маргаан шийдвэрлэх хамгийн дээд түвшний этгээдийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг хэрэгжүүлснээр тухайн эрх бүхий этгээд хараат бусаар бие даан ажиллах баталгааг бүрдүүлэхэд тусалж, бие даан ажиллах цаашлаад бусад хувийн баталгаа тухайлбал, үүргээ ухамсарлах болон хариуцлага хүлээх чадварыг бий болгодог.

3. СМШЭ-ийн баримтлах зарчим болон бүтцийн баталгааны загвар

233.Зүй ёсны сонгуулийн эрх зүйн нэгэн суурь хэсэг нь “бүтцийн баталгаа”, “шүүхийн баталгаа” байдаг. Эдгээр баталгаа нь СМШЭ-ийн зүгээс төрийн бусад байгууллага, улс төрийн нам, бусад сонгуулийн үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдээс хараат бус, бие даан ажиллахыг баталгаажуулсан эрх зүйн механизм юм. Энэ нь СМШЭ-ээс маргааныг объектив байдлаар, хараат бусаар шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

234.Дээр дурдсан “бүтцийн” болон “шүүхийн баталгаа”-ны талаар шүүхийн (анхан шатны, Үндсэн хуулийн, захиргааны болон тусгайлсан сонгуулийн шүүхийн) тогтолцоонд суурилсан СМШТ-нд илүүтэй авч үздэг. Энэ баталгааг бусад сонгуулийн маргааны шийдвэрлэхэд оролцдог этгээдүүдэд авч хэрэглэх боломжтойг зөвлөж байна. Тухайлбал, сонгуулийн байгууллага, олон улсын байгууллага, түр байгууллага, тэр ч байтугай хууль тогтоох байгууллага ч хэрэглэж болно. Уг баталгааг авч хэрэгжүүлэх нь сонгуулийн маргааныг чиг үүргийн хувьд хараат бусаар, хуулинд нийцүүлэн шийдвэрлэх үндсэн зорилготой байдаг.

Хууль тогтоох болон Засгийн газрын харьяа сонгуулийн байгууллага дээрх баталгааны хувьд илүү хэцүү ч тэдэнд энэхүү эрхийг олгосон тохиолдолд тэд бүх зарчмыг нэг бүрчлэн даган мөрдөж өөрийн үйл ажиллагааг хараат бусаар явуулдаг. Хууль тогтоох байгууллага болон ЗГ-ын харьяа сонгуулийн байгууллагын хувьд энэ нь зарчмын хувьд ихээхэн хүндрэлтэй. Гэхдээ тухайн байгууллагууд нь сонгуулийн маргаан шийдвэрлэх функцийг мөн хүлээдэг ба үйл ажиллагааны хувьд хараат бус гэдгийг найдвартай ханган ажилласнаар сонгуульд итгэх итгэл, түүний хууль ёсны байдлыг хангана. Түүнчлэн тусгайлсан сонгуулийн шүүхэд олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь энэхүү хараат бус байдлын баталгааг илүүтэй хангадаг.

235. Бүтцийн болон шүүх эрх мэдлийн баталгаа нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гол удирдах зарчим байдаг. Эдгээр зарчмуудын тоонд сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдлыг хуулиар зааж өгөх, үүнд гишүүдийн хараат бус байдлыг хангах, байгууллагын эргэн тайлагнах байдал болон хариуцлагын хууль зүйн үндэслэлийг бий болгох, гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа болон шударга байдал, санхүүгийн хараат бус, тогтвортой байдал зэрэг багтана (Мэдээлэл 6.1-ийг үзнэ

үү). Үүнтэй холбоотойгоор Бүлэг 4, 6 болон 7 нь хараат бус байдлыг хангах талаарх гол мэдээлэл, зарчмыг тусган харуулсан, сонгуулийн байгууллагатай холбоотой олон зарчим, баталгаанд дүн шинжилгээ хийсэн юм.

Мэдээлэл 6.1 Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндсэн зарчмууд

- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдал;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус, бие даасан байдал;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага, гишүүдийн хариуцлага, эргэн тайлагнах байдал;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн мэргэжлийн ур чадвар, шударга байдал;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын санхүүгийн хараат бус, тогтвортой байдал.

а) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдал

236. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдлыг хангахад хууль, эрхзүй хамгийн гол тулгуур болж өгдөг. Мөн тус байгууллагын хараат бус байдал нь иргэний улс төрийн эрхийг хангах гол тулгуур болж өгдөг байна. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага, тэр дундаа сонгуулийн холбогдолтой захиргааны зөрчил, гэмт хэргийг мөрдөн шалгах албаны үйл ажиллагаа, функцын хараат бус байдал нь шударга, үр нөлөөтэй, хараат бус шийдвэрийг гаргах үндэс суурь болно.

237. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь тухайн улсынхаа шүүхийн байгууллагын нэг хэсэг байхын зэрэгцээ, олон тооны улс орнуудад Үндсэн хуульд заасан баталгааны хүрээнд сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог бусад этгээдүүдэд (Үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн шүүх, тусгайлсан сонгуулийн шүүх, хараат бус сонгуулийн байгууллага болон түр байгууллага) олгодог. Тэдгээр нь засаглалын уламжлалт салбаруудаас (хууль тогтоох, гүйцэтгэх) өргөн хүрээний үйл ажиллагааг явуулж, хараат бус байдлыг хангадаг болно.

238. Үндсэн хуулийн шүүх нь үндсэндээ засаглалын бусад салбарын адил Үндсэн хуулиар олгогдсон хэм хэмжээ, статустай байдаг. Шүүх эрх мэдлийн харьяанд байдаг сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллагыг Үндсэн хуулийн байгууллага хэмээн үзэх ба зарим улсад засаглалын нэг салбар хэмээн үздэг. Үүний жишээ нь Никарагуа улсын Сонгуулийн дээд зөвлөл (дээр дурдагдсан) нь өөрийн улсдаа

сонгуулийн засаглал (Poder Electoral) буюу дөрөв дэх засаглал хэмээн нэрлэгддэг (Хэсэг 198-ыг үзнэ үү) ба энэ жишээ мөн Венесуэл улсад байдаг.

239. Орчин үеийн Үндсэн хуулийн онолоор сонгуулийн маргааныг шийдвэрлэх Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан байгууллага (Үндсэн хуулийн шүүх, хараат бус захиргааны болон сонгуулийн шүүх эсвэл бие даасан сонгуулийн байгууллага) нь засаглалын гурван салбараас хараат хэмээн үздэг. Гэхдээ хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн хүрээгээр дамжуулан шууд бусаар олгосон хараат бус байдлыг Үндсэн хууль хангадаг хэдий ч тухайн засаглалын салбарын аль нь ч энэхүү дөрөв дэх салбарын оршин тогтнох, үйл ажиллагаа явуулахыг хориглож чадахгүй юм.

240. Шүүх эрх мэдлийн салбарт сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх мэдэл олгосон улсуудад энэхүү эрх мэдэл нь Үндсэн хуулиар баталгаажсан. Энэ нь Латин Америкт түгээмэл байдаг ба тусгайлсан сонгуулийн шүүхийн баталгаан дээр мөн төвлөрч байдаг.

Мэдээлэл 6.2 Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хараат бус байдлын баталгаа

- Хараат бус байдлыг Үндсэн хуулиар олгосон;
- Үйл ажиллагааны хараат бус байдал;
- Захиргааны болон зарим тохиолдолд санхүүгийн хараат бус байдал.

ii) Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хараат бус байдлын талаарх Үндсэн хуулийн болон заншлын хуулийн заалтууд

241. Үндсэн хуулийн болон заншлын хууль тогтоомж, хэм хэмжээнд ихэнхдээ сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь өөрийн үйл ажиллагааг явуулахдаа хараат бус байна гэдгийг шууд зааж өгсөн байдаг. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гүйцэтгэж буй үйл ажиллагааны ач холбогдлоос аваад үзвэл тэдний үйл ажиллагааны хараат бус байдал нь амин чухал юм.

242. Шүүх эрх мэдлийн салбар дахь ердийн шүүхэд эрхийг нь олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь (Хэсэг 170-176-г үзнэ үү) Үндсэн хуулиар заагдсан хараат бус байдалтай байдаг. Жишээ нь 'Шүүх нь тусгайлсан эрх мэдлийг эдлэх бөгөөд засаглалын бусад салбараас хараат бус байна' (Польш); 'Шүүх нь хараат бус байх бөгөөд зөвхөн Үндсэн хууль болон хуульд захирагдана'

(ЗүүнТимор); ‘Шүүх эрх мэдлийн тогтолцоог дахин зохион байгуулсан, үүний гишүүдийн эрхийг хязгаарласан хуулийг батлан гаргахыг хориглоно’ (Филиппин); ‘Шүүх нь тусгайлсан эрх мэдлийг эдлэх бөгөөд, засаглалын бусад салбараас хараат бус байна’ (Польш); ‘Шүүх нь хараат бус байх бөгөөд зөвхөн Үндсэн хууль болон хуульд захирагдан, хараат бус байдалтай байна. Шүүх эрх мэдэл нь тусдаа байх ба хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалаас хараат бус үйл ажиллагаа явуулна’ (ОХУ) хэмээн заасан байдаг.

243. Шүүх эрх мэдлийн салбарын хараат бус байдлыг заасан Үндсэн хуулийн заалтууд нь мөн сонгуулийн маргаан шийдвэрлэх Үндсэн хуулийн шүүхэд олгосон улсуудад хамаардаг (Хэсэг 181–182-ыг үзнэ үү). Жишээ нь “Шүүхийн хараат бус байдлыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулна” (Армени); “Шүүх нь хараат бус байж, зөвхөн хуулинд захирагдана” (Португал); эсвэл “Шүүх эрх мэдэл хараат бус байж хууль, зүй ёсыг тогтоохын тулд шүүх эрх мэдлийн харилцааг эрхлэн явуулах ба ... Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлнэ” (Индонези). Заримдаа бүр тусгайлсан заалтууд байх бөгөөд жишээ нь “Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хэрэгжилтийг хамгаалах үүрэг бүхий хараат бус шүүх эрх мэдлийн байгууллага байна” (Словак).

244. Шүүх эрх мэдлийн салбарт хамаарахгүй хэмээн Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг заасан Үндсэн хуулийн заалт байх нь түгээмэл бус ч тухайн байгууллага нь Үндсэн хуулиар олгосон эрх ямба, статустай байдаг нь шүүх эрх мэдлийн дээд байгууллагатай нэг адил байж, гишүүд нь Дээд шүүхийн гишүүдийн адил хэмжээний эрхийг эдэлдэг болохыг хэсэг 298-д дурдсан.

245. Захиргааны хэргийн шүүхэд сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг олгосон тохиолдол байдаг. Жишээ нь, Колумб улсын Захиргааны хэргийн хууль тогтоомжийн 5 дугаар зүйлд ‘Шүүх эрх мэдлийн салбар нь өөрийн Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг болон захиргааны хууль зүйн үүргээ биелүүлэхэд хараат бус байна’ хэмээн заасан байдаг. Үүний нэгэн адил Финлянд улсын захиргааны хэргийн шүүхэд сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг олгосон байдаг. Жишээ нь, Колумб улсын Захиргааны хэргийн хууль тогтоомжийн 5 дугаар зүйл.

246. Тусгайлсан сонгуулийн шүүхэд сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг олгосон тогтолцооны жишээнд Мексик улс багтана. Тус улсын Үндсэн хуулийн 99 дүгээр зүйлд “Мексикийн холбооны улсын шүүх эрх мэдлийн салбарын харьяа Сонгуулийн шүүх нь (Tribunal Electoral

del Poder Judicial de la Federaciyn) Дээд шүүхийн эрхлэн шийдэх ёстой сонгуулийн хууль болон үүнтэй холбоотой хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцэж буйг шийдэхээс бусад сонгуулийн холбогдолтой асуудлуудыг эрхлэх дээд байгууллага байна.” хэмээн заасан байдаг. Түүнчлэн Үндсэн хуулийн 17 дугаар зүйл дээр “Шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулах статусыг бий болгон, Холбооны шүүх эрх мэдлийн салбарын органик хууль дээр заасан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлнэ.” хэмээн заажээ.

247. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг сонгуулийн байгууллагад олгосон тогтолцооны хувьд Коста Рика улс орно. Тус улсын Үндсэн хуульд “Сонгуулийн дээд шүүх дангаар хариуцах үйл ажиллагаа, зохион байгуулалт, чиглэл болон хяналтын үүргээ биелүүлэхдээ хараат бус байх эрхийг эдэлнэ” хэмээн заасан байдаг.

ii) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал

248. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь ямар нэг байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаанаас хараат бус байж, бусад байгууллагад институцын хувьд хамаарахгүйгээр үйл ажиллагаа явуулах хараат бус эрхийг эдэлдэг. Өөрийн үүргээ биелүүлэхдээ ямар нэг байгууллагын (дээрээ болон доороо) өмнө хуулиар заасан үүрэг биелүүлэх ёсгүй. Зөвхөн Үндсэн хуульд буй хамаарах заалтуудад захирагдаж үйл ажиллагаа явуулах ёстой. Сонгуулийн маргаан шийдвэрлэх хэд хэдэн тогтолцоон дээр үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахдаа тус байгууллагын гаргасан шийдвэрийг эцсийн хэмээн үзэж, үүнийг авч хэлэлцэх, оорчлох ямар нэг дээд бүтэц байхгүй болохыг зааснаар хангаж байдаг.

249. Гэхдээ хэрэг дээрээ тухайн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь шүүх эрх мэдлийн салбарт хамаарч байдаг бөгөөд шүүх эрх мэдлийн салбарын хувьд Дээд бүтэц нь Дээд шүүх байдаг. Харин энэ нь сонгуулийн шүүхийн хувьд заавал Дээд шүүхэд захирагдана гэсэн үг биш хэдий ч шүүх эрх мэдлийн салбарт хамаарч байдаг утгаараа сонгуулийн шүүхийн хувьд заавал Дээд шүүхэд захирагдаж байх ёстой байдаг.

250. Ерөнхийдөө сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг байнгын, хараат бус байгууллагад ноогдуулах нь сайн гэж үздэг боловч сонгуулийн хуулиар сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагыг сонгууль дууссаны дараагаар үйл ажиллагаа явуулах эрхгүйгээр байгуулж болдог.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх байнгын байгууллага нь санхүүгийн хувьд үргэлж асуудал үүсгэж болох ч сонгуулийн бус үеэр гарч болох сонгуультай холбоотой ямар нэгэн маргааныг шийдэх зардалтай харьцуулан үзэх шаардлагатай.

251. Хэд хэдэн орон өөрийн сонгуулийн хуулиар зохих заавар, журмыг боловсруулан гаргаж мөрдөх эрхийг Сонгуулийн шүүхийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагад олгосон байдаг. Зарим орны сонгуулийн шүүхүүд нь журам гаргах эрх бүхий байдаг ба үүнд Мексик улс багтана. Энэхүү эрхийг мөн сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий сонгуулийн байгууллагад олгосон байдгийн жишээнд Доминикан, Сальвадор, Гамби, Уругвай болон Йемен улсууд багтаж байна.

252. Түүнчлэн зарим улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь сонгуулийн холбогдолтой хууль санаачлах эрхтэй байдаг бөгөөд жишээ нь Эквадор болон Перу улсууд үүнд багтана. Бусад улсуудад сонгуулийн холбоотой асуудлууд болон хууль хэлэлцэх үед хууль тогтоох байгууллага нь сонгуулийн байгууллагын саналыг харгалзан үзэх хуулиар хүлээсэн үүрэгтэй байдаг. Жишээ нь Коста Рика улсад Сонгуулийн Дээд шүүхийн гаргасан саналыг няцаахын тулд хууль тогтоох байгууллагын гишүүдийн гуравны хоёрын дэмжлэг заавал шаардлагатай байдаг ажээ.

253. Мөн зарим улсад Дээд шүүхдээ сонгуулийн маргаан шийдвэрлэх зарим тогтолцооны дүрэм, журмыг гаргах эрхийг олгосон байдаг. Мексикийн холбооны улсын Шүүх эрх мэдлийн салбарын Сонгуулийн шүүхийн Дээд танхим нь бүсийн танхимуудын хоорондын зөрчилдөөнтэй асуудлыг, ижил төстэй хэргүүдийг шийдэхдээ нэг хандлагыг баримтлан, улмаар цаашид баримтлах шалгууруудыг зааж өгдөг. Энэхүү тогтоосон шалгуур, жишгийг цаашид сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо болон сонгуулийн байгууллага үйл ажиллагаандаа мөрддөг байна. Энэ нь эрх зүйн тогтолцоонд байдаг түгээмэл практик бөгөөд ийм төрлийн хууль зүйн тогтолцоонд заавал бичигдээгүй ч гэсэн үүнийг хэрэг шийдэхэд даган мөрддөг байна. Гэхдээ иргэний хуулийн тогтолцоотой зарим оронд тухайлбал Сальвадор улсад ийм тогтолцоог хүлээн зөвшөөрдөггүй ажээ.

iii) Захиргааны болон санхүүгийн хараат бус байдал

254. Шүүх эрх мэдэл бүхий тусгайлсан сонгуулийн шүүх эсвэл сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдлыг үнэлэх

өөр нэгэн чухал зүйл нь тэдний төсөв болон захиргааны хараат бус байдал юм. Зарим тохиолдолд тухайн байгууллагуудын төсвийн төслийг Ерөнхийлөгч боловсруулдаг бол зарим улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь өөрөө төсвөө боловсруулан Парламентын нэгдсэн хуралдаанаар батлуулдаг.

255. Сонгуулийн байгууллагын тухай санхүүжилтын тусгайлсан хуулийн заалтууд байх нь нэг тогтолцоо юм (Бүлэг 7 Сонгуулийн менежментийн төлөвлөлт хэсгийг үзнэ үү). Гэхдээ Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад зориулсан ийм заалт нь тийм түгээмэл бус ба сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын санхүүгийн бие даасан байдлын тухай ярих нь тэр бүр боломжгүй байдаг. Харин улсын төсвийн тодорхой заагдсан хувийг хуваарилахыг хуулиар заах тохиолдол байх ба тухайлбал Гватемал улс (Мэдээлэл 6.3-ыг үзнэ үү) үүний жишээ юм. Түүнчлэн Чили, Панам улсад төсвийн асуудалд баримталдаг ерөнхий заалтуудын хүрээнд зохицуулагддаг байна.

Ерөнхийдөө сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад зориулсан ийм заалт нь тийм түгээмэл бус хэдий ч сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын санхүүгийн бие даасан байдлын тухай болон өөрийн өөрчилсөн төслийн төсвийг хууль тогтоох байгууллагад хүргүүлж байх үүрэгтэй байдаг болно.

Мэдээлэл 6.3 Гватемал

Гватемал улсад улсын нийт төсвийн 0,5%-ийг сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад хуваарилдаг бол сонгуулийн жил энэхүү төсвийг Сонгуулийн дээд шүүхийн гаргасан саналын дагуу хүсэмжилсэн хэмжээгээр нь хуваарилдаг. Төсөв батлах байгууллага өөртөө шаардлагатай буй төсвийг хүлээн авахгүй бол Шүүх нь банкны зээл авах, засгийн газраас хамааралгүй талаас гадны тусламж хүсэх зэргээр өөрийн санхүүгийн хараат бус байдлыг хангах эрхтэй байдаг.

256. Дээр дурдсан хоёр сонголтын дунд нь сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь өөрийн төсвийн төслийг хууль тогтоох байгууллагад шууд өргөн барьдаг жишээ байх ба энэ нь Боливи, Перу улсуудад хэрэгждэг бол сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг гүйцэтгэх засаглалын хамаарах алба нь өөрчлөх эрхгүй байдаг жишээ Коста Рика улсад байдаг. Үүнээс гадна сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын төсөв нь шүүхийн төсөвт суусан жишээ байх ба үүнд Мексик болон Венесуэл улс багтана.

257. Санхүүгийн хараат бус байдал хомс байх нь гарч буй хэрэг, зөрчлийг үр дүнтэйгээр шалган шийдэх боломжийг хаадаг. 2004 оны Индонезийн сонгуулийн Сонгуулийн хяналтын хороо (Panitia Penga-

was Pemilihan Umum, PANWASLU) буюу сонгуулийн үйл ажиллагааг хянах, зөрчлийг шалган шийдэх хууль ёсны эрх бүхий байгууллага нь санхүүжилтын хувьд сонгуулийн байгууллагаасаа хараат байжээ. Олон нийтийн зүгээс тухайн хороог сонгуулийн байгууллага болон бусад этгээдээс хараат бус болгох шаардлага тавих эрхтэйгээс бусдаар Сонгуулийн хуулиар тухайн хороог сонгуулийн байгууллага байгуулан, тус хороо нь захиргааны хувьд сонгуулийн байгууллагад хамаарна хэмээн заажээ. Энэ хуулиас үүдэлтэйгээр зарим асуудал гарсан бөгөөд сонгуулийн байгууллага нь хорооны төсвийн төслийг хууль тогтоох байгууллагад цаг тухайд нь өргөн мэдүүлээгүй байснаас төсөв нь ихээхэн хасагдсан байна. Сонгуулийн байгууллагын зүгээс тухайн хорооны төсвөөс хассан зүйл нь тосгоны түвшинд сонгуулийн хянагч нарыг (нэг тосгонд нэг хянагч) ажиллуулахтай холбоотой асуудал байжээ. Үүнээс үүдэн хорооны маргаан шийдвэрлэх чадавхи илтэд буурсан. Энэ асуудлыг дараа нь хууль тогтоогч нар оорчлон 2009 оны сонгуулийн хуулиар зассан байна.

258. Шүүх нь захиргааны асуудлуудад оролцохгүй байх хандлагын дагуу Мексик улсад энэ эрхийг шүүхийн зөвлөлд өгсөн байдаг (тус зөвлөлийн зарим гишүүд нь шүүгч нар байдаг). Шүүхийн захиргаа, хяналт болон сахилга батын асуудлыг Сонгуулийн шүүхийн Дээд шүүгчийн ахалсан санамсаргүй сонгосон Дээд шүүхийн шүүгч болон Холбооны шүүхийн зөвлөлийн гурван гишүүн бүхий Холбооны шүүхийн зөвлөл (Consejo de la Judicatura Federal) хариуцан ажилладаг.

в) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус, бие даасан байдал

259. Үндсэн хууль болон бусад хуулийг хэрэгжүүлэх үнэмлэхүй эрх олгох, үүнийг итгэл даахуйц хэмжээнд байлгахын тулд сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь зөвхөн бүтэц, санхүүгийн хувьд хараат бус байх нь хангалтгүй юм. Тиймээс зөрчил маргааныг шүүж буй этгээд (хүн) нь хараат бус, бие даасан, мэргэжлийн өндөр ур чадвартай, ямар нэгэн ашиг сонирхолд автагдаагүй байхыг хуулиар зааж өгсөн байдаг. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус, бие даасан байдлыг хангах механизмыг Мэдээлэл 6.4 дээр үзүүлээ.

Мэдээлэл 6.4 Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус байдлын баталгаа

- Үндсэн хуулиар хараат бус, бие даасан байдлыг хангах;
- Сонгон шалгаруулах болон томилох үйл явц;
- Тухайн албан тушаалд тавигдах шаардлагууд;
- Тогтвортой байдал болон албан тушаал;
- Зохиц цалин хангамж;
- Бусад албан тушаал хашихыг хориглох;
- Хараат бус байдал алдагдаж болох хэрэг дээр татгалзах.

i) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус, бие даасан байдлыг Үндсэн хуулиар хангах

260. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын (захиргааны, олон улсын, түр, хууль тогтоох зэрэг бүгд) гишүүдийн хараат бус, бие даасан байдал, мэргэжлийн ур чадварыг баталгаажуулах олон арга, зарчмуудын нэгэнд Үндсэн хуулиар баталгаажуулах явдал орно. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал гэдэг нь зөвхөн хэрэг, зөрчлийг хуулийн дагуу, цаг тухайд нь шийдэх асуудлаар тогтохгүй улс төрийн болон төрийн ямар ч байгууллага хэргийг шударгаар шийдсэний төлөө хариуцлага тооцох (улс төрийн ашиг сонирхлын эсрэг шийдсэний төлөө) эсвэл шагнах (улс төрийн ашигт сонирхолд нийцүүлэн шийдсэний төлөө) явдал байж болохгүй гэсэн үг юм.

261. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус, бие даасан байдлыг хангах Үндсэн хуулийн болон бусад хууль тогтоомжийн заалтуудад доорх агуулга багтаж болно:

- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүнээр томилогдоход тавигдах шаардлагыг бий болгох;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг сонгох, томилох үйл явцыг явуулахдаа тухайн этгээдүүд нь бусдаас хараат бус байхыг баталгаажуулах, зохицуулах;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд хувийн ашиг сонирхол нь хөндөгдөж болох хэргийг шийдэхдээ татгалзах, үүнийг хориглох тогтолцоог бий болгох, шүүгч нэхэмжлэгчид тэгш хандахыг хуульчлах;
- Хуулиар тогтоосон урт хугацааны тогтвортой байдал, тэдний цалин, ажиллах хугацаа болон томилох нөхцөл зэргийг баталгаажуулах;
- Гишүүд нь улс төрийн болон захиргааны үндэслэлээр чөлөөлөгдөж болохгүй, зөвхөн хуулийн үндэслэлээр чөлөөлөгдөх;

- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь өөрийн албан тушаалаа буруугаар ашигласан бол шийтгэл, хариуцлага ноогдуулах асуудлыг зохицуулах.

Мэдээлэл 6.5 Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус байдлын Үндсэн хуулийн баталгаа

Байнгын шүүхийг сонгуулийн маргаан шийдвэрлэхэд ашиглах нь

Ирланд улсын Үндсэн хуулийн 35 дугаар зүйл:

"Бүх шүүгч нар өөрийн шүүх эрх мэдлийн үүргийг гүйцэтгэхдээ хараат бус, бие даасан байх ба зөвхөн Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид захирагдана."

АНУ-ын Үндсэн хуулийн Бүлэг 1, зүйл 3:

"Дээд болон доод шатны бүх шүүгчид өөрийн албыг сайн хашиж, тухайн томилогдсон хугацаандаа өөрийн гүйцэтгэсэн үйл ажиллагаанд нийцэхүйц цалин урамшууллыг авах ба үүнийг албаа хаших хугацаанд нь бууруулахгүй."

Гуяана улсын Үндсэн хуулийн 131 зүйл:

"Шүүгч нар нь албаа хаших хугацаандаа бүрэн хэмжээний аюулгүй байдлаар хангагдана..."

Шүүх эрх мэдлийн хэсэг болох Үндсэн хуулийн шүүхийг сонгуулийн маргаан шийдвэрлэхэд ашиглах нь

Чех улсын Үндсэн хуулийн зүйл 82:

"Шүүгч нар нь өөрийн үүргээ биелүүлэхдээ хараат бус байна. Шүүгчийн бие даасан байдалд хэн ч халдаж болохгүй."

Мэдээлэл 6.6 Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн тангараг

Индонези

Аллахын нэрийн өмнөөс миний бие Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн үүргийг өөрийн бүх хүчин чадлаа дайчлан хашиж, шударга байж, Индонези улсын 1945 оны Үндсэн хуулийг чанд сахин, улс орон ард түмнийхээ төлөө үйлчлэхээ тангараглаж байна.

Чех улс

"Хүний эрх болон иргэний эрхийг хамгаалан, Үндсэн хууль, бусад хуулийг даган мөрдөж, өөрийн гаргах шийдвэрээ хамгийн дээд хэмжээнд хараат бус, бие даасан байдлаар гаргахгаа тангараглаж байна."

Словак

"Миний бие хүний эрх болон иргэний эрхийг чанд хүндэтгэж, эрх зүйт засаглал бүхий төрийн зарчмыг хангаж, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжууд, Словак улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийг сахин мөрдөж, хуулиар тогтоосны дагуу үйл ажиллагаагаа явуулан өөрийн бүх хүчин чадлаар хараат бус, бие даасан байдлаар шийдвэр гаргаж байхаа тангараглаж байна."

ii) Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг сонгох болон томилох

262. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын дийлэнх хэсэг нь тухайн улсынхаа түүхэн, хэм хэмжээний болон институцын хувьслыг тусган, шинэ хууль тогтоомж батлагдан гарах үед улс төрийн хүчнүүдийн зүгээс гаргах нэхэмжлэл, зөвшилцлийг хангаж байдаг. Тиймээс цаашид улс төр, түүхийн өөр нөхцөлд авч хэрэгжүүлэх сургамжуудыг тогтооход ихээхэн хэцүү байдаг. Иймд сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг сонгон шалгаруулж, томилдог үзүүлэлтүүдийг бий болгох нь чухал.

263. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж нь доорх нөхцлийг хангаж буй бол олон нийтийн зүгээс сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад итгэх итгэл бэхэждэг:

- Гишүүдээ сонгох, томилох тэр дундаа хамгийн дээд шатны байгууллагын гишүүдийг өрсөлдөөнт шалгаруулалтаар, хүйс болон үндэстэнд суурилж тэгш хамрах шалгуураар томилох, тэд нийгмийн ямар бүлэг, ямар хувь хүнээс хамааралгүй байхыг баталгаажуулсан ил тод механизмтай байх;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүнээр томилогдохын тулд зайлшгүй хангах ёстой техникийн болон мэргэжлийн шаардлагууд нь тухайн албыг хараат бусаар хашиж, чухал хариуцлагыг хүлээх боломжтой болохыг харуулах;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг томилоход тавигдах шаардлага, шалгууруудын ач холбогдлын талаар улс төрийн намуудын дунд зөвшилцөл бий болсон байх;
- Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн бүрэлдэхүүн нь жендэрийн тэгш байдлыг хангах;
- Шаардлагатай тохиолдолд үндэстний цөөнхийг ч хамруулсан байх (Мэдээлэл 6.7-г үзнэ үү).

Мэдээлэл 6.7 Босни Герцеговина дахь мөргөлдөөний дараа үндэстний төлөөллийг сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хамруулсан нь

Зоран Докович

1995 онд АНУ-ын Дайтонод сөргөлдөгч гурван тал гарын үсэг зуран энхийн гэрээ байгуулсан ба үүгээр Босни Герцеговинаг нэгдсэн гурван үндэстнээс (Босни, Серби, Хорват) бүрдсэн улс болгосон бөгөөд энэхүү холбооны гэрээнд хоёр субъект хамарсан нь Босни ба Герцеговины холбоо болон Серби улс түүний Брско дүүрэг багтжээ. Улс төрийн хувьд энэхүү үндэстний дагуу хуваарилалт хийн цөөн тооны улс төрийн намууд бусад асуудлаар санал хураалт явуулах болжээ.

Ерөнхийлөгчийн хувьд гурван үндэстэн ротацийн зарчмаар сонгох ба Босни, Герцеговины сонгогчид Босни болон Серби Ерөнхийлөгчид санал өгөх, харин Серби нь Сербийн Ерөнхийлөгчид санал өгөхөөр улс болгосон байна. Сонгуулийн маргааныг анхны болон хоёрдогч түвшинд шийдэх эрх бүхий сонгуулийн байгууллага болон Сонгуулийн ерөнхий хороог (Centralna Izborna Komisija Sredilnje Izborna Povjerenstvo), Парламентаас 5 жилийн хугацаагаар сонгосон (Parlamentarna skupština Bosne i Hercegovine) байна. Энэхүү хорооны бүрэлдэхүүнд үндэстний төлөөллийг багтаасан ба үүнд 2 Босни, 2 Серби, 2 Хорват багтаж дээрээс нь үндэстний бусад цөөнхийг төлөөлсөн нэг гишүүн оржээ. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эцсийн шат нь Босни Герцеговины давж заалдах шатны шүүх байжээ. 2001 оныг хүртэл Босни Герцеговина дахь Сонгуулийн ерөнхий хороо нь сонгууль зохион байгуулах болон сонгуулийн байнгын хууль тогтоомжуудыг боловсруулах явдал байв. 2006 онд Босни Герцеговинад болсон сонгууль нь Дайтоны гэрээнээс хойш болсон анхны сонгууль байсан ба үүнийг Босни Герцеговины эрх баригчид бүрэн хэмжээгээр зохион байгуулжээ. Энэ үеэр олон улсын хамтын нийгэмлэгийг тухайн үеийн Сонгуулийн ерөнхий хороонд зөвлөх эрхтэйгээр оролцуулсан байна.

264. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ямар ч төрлийн байгууллагын дээд эрх барих шатанд гишүүн сонгох, томилохыг томилж буй байгууллагаас нь хамааруулан дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- a. Шүүх эрх мэдлийн байгууллагаас;
- b. Шүүхийн салбарын гаднаас хүн томилсон, хэн нэгнийг сонгосон ч гэсэн ихэнх тохиолдолд шүүхийн байгууллагын гишүүдээс;
- c. Хууль тогтоох байгууллагаас;
- d. Төрийн тэргүүн, улс төрийн намууд болон нийгмийн бусад салбар, шүүх эрх мэдлийн байгууллагын саналаар хэн нэгнийг парламентаас;
- e. Төрийн тэргүүнээс;
- f. Шүүх, хууль тогтоох байгууллага болон засаглалын бусад салбараас санал болгосон, эсвэл тэдэнтэй зөвлөлдөн төрийн тэргүүнээс
- g. Дээрх сонголтуудын хослол;
- h. Зарим тохиолдолд гадаад дотоодын бусад байгууллагуудаас оролцуулж болно.

Мөн сонгон шалгаруулалтыг эхлэхээс өмнө нэр дэвшүүлэх урилга хүргүүлэн, нэр дэвшүүлсний дараагаар өрсөлдөөнт шалгаруулалтаар сонгох боломжтой байдаг ба нэр дэвшигчдийн хувьд тухайн албыг хаших хүсэлтэй эсэхийг асуух нь түгээмэл. Өрсөлдөөнт шалгаруулалт болсон болоогүйгээс үл хамааран нэр дэвшигч нарын мэргэжил, ур чадварыг баталгаажуулж, ил тод нээлттэйгээр үнэлж байх ёстой.

Мэдээлэл 6.8 Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гишүүдийг сонгох, томилох

Томилох субъект:

а. Шүүх:

- Чөлөөтэй нэр дэвшүүлэх эсвэл нэр дэвшигч нараас шалгаруулан нэр дэвшүүлэх;
- Шүүхийн бусад шатнаас нэр дэвшүүлэх (чөлөөтэй нэр дэвшүүлэх эсвэл сугалах);

б. Хууль тогтоох байгууллага:

- Чөлөөтэй нэр дэвшүүлэх эсвэл нэр дэвшигч нараас шалгаруулан нэр дэвшүүлэх;
- Шүүхээс нэр дэвшүүлэх;
- Төрийн тэргүүн нэр дэвшүүлэх;
- Улс төрийн намууд нэр дэвшүүлэх;
- Нийгмийн бусад салбараас нэр дэвшүүлэх;

с. Төрийн тэргүүн:

- Шүүхээс нэр дэвшүүлэх эсвэл шүүхтэй зөвлөлдөн нэр дэвшүүлэх;
- Хууль тогтоох байгууллага дэвшүүлэх эсвэл үүнтэй зөвшилцөн нэр дэвшүүлэх;
- Засаглалын бусад салбараас нэр дэвшүүлэх;

д. Дээрх гурван сонголтын хослол:

- Шүүх болон/эсвэл хууль тогтоох байгууллага болон/эсвэл төрийн тэргүүн санал болгох, үүн дээр олон улсын болон дотоодын байгууллага оролцох.

265. Олон тооны шинжээчид улс төрийн намуудын төлөөлөл сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад байх нь сонгуульд өрсөлдөгчдийн дунд зөвшилцөл үүсэхэд тусалж, сонгуулийн ил тод байдлыг бэхжүүлдэг гэж үздэг. Практик дээр улс төрийн намууд сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад нэр дэвшүүлэх гурван хандлага байдаг. Үүнд:

- (а) огт нэр дэвшүүлэхгүй байх (хамгийн түгээмэл хандлага);
- (б) улс төрийн намууд гишүүдийн цөөнхөд нэр дэвшүүлэх (Уругвай);
- (в) улс төрийн намууд гишүүдийн олонхид нэр дэвшүүлэх (Колумб ба Эквадор).

Гэхдээ олон намын төлөөлөл бүхий сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь маргааныг үнэнч шударгаар шийдвэрлэхэд саад учруулах, шийдвэр гаргах үйл явц ба сонгуулийн хуулийн хэрэгжилтэд аюул авчирч болно. Ялангуяа улс төрийн ашиг сонирхлыг нь хондож буй маргаанд бүр эрсдэлтэй тул улс төрийн намаас нэр дэвшсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь өөрсдийн үүргийг сайтар ухамсарлаж сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын журам, үйл ажиллагааг өөрийн намын эрх ашигт ашиглахгүй байх шаардлагатай. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь Үндсэн хууль болон бусад хуульд заасныг умартан нэг намын эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргахаас байнга зайлсхийх үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор тухайн этгээд нь нэгэнт л сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүн болсон бол

байгууллагын үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа намыг эрх ашгийг үл хамгаалан, маргааныг зөвхөн хуулийн хүрээнд шийдвэрлэж байх ёстой.

266. Ерөнхийдөө байнгын шүүх, Үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн шүүхэд эрх олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь улс төрийн намуудын төлөөллийг албан ёсоор, шууд оруулдаггүй билээ.

267. Тусгайлсан сонгуулийн шүүх, сонгуулийн байгууллагад (шүүхийн эрх мэдэл бүхий) эрх олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо дээр гишүүдийг нь шүүх эрх мэдлийн салбараас томилдог тул улс төрийн намын төлөөлөл байдаггүй. Жишээ нь:

- Коста Рика улсад Сонгуулийн дээд шүүхийн гишүүд нь (Tribunal Supremo de Elecciones) Дээд шүүхийн шүүгчдийн гуравны хоёрын саналаар томилогддог (Corte Suprema de Justicia de Costa Rica);
- Чили улсад Дээд шүүх нь Сонгуулийн дээд шүүхийн 1 гишүүнийг чөлөөтэй сонгож, 3 гишүүнийг өөрийн бүрэлдэхүүн дундаас сонгож, 1 гишүүнийг бусад хуульч нарын дундаас сонгодог бол 5 дахь гишүүнийг хууль тогтоох танхимын даргаар ажиллаж байсан хүмүүсийн дундаас сонгодог;
- Турк улсад сонгуулийн байгууллагын 6 гишүүнийг Давж заалдах шатны шүүхийн нэгдсэн хуралдаанаас сонгодог бол үлдэх 5 гишүүнийг төрийн зөвлөлийн нэгдсэн хуралдаанаас сонгодог (Danıştay);
- Албани улсад сонгуулийн хороо нь Дээд шүүхийн 8 шүүгчээс бүрддэг бөгөөд тэднийг сугалаагаар сонгон, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэр дэвшүүлдэг (Këshilli i Lartë i Drejtësisë).

268. Колумб улсад Төрийн зөвлөл (Consejo de Estado) нь захиргааны хэргийн шүүхийн хамгийн дээд шатны байгууллага хэмээн тооцогддог. Тус зөвлөл нь 27 шүүгчээс бүрдэх бөгөөд тэдгээрийг нэг бүрчлэн Төрийн зөвлөл өөрөө шилж сонгон 8 жилийн хугацаагаар томилох ба нэг суудал дээр 5 нэр дэвшигчийн дундаас шалгаруулдаг. Нэр дэвшүүлэх үйл ажиллагааг Дээд Шүүхийн захиргааны хэргийн танхим эрхлэн явуулдаг байна (Sala Administrativa del Consejo Superior de la Judicatura).

269. Франц улсад Ерөнхийлөгчийн сонгууль, үндэсний хууль тогтоох байгууллагын сонгууль болон бүх нийтийн санал асуулгатай холбоотой зөрчил маргааныг Үндсэн хуулийн зөвлөл хэлэлцдэг. Тус зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд эдгээрийн 3-ыг нь Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, 3-ыг нь хууль тогтоох байгууллагын хоёр танхим болох Үндэсний ассемблей болон Сенат нэр дэвшүүлдэг. Үндсэн хуулийн дагуу энэхүү нэр дэвшсэн хүмүүсийг хууль тогтоох байгууллага саяхнаас баталж байх болсон ч 2009 оны байдлаар энэхүү хуулийг хараахан хэрэгжүүлж эхлээгүй байлаа. Мөн хуучин Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүс хэрэв хүсвэл Зөвлөлд ажиллаж болох бөгөөд тэд улс төрөөс бүр мөсөн ангид байх шаардлагатай байдаг. Нэр дэвшсэн гишүүд нь зөвхөн нэг бүрэн эрхийн хугацаанд буюу 9 жил ажиллана. Нэр дэвшсэн 9 гишүүний гурав нь гурван жил тутамд солигдоно.

270. Хууль тогтоох байгууллага нь бусад төрийн байгууллагатай хамтран гишүүдийг томилж болох ба ийм төрлийн хэд хэдэн загвар байдаг. Үндсэн хуулийн, захиргааны эсвэл тусгайлсан шүүх мөн сонгуулийн байгууллага болон түр байгууллагад олгосон тогтолцоонд энэ нь түгээмэл байдаг. Мексикийн Сонгуулийн шүүхийн шүүгч нарыг томилоход Сенатын гуравны хоёроос доошгүй хувийн саналаар батлагдаж, жагсаалтад буй гурван хүний дундаас нэгийг нь Дээд шүүх олон нийтэд зарладаг. Гватемал болон Перу улсад энэхүү үйл явцыг Конгресс эрхлэн шийддэг бөгөөд үүний зэрэгцээ мэргэжлийн хуулийн холбоод, их сургуулиуд мөн оролцдог байна. Швед улсад Сонгуулийн хяналтын хорооны (Valprvningsnmden) гишүүдийг Парламент томилдог бөгөөд үүнд Ерөнхийлөгчийн оролцоо бас байдаг.

271. Зарим улсад хууль тогтоох байгууллагын нэг болон хоёр танхим бүх гишүүдийг сонгон, баталдаг байх ба ихэнхдээ төрийн тэргүүнээс гарсан саналыг харгалзан үздэг байна. Энэ нь дэлхий даяарх хамгийн түгээмэл практик юм. Киргизстан, Словен улсуудад Ерөнхийлөгчийн санал болгосноор Үндэсний ассемблей гишүүдийг сонгодог. Чех улсад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг (Soud) Ерөнхийлөгч томилох ба ингэхдээ Сенаттай зөвшилцдөг. Энэ нь АНУ-д хэрэглэдэг тогтолцоотой ижил бөгөөд Ерөнхийлөгч нь Сенаттай зөвшилцөн, зөвшөөрсний үндсэн дээр, сонсгол явуулан Дээд шүүхийн шүүгчдийг томилдог. АНУ-ын зарим мужуудад шүүгч нарын сонгууль явагддаг бөгөөд тэдний ихэнх нь Холбооны хууль тогтоох байгууллагын сонгуулийн маргааныг шийдэхэд ажилладаг.

272. Литва улсад Парламент нь Үндсэн хуулийн шүүгчдийг 9 өрсөлдөгчдийн дундаас томилдог бөгөөд эдгээрийн гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Сеймийн дарга, үлдэх гурвыг нь Дээд шүүхийн дарга санал болгодог байна. Хорват улсад Үндсэн хуулийн шүүхийн 13 шүүгчийг Хорватын парламент (Hrvatski Sabor) нэр бүхий хуульчид, прокурорууд, их сургуулийн хуулийн профессоруудын дундаас томилдог ба үүний өмнө иргэний нийгэмд хандан нэр дэвшүүлэхийг урьж, дараа нь нэр дэвшигчдийн талаар нээлттэй сонсгол явуулдаг байна.

273. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг төрийн тэргүүнд олгосон тогтолцооны жишээ нь Словакын Үндсэн хуулийн шүүх (Ľstavnэ Sэd) юм. Тус шүүхийн шүүгчдийг Ерөнхийлөгч парламентын гаргасан санал дээр үндэслэн томилдог байна. Парламент нь нийт сонгогдох гишүүний тооноос хоёр дахин илүү хүний нэрийг дэвшүүлэх ба эдгээрийн дундаас Ерөнхийлөгч сонголтоо хийн томилдог. Финланд улсад эрх бүхий шүүгч нарыг (Захиргааны хэргийн шүүгч нарыг оролцуулаад) Ерөнхийлөгч нь хуулиар заасан процедурын дагуу томилдог.

274. Вануату улсад Дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон бусад гурван шүүгчээс бүрддэг. Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгчийн зүгээс Ерөнхий сайд болон сөрөг хүчний удирдлагатай зөвшилцөн томилдог. Бусад шүүгч нарыг Шүүхийн үйлчилгээний комиссын (Хууль зүйн сайд даргалж, Ерөнхий шүүгч, төрийн албаны комиссын дарга болон шүүхийн үндэсний зөвлөлийн дарга нар багтдаг) өгөх зөвлөмж дээр суурилан томилдог ажээ.

275. Ямайкад сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны талаарх заалтууд нь сонгуулийн өргөдөл, гомдлын хуулинд тусгагдсан байдаг. Энэхүү хуулийг сонгуулийн холбогдолтой маргаан, өргөдөл гаргахад баримталдаг ба Дээд шүүхийн нэг шүүгч тухайн өргөдлийг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл нэхэмжлэгч тал давж заалддаг байна. Ерөнхий шүүгчийг төрийн тэргүүн болох Амбан захирагч (Британи тогтолцооны) томилох ба Ерөнхий сайд нь сөрөг хүчинтэй зөвшилцсөний үндсэн дээр санал болгоно. Үлдэх шүүгчдийг Амбан захирагч нь Шүүхийн үйлчилгээний комиссын саналд үндэслэн томилдог.

276. Шүүхийн зөвлөлийн хийсэн судалгаан дээр үндэслэн гүйцэтгэх салбарын зүгээс хууль тогтоох байгууллагад хандан санал болгох нь мөн боломжит нэг хувилбар юм. Шүүхийн үйлчилгээний комисс бүхий улс орнууд нь үндсэндээ Британийн колонийн үеийн уламжлалтай

байх тул сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь хууль зүйн тогтолцооны нэг салшгүй хэсэг болдог. Өмнөд Африкд шүүхийн үйлчилгээний комисс нь сонгуулийн шүүхийн орон тоог зарлаж, сонирхсон этгээдийг өргөдөл гаргахыг урьдаг. Нэр дэвшигч нартай ярилцлага хийсний дараагаар комисс нь тэнцсэн нэр дэвшигчдийн нэрсийг Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Улмаар Ерөнхийлөгч нь тэднийг томилдог. Энэ улсын сонгуулийн шүүх нь 5 гишүүнтэй бөгөөд эдгээрийн тоонд Дээд шүүхийн давж заалдах шатны хэсгийн дарга, Дээд шүүхийн бусад 2 шүүгч болон Өмнөд Африкын иргэн бусад 2 төлөөлөл байдаг.

277. Шүүхийн зөвлөлөөс гарсан зөвлөмж дээр үндэслэн гүйцэтгэх засаглалын тэргүүн томилгоо хийх тохиолдол байдаг бөгөөд энэ нь Палестины засаг захиргаанд хэрэгждэг. Үүний зэрэгцээ тусгай комисс гишүүдийг сонгох, томилох үүргийг гүйцэтгэж болно. Жишээ нь Эквадор улсын Иргэний оролцоо, нийгмийн хяналтын зөвлөл юм (Consejo de Participaciyn Ciudadana y Control Social).

278. Томилгооны өөр нэг хувилбар нь янз бүрийн төрийн байгууллагууд томилгоо хийж болно. Панам улсад гүйцэтгэх салбар, хууль тогтоох байгууллага болон Дээд шүүх нь Сонгуулийн шүүхийн нэг нэг гишүүнийг томилдог. Түр байгууллагын бүтцийн жишээ болох Афганистан улсад 2010 оныг хүртэл НҮБ-ын ЕНБД-ын тусгай элч нь Сонгуулийн гомдлын комиссын гурван олон улсын гишүүнийг томилж байсан бол Афганы хоёр төлөөллийг Дээд шүүх болон Афганы хараат бус хүний эрхийн комисс томилж байжээ. Гэхдээ энэхүү бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч Хамид Карзай хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн.

279. Франц улсад Үндсэн хуулийн зөвлөлийн 9 гишүүний гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Үндэсний ассемблейн дарга, үлдсэн гурвыг нь Сенатын дарга томилдог байна. Дээр дурдсан 9 гишүүнээс гадна хуучин Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүс нь Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүнээр бүх насаараа ажиллаж болдог байна. Үүний нэгэн адил Казахстаны Үндсэн хуулийн шүүхийн (Konstitwciq Kengesі) 2 гишүүнийг Ерөнхийлөгч, 2 гишүүнийг Сенатын дарга, Үлдсэн 2 гишүүнийг парламентын доод таниим болох Мажилисын дарга томилдог ажээ. Шүүхийн даргыг Ерөнхийлөгч томилох бөгөөд хуучин Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан бүх хүн Үндсэн хуулийн шүүхэд мөн ажилладаг.

280. Болгарын Үндсэн хуулийн шүүх (Konstitucionen съд) нь 12 шүүгчээс бүрдэх бөгөөд үүний гуравны нэгийг Үндэсний ассемблей,

гуравны нэгийг Ерөнхийлөгч, үлдэх гуравны нэгийг Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүхийн шүүгч нарын хамтарсан хурлаас томилдог. Үүнтэй адилаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхийг 9 гишүүний 3-ыг Парламент (saqarTvelos parlamenti), 3-ыг нь Ерөнхийлөгч, үлдэх 3-ыг нь Дээд шүүх томилдог ажээ. Германы холбооны Үндсэн хуулийн шүүх (Konstytucionen съд) нь 12 шүүгчээс бүрдэх бөгөөд үүний гуравны нэгийг Үндэсний ассемблей, гуравны нэгийг Ерөнхийлөгч, үлдэх хувийг Үндсэн хуулийн шүүх (Konstituionen съд) томилдог.

281. Дээр дурдсан жишээнүүдээс өөр жишээнд шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг хэмээн тооцогддог бусад тусгайлсан сонгуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг тогтооход улс төрийн намын төлөөлөл байдаггүй. Жишээ нь, Аргентины Үндэсний сонгуулийн шүүхийн гурван гишүүнийг 1994 оны Үндсэн хуулийн шинэтгэлийн дагуу Ерөнхийлөгч нь Сенаттай зөвшилцөн томилсон. Бразилын Сонгуулийн дээд шүүх (Tribunal Superior Eleitoral) 7 гишүүнтэй бөгөөд гурвыг нь Холбооны дээд шүүх, хоёрыг нь дунд шатны шүүх, хоёрыг нь өөрт нь санал болгосон зургаан нэр дэвшигчээс Ерөнхийлөгч санал болгон томилдог.

282. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг сонгуулийн шүүх, сонгуулийн байгууллага эсвэл түр байгууллагын гишүүдийн заримыг нь улс төрийн намууд нэр дэвшүүлсэн бол үлдэх гишүүдийг нь дээр дурдсаны адил нөхцлөөр нэг бол хууль тогтоох байгууллага (үндсэндээ Дээд шүүхийн санал болгосноор) эсвэл шууд Дээд шүүх нь томилдог байна. Зарим улсад улс төрийн намаас сонгогдоогүй гишүүд нь хараат бус, бие даасан байдлыг хангах баталгаа байдлаар ажилладаг байна. Уругвайд эдгээр гишүүдийг томилохдоо хоёр танхимын гишүүдийн гуравны хоёрын саналыг авсны үндсэн дээр томилно.

283. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг сонгоход улс төрийн намуудын оролцоог тодорхой хэмжээгээр хангадаг тогтолцооны хувьд (а) зөвхөн нэр дэвшүүлэх боломж олгодог буюу улс төрийн намуудын зөвшилцлийг хангах зорилгоор; (б) гишүүнийг томилох эрх олгодог гэж хоёр хуваагдана. Сүүлийн тохиолдол дээр илүү давуу талуудыг олгодог бөгөөд учир нь улс төрийн намуудын нэр дэвшигчид нь шийдвэр гаргах боломжтой болж, гишүүддээ түлхүү хүлээн зөвшөөрөгдөх, хамгийн гол нь нийгэмд бодитоор хараат бус гишүүн байж болохыг харуулах боломжтой болдог. Гэхдээ сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүн нь улс төрийн намын эрх ашгийг хамгаалах эрсдэлтэй. Үүний улмаас

энэ төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагад итгэх итгэл алдарч, намын эрх ашгийг хамгаалсан байр суурь нь хараат бус байдалтай нь нийцэхүй болно.

284. Сонгуулийн зохион байгуулалт болон сонгуулийн асуудлаар гаргах шүүхийн шийдвэр хоёрыг тусад нь өөр өөр байгууллагад хамруулж өгөхийн зэрэгцээ эдгээрийн бүрэлдэхүүнийг мөн тусгаарлаж өгөх хэрэгтэй байдаг. Энэ тохиолдолд сонгууль зохион байгуулагч нь улс төрийн намуудын оролцоотой байж, харин үүнээс гарсан маргааныг улс төрийн намаас ангид сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага хэлэлцэн шийдвэрлэж байх нь зөв шийдэл юм. Энэ тогтолцоо дээр сонгуулийн зөрчлөөс сэргийлэх, зөрчлийг захиргааны арга замаар засах илүү боломжтой байж болохын зэрэгцээ эрх зүйн тодорхой байдлыг улам сайжруулж, захиргааны байгууллагын гаргах шийдвэр нь байнга Үндсэн хууль болон бусад хуулиудад нийцсэн байхыг баталгаажуулдаг. Гэсэн ч хоёр тусдаа хараат бус байгууллагыг байгуулах нь санхүүгийн болоод тогтвортой байдлын асуудлуудыг үүсгэх магадлалтай.

285. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдэд нэр дэвшүүлэхэд улс төрийн намуудын оролцоог бууруулахын тулд бүрэлдэхүүнийг нь тусгаарлаж өгөх хэрэгтэй. Гэвч энэ тохиолдолд сонгууль зохион байгуулагч нь улс төрийн хувьд зарим эрсдэлийг үүсгэдэг гэж судлаачид анхааруулдаг. Үүний хүрээнд ямар нэгэн улс төрийн намын эрх ашгийг хамгаалсан этгээд сонгогдож болох ба ингэснээр асуудлыг улам гүнзгийрүүлж, энэ төрлийн байгууллагын нэр хүндийг сулруулах, шүүх эрх мэдлийн тогтолцоог улс төржүүлдэг байна.

286. Өөр нэгэн сонголт нь хууль тогтоох байгууллагад гишүүдийг томилох эрх олгох явдал юм. Гэхдээ нэлээд олонхийн санал (Мексик болон Гондурас улсад нийт гишүүдийн гуравны хоёрын санал) байх шаардлагатай болдог. Ингэснээр улс төрийн сөрөг хүчинтэй зөвшилцөлд хүрэх шаардлагыг үүсгэдэг (учир нь цөөнх нь тухайн асуудалд хориг тавих боломжтой тул заавал харилцан ойлголцлыг шаардана). Харамсалтай нь энэхүү тогтолцооны хүрээнд гишүүдийн суудлыг зүгээр л улс төрийн гол намууд хуваан авах явдал гарч байгаа нь бусад намуудаа шахаж буй хэрэг юм.

287. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг томилоход зөвшилцөлд хүрэх хэрэгцээ нь хууль тогтоох байгууллагын гишүүдийн тусгайлсан олонхийн саналаар шийдэгдэж байх зарчимд үндэслэдэг болно. Жишээ нь Герман, Литва, Португал улсуудад

Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийг энэ замаар томилдог.

288. Хууль тогтоох байгууллагад санал хураахад тусгайлсан олонхийн саналаар дэмжихийн нэг асуудал нь олон нийтийн зүгээс нэр дэвшүүлэх үйл явцад оролцох оролцоог хязгаарлах, хамгийн сайн тохирох хүнийг сонголгүйгээр орхих зэрэг явдал юм. Мөн цөөнхийн хувьд энэхүү тогтолцоогоор өөрийн төлөөллийг баталгаажуулах боломж хязгаарлагдмал ба энэ нь зарим улсуудад илүү их хамааралтай байдаг. Ардчилсан дэглэмийг тодорхойлж байдаг оролцоо болон зөвшилцөл нь цөөнхийн төлөөллийг техникийн байгууллагуудад заавал хамруулж байх үндэслэл болдог. Мөн хууль тогтоох байгууллага нь зөвшилцөлд хүрч чадаагүйн улмаас гишүүдийг томилохгүй удах зэрэг тохиолдлууд олон гардаг.

289. Ихэнх тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын даргыг томилох асуудлыг тухайн байгууллагын дээд тушаалтнуудад хариуцуулдаг. Гэхдээ ингэхгүй байж болох тохиолдол ч бас бий. Үүний нэг жишээ нь даргыг нь тухайн гишүүдийг томилсон байгууллага шууд томилох явдал бөгөөд жишээ нь Никарагуаг улсын Үндэсний ассемблей нь Сонгуулийн дээд шүүхийн даргыг томилдог, Шведэд Риксдаг нь Сонгуулийн хяналтын хороог томилдог, Словакд Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн шүүхийн даргыг томилдог жишээнүүд багтаж болох юм. Францад Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн зөвлөлийн зарим гишүүдийг нэр дэвшүүлдэг бөгөөд үүний зэрэгцээ Үндсэн хуулийн зөвлөлийн Ерөнхийлөгчийг томилдог байна. Өөр нэгэн сонголт нь Үндсэн хууль болон бусад хуулиар даргын суудлыг сонгуулийн маргаан шийдэх байгууллагын тодорхой нэг гишүүнд шууд зааж өгөх (жишээ нь Перу улсад Дээд шүүхээс томилогдсон төлөөлөл даргаар нь ажилладаг бол Чилид дээд шүүхийн төлөөлөл даргалах ба нэгээс илүү төлөөлөл байвал Дээд шүүхэд албан тушаал, ажилласан жилээр нь харгалзан томилно) тохиолдол байдаг.

290. Заримдаа дарга болон хамгийн дээд тушаалын гишүүнийг бусад гишүүдээс өөрөөр томилдог сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо байх ба эдгээр нь шүүх эрх мэдлийн салбарын харьяа тусгай сонгуулийн шүүх байдаг.

291. Нам бус хүмүүсээс бүрдсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь улс төрийн хувьд ямар нэгэн эвсэлд нэгдээгүй хүмүүсийг мэргэжилийн ур чадвар дээр нь суурилан сонгодог бөгөөд олон нийт ч тэдгээр хүмүүсийн хараат бус, бие даасан байдалд итгэлтэй байдаг. Ер нь ихэнх тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг улс төрийн намтай холбоогүй

байх, ялангуяа сүүлийн үед, албан үүргээ гүйцэтгэж байх үедээ улс төрийн намын гишүүнчлэлгүй байх зэргийг шаарддаг.

iii) Тогтвортой байдал болон мэргэжлийн ур чадварын шаардлагууд

292. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын үүрэг нь тодорхой хэмжээний хууль эрх зүйн мэдлэг шаардана. Зарим тогтолцоо нь гишүүдийг заавал эрх зүйч мэргэжилтэй байхыг шаарддаг (жишээ нь Хорват, Киргизстан, Мексик болон Словак улсуудад хамгийн багадаа 15 жил хууль зүйн чиглэлээр ажилласан байхыг шаарддаг) эсвэл ижил төстэй мэргэжлээр ажилласан туршлагатай байхыг шаарддаг. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг байнгын шүүхэд олгосон тогтолцоо дээр энэхүү заалт түлхүү хэрэгждэг бөгөөд захиргааны хэргийн шүүх дээр хэрэгждэг. Зарим улсын хувьд сонгуулийн тусгай шүүх дээр мөн хэрэгжинэ. Бүр зарим тогтолцоонд Дээд шүүхийн гишүүн байх шаардлагыг тавьдаг.

293. Практик дээр бүх эрх зүйн тогтолцоо нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллагын гишүүнийг тухайн улсын иргэн байх, 35-40 наснаас дээш настай байх шаардлагыг тавьдаг. Зарим улсад насны дээд хязгаарыг 70-75 жил хэмээн тогтоосон байдаг. Олон тохиолдолд сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллагын гишүүн болох тэгш боломжийг хүн бүрд олгох шаардлагатай бөгөөд ямар нэгэн байдлаар жишээ нь хүйс болон яс үндсээр ялгаварлан гадуурхахыг хориглодог юм.

294. Олон төрлийн сонгуулийн маргааныг шийдвэрлэх хараат бус байдлыг авч үзвэл сүүлийн үед улс төрийн ямар нэгэн албан тушаал хашиж байгаагүй, нэр дэвшсэн аль нэг талыг дэмжихгүй байх шаардлагыг гол болгодог. Өөр бусад шаардлагуудын тоонд шударга байх, нэр хүндтэй хүлээн зөвшөөрөгдсөн байх болон гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял эдэлж байгаагүй зэрэг шаардлага түгээмэл байдаг болно.

295. Түүнчлэн зарим эрх зүйн тогтолцоо нь сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүн болохын тулд төрийн албан хаагч байх, эсвэл эрхэлж буй албан тушаалаасаа түр хугацаагаар түдгэлзэх зэрэг шаардлагыг тавьдаг ба энэ нь хараат бус байдлыг хангах хамгийн шилдэг арга юм. Үүний нэгэн адилаар зарим тогтолцоо нь цэрэг армийн албан хаагч бус байх, хууль тогтоох байгууллагад гэр бүлийн гишүүн нь ажилладаггүй байх зэрэг шаардлага тавьдаг. Эдгээрээс аваад үзвэл тухайн гишүүд нь гүйцэтгэх засаглалтай ямар

нэгэн бизнесийн холбоогүй, тороос ямар нэгэн гэрээт ажил авч гүйцэтгээгүй байх шаардлагатай юм.

iv) Албан тушаалын аюулгүй байдал болон ажлын гүйцэтгэл

296. Сонгуулийн маргаан болон сонгуультай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх албан тушаалд ажиллаж буй хүмүүс нь хараат бус, бие даасан байх зайлшгүй шаардлагатай бөгөөд хууль тогтоомжууд ч тэдгээр гишүүдийг ямар нэг шийтгэл, хариуцлага зэргээс тусгаарлах тодорхой арга замуудыг зааж, мөн бэлэг шан авахыг хүртэл хорьдог.

297. Хуулиар үндсэндээ албан тушаал хаших тодорхой хугацааг заасан байх ба тухайн хугацааг бууруулах болон сунгаж болохгүй. Энэ нь сонгуулийн маргаан болон сонгуультай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хараат бус, бие даасан байдлыг хангадаг. Өөрөөр хэлбэл тэднийг шийдвэр гаргасных нь төлөө албан тушаалаас нь огцруулах, хувь хүмүүс болон улс төрийн намуудаас буруушаах эрхгүй юм. Тухайн гишүүдийг зөвхөн Үндсэн хууль болон бусад хуулинд заагдсан үндэслэлээр л огцруулж болно.

298. Шүүгчдийн ажлын байрны баталгаа нь хамгийн чухал баталгааны нэг юм. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хамгийн хүчирхэг баталгаа нь үндсэндээ тэдний эдлэх эрх бөгөөд шүүх эрх мэдлийн салбарын гишүүдэд эрх мэдэл олгох Англи-Америкийн уламжлалыг хадгалсан тогтолцоо энэ хүрээнд хэрэгждэг. Жишээ нь Аргентин, Киргизстан болон АНУ-д энэ тогтолцоо үйлчилдэг. Зарим улсад энэ асуудал арай зөөлөн үйлчилдгийн тоонд Бразил улс орно. Тус улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь зөвхөн хоёр жилийн хугацаагаар ажиллаж, нэг удаа л дахин сонгогдох боломжтой байдаг ажээ.

299. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь байнгын үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд гишүүдийн ажлын байр баталгаатай байх нь онцгой чухал. Түр хугацаагаар үйл ажиллагаа явуулдаг байсан ч гэсэн гишүүдийг бусад шүүхийн байгууллагаас томилсон бол тэдэнд ажлын байрны баталгаа өгч, хараат бус байдлыг нь баталгаажуулж байх шаардлагатай.

300. Үндсэн хуулийн шүүхийн гишүүд нь дахин сонгогдох эрхгүйгээр 12 жил (Словак), 9 жил (Болгар, Франц, Литва, Португал) эсвэл 8 жил (Хорват) ажиллаж болно. Тусгайлсан сонгуулийн шүүх бүхий орнуудын дунд хамгийн удаан хугацаа нь 10 жил хүртэл байх ба

эдгээрийн зарим нь дахин сонгогдоход ямар нэгэн хязгаарлалтгүй (Панам), бусад орнуудад 9 жил (Венесуэл) дахин сонгогдох боломжтой эсвэл боломжгүйгээр (Мексик), 6 жил (Коста Рика) дахин сонгогдох хязгаарлагдмал бус боломжтойгоор ажиллаж болдог ажээ. Индонезийн Үндсэн хуулиар Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нар нь 5 жилийн хугацаагаар ажиллах ба зөвхөн нэг удаа улиран ажиллаж болдог. Колумб улсад Төрийн зөвлөлийн гишүүдийн ажиллах хугацаа нь 8 жил байдаг.

301. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хувьд өөрийн улсын Ерөнхийлөгчийн үүрэгт хугацаа болон хууль тогтоох байгууллагын ажиллах хамгийн дээд хугацаанаас илүү урт хугацаагаар ажиллаж байдаг нь давуу тал юм.

302. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийг хэсэгчлэн болон тодорхой хугацаанд шатлан шинэчилснээр бүх гишүүдийн эрх зэрэг дуусахгүй байх бололцоог хангадаг. Үүнийг мөн давуу тал хэмээн үздэг. Энэ нь институцын тогтвортой байдлыг хангаж, шинэ болон хуучин гишүүдийн хооронд институцын ой санамж, туршлагыг дамжуулах боломжийг олгоно. Ингэснээр сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь шинээр суралцах, алдаа гаргахаас сэргийлэх, хууль тогтоох байгууллага дахь улс төрийн хяналтыг гартаа авсан бүлэг нь сонгуулийн маргаан шийдвэрлэх гишүүдийн томилгоонд нөлөөлөхөөс сэргийлж байдаг. Хэсэгчилсэн болон шаталсан байдлаар гишүүдийг сольж байхын жишээнд Францын Үндсэн хуулийн шүүх багтах ба 9 гишүүний гурвыг нь гурван жил тутам сольдог. Энэтхэгийн Дээд шүүхийн 31 шүүгчийн ажиллах хугацаа нь тэднийг 65 нас хүртэл нь л хүчинтэй байдаг. Коста Рика улсын Сонгуулийн дээд шүүхийн 9 гишүүний гурав нь (Нэг байнгын гишүүн 2 орлогч гишүүн) хоёр жил тутамд солигдож байдаг зэрэг жишээ байна.

303. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд дахин сонгогдох боломжтой байх нь ихэнхдээ эрүүл үзэгдэл юм. Учир нь тэдний үйл ажиллагааны гүйцэтгэлийг тодорхой хугацаагаар хийдэгт оршино. Энэ нь мэргэжлийн өндөр чадвар бүхий гишүүдийг тогтоон барихын зэрэгцээ шинэ гишүүдээр цус сэлбэх боломжийг олгодог. Гэхдээ энэхүү хандлага нь мөн өөрийн гэсэн сул талуудтай бөгөөд дахин сонгогдох үйл явц нь ойр ойрхон явагддаг бол нэр дэвшүүлэгч этгээд нь томилгоог хянах боломжтой болж ирдэг.

304. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын тогтвортой байдал нь ихээхэн чухал. Түр бус байнгын болгоход чиглэсэн

шинэтгэл дэлхийн улс орнуудад явагдсаар байгаа. Учир нь түр байгууллага байснаараа сонгуулийн үр дүнд байгуулагдсан хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаатай энэ нь давхцах юм. Энэ нь тус байгууллагыг мэргэжлийн түвшинд хүргэх, сонгуулийн үйл явцыг шинэчлэхэд чухал билээ. Өмнөх сургамжуудаас үзвэл тус байгууллагыг байнгын болгосноор гарах улс төрийн болон санхүүгийн үр дүн нь түр байгууллага байснаас хавьгүй илүү байдаг.

305. Хэд хэдэн оронд сонгуулийн шүүхийн алба хэмээх ойлголт хэдийнээ бүрэлдэн тогтсон байдаг. Энэ нь өөрөө тухайн байгууллагын тогтвортой байдал болон мэргэжлийн үйл ажиллагааны бүтцийн нэг баталгаа болдог. Энэ нь гишүүнээр сонгогдох, тушаал дэвших, албан тушаалдаа үлдэх гэх мэт өрсөлдөөнт үе шатаар бусдаасаа ялгардаг. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын дээд шатны албыг тус байгууллагын гишүүдийн дундаас мэргэжлийн хүрээнд хашуулах нь зүй ёсны аргачлал ба байнгын мэргэжлийн ур чадварын өсөлт, бүтээлч үйл ажиллагааг идэвхжүүлэх чухал хүчин зүйл болдог. Энэ нь мөн институцын залгамж чанрыг хадгалах, гишүүд болон бусад ажилтнууд бүрэн солигдсон тохиолдолд шинээр суралцахтай холбоотой зардлаас зайлсхийх боломжийг олгоно. Жишээ нь, Мексикийн холбооны улсын шүүх эрх мэдлийн салбарын Сонгуулийн шүүх нь олон нийтэд нээлттэй зарлах байдлаар хуулийн ажилтнуудыг сонгон авч ажиллуулдаг. Үүнтэй холбоотой байнгын сургалтын хөтөлбөр байдаг бөгөөд бүсийн 15 сонгуулийн шүүгчийн 10 нь Сенатаас сонгогдохоос өмнө Сонгуулийн шүүхийн хуулийн ажилтан байх шаардлагыг тавьдаг байна.

v) Зохистой цалин хангамж

306. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн бүтцийн баталгаа болгон хэд хэдэн тогтолцоод Англи-Америкийн уламжлалаас авсан зарчмын зүйл байдаг нь гишүүдийг үйл ажиллагаа явуулж байх хугацаанд тэдний цалин хангамжийг үл хасах, бууруулах зарчим юм. Ялангуяа шүүх эрх мэдлийн салбарт түлхүү хамааралтай. Түүнчлэн Үндсэн хуулийн болон захиргааны хэргийн шүүхийн гишүүдэд энэ зарчим хамаарна.

307. Хэдийгээр хуулинд тэр бүр байнга тусаад байдаггүй хэдий ч сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүд нь өөрийн үүрэгт ажил, үүний ач холбогдол, мэргэжлийн өндөр ур чадварт нийцэх, зохих хэмжээний цалин хангамжийг хүртэж байх шаардлагатай байдаг. Цалин хангамж нь гишүүдэд дарамт шахалтаас ангид амьдрах, өөр ажил хийлгүйгээр зөвхөн өөрийн ажлаа гүйцэтгэх

боломжоор хангана. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүн нь ажлын ачаалал, тухайн асуудлын ээдрээ, мөн хараат бус, бие даасан байдлаа хангахын тулд өөрийн ажилд бүрэн хандан ажиллах боломжийг энэхүү тогтолцоо олгодог. Үүнийг харгалзан үзэж хуулиар сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн цалин хангамж Дээд шүүхийн шүүгчдийн хэмжээнд адил байхыг заасан байдаг нь Мексик Улс юм.

vi) Ангид байлгах

308. Сонгуулийн асуудлыг шийдвэрлэх этгээд нь хараат бус байж, хувийн ашиг сонирхолд хөтлөгдөхгүй байхыг баталгаажуулахын тулд хуулиар сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүн нь ашиг сонирхлын зөрчилтэй байж болох хэргийг хэлэлцэхэд үл оролцуулах үндэслэлийг зааж өгсөн байдаг явдал юм.

с) Үнэгүй зүй ёсны сонгууль, эсхүл боломжийн зардалтай үйлчилгээ

360. Сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээдэд очиход аливаа бонд эсхүл баталгаа шаардлагагүй үед зүй ёсны сонгуульд хүрэхэд чөлөөтэй байдаг бөгөөд энэ үйлчилгээ гомдол гаргагч болон түүний төлөөлөгчийн санхүүгийн зардалтай холбоогүй байдаг. Шударга ёсонд хүрэх энэхүү дэмжлэг гомдол гаргагчдын санхүүгийн нөхцөл байдалтай хамааралгүй юм.

361. Зүй ёсны сонгуулийн үйлчилгээ тодорхой хэмжээний зардал гаргадаг. Олон оронд тус тусын Үндсэн хуульд заагдсан хүний эрхийн үүднээс зардлыг нийтийн хөрөнгөөс гарган улсаас барагдуулсан, татваргүй төлөгдсөн тохиолдолд зүй ёсны сонгуулийн үйлчилгээг хэрэглэхэд үнэгүй байдаг. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог ашиглахад хүний үндсэн эрхийг хангах болон шүүхийн хамгаалалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс хураамжгүй байна. Түүнчлэн төрийн бус байгууллага (ТББ), иргэний нийгмийн байгууллагаас заримдаа нийтийн ашиг сонирхлын зүйлтэй холбогдсон сонгуулийн маргаануудыг дэмждэг.

362. Зүй ёсны сонгуулийн тогтолцоог хэрэглэж байгаа этгээд тодорхой хураамж, зардал гаргасан бол энэ нь тухайлбал шаардлагатай зүйл, тэнцүү байдлын хэмжээнд тооцоолон дүгнэсэн боломжит үнэтэй байх ёстой. Энэ нь зүй ёсны сонгуульд хүрэхэд саад болох ёсгүй. (жишээ болгон Хүснэгт 6.13-ыг үзнэ үү). Жишээлбэл Перу улсад хэрэв маргаж байгаа нэр дэвшигч сонгуулиас хасагдсан бол үндэслэлтэй байхаар зарлагдсан маргааны тохиолдолд буцаагдах маргаж байгаа

нэр дэвшигчийн томилолтын үед бүх мөнгө төлөгдсөн байх ёстой. Ихэнх улс орнууд хуульдаа хураамжгүй байх хэрэгтэй гэж заасан байдаг боловч зарим улс орнууд дээрх шалтгаанаар шүүхийн барьцаа, баталгаа эсхүл эргэн төлөгдөхгүй дүнгийн хэлбэрээр СМШС-д хүрэхэд урьдчилан шаарддаг. Бусад улс орнууд төлөгдсөн зардал эсхүл өчүүхэн хэмжээгээр маргадаг, эсхүл илт үндэслэлгүй байр сууринд байгаа талд торгууль оногдуулахаар заасан байна.

Хүснэгт 6.13. Нэхэмжлэлийн хураамжийн боломжтой үр ашиг: Япон улсын жишээ

Майко Шимицу

Япон улсад орон нутгийн сонгуулийн СМШ хэргийн тоо үндэсний хэмжээний сонгуулиас өндөр байдаг. Үүний нэг шалтгаан нь үндэсний шатанд (шүүхийн нэхэмжлэл) нэхэмжлэл гаргахад хамгийн эхэнд хураамж төлөхийг шаарддаг байхад орон нутгийн шатанд (захиргааны) хураамж шаарддаггүйд оршиж болох юм. Түүнчлэн захиргааны нэхэмжлэлүүд шүүхийн процессоор шийдүүлэхээс хамаагүй хурдан байдаг. Мөн үүнийг орон нутгийн сонгууль дахь тэмцэл маргааны үр дүнгээр өндөр байх хандлагатай гэж үзэж болно. СМШ нийтийн ойлголт СМШ системийн маргаантай шинжийн үр дүн, нийтийн дунд байгаа сонгуулийн ашиг сонирхлын доод түвшингийн боломжоор Япон улсад маш өндөр байдаггүй.

Эхний шаардлагад гаргасан гомдлын тоо

	Сонгуулийн өөрийн нь хүчин төгөлдөр байдлын талаар маргахтай холбоотой маргаанууд		Сонгогдсон хүний хууль зүйд нийцэх байдалтай холбоотой маргаанууд	
	Орон нутгийн хурлын сонгууль/ Орон нутгийн захирагчийн сонгууль	Хотын захиргааны хурлын сонгууль/ захирагчийн сонгууль	Орон нутгийн хурлын сонгууль/ Орон нутгийн захирагчийн сонгууль	Хотын захиргааны хурлын сонгууль/ захирагчийн сонгууль
1999	9	38	5	41
2000	0	25	0	16
2001	0	23	1	12
2002	2	34	0	13
2003	16	57	9	35

Тэмдэглэл: 1999 болон 2003 онд үндэсний хэмжээнд орон нутгийн сонгууль явагдсан тул энэ онуудад сонгуулийн маргааны тоо өндөр байсан.

363. Нэгдсэн вант улсад сонгуулийн гомдол гаргагч батлан даалт болгож (парламентын сонгуульд) 5000 паундаас илүүгүй хэмжээний эсхүл гомдол гаргагчийн нэрийн өмнөөс аливаа гэрч, эсхүл

аливаа хариуцагчийг дуудахад төлбөр болгож болох Дээд Шүүхээс зааварласан бүхий л зардлыг нэхэмжлэл гаргахдаа гурван өдрийн дотор төлөх ёстой.

364. Зарим улс орнууд хорлох санаатайгаар илт үндэслэлгүй байр суурийг тавьж гомдол гаргасан гомдол гаргагчаар зардлыг төлүүлэх эсхүл үндэслэлгүй эсхүл худал маргаж гомдол гаргасан аливаа этгээдэд торгууль оногдуулах боломжийг заасан байдаг.

Хүснэгт 6.14. “Ричмондын хэрэг”: Нэгдсэн вант улс

Andrew Ellis

Британийн системийн дагуу иргэний процесс болон хууль зүйн зардлын дагуу байгуулагдсан сонгуулийн шүүхээс хянан шийдвэрлэсэн гомдол ялагдагчийн эсрэг шийдвэрлэгдсэн байж болно. 1980-аад онд Лондон хотын Ричмондод Лондонгийн Их Зөвлөлийн сонгуульд амжилттай нэр дэвшигчийн эсрэг маргааны тохиолдолд амжилттай нэр дэвшигч болон түүний сонгуулийн агентлаг сонгуулийн зардлаас нөхөн төлөх 19 паундын нэхэмжлэхийг анхааралгүй орхисон. Ингэснээр компани ажлын зардал хуулийн хязгаараас бага зэрэг хэтэрч байсан. Түүнчлэн тэд албан ёсны зардлыг зөв хэлбэрээр буцаан өгөхдөө алдаа гаргасан. Эдгээр алдаанууд нотлогдсоноор шүүх энэхүү нэр дэвшигчийг эгүүлэн татахаас татгалзсан ч тэр өөрийн хууль зүйн бүхий л зардлыг төлөх ёстой болсон. Мөн ялагдагч нөхөн төлөх зардлыг төлөөгүй нь мэдэгдсэн бусад олон алдаа байсан ч гэсэн ялагдаж хэрэг үүсгэсэн нэр дэвшигчийн хууль зүйн зардлын дөрөвний гурвыг төлөх ёстой болсон. Нэхэмжлэх 50,000 паундын хэмжээтэй байсан. Сонгуулийн хэргийн зардалтай холбоотой энэ систем үндсэндээ Нэгдсэн вант улс-хууль тогтоомжийг системд хавсаргадаг. (жишээ болгон Ямайк улсын Сонгуулийн Нэхэмжлэлийн хуулийн 28 дугаар зүйлийг үзнэ үү). Энэ нь хүмүүсийг хэрэг үүсгэхээр гомдол гаргах эсхүл түүнийг хамгаалахад илэрхий саад болж болно, гэхдээ өөр сонголт олоход хүндрэлтэй байж магадгүй. Нийтийн хөрөнгөөс гаргах хууль зүйн зардлын хэмжээлшгүй төлбөр нь олон тааламжгүй хэрэгт хөтөлж болно. Өөр нэг холбоотой асуудал бол шүүх хуралдаан дахь хэрэгт маргах эрх олгогдсон-олон түмний эрх байдаг. Хэрэв шүүхэд зарим салбарын хууль зүйн мэргэжил эзэмшсэн хуульчийг шаардвал зардал өсдөг.

г) Хугацаа

365. Сонгуулийн процессын хууль зүйн хугацаа, шатанд багтаан хугацаанд нь, яаралтай шийдвэр гаргах хэрэгтэй шүүхийн процесс хугацаандаа явагдах ёстой. Хугацааны энэ хүрээнээс гадуур гаргасан шийдвэр магадгүй шударга бус бөгөөд сонгуулийн зарим эрхэд учирсан хохирлыг засах боломжгүй болгоно.

366. Үндэслэл бүхий эцсийн хугацаа маргаан үүсгэхээр байх хэрэгтэй (иргэний шүүх хуралдаан болон захиргааны эрх зүйн бусад салбарынхаас ерөнхийдөө богино). Шийдвэр, үйл ажиллагааны агуулга, хүрээг бүртгэх болон нотлох баримт цуглуулах сонгуулийн тодорхой үйл ажиллагаа, шийдвэрээр мэдэгдэж байгаа аюулыг хүн шаардлагатай цаг хугацааг тэнцвэржүүлэх шаардлагатай. Нэг талаар энэ нь өөрчлөгдөх, тасалдах боломжгүй үе шатанд явагдаж байгаа сонгуулийн процессын үед цаг хугацаандаа багтсан шийдвэрийг гаргах шаардлагын эсрэг байдаг.

Иймд системд сонгуулийн процессын янз бүрийн үе шатуудын богино мөчлөгүүдийг тодорхой тооцоолох хэрэгтэй бөгөөд мөчлөг тус бүрийг дараагийн үед шилжихээс өмнө дуусгах хэрэгтэй. СМШЭ-д тухайн маргааныг үнэн зөвөөр шийдэх, процессыг явуулах, шүүх хуралдааныг явуулах хугацааг өгөхийн тулд тэнцвэржүүлэлт сонгуулийн богино хугацаа, өөрийнх нь эсрэг гомдол гарсан этгээд, хүн өөрийгөө хамгаалах эрх, мөн хугацаандаа байгаа захиргааны байгууллагын захирамжилсан үйлдлийн хооронд тохируулсан байх ёстой. Энэ нь зүй ёсны сонгуулийн үр ашиг болон СМШЭ, СЗБЭ-үүдийн хоорондын хангалттай харилцаа холбоотой байхыг шаарддаг. Үүнээс гадна энэ гомдлоор үүссэн маргааныг шийдвэрлэх богино хугацаанд хууль зүйн процессын эрүүл практикийг олгодог.

367. СМШ олон системүүд сонгуулийн эрх бүхий байгууллагын бүхий л шийдвэр, үйл ажиллагаанд хуульд тусгайлан заасан хугацааны дотор маргаан үүсгээгүй бол эргэлт буцалтгүй байх зарчмыг суулгасан байдаг (217 дахь хэсгийг үзнэ үү). Энэ зарчим нь дараагийн шатанд нэгэнт хөдөлшгүй болсон сонгуулийн тодорхой шийдвэр, үйл ажиллагааны хүчин төгөлдөр байдлыг үгүйсгэх боломжгүй болгодог. Тухайлбал хэд хэдэн оронд Мексиктэй адил хэрэв сонгуулийн бэлтгэл шатанд нөлөөлсөн иргэн, намаас эсэргүүцээгүй бол сонгуулийн дүнг зарлах шатанд сонгуулийг хүчингүй болгох үндэслэл болсон сонгуулийн сурталчилгааны үед гаргасан алдааг хууль зүйн дагуу зөвшөөрөхгүй.

368. Энэ зарчим нь зөвхөн мэдэгдсэн алдааны талаар цаг тухайд нь маргаан үүсгэсэн үед хэрэгжинэ гэдгийг тэмдэглэн хэлэх нь чухал. Хэрэв өмнөх шатанд нь гаргасан маргааны зүйл байхгүй бол үүнийг маргах нь зүй ёсны гэж үзэх үндэслэл болох байсан. Тухайлбал сонгуулийн дүнг гаргах шатанд. Ийм учраас сонгуулийн хуулиар тодорхой шийдвэр, үйл ажиллагааны талаар (жишээ нь: сонгуулийн бүртгэл, нэр дэвшигчийн дэвшүүлэлтэт холбоотой) гаргах болон СМШЭ-ээс маргаж байгаа шийдвэрийг хэлэлцэх тусгайлан системчилсэн хугацааг тусгах хэрэгтэй.

369. Сонгуулийн процесс нэгэнт эхэлсэн бол Засгийн газрын бүтцийн төлөөлөгчийн цаг хугацааг сунгах нь үүнээс хамаарах учир зогсоох боломжгүй. Энэ нь маргааныг заавал цаг хугацаанд нь багтаах биш, харин гомдлоор үүссэн маргааны зүйл маргаж буй сонгуулийн шийдвэр, үйл ажиллагааны үр дагаврыг түдгэлзүүлэхгүй гэсэн сайн зүйл юм. Энэ нь сонгуулийн процессын зохих үйл ажиллагаанд СМШЭ-ээс саад хийхээс зайлсхийхэд тусалдаг. Шүүхийн урт процессоос сонгуулийн процессыг тасалдуулж, саатуулаагүй гэдгийг батлахын тулд сонгуулийн дүнгийн шатанд бүхий л маргааныг хойшлуулдаг.

Энэ хандлагын муу тал нь аливаа үр ашиг гаргах бусад зөв аргыг авахад хэтэрхий хожимдсон учир дүнд нөлөөлсөн, сонгуулийн процессын үед гарсан маш ноцтой аливаа алдаа зөвхөн сонгуулийг хүчингүйд тооцсоноор засагдаж чадна.

370. Маргааны гомдол гаргах, түүнийг шийдэх хугацаа өөр өөр байх тохиолдолд сонгуулийн процессыг нийтэд дэлгэхэд нөлөөлсөн үйл ажиллагаа, шийдвэрүүд болон чанд хатуу яриатай, түүний хүрээнээс гадуур гарсан байдал хоорондоо ялгаатай. Маргааны зарим төрлүүд илүү төвөгтэй бөгөөд үүнээс шалтгаалан маргааны процесс, хэлэлцүүлэг, шийдэлд шаардлагатай мэдээллийг цуглуулахад илүү цаг шаардлагатай болж магадгүй (тухайлбал улс төрийн намуудын санхүүжилтэд хяналт тавихтай холбоотой тохиолдолд). Ийнхүү хугацааг сунгах нь сонгуулийн процесст нөлөөлөхгүй тохиолдолд маргааныг шийдэх хугацаа илүү урт байж болно. Хугацаа сунгаснаар сонгуулийн процесст муу нөлөө үзүүлэхгүйн тулд энэ үед хийгдэх ёсгүй захиргааны болон шүүхийн шийдвэрийг хуульд зааж болно.

371. Сонгуулийн гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд эрх бүхий байгууллагаас объектив, хойшлуулшгүй, алагчлалгүй аргаар явуулсан мөрдөн байцаалт, аливаа гэмт хэрэгт ял оногдуулах ажиллагааг баталгаажуулахад анхаарал болгоомжтой хандах ёстой. Сонгуулийн гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах бүрэн эрхтэй байгууллагын мэргэжлийн бие даасан байдлыг авч үзэх нь зүйтэй бөгөөд олон талт улс төрийн хүчний дэмжлэгийг сайшаах хэрэгтэй. Панама улсад хууль тогтоох байгууллагаас олгосон бие даасан байдалтай Сонгуулийн Гэмт хэргийн бүрэн эрхэт Ерөнхий Этгээдийг Үндсэн хуульд заасан жишээ байна.

372. Сонгуулийн сурталчилгааны үед болон дүнг зарлахаас өмнө гарсан гэмт хэрэг, зөрчилд оногдуулах эрүүгийн болон захиргааны хариуцлагыг тогтоох шаардлага байдаггүй. Хэдий тийм боловч шүүх хурлыг явуулах хөдөлгөөн болон сонгуулийн процессын шатанд шийдэгдсэн байх шаардлагатай маргааны шийдэл хоёр тус тусдаа зүйл юм. Хэрэв сонгуулийн зөрчил гарсан нь (нотлогдсон бол) сонгуулийг хүчингүйд тооцох үндэслэлд тооцогдох бол эрүүгийн болон захиргааны хариуцлагыг тогтоох процессын дараа хүрсэн дүгнэлтийг үл харгалзан журмын дагуу маргааны байцаалтыг явуулахаар нотлох баримтыг бүрдүүлсэн, фактыг авч үзсэн байх ёстой.

373. СМШЭ-ийн тогтоолыг үндэслэлгүйгээр хойшлуулах ёсгүй, сонгуулийн эрхийн зөрчлийг засахад бэрх болохоос өмнө шийдвэрт

хүрэх, шийдвэр гаргахыг хичээнэ. Түүнчлэн сонгогдсон хүн, байгууллагыг томилохоос өмнө шийдвэрийг гаргах хэрэгтэй. СМШЭ-үүд үргэлжлүүлэн мөн хугацааны маш урт цагуудад тохируулах нь нийтлэг байдаг.

374. Гэхдээ СМШ зарим тогтолцоонд эцсийн шийдвэрийг дараа нь гаргах боломжтой байдаг. Албан ёсоор маргасан хугацааны дараа шийдвэрийг гаргасан тохиолдлууд байдаг ч шийдвэр гагцхүү санхүүгийн үр дагавартай байдаг (сонгогдсон гишүүний цалингийн төлбөр). Нэгдсэн улсын СМШ тогтолцоонд хууль тогтоох байгууллагын, Колумб улсын СМШ тогтолцоонд шүүхийн байгууллагад эрхийг олгодог. Эсрэгээрээ Нигер улсад Anambra мужийн мужийн захирагчийн сонгуульд нэр дэвшигч Peter Obi 2007 онд мужийн захирагчийн үүрэг гүйцэтгэж байсан Emeka Ngige-ийн дахин сонгуулийн маргаанд ялж, түүний албан тушаалд томилогдон өмнөх хугацааг хэвээр үлдээхийн оронд бүтэн 5 жилийн хугацаанд энэхүү албан тушаалыг гүйцэтгэхээр эрх олгогдсон. Энэ нөхцөл нь мөнгөн хэлбэрийн нөхөн төлбөрийн оронд Obi-ийн сонгуулийн эрхийг бүхлээр нь сэргээсэн.

375. Шийдвэрийн үр ашиггүй байдал, шинж чанарын үр дүнд СМШЭ-ээс маргааныг хуульд заасан хугацаанд багтаан шийддэггүй тохиолдолд энэ нь өөрөө зарим төрлийн хариуцлагыг үүсгэж болно.

е) Өмгөөлөх, сонсох эрх ба due process of law

376. СМШЭ гомдол гаргагч болон өөрийнх нь эсрэг гомдол гаргасан хүн, байгууллагад маргаанд өөрийгөө хамгаалах болон сонсох эрхийг нь баталгаажуулах хэрэгтэй. Үүнд өөрсдийн аргументыг гаргах боломж, СМШЭ-ээс тэднийг сонсох, судлах үүрэг хамаарна. СМШЭ маргааны хоёр талаас санал болгож, бүрдүүлсэн маргааныг дэмжиж, эсхүл няцааж байгаа нотлох баримт болон СМШЭ эдгээр нотлох баримтыг шинжлэх, яагаад фактад холбоотой эсхүл холбоогүй гэж үзэж буйгаа болон үр ашгийг нь тайлбарлах үүргийг хүлээнэ (7 дугаар бүлгийн 5 дахь хэсгийг үзнэ үү). Бүх процесс талуудын тэгш байдлын зарчмыг баримтлах ёстой. Үндсэндээ (а) маргаан гаргах эрх олгогдсон бөгөөд маргааны гомдол гаргасан тал (7 дугаар бүлгийн 3 дахь хэсгийг үзнэ үү); (b) СЗБЭ-ийн үүрэгтэй эрх бүхий байгууллага болох хариуцагч. (бусад боломжид улс төрийн намын тэргүүний гаргасан шийдвэр хамаардаг) Ерөнхийдөө СЗБЭ-ийн үйл ажиллагаа шийдвэрийн улмаас маргаан үүсдэг, (c) хэрэв сонсох эрхтэй бол гуравдагч этгээдийн хооронд ялгаа гардаг. Хэд хэдэн тогтолцоо сонирхогч гуравдагч тал-өөр улс төрийн нам эсхүл маргаан

гаргах сонирхолтой нэр дэвшигчийг оруулдаг. Зарим СМШЭ-үүдийн маргаан (ихэнх нийтлэг эрх зүйн системтэй улс орнууд) шууд улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн хооронд байдаг бөгөөд үйл ажиллагаа, шийдвэрийнх нь эсрэг маргасан захиргааны агентлаг (ерөнхийдөө СЗБЭ) болон шийдвэр, үйл ажиллагаа нь нөлөөлсөн талуудын хооронд байдаггүй.

377. Сонгуулийн хуулиар маргааныг хүлээн авахад тавигдах шаардлагуудад шүүхэд маргаан үүсгэх эрх, хууль зүйн статусыг хамруулан тодорхой заах хэрэгтэй. Үндэслэлгүй, хуурамч, хор хөнөөлтэй маргаануудыг хүлээн авахгүй, гаргасных нь төлөө шийтгэл оногдуулж болно. СМШЭ маргааныг хүлээн авсан, эсхүл хүлээн аваагүй талаар сонирхогч талуудад бичгээр мэдэгдэх хэрэгтэй бөгөөд үүний шалтгаан нь сайн үндэслэгдсэн, шалтгаалсан байх хэрэгтэй.

Хүснэгт 6.15. Үндэсний хэмжээний сонгууль, ард нийтийн санал асуулгын дүнгийн маргаан: Франц улс

Andrew Ellis

Франц улсад үндэсний хэмжээний сонгууль, ард нийтийн санал асуулгын дүнгийн маргаануудыг Үндсэн Хуулийн Зөвлөлөөс шийдвэрлэдэг. Гомдлыг хүлээн авснаар Зөвлөл хэргийн хэлтсүүдээс нэгийг томилно. Хэрэв гомдлыг хүлээн авах боломжгүй нь тогтоогдвол эсхүл гаргасан зөрчил нь сонгуулийн дүнг өөрчилж чадахгүй бол хэрэг хэрэгсэхгүй болно. Нөгөө талаар сонгуулийн хэрэгт Зөвлөлөөс гомдлын хариу тайлбарыг шаарддаг. Үүнээс гадна Зөвлөлийн хэлтсийн үүрэг нь баримт бичгийг өөрөө шаардах, мөрдөн шалгах ажиллагааг цаашид явуулах байдаг. Процесс дууссан тохиолдолд илтгэгч Зөвлөлөөс гомдлыг хувийн байцаалтаар явуулах үндсэн хэлбэрээр тайланг гаргана. Зөвлөл сонгогдсон этгээдийг эргүүлэн татаж, ард нийтийн санал асуулгын дүнг бүхэлд нь болон хэсэгчлэн хүчингүйд тооцож болно. Орон нутгийн, бүсийн болон Европын сонгуулийн дүнгийн маргааныг захиргааны хэргийн шүүх зөвхөн хуульд заасан зорилгод чиглэн давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг. Сонгуулийн бүртгэлийн маргааныг энгийн шүүхээс давж заалдах нөхцөлгүйгээр шийдвэрлэнэ.

378. Хэд хэдэн тогтолцоонд зүй ёсны сонгуулийг газар зүйн байрлалаар илүү хүртээмжтэй болгохын тулд маргааныг эрх бүхий байгууллагаар (ерөнхийдөө СЗБЭ) хийгдэх ёстой гэж үздэг (356 дахь хэсгийг үзнэ үү). Энэ мэтчилэн СЗБЭ маргаж байгаа үйл ажиллагааны хувьд суурь мэдээлэлтэй байдаг. Хэргийн гомдлыг зүй ёсоор гаргасан гэдгийг батлахад үр дүнтэй хамтран ажиллах СЗБЭ-ийн үүргийг СМШЭ-ээс олгох нь гарцаагүй байна. Өрсөлдөж буй нам, нэр дэвшигчид СЗБЭ-ийн материалтай бүрэн танилцах эрхтэй. СМШ зарим тогтолцоо хэрэв СЗБЭ өөрийн байр сууринд байхад хэрэгтэй хэрэгт холбогдолтой сонгуулийн бүхий л мэдээллийг шилжүүлэхгүй бол захиргааны хариуцлага хүлээлгэж болохыг заасан байдаг. СЗБЭ-ийн үйл ажиллагааны хүчин төгөлдөр байдлыг СМШЭ магадгүй нотлох боломжгүй бол хүчингүйд тооцож, эсхүл өөрчилнө.

379. Сонгуулийн хууль тогтоомж сонгуулийн дүнгийн маргааны үр дагаварт авах хууль зүйн арга хэмжээг тодорхой заах хэрэгтэй. Тодруулбал, механизм, тусгай нөхцлүүд, бүхэлд нь болон хэсэгчилсэн дахин тооллого явуулахыг даалгах эсхүл сонгуулийн дүнг бүхэлд нь болон зарим хэсгийг хүчин төгөлдөр бусад тооцоход шаардагдах нотлох баримтуудыг ялгах хэрэгтэй бөгөөд СМШЭ-ээс эдгээр шийдвэрийг гаргах бүрэн эрхийг ялган заах хэрэгтэй (7 дугаар бүлгийн 6 дахь хэсгийг үзнэ үү). СМШ процессын шаардлагыг баталгаажуулахад дараахь зүйлстэй холбогддог. Үүнд:

- хуульд урьдчилан тодорхойлсон, бие даасан, шударга, мөн хялбар дөхөм СМШЭ-ээс явуулах сонгуулийн үйл ажиллагаа;
- маргааны тогтолцоо, процесст хүрэх, үндэслэлтэй тайлбарлагдсан журам;
- сонсох баталгаа, тэгш нөхцөлтэйгөөр өөрийгөө хамгаалах эрхийн зарчим;
- СМШ процесс, холбогдох баримт, материалтай бүрэн танилцах тэгш нөхцөл;
- үр дүнтэй болон цаг хугацаанд авахаар тогтоогдсон аливаа арга хэмжээг авах шийдвэрийн түргэн шуурхай байдал болон нийтийн процесс;
- үндэслэл бүхий зөв тайланд үндэслэн гаргах хэрэгтэй, талуудын гомдол бүрт хүрсэн (бүхнийг хамрах зарчим), үйл ажиллагаагаар (харьцуулалтын зарчим) батлагдсан фактын дагуу гаргасан шүүхийн шийдвэрийг хамруулсан шийдвэр;
- баталгаажсан шүүхийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх.

е) Шүүхийн шийдвэр, журмыг цаг хугацаанд нь, бүрэн хэрэгжүүлэх

380. Маргааны хариу болон гарсан шүүхийн шийдвэр, журмыг цаг хугацаанд нь, бүрэн хэрэгжүүлэх нь СМШ аливаа тогтолцоонд хамгийн чухал байдаг. Эрх бүхий байгууллагын шүүхийн шийдвэрийн хэрэгжүүлэлт нийтийн бодлогын асуудал байдаг бөгөөд бүх эрх бүхий байгууллагууд түүний бүрэн хэрэгжүүлэлтэд хувь нэмэр оруулах үүрэгтэй.

381. Сонгуулийн маргааны талаар гарсан аливаа шийдвэр эсхүл дүгнэлт нь түүний бүрэн хэрэгжиж байгаа эсэхийг ажиглах боломжтой журмыг гаргаж түүний талаар мэдээлсэн байх шаардлагатай. Жишээлбэл, уг шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий этгээд нь ямар үйлдэл хийх, тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан уг үүргээ биелүүлэх цагийн хуваарийн талаар тодорхой дурдсан байж болно. Уг цагийн хуваарийг тухайн шийдвэр болон дүгнэлтдээ заавал дурдана. Хэрэв энэ шийдвэрт заасан үйлдэл цаг

хугацаанд хийгдэхгүй тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх этгээд уг үүргийг биелүүлүүлэхээр албадлагын арга хэмжээ авах эрхтэй байна. Энэ нь зарим төрлийн хариуцлагын механизмуудаар хэрэгжинэ. Жишээ нь торгох, баривчлах, төрийн албадлага, тухайн үйл ажиллагааг хүчингүй болгох, ажлаас халах, нэр дэвшигчийг татгалзах зэрэг байж болно.

382.Хэрэв маргааныг шийдвэрлэсэн шийдвэрийг биелүүлэхээс түүнийг биелүүлэх үүрэгтэй этгээд татгалзвал сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн этгээд тухайн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахын тулд түүнийг ажлаас халах эрхтэй байдаг. Сонгуулийн маргаан шийдвэрлэсэн этгээд нь иймэрхүү эрхийг хэрэгжүүлэх нь түүний шийдвэр бүрэн хэрэгжих болон зөрчлийн улмаас иргэд, нэр дэвшигчид, байгууллага, улс төрийн эвсэл, улс төрийн намуудын зөрчигдсөн сонгуулийн эрхийг сэргээн тогтоох боломжийг бүрдүүлж байдаг учраас чухал байдаг.

БҮЛЭГ 7

БҮЛЭГ 7

Сонгуулийн маргаан шийдвэрлэх системийн үндсэн элементүүд

1.Зөрчил, маргааныг шийдвэрлэх төрлүүд

390. Ерөнхийдөө, гарын авлагын 4 дүгээр бүлэгт сонгуулийн маргааныг шийдвэрлэх арга хэмжээнүүд гэдгийг хууль бус үйлдлийг хүчингүй болгох, өөрчлөх болон танин мэдэж, хүлээн зөвшөөрөх зэргийг багтаасан уг зөрчлүүдийн үр дагаврыг засан залруулахын тулд зөрчлийг арилгах, сонгуулийн эрхийг баталгаажуулах болон сэргээн тогтоохтой холбоотой үйл ажиллагаа гэж заасан.

391. Сонгуулийн зөрчлүүдийг шийдвэрлэх үндсэн элементийг захиргааны, шүүхийн, хууль тогтоох болон олон улсын гэж ангилж болно. Хүндрэлтэй асуудал нь гэвэл улс орнуудын сонгуулийн хуулийн тогтолцооны ялгаатай байдал болон энэ гарын авлагаар зөрчлүүдийг шийдвэрлэх механизмыг захиргааны, шүүхийн, хууль тогтоох эсхүл олон улсын гэж төрөлжүүлэн тодорхойлох уу үгүй юу гэдгийг албан ёсны шалгуур болгон ашигласан нь тодорхойгүй байдалд хүргэж магадгүй юм. Энэ шалгуур нь зөрчлийг зөвшөөрөх болон шийдвэрлэх үндсэн мөн чанарт үндэслэсэн арга хэрэгслүүд юм. Магадгүй сонгуулийн олон зөрчлүүд байдагтай холбоотойгоор үүнээс өөр төрлийн уг зөрчлүүдийг шийдвэрлэх шалгуур болон ангилал байж болох боловч эдгээр шалгуур нь олон төрлийн сонгуулийн маргааныг шийдвэрлэх системд нийцсэн олон төрлийн зөрчлүүдийн механизмуудад тохиромжтой бөгөөд батлагдсан арга хэрэгслүүд юм.

392. Сонгуулийн маргаан шийдвэрлэх системийн хувьд захиргааны хамааралтай зөрчлийг шийдвэрлэх ажиллагаа нь сонгуулийг зохион

байгуулах этгээд болон шүүхийн шатанд сонгуулийн зөрчлийг шийдвэрлэхээс өмнө яригдах нь хамгийн түгээмэл байдаг. Мөн зарим тохиолдолд хууль тогтоох болон олон улсын журмаар сонгуулийн зөрчлүүдийг арилгах аргуудыг ч авч үздэг.

а) Сонгуулийн маргааныг шийдвэрлэх захиргааны хамааралтай элемент

393. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх захиргааны хамааралтай арга хэмжээ нь сонгууль зохион байгуулах этгээдийн хариуцан шийдвэрлэдэг сонгуулийн үйл ажиллагааг чиглүүлэх, зохион байгуулах, удирдан явуулах болон хяналт тавих ажиллагааг хамааруулна. Энэ захиргааны ажиллагаа нь сонгуулийн үйл ажиллагаа болон шийдвэр нь (улс төрийн намууд, нэр дэвшигчид болон жирийн иргэдэд) сонгууль зохион байгуулах этгээдийн болон түүнтэй адил байгууллагууд нь сонгуулийн үйл ажиллагааг ашиглан зөрчилтэй үйлдэл болон шийдвэр гаргах эсхүл дээд шатны өөр албан тушаалтны зөрчилтэй шийдвэр нь маргаан үүсгэхийн эсрэг байхад нөлөөлдөг.

394. Ихэнх улс орнууд нь сонгуулийн зөрчлүүдийг шийдвэрлэдэг захиргааны арга хэмжээг сонгууль зохион байгуулдаг нэг этгээдийн шийдвэрээр тодорхойлогддог гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Сонгуулийн зөрчлийг шийдвэрлэдэг зарим системүүд зөвхөн захиргааны шинжтэй байдаг бол зарим нь шүүхийн болон хууль тогтоох шинжтэй, өмнөх шинжүүдтэй хоршсон шинжтэй байдаг. Ийм учраас сонгуулийн маргаан шийдвэрлэх систем нь холимог шинжээс бүрддэг.

395. Сонгууль зохион байгуулах загварыг тодорхой болгох нь: Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын хүрээлэнгийн энэхүү гарын авлагаар дэлхийн хэмжээнд олон төрлийн сонгууль зохион байгуулах этгээдүүдийн сонгуулийн зохион байгуулалтын (of electoral management) бие даасан загвар, Засгийн газрын загвар болон холимог загваруудыг ялгаатай байдлаар хэрэглэдэг. Ерөнхийдөө, Сонгууль зохион байгуулах этгээд нь үндэсний хэмжээний сонгууль зохион байгуулах дээд түвшний этгээдүүд, голдуу нутаг дэвсгэрийн байдлаар харьяалагддаг сонгууль зохион байгуулдаг дунд түвшний этгээдүүд, улс төрийн, захиргааны болон сонгуулийн тойргууд цаашлаад сонгуулийн доод түвшний хэсгүүд гэсэн пирамид зохион байгуулалттай байдаг. Захиргааны зөрчлийг шийдвэрлэх нь тодорхой эсрэг үйлдлийн улмаас бий болсон сонгуулийн зөрчлүүдийг захиргааны байгууллагаас мэдэгдэх, уг үйлдлийг зөрчил гэж үзэх, эсхүл уг зөрчлийг шийдвэрлэх зэргээр сонгуулийн маргаан, зөрчлийг

шийдэх шатлалын дээд түвшинд хүрэх хүртэлх шаталсан үйл ажиллагаа юм.

396. Сонгууль зохион байгуулах этгээдүүд нь Бие даасан, эсхүл Холимог загварт үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг, эдгээр загварыг үндэслэсэн үед голдуу төрийн байгууллагуудын шинжийг голчлон агуулсан дээд түвшний байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнтэй байх нь нийтлэг байдаг (ерөнхийдөө, хууль тогтоох байгууллагын салбарууд болон шүүхийн байгууллагын салбарууд, зарим тохиолдолд гүйцэтгэх эрх мэдлийн салбаруудын оролцогчид ч байж болдог). Эдгээр системүүд нь улс төрийн намуудад ерөнхийдөө цөөнх болсон намд тэдгээрийн төлөөлөгчдийг санал өгөх эрхээр хангах нь зарим төрлийн үүрэг ролийг бий болгодог, гэхдээ бие даасан шинжээчид гишүүдийн дийлэнх хэсгийг бүрдүүлнэ. Зарим тохиолдолд бие даасан шинжээчид нь зөвхөн санал өгөх эрхтэй бөгөөд улс төрийн намуудын төлөөлөгчид нь зөвхөн ярих эрхтэй, эсхүл хяналт тавих чиг үүрэгтэй байдаг. Ийм төрлийн сонгууль зохион байгуулах этгээдүүд нь бие даасан шинжээчдээс бүрддэг бөгөөд эдгээр нь улс төрийн намуудын хувьд өөрсдийн гишүүдийг сонгох үйл ажиллагаанд нь чухал үүрэг гүйцэтгэх нь нийтлэг байдаг. (Сонгууль зохион байгуулах Загвар: Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн энэхүү гарын авлага.

б) Сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүхийн хамааралтай элемент

397. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүхийн ажиллагаа гэдэг нь шүүхийн өмнөх шатанд хоёр болон түүнээс дээш этгээдийн хоорондох сонгуулийн зөрчлүүд болох хууль ёсны болох нь эргэлзээтэй, хууль бус, буруутай, алдаатай, хуульд нийцээгүй, сонгуулийн үйлдлүүд болон шийдвэрүүдийн улмаас үүссэн сонгуулийн маргааныг шат шатны шүүхээс хуульд заасан маргаан шийдвэрлэх арга хэрэгслүүдийн дагуу шүүхийн маргаан шийдвэрлэх процессын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ. Шүүхийн байгууллагууд гэдэг нь маргааныг эцэслэн болон шударгаар хянан шийдвэрлэх шүүхийн тогтолцоо юм.

398. Сонгуулийн тогтолцоонд сонгуулийн зөрчлийг шүүхийн журмаар шийдвэрлэх нь осох чиг хандлагатай байна. Гарын авлагын 5 дугаар бүлэгт дурдсанаар шүүхийн журмаар шийдвэрлэх ажиллагаа нь жирийн шүүхийн шатнаас өмнө, шүүхийн шатууд, үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн шүүх, дагнасан сонгуулийн шүүх болон хамтарсан шүүхүүдээс бүрдэнэ. (мэдээлэл 7.1-ийг харна уу)

Мэдээлэл 7.1. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүхийн төрлүүд

- Жирийн шүүхүүд
- Үндсэн хуулийн шүүх
- Захиргааны хэргийн шүүх
- Дагнасан сонгуулийн шүүх

399. Олон төрлийн сонгуулийн маргаан нь хэд хэд ангилагдаж болох бөгөөд ерөнхийдөө ярилцах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа, давж заалдах ажиллагаа, тусгай болон онцгой эрх зүйн хамгаалалтын арга хэмжээ (мэдээлэл 7.2-ийг харна уу) байна.

Мэдээлэл 7.2. Шүүхийн журмаар сонгуулийн маргааныг шийдвэрлэх ажиллагааг ангилах нь

- Шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа
- Давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа
- Онцгой журмаар болон онцгой журмаар давж заалдах ажиллагаа (нэр томъёоны тайлбарыг харна уу)

1. Шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

400. Шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь албан ёсоор шүүхээс нотлох баримтыг хянан шийдвэрлэх болон хууль ёсны нэхэмжлэлийг тодорхойлохыг хэлнэ. Сонгууль зохион байгуулах этгээдээс болон улс төрийн намаас гаргасан сонгуулийн-захиргааны үйлдэл болон шийдвэр нь шүүхийн журмаар хянан шийдвэрлэгдэж болно. Шүүхийн шийдвэр нь талуудаас хараат бусаар шударгаар маргааныг шийдвэрлэж гаргадаг. Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь ялангуяа Англи-Америкийн болон Испанийн уламжлалт хуулийн тогтолцоотой орнуудын хувьд байнга талуудын мэтгэлцээний үндсэн дээр явагддаг. Францын хуулийн тогтолцоотой орнуудын хувьд шүүхийн маргаан шийдвэрлэх ажиллагаа нь нотлох баримтыг үндэслэн нягтлан хянан шалгах замаар явагддаг.

2. Давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

401. Давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь анхан шатны шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүх нь дахин хянах болон өөрчлөх ажиллагаа байдаг. Давж заалдах ажиллагааны үед дээд шүүхэд очихоос өмнө анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх болон анхан шатны шүүхийн ажиллагааны зөрчлийг

тогтоодог. Давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь сонгуулийн маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэх механизмын томоохон хувийг эзэлдэг. Давж заалдах журмаар маргааныг зарим тохиолдолд шийдэж дуусдаг зарим үед шүүхийн ажиллагаа нь үргэлжилдэг.

402.Ердийн давж заалдах ажиллагаа нь дээд шүүхээс шүүхийн шийдвэрийг хянах ээлжит ажиллагаа байдаг. Давж заалдах шатны дараа ялагдсан тал нь дахин хянуулахаар ханддаг бөгөөд энэ тохиолдолд ихэнхдээ нэгээс дээш шүүгч хэргийг бүхэлд нь, факт, хууль зүйн талаас болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон бусад зөрчил байгаа эсэхийг хянан шалгадаг. Шүүхийн шийдвэр нь магадгүй үндсэн дүрэм, журмын заалтыг зөрчилтэй байна гэж тогтоох, анхан шатны шүүхийн шийдвэрийг оорчлох, хүчингүй болгох, үндсэн дүрэм, журмын заалтыг хэвээр үлдээх, эсхүл анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, анхан шатны шүүхийн ажиллагааг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлэх талаар даалгах зэргээр шийдвэрлэж болно.

403.Тусгай болон онцгой давж заалдах ажиллагаа гэдэг нь давж заалдах шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзээд сонгуулийн хууль бус болон алдаатай зөрчил гаргасан байна гэдгийг тогтоож гаргасан шийдвэр, магадлал нь зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд (procedural law) тусгайлан үндэслэсэн байна (жишээ нь, давж заалдах журмаар зөрчлийг баталж хүлээн зөвшөөрсөн бол сонгуулийн үр дүнг оорчлоход нөлөөлнө). Давж заалдах шатны шүүхийн шийдвэр болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед асуудлыг хууль зүйн хувьд хянах утга агуулгатай байдаг ийм учраас давж заалдах шүүхийн шийдвэр нь зөвхөн хууль зүйн асуудлыг багтаадаг харин факт буюу бодит нөхцөл байдал нь ихэвчлэн доод шатны шүүхээр авч хэлэлцэгддэг.

Мэдээлэл 7.3.Орос Улсад сонгуулийн маргааныг шийдвэрлэх нь (сонгууль зохион байгуулах этгээдийн эс үйлдэхүйн эсрэг давж заалдахыг хамруулсан)

Сергей Кузницов

Сонгуулийн эрхийн үндсэн баталгаануудын тухай хуулийн 75 дугаар зүйл болон Оросын Холбооны Улсын бүх нийтийн санал асуулгад оролцогч иргэний эрхийн тухай хуульд зааснаар, сонгуулийн маргааныг шүүхээр шийдвэрлэх болон сонгуулийн комиссоор дараах аргаар шийдвэрлэнэ:

А.Сонгуулийн ерөнхий комиссын шийдвэр, үйл ажиллагаа болон эс үйлдэхүйн талаарх гомдлыг давж заалдах журмаар ОХУ-ын Дээд шүүхэд хандах боломжтой;

Б.Холбооны улсуудын сонгуулийн комиссын шийдвэр, үйл ажиллагаа болон эс үйлдэхүйн талаарх гомдлыг тус тусын харьяалагдах байгууллагын дээд шүүх болон хоёрдугаар шатны шүүх (холбооны статустай хотуудын бүс нутгийн болон нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхүүдэд) хандаж болно;

С.Бусад сонгуулийн комиссын шийдвэрийг ерөнхий харьяаллын шүүхүүдэд хандан хянан шийдвэрлүүлж болно.

Иргэд болон холбоод нь сонгуулийн комиссын шийдвэрийн талаар комиссын түвшинд яаралтай гомдол гаргаж болно. Хотын сонгуулийн комиссын шийдвэрийн талаар холбооны сонгуулийн комисст гомдол гаргаж болно, холбооны сонгуулийн шийдвэрийн талаар ОХУ-ын Сонгуулийн ерөнхий комисст гомдол гаргаж болно. Сонгуулийн эрхийг зөрчсөн гэдгийг тогтоосон шүүхийн шийдвэрийг бүх шатны сонгуулийн комиссууд биелүүлэх үүрэгтэй.

Сонгуулийн эрхийн үндсэн баталгаануудын тухай хуульд маргааныг хянан шийдвэрлэх процедурыг нарийвчлан оруулсан байдаг.

ОХУ-д сонгуулийн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг онцлог шинж нь гэвэл зөвхөн иргэний сонгуулийн эрхийг зөрчсөн талаарх сонгуулийн комисс болон төрийн албан хаагчдын шийдвэр болон үйл ажиллагаануудын эсрэг гомдол гаргахаас гадна эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын үйлдэл хийхгүй байх, үүргээ биелүүлэхгүй байх дутагдалтай үйлдэл, үйл ажиллагааны эсрэг гомдол гаргаж болохоор заасан байдаг.

сонгуулийн комиссууд болон төрийн албан хаагчаас иргэний сонгуулийн эрхийг зөрчсөн тухай Сонгуулийн гомдлыг шийдвэрлэх дээр дурдсан эрх бүхий байгууллагуудаас дараах шийдвэрийг гаргадаг:

а.гомдлыг хянан үзээд гомдлоос татгалзах;

б доод шатны комиссын шийдвэрийг буцаах эсхүл дахин асуудлыг шийдвэрлүүлэхээр буцаах;

в.доод шатны комиссийн шийдвэрийг буцаах, шинээр асуудлыг хянан үзүүлэхээр явуулах, тохирсон үйлдэл хийлгүүлэхээр даалгах.

2.Маргааныг бий болгодог үйлдлүүд

Улс төрийн намуудын дүрэм, дотоод журамд тавих хяналт

446. Үндсэн хууль, хуулиар улс төрийн намуудын чанд мөрдөх ёстой үндсэн суурь зарчим, зааварчилгаа, эсхүл ардчилсан шаардлагуудыг заасан байдаг. Хэдий тийм боловч улс төрийн намууд өөрсдийгөө зохион байгуулах эрх чөлөөгөө ашиглан өөрсдийн бүтэц, дотоод ардчилсан зохион байгуулалтын дүрмийг батлах эрхтэй байдаг. Намууд өөрийн дотоод журмыг батлах, мөн түүнчлэн Үндсэн хуулийн болон хуулийн шаардлагууд дүрэмд нотолгоожсон эсэхийг шалгах зорилгоор эрх бүхий байгууллагатай (боломжтой бол СЗБЭ) хамтран дотоод дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлах үүргийг хуулиар заасан байдаг.

Улс төрийн намын дотоод журам, аливаа нэмэлт, өөрчлөлт нь үндсэн хууль, бусад хуультай нийцэж байгаа эсэх аливаа маргааныг СМШЭ шийдвэрлэнэ (жишээлбэл, Коста Рика, Мексик, Панам). Эдгээр орнуудад СМШЭ-ийн шийдвэр эцсийн байдаггүй, давж заалдах, дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй.

Улс төрийн намын тэргүүн, сонгуульт албан тушаалд нэр дэвшигчийг сонгох

448. Улс төрийн зүүний чиглэлтэй намууд намаа өөрсдөө зохион байгуулах эрхээ ашиглаж намын тэргүүн, сонгуульт албан тушаалд нэр дэвшигчийг сонгох ардчилсан үйл ажиллагааг зохицуулдаг. Ихэнх тохиолдолд хуулиар намын дүрэм, тусгай үйл ажиллагааг

зохицуулсан байдаг тул заавал мөрдөх үндсэн дүрмийг дагах ёстой. Хуулийн дагуу заримдаа тэргүүн, нэр дэвшигчээ сонгох намын дотоод процесст СЗБЭ хөндлөнгөөс оролцдог. Зарим тохиолдолд зөвхөн СМШЭ-ээс гарсан шийдвэр, маргаантай үйл ажиллагааны боломжийг хуулиар зааж болно.

449. Энэ мэтчилэн, жишээлбэл, намуудын засаглалын бүтцийг авч үзвэл, голдуу хууль тогтоох байгууллага нь улс төрийн нам бүрт байх ёстой дотоод процесс, үндэстэн, улс, орон нутаг, салбар эсхүл боломжит давхаргад байх хэрэгцээний талаар хамгийн бага хэмжээгээр үг цухуйлгадаг.

450. Онцлог нь, хууль тогтоох байгууллага эдгээр бүтцийг хэрхэн бүрдүүлсэн, албан тушаалын хугацаа, дахин сонгуульд тавих хязгаарлалт, СЗБЭ-тэй хамтран гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх үүрэг оногдуулах, мөн намуудын дотоод журам, эргүүлэн татах үндэслэл, процесс, тэргүүнд тавих ардчилсан хяналтыг зохицуулж болно. Гэвч нарийвчилсан зохицуулалт байдаггүй. Хэд хэдэн орны хуульд улс төрийн намын тэргүүн, нэр дэвшигчдийн сонгууль тогтсон хугацаанд явагдах ёстой гэж заасан байдаг (жишээлбэл, Аргентин, Коста Рика, Никарагуа, Панама, Урагвай). Гэсэн хэдий ч сонгууль нь шууд эсхүл шууд бус, эсхүл дотоод болон анхдугаар сонгуулиар намын гишүүдийг чөлөөтэй, нууц санал хураалт, эсхүл шууд, чөлөөтэй, тэгш болон нууц санал хураалтыг бий болгох шаардлагатай байдаг.

451. Практикт de facto-ийн ялгаварлалыг багасгах зорилгоор зарим оронд намд нэгдэх, сонгуульд албан тушаалд томилогдох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш боломжийг онцлон авч үзэж, ялгаварлан гадуурхах үзлийн аливаа хэлбэрийг хуулиар хориглодог (жишээлбэл Коста Рика, Экуадор). Ингэснээрээ эмэгтэйчүүдийг намын менежментийн бүхий л үе шатанд, төлөөлөх албан тушаалд, сонгуульд албан тушаалд нэр дэвшүүлэхэд харгалзан үзэх боломжыг эмэгтэйчүүдэд олгодог (жишээлбэл, Армений, Буркина Фасо, Индонез, Панама, Прагвай).

452. Зарим улсын сонгуулийн хуулиар сонгуульд албан тушаалд нэр дэвшигчдийн дунд олон ургалч үзэл болон цөөнхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоох байгууллагад суудал хуваарилах пропорциональ төлөөллийн тогтолцоог заасан (жишээлбэл Гондурас, Прагвай).

Зарим орны хуульд намын тэргүүлэгч болон сонгуульд албан тушаалд нэр дэвшигчийг сонгох үйл ажиллагаанд СЗБЭ оролцохоор заасан байдаг. Энэ тохиолдолд СЗБЭ улс төрийн нам, хөдөлгөөнүүдтэй

хамтарч ажилладаг. Ингэхэд үндэсний хэмжээний удирдлагын байгууллагад нам, хөдөлгөөнүүд гишүүдийнхээ шууд оролцоотойгоор өөрсдийн нэр дэвшигчдээ сонгодог. Энэ нь сонгуульт албан тушаалд нэр дэвшигчдийг сонгоход ч мөн адил хамаардаг (жишээлбэл Колумб).

Харин зарим тогтолцоонд СЗБЭ нь намын дотоод эрх мэдэл, сонгуульт ажилд нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг сонгох сонгуулийг зохион байгуулах, удирдах, хянахад намын доторх эрх бүхий байгууллагууд төлөөлөн оролцдог. Тухайлбал Гондурас, Доминиканы Бүгд Найрамдах Улсад СЗБЭ нь намаас дотоод сонгууль явуулахыг шаарддаг. Бусад СЗБЭ-үүд (жишээлбэл Чили, Мексик) намуудын удирдлага, нэр дэвшигчдийг сонгох сонгууль хууль, дүрэм, намын дотоод журмын дагуу явагдаж байгаа эсэхийг өөрсдийн санаачлагаар эсхүл намын шаардлагаар шалгах, мөн улс төрийн намын хурал, конвенцуудыг хянах бүрэн эрхтэй байдаг. Намын дотоод сонгууль ийм хяналт шалгалтгүй явагдсан тохиолдолд хүчингүйд тооцогдоно.

453. Урагвайн хуульд тусгайлан заасан байдаг. 1998 оны шинэчлэлтээр Сонгуулийн шүүх улс төрийн намуудын дотоод сонгууль, тодруулбал ерөнхийлөгчид нэр дэвшигч, улсын хэмжээнд шийдвэр гаргах байгууллагын гишүүнийг сонгохоор улс даяар ижил өдөр зохион байгуулагддаг сонгуулийн үйл явц, процесстой холбоотой маргааныг хянан шийдвэрлэх болсон. Мөн сонгуулийн шүүх эдгээр сонгуулийг зохион байгуулах, журам, шаардлагуудыг гаргах, сонгуулийн болон намын үйлдлийн эсрэг гаргасан нэхэмжлэл, давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг явуулдаг. Сонгуулийн шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхгүй.

454. Үндсэндээ СЗБЭ нь сонгуульт албан тушаалд улс төрийн намаас нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийг бүртгэнэ. СЗБЭ нь нэр дэвшигчийг хууль, намын дотоод журамд заасан процессын дагуу сонгосон эсэх, шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана.

455. Үүнээс гадна улс төрийн намын тэргүүн, нэр дэвшигчийг сонгох дотоод сонгуулийн процесстой холбоотой маргаан гарсан тохиолдолд сонгуулийн эрх бүхий этгээдийн үйлдлийн эсрэг эсхүл намд ашигтай үйлдлийг баталсан, бий болгосон сонгуулийн эрх бүхий этгээдийн үйлдлийн эсрэг маргааныг шийдвэрлүүлэхээр СМШЭ-д гомдол гаргана. А нам үндсэн хууль, бусад хууль, намын дотоод дүрмийн алийг зөрчсөнөөс үл хамааран А маргааныг хянан шийдвэрлэнэ. Ийнхүү маргааныг СЗБЭ-д хянан шийдвэрлэхээс өмнө нам дотроо маргааны талаар шийдэлд хүрэх бүхий л аргаа хэрэглэсэн байхыг шаарддаг.

Гишүүнийг хасах, бусад шийтгэл

456. Улс төрийн намын гишүүн бүр намын аливаа дотоод үйлдэл, шийдвэрийг хууль бус эсхүл эрхийг нь зөрчсөн гэж үзэж СМШЭ-д маргаан үүсгэж болно. Жишээлбэл гишүүнчлэлээс хасагдсан бол улс төрийн нэгдэлд нэгдэх эрхээ зөрчигдсөн гэж үзнэ. Ийнхүү маргаан үүсгэхэд дотоодод авах бүхий л аргаа шавхсан байх ёстой. Хэд хэдэн оронд намаас гишүүн хасах дотоод шийдвэрийг гаргахдаа гишүүний нэхэмжлэл гаргах эрх болон хууль, намын дүрэмд заасан процессыг хүндэтгэн авч үзэхийг хуулиар шаардсан байдаг.

457. СМШЭ намын гаргасан сахилгын шийдвэрт хууль зүйн хүрээнд бага хэмжээний судалгаа хийнэ. Энэ судалгаа нь журмын эсхүл хэлбэрийн өргөн хүрээнд хийгддэг боловч материаллаг эсхүл агуулгын хүрээнд илүү хязгаарлагдмал байдаг.

458. Өөрсдийн гишүүний эрхийг хүндэтгэн үздэг улс төрийн намын сахилгын шийтгэл оногдуулах нь гишүүдийн өөрсдийгөө зохион байгуулах эрхийн нэг хэсэг, мөн холбоонд нэгдэх суурь эрхийн нэг хэсэгт хамаардаг. Нам бүр өөрийн намын дүрэмдээ намын гишүүнийг намаас хасах шийтгэлийг оногдуулах үндэслэл, мөн бас гишүүнийг хасахад дагаж мөрдөх журмыг тусгадаг. Үүний гол санаа нь аливаа намын энэ төрлийн шийдвэр хууль зүйн хяналт шалгалтын нөгөө талд байна гэж үзэж нийтийн захиргааны байгууллага хөндлөнгөөс оролцох явдлаас зайлсхийхэд оршино.

459. Тодруулбал, холбооноос гарсан гишүүний тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүйтэй холбоотой маргаанд холбоонд нэгдэх сонгуулийн суурь эрхэд хууль, дотоод журамд гишүүнээс хасахаар заасан үндэслэл, шалтгааныг бүрдүүлэхэд оролцоогүй байгууллагадаа үлдэх гишүүний эрх багтаж байдаг.

Шүүхийн байгууллагаас гишүүний суурь эрхээ эдлэхийг үгүйсгэж, эсхүл хасаж болохгүй гэж хамгаалагдаж байдаг. Ялангуяа үндсэн хуулийн мандаттай байснаараа улс төрийн намууд иргэдийн улс төрийн оролцооны үндсэн хэрэгсэл, ардчилсан амьдралын дэмжлэгийн хувьд давамгайл үйл ажиллагаатай байдаг (жишээлбэл Испани).

460. Журмыг авч үзвэл, өөрийгөө хамгаалах чадваргүй байдалд оруулахын тулд хасахаар заналхийлүүлсэн гишүүнд сэрэмжлүүлэхийн зорилгоор СМШЭ-ээс Үндсэн хууль, намын үндсэн дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянан шалгадаг. Ингэхдээ дараахь зүйлсийг шалгах хэрэгтэй. Үүнд:

- Шийдвэрийг зүй ёсны байгууллага гаргасан эсэх
- Намын дотоод журамд заасан журмын дагуу явагдсан эсэх
- Явуулсан энэ журам нь нотолгоотой эрхийн замаар явагдсан эсэх. Жишээлбэл, түүнд хүний эрх, өөрийгөө хамгаалах эрхийг (сонсох, нотлох баримт бүрдүүлэх эрх, үүнээс гадна гэм буруугүйдээ итгэлтэй байх эрх) мэдэгдэнэ.
- Ерөнхийдөө хууль, намын дотоод журамд заасан ёсоор процессыг явуулах эрх.

Хэрвээ сахилгын шийтгэл оногдуулах үйл ажиллагаа эдгээр шинжүүдийг агуулдаггүй бол гишүүн намын дүрэмд заасан хууль зүйн үндэслэл, нотолгоог бүрэн хангасан журмаас гадуур намаас хасагдахгүй байх эрхийг зөрчих явдалтай нүүр тулахад өөрийгөө хамгаалах чадваргүй болно.

461. Намын дотоод маргааны агуулгын талд, улс төрийн нам өөрсдийгөө зохион байгуулах эрх чөлөөтэй болсноос эхлэн СМШЭ гишүүнийг намаас хасах шийдвэр гаргах үндэслэл үнэхээр бий болсон эсэх, намын захиргааны албаны шийдвэр үндэслэлтэй эсэхийг тодорхойлохын тулд өөрийгөө хязгаарладаг. Үндэслэл, шалтгааныг шалгахдаа шийдвэрийг дураараа биш, хувь тэнцүүлэн гаргах зарчмыг багтаасан эсэх, намын дотоод журам, хуулийн нөхцлийг хангасан эсэхийг шалгана.

Гэвч шүүхийн байгууллагын үүрэгт тавих энэ хязгаарлалт хамаарахгүй байж болно. Улс төрийн намд давамгайл байдал өгснөөр хасах шийдвэр гаргах эдгээр нөхцөл байдалд тухайлбал, гишүүний суурь эрхэд ялимгүй хэмжээгээр хохирол учруулах эсхүл зөрчихөд (жишээлбэл тэгш нөхцлөөр нийтийн өндөр албан тушаалд томилогдох эсхүл мөн чанараараа сонгуулийн бус бусад эрхүүд, жишээ нь нэр төртэй байх эрх, эдийн засгийн эрх) СМШЭ энэ фактыг тайлбарлаж, үнэлгээ өгч болно.

Улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналт

462. Улс төрийн намуудад олгосон нийтийн санхүүжилтийн хуваарилалт, намуудын санхүүжилт, тогтмол гарч буй зарлагын эх үүсвэрийн тайлан дахь мөнгө, хөрөнгөд тавих хяналт шалгалтын талаарх холбогдох байгууллагын (зарим тохиолдолд СЗБЭ) шийдвэрүүд маргааны зүйл байж болдог. Намуудын кампанит ажлын зардлын тайланд хийсэн хяналт шалгалтыг сонгуулийн дараа хийдэг. Түүнчлэн тогтмол бус хэрэглээнд гаргасан гомдолд холбогдох захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрүүд, нийтийн санхүүжилтийн тайлан, хэрвээ хууль, дүрэм зөрчсөн бол оногдуулсан шийтгэл, эсхүл оногдуулаагүй тухай

сонгуулийн байгууллагын шийдвэрүүд мөн маргааны зүйл байж болдог.

ii) Сонгуулийн үеийн маргаан

463. Сонгуулийн үеэр сонгуулийн бүртгэлийн мэдээлэл, санал өгөгчдийн бүртгэлийн хуудсын жагсаалт, бэлтгэн нийлүүлэлт, нэр дэвшүүлэлт, нэр дэвшигчдийн бүртгэл, санал өгөх байр, санал өгөх байранд томилогдсон албан хаагчдын томилгоо, сонгуулийн ажиглагчдын бүртгэл, сонгуулийн компани тэй ажилтай холбоотой үйл ажиллагаа зэрэг бэлтгэл үе шатны үйл ажиллагаанууд маргааны зүйлд хамаардаг.

464. Сонгуулийн дүнгийн талаарх маргаанууд голчлон сонгуулийн одортэй холбоотой байдаг. Тодруулбал санал өгөх журам, зохион байгуулалт, менежмент, санал өгөх байр, хэн санал өгөх боломжтой, боломжгүй болох талаар гаргасан санал өгөх байрны албан хаагчийн шийдвэр, санал хураалтын эрх чөлөө, нууц байдалтай холбоотой байдаг. Маргаанд бичигдсэн бусад зүйлсэд санал хураалтыг тоолох, нийлбэр дүнг гаргах үйл явц, сонгогдсон суудалд хийх хуваарилалт, үр дүнг зарлах, сонгуулийн хүчинтэй тухай шийдвэр, сонгуулийн үр дүнгийн нийтлэл багтдаг.

Сонгуулийн бүртгэлийг мэдээлэх

465. Сонгуулийн явцын бүртгэлийг мэдээлэхийн зорилго нь сонгогчдыг сонгуульд бүрэн оролцох иргэний сонгуулийн эрхийг бататгах боломж олгодог. Үүнээс гадна хууль бусаар сонгуульд оролцох, эсхүл бүртгэлтэй иргэнийг сонгуульд оролцуулахгүй байхтай тэмцэх боломжийг бий болгосон байх хэрэгтэй. Ийнхүү анхаарахад сонгуулийн өдрийн бэлтгэл ажиллагааны үед янз бүрийн үйл ажиллагааг зохион байгуулахад хувийн холбоотой 2 асуудал гарч ирдэг. Эдгээр асуудал нь сонгуулийн бүртгэлийн ерөнхий маргаан болон сонгогчдын жагсаалтын хувийн маргаан юм. Эхний төрлийн маргааныг гаргах эрхийг улс төрийн намууд ерөнхийлөн зөвшилцсөнөөр, хоёр дахь төрлийн маргааныг гаргах эрх сонгогчдод энгийнээр олгогдсон байдаг.

Нэр дэвшүүлэлттэй холбоотой бүртгэл, нэр дэвшүүлэлт

466. Ихэнх сонгуулийн дэглэмд улс төрийн намууд гол үүрэг гүйцэтгэдэг ч гэсэн хувийн нэр дэвшигчид голлодог. (Зарим сонгуулийн тогтолцоо улс төрийн намаас нэр дэвшээгүй, бие даан

нэр дэвшигчдэд боломж олгодог.) Нэр дэвшүүлэлтийн бүртгэл, эсхүл нэр дэвшүүлэлт нь энэ мэтээр аливаа сонгуулийн гол бүрэлдэхүүн болж байдаг. Нэр дэвшигчид тодорхой шаардлагуудыг хангаж байх ёстой бөгөөд үүнийг СЗБЭ-ээс шалгаж дүгнэлт гарган СМШЭ-ээс энэ дүгнэлтийг шалгана.

Сонгуулийн хорооны албан хаагчийн шийдвэр, сонгуулийн хорооны байршил

467. Сонгуулийн хорооны байршил, албан хаагчийг томилох шийдвэр сонгууль, бүх ард түмний санал асуулгыг зохион байгуулахад чухал үүрэгтэй. Үүний зорилго нь хуулиар тогтоосон газарт, хуулийн шаардлагад нийцсэн албан ёсны байгууллагаар санал хураалт тоологдож, тооцоологдсон болохыг батлахад оршино. Зарим сонгуулийн тогтолцоонд иргэд таамгаар сонгогдож, санал хураалтын албан хаагчаар ажиллахаар бэлтгэгддэг. Өөрөөр хэлбэл тэд улс төрийн намаас санал болгосон эсхүл энгийн албан хаагчид байдаг.

468. Санал хураах хорооны албан хаагчдын холбоо хамаарал сонгуулийн тогтолцоо хооронд ялгаатай байх бөгөөд орон бүрийн туршлага, уламжлалыг тусгасан байдаг. Олон оронд, жишээлбэл Зүүн Европын орнуудад улс төрийн намуудын төлөөлөгчид санал авах болон тоолох ажлыг хариуцдаг. Бусад орнуудад хорооны албан хаагчид сонгуулийг хуулийн дагуу явуулж байгааг батлах, тэдний үйл ажиллагааг хянах зорилгоор хорооны албан хаагчдын холбоо хамаарал бага байдаг. Иймэрхүү тохиолдолд хариуцлагыг нийтийн албан хаагчдад оноодог (жишээлбэл Урагвай), эсхүл таамгаар сонгогдож, бэлтгэгдсэн иргэдэд хариуцлагыг шууд оноодог (жишээлбэл Индонез, Мексик).

Нийтийн албан хаагчдын холилдсон байдал засгийн газарт суудалтай намд ашигтай үйл ажиллагаа явуулсан байж магадгүй гэсэн сэжгийг ихэсгэдэг болохыг зарим орны туршлага харуулсан. Зарим оронд сонгуулийн хорооны албан хаагч нийтийн албан хаагч биш байх шаардлага тавигддаг. Бусад оронд СЗБЭ сонгуулийн хорооны албан хаагчдыг томилох ба үүгээр хязгаарлагдахгүй иргэний нийгмийн байгууллагуудыг багтаадаг.

469. Үүнтэй адилаар санал хураах газрын байршлыг тогтоохдоо тодорхой, бодит журмыг баримтлан байршлыг тодорхойлсон шаардлага тавигддаг. Ингэхдээ сонгогчдын явж хүрэх зам болон оролцоог хамгийн ихээр дэмжих зорилгоор газар зүйн хувьд сонгогчдод боломжит хэмжээгээр ойр байх, мөн үйл ажиллагаагаа

хэвийн явуулахад зөвшөөрөгдсөн зай, талбай нөхцөл байдалтай байх, сонгогчид сонгуулийн өдөр хяналт тавих боломжтой байх гэсэн журмыг баримталдаг. Ашигтай зохион байгуулалт жишээлбэл нууц санал хураалт, шударга байх нотолгооны аливаа зөрчилд саад хийх ёстой. Шударга байх нотолгоог барилгын эзэмшигч, эсхүл барилгыг хариуцах тэдний хууль ёсны хариуцлага, эсхүл нам, нэр дэвшигчидтэй зарим оронд засгийн газартай аливаа улс төрийн холбоогүй гэсэн нотолгоо хамаарна.

Үүнээс гадна зарим сонгуулийн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод тохирсон замтай байх, сонгуулийн хороо хүйсээр хуваагдсан байх, тайлан мэдээ сонгуулийн тойргуудын хил заагаар хүлээн авагдсан байх, санал хураах газрын талбай нэг сонгуулийн тойргийн хязгаар дотор бүрэн хамарсан байх, сонгуулийн өдөр бүгдийг хамарч үйлчлэх боломжгүй тэнцүү бус олон тооны сонгогчдод сонгуулийн хороо үйлчлэхгүй байх ёстой.

470. Санал авах газрын албан хаагчид, санал авах газрын байршлын талаар гаргасан СЗБЭ-ийн шийдвэрүүдийг үндсэн хууль, хуулийн дагуу эсэхийг баталгаажуулахаар СМШЭ-ээс шалгаж болно.

Сонгуулийн кампанит ажилтай холбоотой үйл ажиллагаа

471. Төрөл бүрийн СМШ тогтолцоо өрсөлдөгчид (улс төрийн намууд, нэр дэвшигчид)-тэй холбогдуулан сонгуулийн кампанит ажил үндсэн хууль, хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг батлах янз бүрийн механизмыг санал болгодог. Магадгүй холбогдсон (жишээлбэл мэдээллийн хэрэгсэл) бол гуравдагч этгээдтэй холбогдуулан шалгана. Энэ нь сонгуулийн тэмцээний тоглолтын талбарыг батлахад чиглэдэг. Өрсөлдөгчид болон бусад хүмүүсийн аль алины үйл ажиллагаа сонгуулийн тэмцлийг нэмэгдүүлж болно.

472. Сонгуулийн кампанит ажлууд өндөр ачаалалтай байж болно. Эдгээр ажлууд зөвхөн сонгуулийн маргааныг бус сонгуулийн үйл ажиллагаа, дүрэм, журмыг зөрчихтэй холбогдуулан ял оногдуулах явдлыг үүсгэдэг.

Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар энэхүү гарын авлагад өгүүлээгүй болно.

473. Зарим СМШ тогтолцоо маргааныг шууд СМШЭ шийдвэрлэх механизмтай байдаг. Өөрөөр хэлбэл, эхлээд СЗБЭ-ээс өмнө асуудлыг хүлээж авах нь чухал. Ингэхдээ ихэвчлэн захиргааны шинжтэй сонгуулийн маргаан эсхүл захиргааны үүрэг хариуцлагыг зөрчсөн

этгээдтэй холбоотой асуудалд чиглэгддэг.

474.СМШЭ-ийн хяналт шалгалт ерөнхийдөө СЗБЭ-ийн сонгуулийн компанит ажлын бүхий л шийдвэрүүдийг анхааран авч үздэг. Эдгээр шийдвэрүүд компанит ажилд зориулсан санхүүжилт, сонгуулийн материалыг тараахаар тогтоосон газрууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сонгуулийн зар сурталчилгааг үзүүлэх албан ёсны цагийн хуваарилалт зэрэгтэй холбоотой шийдвэрүүд байдаг. Сонгуулийн үр дүнд чухал нөлөөлөх аливаа тогтмол бус зүйлээс сэргийлэхийн тулд маш богино хугацаанд үр дүнтэй арга хэмжээг цаг хугацаанд нь авах ёстой.

Сонгуулийн өдөр, сонгуулийн дүн

475. 464 дүгээр хэсэгт заасан сонгуулийн дүнг тоолох, зарлах өдөртэй холбогдон олон асуудал үүсдэг. Зарим оронд эрх бүхий байгууллагаас (ихэвчлэн СЗБЭ ба/эхсүл СМШЭ) шийдвэрлэж, баталсан сонгуулийн дүнгийн маргаан албан ёсоор сонгуулийн дүн болон сонгогдсон хүний нэрийг зарладаг. Хэдий тийм боловч ихэнх СМШ-ны тогтолцооны үед маргаан үүсгэсэн үйл ажиллагаа, шийдвэрүүд сонгуулийг батлахтай холбоотой байдаг (сонгууль хүчин төгөлдөр явагдсан болохыг зарлах мөн түүний үр дүн, сонгогдсон хүмүүсийн нэрсийг зарлах). Эдгээр маргааныг СЗБЭ эхсүл сонгуулийн хэрэг хянан шийдвэрлэх доод шатны байгууллага, эхсүл СМШЭ-ийн хамгийн дээд шатны албан байгууллага хариуцна.

476. Зарим тогтолцоонд сонгууль албан ёсны болж, дүн зарлагдсаны дараа хууль тогтоох байгууллага эхсүл өөр шүүхийн байгууллагаас маргааныг хүлээн зөвшөөрдөг. Нэгдсэн вант улсад сонгуулийн дүнг тооллого дуусмагц зарладаг. Дараа нь сонгогдож чадаагүй нэр дэвшигч сонгуулийн шүүхэд (хүснэгт 6.14-г жишээ болгон харна уу) зарга (сонгуулийн зарга гэнэ) гаргаж болно. Францад үндэсний сонгууль, ард нийтийн санал асуулгын дүнгийн маргааны талаар нэр дэвшигч, бүртгэлтэй сонгогчийн аль нь ч Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно.

iii) Сонгуулийн дараа үеийн маргаан

477. Сонгууль болсны дараа улс төрийн намуудын хөрөнгийн эх үүсвэрийг хянан шалгах болон тэд сонгуулийн компанит ажлын үеэр хөрөнгийг хэрхэн зарцуулсантай холбогдон маргаан үүсдэг. Кампанит ажлын хэвийн зардлыг улс төрийн намын тогтмол зардлаас илүү шалгадаг. Өөр нэг маргаан нь сонгуулийн бүртгэлийн эцсийн мэдээг зарлахтай холбоотой үүсдэг.

478. Орон нутгийн, үндэсний хэмжээний сонгууль, үүнээс гадна үндэсний сонгууль, шууд ардчилсан хэрэгсэл зэрэг сонгуулийн процессын бусад төрлүүдээс маргаан бий болж болно. Энэ нь сонгууль болсон үеийн тохирох хууль, дүрмээр шалгах, СМШ тогтолцооны үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, сонгуулийн журмыг шинэчлэхийг санал болгох сайн туршлага болдог.

Сонгуулийн бусад төрлийн маргаан

479. Зарим СМШ тогтолцоонд сонгуульд албан тушаалын, тухайлбал улс төрийн намын дотоод сонгууль (442-445 дахь хэсэг), мэргэжлийн холбоо, дундаж бүлгүүд (Чили, Прагвай), их сургуулийн албан тушаал (Прагвай, Урагвай) гэх мэт албан тушаалын сонгуулиас бусад гол сонгуулийн маргааныг СМШЭ хянан шийдвэрлэж, хэлэлцэх бүрэн эрхтэй байдаг. Мексикийн Холбооны Шүүхийн салбарын Сонгуулийн шүүхийн Дээд танхим сонгуулийн байгууллага (СЗБЭ, СМШЭ) болон ажилчдын хоорондын хөдөлмөрийн маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх, дүрэмтэй.

480. Олон СМШ тогтолцоонд СМШЭ ардчиллын журамтай холбоотой маргааныг, тухайлбал иргэдийн санаачлага, ард нийтийн санал асуулга, дахин сонгууль, тодруулбал СЗБЭ-ийн бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулагддаг сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг хуульчилсан байдаг. Жишээлбэл, Францын Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн дагуу ард нийтийн санал асуулгын дүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэнэ. Үндсэндээ ардчиллын хэрэгслүүдийг төлөөллийн сонгуулийн үед ч хэрэглэдэг, бусад үед ч хэрэглэдэг. Ардчилсан үзлийн хэрэгслийн талаар илүү дэлгэрэнгүйг Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн “Шууд ардчилал” гарын авлагаас үзэж болно.

3. Маргаан үүсгэхээр гомдол гаргах

481. Иргэн, хуулийн этгээд, тухайлбал улс төрийн нам, нэр дэвшигч, сонгогч, иргэн, эрх бүхий байгууллага, ажиглагч, мэдээллийн хэрэгслүүд сонгуульд нөлөөлсөн үйл ажиллагаа, процессын эсрэг маргаан үүсгэх төрөл бүрийн нөхцлүүд СМШ тогтолцоонуудад байдаг. Ингэх нь аливаа сонгуулийн үйл ажиллагаа, шийдвэр өөрт нь хохирол учруулж байна гэж үзсэн хүн бүр үүний эсрэг СМШЭ-д гомдол гаргах иргэний суурь эрхийг СМШ тогтолцоод үндэслэхэд чухал үүрэгтэй. Энэ нь хэд хэдэн олон улсын хүний эрхийг хангах хэрэгсэл болох сонгуулийн шударга ёсонд хүрэх хүний эрхийн нэг хэсэг юм. Хэрвээ олон улсын эсхүл бүсийн аливаа хэрэгслийн тал гэж тухайн

оронд олгогдсон эрхийн дагуу сонгуулийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн хүнийг сонгуульд оролцуулахаас татгалзвал хүний эрхийг хамгаалах олон улсын эсхүл бүсийн арга хэрэгслүүдийг хэрэглэн зарим тохиолдолд эдгээрийг бие биеээ нөхөн хэрэглэх бүрэн эрхтэй (407 дахь хэсгийг үзнэ үү).

482. Тустай зүйл гэвэл сонгогчид иргэний үнэмлэх эсхүл сонгогчийн бүртгэлийн хуудсаар сонгуулийн бүртгэлд хууль бусаар бүртгэгдсэн, эсхүл бүртгэгдээгүй, тэднийг бүртгэхээс татгалзсан явдлын эсрэг маргаан үүсгэх эрхийг бүхий л СМШ тогтолцоогоор хүлээн зөвшөөрсөн байдаг. Түүнчлэн зарим оронд зөвхөн сонгогч хувь хүний сонгуулийн бүртгэлтэй холбоотой шийдвэр байсан ч улс төрийн нам, нэр дэвшигч, нийтийн болон сонгуулийн прокурор ч гэсэн үүнтэй холбогдуулан маргаан үүсгэх эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн улс төрийн намууд сонгуулийн бүртгэлийн дүн, дээрх намуудын ажиглалт дээр үндэслэсэн сонгуулийн байгууллагын хариуцлагын дараагийн тайлангийн эсрэг маргах эрхтэй.

483. Үүнээс гадна СЗБЭ эсхүл эрх бүхий байгууллагын улс төрийн намыг шинээр бүртгэх эсхүл бүртгэхээс татгалзахтай холбоотой шийдвэр бусад улс төрийн намууд, эсхүл сонирхсон этгээдийн (олон оронд зөвхөн иргэн байхыг шаарддаг) зүгээс гаргах маргааны зүйл болж байдаг.

484. Улс төрийн намуудын дотоод дүрэмтэй холбогдуулан маргаан үүсгэх эрх ихэвчлэн тухайн намын гишүүн эсхүл бусад улс төрийн намуудад (СЗБЭ-ээс баталж, хүчин төгөлдөр болгосон тохиолдолд) олгогддог боловч Колумбад аль ч иргэн улс төрийн намуудын дүрмийн заалтууд Үндсэн хууль, хуультай зөрчилдөж байна гэж Сонгуулийн үндэсний шүүхэд маргаан үүсгэх эрхтэй. Зарим сонгуулийн тогтолцоод СЗБЭ эсхүл бусад эрх бүхий байгууллага намын дүрмийг үндсэн хууль зөрчсөн, эсхүл хууль бус байна гэж маргаан үүсгэх боломжтой.

485. Тустай нь бүх орон улс төрийн намуудыг СЗБЭ-ийн тэдэнд нөлөөлсөн эсхүл хууль бус гэж үзсэн шийдвэрийн эсрэг, мөн СЗБЭ-ийн сонгууль, сонгуулийн дүн, эсхүл сонгогдсон этгээдэд бэлдсэн гэж үзсэн шийдвэрүүдийн эсрэг маргаан үүсгэх эрхийг зөвшөөрдөг. Голдуу улс төрийн байгууллагын бусад төрлүүд мөн ингэж болно.

486. СМШ тогтолцоод ерөнхийдөө үүнийг хууль тогтоох байгууллага, нэмээд улс төрийн намуудад хариуцуулсан байдаг. Нэг болон түүнээс дээш засгийн эрхэнд гарсан эсхүл шинээр сонгогдсон аль ч хууль

тогтоогчид хууль тогтоох байгууллагад сонгуулийн маргааны гомдол гаргах эрхтэй байдаг (жишээлбэл Аргентин, Герман, эсхүл АНУ-ын сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгт).

487. Үүнээс гадна ихэнх улс орнуудад СЗБЭ-ийн зохион байгуулсан сонгуулийн дүнг хууль ёсны эсэх талаар СМШЭ-д маргаан үүсгэх эрхийг нэр дэвшигчид хүлээн зөвшөөрсөн байдаг. Зарим тохиолдолд нэр дэвшигчид дээр дурьдсан шиг эрх олгоогүй үед нэр дэвшигч зөвхөн маргаан үүсгэгч гуравдагч этгээдийн байр сууринаас оролцоно. Харин нэр дэвшигчийн хүсэл зоргийг илэрхийлэх үүднээс оролцохгүй.

Ийм байдлаар нэр дэвшигч маргаан үүсгэх нь голдуу хувьслын үе шат, улс төрийн намын тогтолцооны шинж чанар, цаашлаад бие даан нэр дэвшүүлэх боломжтой холбоотой байдаг нь үнэн юм.

489. Үүнээс гадна зарим орнуудад сонгогдсон нэр дэвшигчтэй холбогдуулан, улс төрийн намууд, нэр дэвшигч, түүнчлэн гомдол гаргах эрх олгогдсон иргэнд сонгуулийн дүнтэй холбогдуулан маргаан үүсгэх боломжийг (жишээ нь) олгосон байдаг. Хэдий маргааны боломжит тархац СМШЭ-ээс маргааныг зүй ёсоор хянан шийдвэрлэж, хэлэлцэхэд ялангуяа хугацаа бага байх үед саад болж магадгүй боловч СМШ тогтолцоод хүрэхийг хялбарчлахад чухал бөгөөд сайн хүчин зүйл юм. Энэ нь сонгуулийн итгэл үнэмшил, хууль ёсыг бууруулж болзошгүй.

489. Зарим оронд маргааны бий болгосон улс төрийн нам ба/эсхүл аливаа сонирхолтой гуравдагч этгээдийг бус сонгуулийн прокурор ба/эсхүл үндсэн өмгөөлөгч, эсхүл нийгмийн ашиг сонирхлыг төлөөлж буй яамыг оролцуулан хянан хэлэлцдэг.

4. Маргаан гаргах хугацаа, шийдвэр

490. Засгийн газрын байгууллага хугацаандаа шинэчлэгдэх ёстой, мөн сонгуулийн кампанит ажил илүү богино байх хандлага байдаг учир сонгуулийн маргааныг гаргах, шийдвэрлэх хугацаа маш богино байдаг.

Хүснэгт 7.1. Сонгуулийн дүнгийн маргааны гомдол гаргах хугацааны хязгаарлалт: зарим жишээ

Сонгуулийн 1 өдрийн дараа
2 өдрийн дараа
3 өдрийн дараа
10 өдрийн дараа
28-30 өдрийн дараа
30 болон түүнээс дээш өдрийн дараа

491. Сонгуулийн бүртгэлтэй холбоотой маргааны гомдол гаргах хугацааг өргөн тогтоосон байдаг. Ихэнх тохиолдолд гурваас таван өдөр байх бөгөөд хамгийн ихдээ 30 хүртэл хоног байна. Ихэнх тохиолдолд маргаан үүсгэсэн үйл ажиллагаа эсхүл шийдвэрийн өдөр, эсхүл сонирхогч этгээдэд албан ёсны мэдэгдэл хүргэсэн өдрөөс тоолж эхэлдэг. Сонгуулийн бэлтгэл үеийн үйл ажиллагаатай холбоотой маргааны гомдлыг гурваас таван өдөрт гаргах ёстой.

492. Сонгуулийн дүнтэй холбоотой зарим маргааны гомдлыг санал хураах байранд тооллого явагдсаны дараа нэн даруй гаргах хэрэгтэй. Бусад гомдлууд буюу зарга, урьдчилсан шалгалтын гомдлыг сонгуулийн дээд шатны байгууллагад хоёр хоногийн хугацаанд маш товч гомдол гаргаж болно (жишээлбэл Босниа, Херцеговина). Хэд хэдэн оронд сонгуулийн дүнгийн гомдлыг гурваас таван өдөрт гаргах бөгөөд зарим тохиолдолд 15 эсхүл 30 хоногоор сунгадаг. Зарим жишээг Хүснэгт 7.1-ээр үзүүлэв. Жишээлбэл Нэгдсэн вант улсад 21 хоногийн хугацаатай бөгөөд авлигатай холбоотой тохиолдолд 28 хүртэл хоногоор сунгадаг. Зарим тохиолдлыг онцгойлж авч үздэг, жишээлбэл албан ёсоор зарлаж сонгогдсон иргэний эсрэг маргааны гомдол. Энэ нь зарим шаардлагагүй байдлыг үүсгэж, энэ шаардлагагүй байдал нь сонгогдсон хүнийг өөрийгөө хамгаалах боломжгүй болгоход хүргэж болно.

493. Зарим СМШ тогтолцоо СМШЭ-ээс сонгуулийн дүнгийн маргааныг хянан шийдвэрлэх тодорхой механизмтай байдаг. Шийдвэрийг гурван өдрийн дотор давж заалдах боломжтой. Дээр дурдсанаар зарим тогтолцоонд Үндсэн хууль, хуулийн дагуу байгуулагдсан сонгуулийн бус шүүхийн байгууллага эсхүл хууль тогтоох байгууллагад дараагийн гомдлыг гаргаж болохоор заасан байдаг.

494. Зарим оронд сонгуулийн үеийн гадна гаргасан шийдвэртэй, тухайлбал улс төрийн намуудын бүртгэлтэй холбоотой маргааны гомдол гаргах хугацаа арай урт байдаг.

495. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх хугацаа байнга тодорхой тогтоогдсон байдаггүй бөгөөд нөхцөл нь өөр өөр байдаг. Хамгийн чухал зарчим бол маргаан нөхөгдөшгүй хохирол учруулахаас өмнө шийдвэрлэгдсэн байхад оршино. Энэ нь магадгүй маргаан гарсан үед байхад үүнийг шийдэх боломжит хугацаа байхгүй байна гэж СМШЭ үздэг. Хэрвээ маргаан хойшилсон, зөрчил гарсан гэх нотлох баримт хангалтгүй бол шийдвэр гаргах, зөрчлийг агуулгын хувьд засах арга хэмжээг авах хугацаа шаардлагатай. Хэрвээ үүнийг хийгээгүй тохиолдолд маргааныг хүлээн зөвшөөрөх боломжгүй, үл тоомсорлосон болохыг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ энэ нь эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх дараагийн үйл ажиллагаанд саад болсон, урьдчилан шийдвэрлэсэн явдал биш. СМШЭ сэрэмжтэй, байр суурин дээрээ байх ёстой боловч тодруулбал, сонгуулийн процессын өдрийн турш, хэрвээ шаардлагатай бол хэт урт хугацааны хэрэгт ч гэсэн гаргасан шийдвэр нь түүний хэлэлцүүлэг, шийдвэр гаргахад чанарын нөлөөлөл бий болгохгүй.

496. Сонгуулийн бүртгэлийн маргааныг шийдвэрлэх хугацаа голдуу маргааныг гаргаснаас хойш зургаагаас арван өдрийн хооронд байна. Улс төрийн намын байгуулалтын дагуу шийдвэртэй холбоотой маргааныг шийдвэрлэх хугацаа голдуу гурваас арван таван өдрийн хооронд байна. Сонгуульд бэлтгэх хугацаанд гарсан шийдвэр, явуулсан үйл ажиллагааны эсрэг гаргасан маргааныг гурваас зургаан хоногийн дотор шийдвэрлэнэ.

497. Сонгуулийн дүнтэй холбоотой маргааныг СМШЭ маргааныг зөвшөөрч болохуйц гэж үзсэнээс хойш нэгээс арван өдрийн дотор шийдвэрлэнэ. Жишээлбэл, Гуатемалад Шударга ёсны Дээд Шүүх атр-ого өргөдөл, сонгуулийн эрхийг шүүхээс хамгаалах маргааныг гурван өдөрт, Үндсэн хуулийн шүүх давж заалдах гомдлыг таван өдөрт шийдвэрлэнэ. Колумби болон бусад нийтийн эрх зүйн системд энэ хугацаа 50 өдөр байдаг хэдий ч, жишээлбэл Бангладешд сонгуулийн маргааныг шийдвэрлэх хугацааны дээд хугацаа байдаггүй. Зарим системд сонгогдсон байгууллагыг бүрдүүлэх, тангараг өргөхөөс өмнө зарласан байхын тулд сонгуулийн дүнг зарлахаас өмнө маргааныг шийдвэрлэсэн гэсэн тайлбар хийж мэдэгддэг.

498. Хууль тогтоох байгууллагын өмнө сонгуулийн дүнгийн маргаан хийгдсэн газар, жишээлбэл Аргентин, АНУ-д тус тусын танхимуудын дүрмээр аливаа хязгаарлалтыг хийдэггүй. Эсрэгээрээ сонгогдсон байгууллага чуулганаа эхэлсний дараа маргааныг шийдвэрлэхийг зөвшөөрдөг. Энэ нь зарим хууль тогтоогчид танхимын суудлыг түр зуурын хугацаанд авсан, тус тусын маргааны дүнгийн зүйлийг авсан

байж болно, мөн хожим хэн нэгэнд ашигтай байхаар суудал аваагүй гэдгийг илэрхийлдэг.

499. Түүнчлэн зарим СМШ системд шүүхийн байгууллагад үүрэг оногдуулдаггүй тохиолдол байдаг, жишээлбэл Колумбийн Улсын Зөвлөлийн хэлтсийн (5 дугаар зүйл) үүрэг бол нэг жил хүртэл сонгуулийг хүчингүй болгох, гэвч энэ нь бодит байдалд үүнээс ч удаан байдаг. 2009 оны долдугаар сард энэ хэлтсээс 2006 оны сенаторын сонгуулийг хүчингүй болгож, Үндэсний Ерөнхий Өмгөөлөгчийн байгууллагаас (Procurador General de la Nación) гаргасан маргааны хариуд дахин тоолохыг даалгасан. Дүгнэлтээр улс даяархи сонгуулийн хэд хэдэн хороонд 33000 санал нөлөөлсөн олон янзын буруу ташаа зүйл байна гэж дүгнэсэн. Энэ нь 102 сенатын гишүүний сонгуулийн дүнг өөрчилж болох, тэдний зарим нь суудалгүй болохтой холбоотой байна гэж үзсэн. Үүнтэй ижил үед Үндсэн хуулийн 3 дугаар хэсгийн 179 дүгээр зүйлийн дагуу Улсын Зөвлөхийн 5 дугаар хэсэг 2006 оны сонгуулиас 6 сарын өмнө Засгийн газартай гэрээ хийсэн гэсэн үндэслэлээр нэг Сенаторын суудлыг хүчингүй болгосон. Гэсэн хэдий ч 2010 оны нэгдүгээр сард Улсын Зөвлөх өмнөх шийдвэрээ бүхэлд нь хүчингүй болгосон. Учир нь тэрхүү гэрээг сонгууль болохоос долоон сарын өмнө байгуулсан болохыг олж тогтоон энэ нь Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзсэн.

500. Зарим СМШ системд тусгайлсан бус сонгуулийн шүүхэд маргааныг шийдвэрлэх үүргийг даалгасан байдаг. Жишээлбэл шууд шүүхүүд шүүхийн байгууллага, үндсэн хуулийн, захиргааны шүүхийн (тодруулбал эдгээр нь сонгуулийн бэлтгэл, сонгуулийн дүнтэй холбоотой маргаан, өргөдлийг шийдвэрлэдэг) нэг хэсэг байдаг. Ингэснээр сонгуулийн маргааныг цаг хугацаанд нь шийдвэрлэх боломжтой.

5. Нотлох баримт

501. Аливаа баримт бичиг, мэдүүлэг, мэдэгдсэн фактыг батлах эсхүл үгүйсгэхэд чиглэсэн бодит объект нотлох баримтад хамаарна. Сонгуулийн хуульд нотлохтой холбоотой журам бараг тусгагдаагүй байдаг. Зарим тохиолдолд сонгуулийн хууль иргэний эсхүл захиргааны процессын хуулиас ижилсэн байдаг. Сонгуулийн бус шүүхийн байгууллагаас маргааныг шийдвэрлэдэг тогтолцоотой зарим оронд энэ байгууллагад ихэвчлэн ирдэг маргаанд тохирсон процессын хуулиар нотлох баримтын журмыг олон удаа баталдаг.

а) Нотлох баримтыг бүрдүүлэх

502. Эрүүгийн хэрэгт маргаан хийж байгаа тал өөрийн хамгаалалт, мэдэгдлийг батлахын тулд нотлох баримтыг бүрдүүлэх үүрэгтэй байдаг. Нотлох баримтын бүрдүүлэлтэд СТШЭ-ийн шийдсэн асуудалд хангалттай нотлох баримт танилцуулах намын үүрэг болох бүтээгдэхүүн бүрдүүлэлт хамаардаг бөгөөд үүгээр ч барахгүй СМШЭ-ээс фактыг шалгахдаа энэ талд ашигтай замаар шалгахад СМШЭ-д итгүүлэх үүрэг болох итгэл үнэмшлийг бүрдүүлэх хамаарна.

Иргэний хэрэгт, ялангуяа нийтийн эрх зүйн системд шийдвэрт “магадлалын тэнцвэржилт дээр”, “нотлох баримтын давуу талаар” хүрдэг, мөн эрүүгийн хэрэгт үйлдэл нь “үндэслэл бүхий эргэлзээний нөгөө талд” хийгдсэн байх ёстой.

503. Ихэнх сонгуулийн мөн/эсхүл процессын хуульд мэдэгдэл хийсэн хүн эсхүл тал үүнийгээ батлах үүрэгтэй гэсэн үндсэн зарчим тодорхой эсхүл далд тусгагдсан байдаг. Мэдэгдэл ямар нэг зүйлийг факт гэж баталж байгаа эерэг төрлийн эсхүл ямар нэг зүйлийг факт гэж үгүйсгэж байгаа сөрөг төрлийн байж болно. Зөвхөн маргасан эсхүл маргаантай фактууд нотлох баримтыг бүрдүүлэхийн тулд зарладаг. Хууль өөрөө нотолгооны зүйл биш, сайн мэдэх фактууд биш эсхүл батлах боломжгүй зүйл биш.

504. Эдгээр зарчмууд үндсэндээ СЗБЭ-ийн явуулсан эсхүл хийсэн захиргааны үйл ажиллагаа, шийдвэрүүдийн хүчин төгөлдөр байх таамаглалыг хавсаргаж байдаг. Сонгуулийн захирамжилсан үйл ажиллагааг хууль бус, алдаатай гэж маргасан тохиолдлыг авч үзвэл маргааныг хийж байгаа тал маргаж буй үйл ажиллагаа болсон, энэ нь хууль бус эсхүл бүрдүүлэлт нь алдаатай гэдгийг батална. Хэрвээ маргаж байгаа тал үүнийхээ нотлох баримтыг бүрдүүлж чадахгүй бол гомдол үндэслэлгүй болохыг мэдэгдэн, СЗБЭ-ийн сонгуулийн захирамжилсан үйл ажиллагаа хүчинтэй хэвээр үлдэнэ.

б) Нотолгооны хэлбэр

505. Нотолгооны хэлбэрт СМШЭ-ийн үзлээр нотлох баримтыг үнэмшүүлэх элементүүд багтана. Нотолгооны хэлбэрийг тодорхойлох нь СМШЭ-ээс сонгуулийн хугацааны хүснэгтэд заасан хугацааны дотор шаардлагатай, хангалттай элементэд үндэслэн шийдвэр гаргахад туслах зорилготой.

506. Зарим сонгуулийн эсхүл процессын хуульд (жишээлбэл Колумби, Мексик) маргагч бодит эсхүл хуулийн аргументыг дэвшүүлж болох

нотлох баримтын хэлбэрүүдийг танин мэдүүлэхийн тулд нотолгооны хэлбэрийг тодорхойлсон байдаг. Мөн зарим тохиолдолд СМШЭ-ээс тэдэнд хамааралтай болохыг нөлөөлөх, үйлчлэх зорилгоор тодорхойлсон байдаг. Гэвч ихэнх сонгуулийн процессын хуульд үүнийг тодорхойлоогүй байдаг. Зарим орны хуульд иргэний болон захиргааны процессын хуульд өөрөөр заасан бол хууль гаргаж болно гэж заасан байдаг (жишээлбэл Боливи, Гуатемала, Прагвайн хууль). Ихэнх оронд маргаан гаргаж байгаа өргөдөл, гомдол, гомдлын товч мэдээлэл, мөн нэхэмжлэл, хариуцагчийн тайлбарт холбогдох нотлох баримт бичгийг хавсаргасан байхыг шаарддаг (жишээлбэл Чили, Комта Рика, Экуадор, Мексик, Перу).

507. Талууд нотолгооны аливаа хэлбэрийг санал болгож болно гэж тодорхой заасан хэд хэдэн системд зарим хязгаарлалт, тухайлбал дараахийн заримыг эсхүл бүгдийг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- сонгуулийн баримт бичиг;
- маргаж байгаа үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой албан ёсны баримт бичгийг хамруулсан нийтийн болон хувийн баримт бичиг;
- хураамж, мэдүүлэг, шинжээчийн нотлох баримт, нөхцөл байдлын нотлох баримт;
- хуулийн болон хүний таамаглал

Эдгээр нь бүгдээрээ тусгайлсан хязгаарлалттайгаар хүлээн зөвшөөрөгдөж болно. Жишээлбэл нотлох баримт үйлдэлтэй хамааралтай байх ёстой.

508. Ихэнх улсад СМШЭ гарч ирсэн фактыг илүү сайн ойлгохын тулд мэдэгдэл гаргасан тал үүнийгээ нотлох үүрэгтэй гэсэн зарчмаас хөндийрөлгүйгээр нэмэлт нотлох баримт шаардах эрхтэй байдаг.

509. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх хугацаа бага байдгаас шалтгаалан нотолгооны хэлбэртэй холбоотой хууль, журам байдаггүй газарт СМШЭ-үүд талуудын гомдлыг дэмжихэд хүлээн зөвшөөрөгдсөн тохиромжтой эсхүл нийцсэн нотлох баримтад тавих шалгуурыг гаргасан байдаг. Тухайлбал сонгуулийн дүнтэй холбоотой маргаанд хэрвээ эс тооцоогүй бол гэрчийн мэдүүлгийг хязгаарласан байж болно.

в) Нотлох баримтыг үнэлэх тогтолцоо

510. Процессын болон нотлох баримтыг хуульд баримталсан ихэнх онолоор нотлох баримтыг шинжлэх тогтолцоог дараах дөрвөн бүлэгт ангилдаг. Үүнд:

- a. Хуулийн дагуу эсхүл хууль бусаар нотлох баримтыг үнэлэх тогтолцоо. Энэ тогтолцоонд хуулиар СМШЭ нотолгооны хэлбэрүүдийг анхаарч үзэх хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлдэг.
- b. Чолоот нотлох баримтын тогтолцоо. Энэхүү тогтолцоонд шүүгч аливаа хэлбэрийн саадгүйгээр, тодруулбал хуулийн аливаа саадгүйгээр өөрийн үзэмжээр хэрэг маргааныг чөлөөтэй шийдвэрлэхийн тулд хууль зүйн аливаа саадгүйгээр санал болгосон, хүлээн зөвшөөрсөн, гаргасан нотлох баримтыг СМШЭ үнэлж болно.
- c. Дүгнэлт, шүүхийн шийдвэрт хүрэх зорилгоор нотлох баримтыг үнэлэх, үйл ажиллагааг явуулах логикийн, үндэслэл бүхий журмын тогтолцоо (Испанийн 'sana critica'). Энэхүү тогтолцоонд СМШЭ логикийн болон туршилтын дээд хэмжээний журмыг баримтлан хэрэг маргааны материал дахь элемент бүрийн үр ашгийг тодорхойлох эрхтэй байдаг.
- d. Холимог тогтолцоо буюу дээрх гурван системийн элементүүд холилдсон тогтолцоо.

Sana critica тогтолцоо нэг, хоёрдугаар тогтолцооны хооронд байдаг. Энэ тогтолцоонд нотлох баримтын хэсгийг гаргаж өгөх үүрэг хүлээлгэхийн үр ашгийг хуулиар тусгайлан заагаагүй байдаг. Түүнчлэн энэ нь СМШЭ-ийн мэдэлд чөлөөтэй өгдөг. СМШЭ хэргийн материал дахь элемент бүрийг хэрхэн үнэлсэн шалтгаан, шударга байдлыг заах ёстой байдаг.

511. Маш цөөхөн сонгуулийн хуульд нотлох баримтыг үнэлэх тогтолцоог тодорхойлсон байдаг. СМШЭ-ийн өмнө маргаан ирсэн тохиолдолд үүнийг СМШЭ дагаж мөрдөх ёстой байдаг. Зарим оронд чөлөөт нотлох баримтын тогтолцоо, хэд хэдэн оронд sana critica тогтолцоо, үүнээс арай олон оронд холимог тогтолцоог суулгасан байдаг.

512. Сонгуулийн санал авах тогтолцоонуудын ач тус нь олон янзын СМШЭ байдаг. Энэ сэдэвт заасан маргаанууд нотлох баримтыг шинжлэх, үнэлэх, шийдэгдсэн маргааны арга барилтай холбоотой байдаг. Шүүхийн нэг хэсэг болох шууд шүүхээр маргааныг шийдвэрлэдэг улс орнуудад эдгээр асуудлууд хуулийн шинэчлэл шаардлагатай гэсэн тусгай нөхцлөөр зохицуулагдах хэрэгтэй байж болно. Эдгээрийг үр дүнтэй мөрдөн шалгах, үнэлэхэд СМШЭ-ийн ажилтнуудыг тусгайлан бэлтгэх шаардлагатай. Цахим болон дижитал нотлох баримтыг үнэлэх журам шалгагдсан байх мөн тусгай хэмжүүр, шинэчлэлийг тусгах шаардлагатай.

Хүснэгт 7.8. Цахим санал хураалт, сонгуулийн маргааныг шийдвэрлэх:

Avery Davis-Roberts

Калифорнийн цахим санал хураалт, үүний хэрэгжилтээс үүссэн байж болох маргаан нь түүнийг шийдвэрлэх тусгай механизмд тооцогдохгүй. Цахим санал хураалтын маргааныг байгаа сувгуудаар шийдвэрлэдэг. Цахим санал хураалтын хэрэглээ, технологитой холбоотой маргааны шийдвэрлэлтийг хэвлэлд өргөнөөр нийтэлж, Калифорни, Нэгдсэн Мужуудын иргэний нийгмийн байгууллагуудаар илүү өргөнөөр нэвтрүүлдэг. Санал хураалтын технологи, түүний хэрэглээний тархацтай холбоотой сүүлийн үеийн маргааныг үл харгалзан маргааныг шийдвэрлэх хариуцлагын институцэд итгэх итгэл өндөр түвшинд хэвээр хадгалагдсаар байна. Хэлэлцүүлэг, цахим санал хураалтын хэлэлцээ нээлттэй байна гэж Калифорни мужийн Нарийн бичгийн дарга (МНБД) үздэг. 2000 оны сонгуулийн дараа холбооны Засгийн газар санал хураалтад хэрэглэх технологиуд зарим энгийн шалгуурыг (жишээлбэл сонгогчийн нууцаар саналаа бичгээр өгөх эсхүл бланкийг бөглөх чадвар, хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хялбар дөхөм байдал, сонгогч илүү санал өгсөн тохиолдолд сануулах технологи) хангасан болохыг батлах зорилгоор муж бүр эдгээрийг шалгахыг шаардсан Америкийн санал хураалтын дэмжлэгийн хуулийг (АСХДХ) баталсан. Мужийн хууль тогтоомж АСХДХ-ийн дагуу байх тохиолдолд хэрэгжилт мужийн дур зоргоос гарсан байдаг. Иймээс 50 муж практикийн өргөн хувилбартай. Калифорнийн сонгогчид хараагаар шалгах төхөөрөмж, автомат тэмдэглэгээний төхөөрөмж, шууд бичлэгийн төхөөрөмж (ШБТ), хуруугаар мэдрэгч машин зэрэг олон нийлүүлэгчийн үйлдвэрлэсэн олон технологийг хэрэглэдэг. Хэрэглэж буй бүхий л технологиуд цаасан бүрэлдэхүүнтэй байдаг. Энэ нь процессын ил тод байдал, төвөгтэй байдлыг шийдсэний үр ашиг, ач холбогдолд чухал юм. Калифорнид ШБТ-ийн хэмжих нэгж төсвөөс санхүүжсэн тохиолдолд санхүүгийн хяналт шалгалтад сонгогчийн баталгаажилтын бичгийг боловсруулах ёстой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулан тоноглох зорилгоор санал хураах газар бүр нэг ШБТ-тэй байх ёстой. Калифорни мужид Сонгуулийн албан хаагчдын тэргүүн нь МНБД байдаг. МНБД сонгууль Сонгуулийн хуулийн дагуу явагдсан болохыг батлах үүрэгтэй. АСХТХ-д зааснаар МНБД-д захиргааны процессын гомдлыг батлах шаардлага тавигддаг. Түүнчлэн мужийн дүүргүүдэд хэрэглэж болох цахим сонгуулийн тогтолцоог баталгаажуулах үүрэгтэй. МНБД баталгаажуулахаас өмнө ямар ч тоног төхөөрөмжийг урьдчилан худалдан авч, хэрэглэхгүй. Тэрээр цахим сонгуулийн машин, тоног төхөөрөмжийн, программ хангамж, техник хангамжийн хууль тогтоомжийг эх хуульд нийцүүлэн баталж болно. Чухал нь гэвэл эсхүл захиргааны тусламж хүсэх бүрэн эрхтэй. Тухайлбал мөнгөн хохирол, МНБД-аас баталгаажуулсан цахим сонгуулийн машины, программ хангамж, техник хангамжийг эрх олгогдоогүй байхад өөрчилсөн тохиолдолд эдгээр төхөөрөмжүүдийг баталгаажуулахгүй байх бүрэн эрхтэй. Түүнчлэн баталгаажуулсан технологийг урьдчилан татаж болно. Калифорний ШБТ-ийн механизмын цахим сонгуультай холбоотой дараах маргаанууд гардаг.

Захиргааны гомдлууд

МНБД гаргасан захиргааны гомдолд холбогдуулан газар дээр болсон процессын баталгааг гаргах ёстой. Калифорни мужийн оршин суугч аливаа этгээд АСХТХ-ийн гуравдугаар бүлгийг зөрчсөн, зөрчиж байгаа, зөрчихөөр байна гэж үзэж байгаа бол гомдол гаргах эрхтэй. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй сонгогч сонгуульд саналаа өгөхөд хялбар дөхөм байхтай холбогдуулан гомдол гаргаж болно. Гаргаж буй гомдлыг бичгээр үйлдсэн, нотариатаар баталгаажуулсан, гарын үсэг зурсан, хөгжлийн бэрхшээлтэй сонгогч болон цөөнхийн хэлээр ярьдаг сонгогчид хялбар дөхөм байлгахаар МНБД-аас гаргасан маягт дээр гомдол гаргагч тангарагласан байх шаардлагатай. Зөрчил гарснаас хойш 60 өдөр, зөрчил гарсан гэдгийг гомдол гаргагч ойлгож мэдсэнээс хойш 90 өдрийн дотор МНБД-д гомдлыг гаргах шаардлагатай. МНБД хуулийн нийтлэг зүйл, гол зорилгод үндэслэсэн гомдлыг баталгаажуулж, хариуцагчдад мэдэгдэл илгээнэ. Гомдлын бүртгэлийг хөтөлнө. Гомдлыг хүлээн авснаас хойш 10-60 өдрийн дотор МНБД өөрийн чиглэлээр шүүх хурлыг явуулна. Үүнийг амаар явуулж болно. Шүүх хурлын дараа МНБД эсхүл түүний үүрэг гүйцэтгэгч гомдолд холбогдуулан шийдвэр гаргана. Энэ нь зөрчлийг хүлээн зөвшөөрсөн ч (нөхөн төлөх бус, шийтгэл бус), гомдлыг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд ч хийгдэнэ. Аль ч тохиолдолд МНБД бичгээр гаргасан шийдвэрийн үндэслэлийг бүхий л сонирхогч талуудад хүргэж, цахим хуудаст нийтэлнэ. МНБД эсхүл түүний үүрэг гүйцэтгэгч 60 хоногийн хугацааны дотор гомдлын хариуг өгөөгүй бол гомдлыг Шүүх хурлын албанд ажилладаг бие даасан арбитраар шийдвэрлүүлнэ. Шүүх хурлын албан хаагч хэргийг шалгаж, МНБД-ын шийдвэр гаргах хугацаанаас хойш 60 өдрийн дотор шийдвэр гаргана. Шүүх хурлын албан хаагчийн шийдвэр эцсийнх байх бөгөөд зөрчлийг мөнгөн нөхөн төлбөрөөр арилгаж болохгүй.

Сонгуулийн дүнгийн маргаан

Сонгуулийн дүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэснээр Давж заалдах шатны шүүх магадлал, Дээд шүүх жинхэнэ шийдвэрийг гаргана. Калифорнийн сонгуулийн дүнгийн маргаан дахин тоологдохгүй болон тоологдох дүнгийн маргаан гэсэн 2 категорид хуваагддаг.

Дахин тоолуулахгүй тухай маргаан сонгуульд ялсан, хамгийн их саналаар (гэмт хэрэг үйлдсэн этгээд) сонгогдоогүй, бүх нийтээр сонгууль өгөхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, хэрэв тоологдоогүй бол үр дүн нь өөрөөр гарах байсан гэмт хэрэгтний хууль бус эсхүл луйврын үйлдлүүд үүссэн тохиолдолд гардаг.

Дээд шүүх энэ тохиолдлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй.

6. Сонгуулийн дүнтэй холбоотой маргааны дагуу авах арга хэмжээ

513. Улс орнуудын өөр өөр хууль зүйн уламжлал, түүхийн болон нийгэм-улс төрийн нөхцөл байдлаас ШБТ-ийн механизмуудын олон янз байдал үүсч бий болдог. Эдгээр механизмуудын хоорондын нийтлэг холбоо ард түмнийг сонгууль өгөхөд хурдан шуурхай байлгах гэсэн туйлын хүндэтгэл дээр тогтдог. Сонгуулийн дүнгийн маргаантай холбогдуулан ШБТ-ийг санал бүрийн хууль зүйн засваруудын судалгаагаар ангилж болно. Эдгээр нь улс төрийн нам, нэр дэвшигчийн гаргасан өргөдөл, гомдлын мөн чанарт хэрэгтэй байдаг. Тухайлбал саналыг бүхэлд нь хүчингүй болгохыг хүссэн гомдолд СМШЭ-ээс онолын дагуу саналыг дахин тоолохыг даалгах аливаа шалтгаан байхгүй.

514. Маргаан гаргасан тал эсхүл гомдол гаргагч хэд хэдэн хууль зүйн арга хэмжээ авахыг хүсч болно. Үүнд:

- a. Сонгуулийн дүнгийн өөрчлөлт-хуульд заасны дагуу саналыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн дахин тоолсноор эсхүл буруу ташаа зүйл гарсны улмаас олон сонгуулийн хороонд хүлээн авсан саналыг хүчингүй болгосны улмаас ялагч өөрчлөгдөх;
- b. Сонгуулийн дүнд нөлөөлөхүйц буруу ташаа зүйл өргөн тархсан эсхүл агуулгын алдаа гаргасан тохиолдолд сонгуулийг хүчингүй эсхүл хүчин төгөлдөр бус гэж зарлах, дахин сонгууль явуулахад хүрсэн;
- c. Тодорхой төлөөлөгчдийн сонгуулийн мэдэгдлийг зохих шаардлага хангаагүйн улмаас хүчингүй болгох.

Хүснэгт 7.9. Сонгуулийн дүнгийн маргаанд авах арга хэмжээ

- a. Сонгуулийн дүнгийн өөрчлөлт (ялагчийг өөрчлөх боломж)
 - i. Бүхэлд нь болон хэсэгчлэн дахин тоолох
 - ii. Зарим сонгуулийн хороон дахь саналыг хүчингүй болгох
- b. Сонгуулийг хүчингүй болгох
- c. Зохих шаардлага хангаагүйн улмаас нэр дэвшигчийн ялалтын мэдэгдлийг хүчингүй болгох

515. Сонгуулийн дүнд агуулгын хувьд нөлөөлөхгүй ч алдаатай явагдсан эсхүл сонгуулийн процесст алдаа гарсан гэдгийг СМШЭ хүлээн зөвшөөрсөн тохиолдлыг сануулах нь чухал юм. Ийм тохиолдолд ижил эсхүл тус тусдаа шүүхийн шийдвэрээр шийтгэл оногдуулж болно.

а) Ялагчийг өөрчлөх боломжтой сонгуулийн дүнгийн өөрчлөлт

516. Өргөдөл, гомдлын дагуу авах арга хэмжээний нэг нь СЗБЭ-ээс гаргасан сонгуулийн дүнд өөрчлөлт оруулах явдал байж болно. Энэ нь сонгуулийн өдөр сонгуулийн хорооноос гаргасан шууд дүн, сонгуулийг явуулж дууссан даруй бүхэлд нь тоолж дээд шатны байгууллагаас зарласан нийлбэр дүн, эсхүл томилогдсон сонгуулийн хороон дээр саналыг хүлээн авсан сонгуулийн тодорхой тойргийн нийлбэр дүнг илэрхийлж болно.

517. Маргааны эцсийн зорилго СЗБЭ-ээс сонгогдсон хэмээн зарлагдсан нэр дэвшигчийг өөрчлөхөд оршиж байдаг. Энэхүү төгсгөлд хүрэх дараах боломжууд байдаг. Үүнд:

- СЗБ систем бүрийн хуулиар заасан хугацааны дотор саналыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн дахин тоолуулах;
- Сонгуулийн хороон дээр хүлээн авсан хэд хэдэн саналын дүнд агуулгын хувьд нөлөөлөхүйц алдаа гарсан хэмээн шийдвэрлэсэн шийдвэрийн дагуу саналыг хүчингүй болгуулах,
- Зарим системд батлагдсан аливаа саналыг хүчингүй, хүчин төгөлдөр бус болох тухай нарийн судалгаа хийсний үндсэн дээр хасуулах.

й) Бүхэлд нь болон хэсэгчлэн дахин тоолох

518. Сонгуулийн хуулиар бүхлээр нь болон хэсэгчилсэн тооллогыг хийх төрөл бүрийн арга замуудыг зохицуулсан бөгөөд дараах дөрвөн хандлага байдаг. Үүнд:

- а. Дүн гаргаж дууссан эсхүл дуусаагүй тохиолдолд аливаа сонгуулийн саналын дахин тооллогыг Үндсэн хууль эсхүл бусад хуулиар зохицуулах. Нидерланд мөн Коста Рикагийн хуульд 2009 оны есдүгээр сард ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- б. Дүнг гаргаж дууссан тохиолдолд бүхэлд нь автоматаар эсхүл сонирхогч талын хүсэлтээр дахин тооллого хийхээр хуульд заах. Канад, Унгар, Литуани, Мексикт 2007 оны

- шинэчлэлтээс хойш, мөн АНУ-ын зарим мужид ийнхүү зохицуулсан байдаг;
- c. Хууль зүйн дагуу явагдсан болохыг батлах зорилгоор хэсэгчлэн буюу зөвхөн тодорхой сонгуулийн хорооны саналыг дахин тоолохоор заах. Ихэнх СЗБ системд ийнхүү заасан байдаг;
 - d. Бүхэлд нь эсхүл хэсэгчилсэн дахин тооллогыг хуулиар тодорхой заагаагүй байх. Перу мөн АНУ-ын хамгийн багадаа гурван муж ийм зохицуулалттай.

Сонгуулийн дүнгээс үл хамааран саналыг бүхэлд нь дахин тоолох

519. Нидерланд, Коста Рикагийн (2009 оны нэмэлт, өөрчлөлтөөс өмнө) хуульд СЗБЭ (Сонгуулийн Зөвлөх, Kiesraad, Сонгуулийн дээд шүүх) сонгуулийн дүнг гаргаж дуусан, маргаан гарсан эсэхээс үл хамааран сонгуулийн хороо бүр дээрх саналыг бүхэлд нь шинээр дахин тооллого явуулах үүрэгтэй байхаар заасан. Сонгуулийн өдрийн дараах долоо хоногийн туршид СЗБЭ нөхцөл байдлаас үл хамааран бүхэлд нь дахин тооллого явуулдаг. Энэ тооллого нь албан ёсны тооллого, мэдэгдэл болдог. Энэ нь хэдийгээр дүнгийн хууль ёсны, зүй ёсны байдлыг дээд шатнаас хүлээн зөвшөөрч байгаа ч гэсэн цөөн сонгогчтой нийгэмд хэрэгжүүлэхэд хялбар болох нь тодорхой.

520. Коста Рика болон Нидерландад сонгуулийн хорооны ажилтны хийсэн үйлдэл бүрийг шалгадаг бөгөөд дээд шатны СЗБЭ-ээс залруулж болдог. Сонгуулийн хороо нь СЗБЭ-ийн захиргааны доод шатны байгууллага учир СЗБЭ-ээс сонгуулийн хороон дээр явагдсан үйл ажиллагааг шалгах бүрэн эрхтэй. Коста Рикад улс төрийн намаас санал болгосон орон нутгийн сонгуулийн хорооны албан хаагчид Сонгуулийн дээд шүүх бие даасан, шударга байдлаар маргааныг шийдвэрлэх баталгааг өгч, 60-аас дээш жил гүйцэтгэсэн ажлын үр дүн, шударга байдлаас шалтгаалсан алдар хүндийг авч үздэг.

Дүнг гаргах хүндрэлийн улмаас сонгуулийн саналыг бүхэлд нь дахин тоолох

521. Канад, АНУ-ын зарим муж, Унгар, Литуани, Мексикийн хуульд аль ч талын санал гаргаснаар саналыг бүхэлд нь дахин тоолохоор заасан байдаг. Канад, АНУ-д өргөдөл гаргагч алдаа олсон бол зардлыг даах ёстой. Түүнчлэн нэг, хоёр дахь газрын хоорондын ялгаа тогтоосон хувиас бага байвал СЗБЭ-ийн өөрийнх нь шаардсанаар дахин тооллогыг автоматаар явуулахаар заасан байдаг. Тухайлбал

Канадад ялгаа нь 0,1 хувь, АНУ, Вашингтон мужид 0,5 хувь, Литуанид 50 санал, Унгар, Мексикт 1 хувиас бага байвал автоматаар дахин тооллого явуулна.

522. АНУ-ын зарим мужийн хуулиар Төлөөлөгчдийн ордон, Сенат, захирагч, мужийн хууль тогтоогчийн сонгуулийн саналыг бүхэлд нь дахин тоолохоор заасан байдаг боловч АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг дахин тоолох нөхцөл одоогоор байхгүй байна. Хэсэгчилсэн тооллогыг явуулах боломжтой боловч гурван мужид (Албам, Иллиноис and Кентуки) маргаан дахин тооллогын аливаа боломжийг хүлээн зөвшөөрдөггүй. Эдгээрээс бусад мужид эхлээд маргаан эсхүл сонирхогч талаас хүсэлт гаргаснаар дахин тооллого автоматаар явагддаг. АНУ-ын мужуудын сонгуулийн албан хаагчид ихэвчлэн улс төрийн намаас гаргасан саналын үндсэн дээр томилогддог. Ихэнх мужид санал хураалт компьютерийн тусламжтайгаар явагддаг.

523. Нэгдсэн вант улсад ялагдсан нэр дэвшигч амжилттай нэр дэвшигчийн сонгуулийн тоологдсон санал дээр нарийвчилсан судалгаа хийлгүүлэхээр өргөдөл гаргаж болно, өргөдөл гаргагч сонгуулийн дүнг өөрчлөхийн тулд саналын тоог нэмсэн эсхүл хассан гэдэгт итгэдэг. Энэхүү нарийвчилсан судалгааг сонгуулийн хууль тогтоомж буюу Хүмүүсийн төлөөлөгчийн хуулийн гол хэсгүүдийн хэд хэдэн бүлэгт байдаг гэж үздэг боловч үүнийг хууль тогтоомжид нарийн тодорхойлоогүй байдаг. Энэхүү судалгааны процесс нь санал хураах системийг дагалдаж байдаг. Тухайлбал санал хураалтын цаас дугаарлагдсан, санал өгөх сонгогчдын тоог сонгуулийн хорооны ажилтан санал хураалтын цаасан дээр бүртгэсэн, тохирохгүй болох нь тогтоогдсоны дараа СМШЭ-ээс санал хураалтын цаасыг ялгах, хасах боломж олгогдсон. Үүнийг Нэгдсэн вант улсад өргөнөөр хүлээн зөвшөөрсөн байхад олон оронд санал хураалт нууц байх асуудлаас шалтгаалан энэ аргыг зөвшөөрдөггүй.

524. Үүнтэй адилаар СМШ системийг хууль тогтоомжид тодорхой заагаагүй явдлыг үл харгалзан хэд хэдэн СМШЭ-үүд бүхэлд нь дахин тооллого явуулсан эсхүл явуулахыг даалгасан хууль зүйн шийдвэрүүдийг гаргасан байдаг. Тухайлбал Тайваний шүүх (Zim gai fo yuan) 2004 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа Тайпей (давж заалдах) Дээд Шүүхээс даалгасан улс даяархи бүхэлд нь явуулсан дахин тооллогыг баталгаажуулсан. Өөр нэгэн жишээгээр 2004 оны ерөнхий сонгуулийн дараа Намибийн Дээд Шүүхээс явуулсан үйл ажиллагааг авч үзэж болно. Энэхүү шүүх эсрэг талуудаас саналын тооллогод (дүн гарахаас өмнө тооллогыг баталсан) гаргасан олон тооны алдааг дурдсан өргөдөл гаргасны дараа дахин тооллого явуулахыг даалгасан явдал болон 2009 оны парламентын сонгуулийн дараа Молдавын үндсэн Хуулийн Шүүхээс гаргасан шийдвэрийг дурдаж

болно.

Хууль зүйн дагуу явагдсаныг батлах зорилгоор сонгуулийн хорооны саналыг дахин тоолох

525. Хэсэгчилсэн дахин тооллогыг баталгаажуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг ч дийлэнх СМШ системд хэсэгчилсэн дахин тооллого явуулахыг хуулиар заасан байдаг. Эдгээр СМШ системүүд сонгуулийн хорооны албан хаагчдыг томилгох, сонгогчдыг ялгах, санал хураалтыг өөрөө явуулах, сонгуулийн хороонд хүлээн авсан саналыг тоолох, нийлбэр дүнг гаргах зорилгоор суурилуулсан олон тооны нууцлал бүхий хэрэгслүүд сонгуулийн дүнгийн нарийвчлалыг баталгаатай болгодог гэж үздэг. Хүлээн авсан саналын тайланг сонгуулийн хорооны ажилтан бэлдэж гарын үсэг зурдаг. Улс төрийн намууд сонгуулийн хороо бүрт төлөөлөгчөө оролцуулж болно. Улс төрийн намууд болон тэдгээрийн төлөөлөгчид сонгуулийн өдөр болсон байж болох аливаа алдаа, гажуудлын эсрэг эсэргүүцэл гаргах, сонгуулийн хорооноос гарсан дүнгийн баталгаажилт болгож санал хураалтын тооллогын протокол, эцсийн дүнгийн хуулбарыг хүлээн авах эрхтэй.

526. Улс төрийн нам, тэдгээрийн төлөөлөгч бүр сонгуулийн өдрийн дараах өдрүүдэд сонгуулийн хорооноос гаргасан дүнгийн хуулбарыг СЗБЭ-ийн байгууллагаас гаргасан саналын нийлбэр дүнтэй харьцуулах боломжтой байдаг. СМШ хэд хэдэн системд сонгуулийн хороонд хүлээн авсан дахин тооллого явуулахыг хүсэх боломжийг хуулиар олгосон байдаг. Үүнд:

- Тодорхой сонгуулийн хороон дээр хүлээн авсан саналын тооллого болон нийлбэр дүнгийн мэдэгдэл нь өөрчлөгдсөн гэсэн тэмдэглэгээг үзүүлдэг;
- Мэдээлэлд орсон хөдөлгөөний алдаа нь тодорхой;
- Ийм мэдэгдэл байхгүй;
- Намуудын төлөөлөгчдийн хүлээн авсан хуулбар дээрх мэдээлэлтэй зөрсөн.

Эдгээр нөхцөл байдлууд хэсэгчилсэн тооллого буюу хэд хэдэн тодорхой сонгуулийн хороонд хүлээн авсан саналын тооллогыг дахин явуулахад нөлөөлдөг.

527. Улс төрийн намууд болон хэд хэдэн СМШ системд нэр дэвшигчид СЗБЭ-ээс гаргасан саналын нийлбэр дүнд засвар оруулаагүй сонгуулийн өдөр алдаа гаргасан эсвэл СЗБЭ шинээр алдаа гаргасан аль ч тохиолдолд СЗБЭ-ээс саналын нийлбэр дүнгийн талаар СМШЭ-д гомдол гаргах эрхтэй. СЗБЭ-ийн зүй бус алдаанд СМШЭ сонгуулийн

хороонд хүлээн авсан санал дээр дахин тооллого явуулах боломжтой.

Бүхэлд нь болон хэсэгчлэн тоолохыг хуульд тусгайлан заагаагүй улс орнууд

528. Нэгдсэн улсын 3 муж (522-р зүйлийг үзнэ үү), зарим орнууд, тухайлбал Боливиа, Перу улсад бүхэлд нь болон хэсэгчилсэн дахин тооллого явуулах талаархи зохицуулалтыг хуульдаа тусгаагүй байдаг. Эдгээр системүүд сонгуулийн өдрийн төгсгөлд сонгуулийн хороод дээр тоолсон саналын тоог засварлагдахгүй үйл ажиллагаа, шийдвэр гэж үздэг хасалтын зарчим дээр үндэслэдэг.

ii) Зарим сонгуулийн хороод дээр хүлээн авсан саналыг хүчингүй болгох

529. Хүчингүй болгох 3 төрөл байдаг. Үүнд:

- Саналыг дангаар нь хүчингүй болгох;
- Тодорхой саналын хороод дээр авсан саналыг хүчингүй болгох;
- Сонгуулийг бүхэлд нь хүчингүй болгох.

Саналын хуудсыг хүчингүй болгох

530. Сонгуулийн хууль тогтоомжоор саналын хуудсыг хүчингүй, хүчин төгөлдөр бусад тооцох олон янзын нөхцлүүдийг заасан байдаг. Ерөнхийдөө хуульд хүчинтэй байхаар зааснаас бусад хэлбэрээр сонгогч бөглөсөн аливаа саналын хуудас хүчингүйд тооцогддог. Гол зарчим нь хэрэв сонгогчийн санааг тодорхой, нарийн, зүй ёсны тодорхойлох боломжгүй бол санал хүчингүй гэж үздэг.

531. Хүчингүй саналыг тэмдэглэгдээгүй саналын хуудаснаас ялгах хэрэгтэй бөгөөд үүнийг бланкд тооцогдоно. Эдгээр системд энэ ялгалт нь улс төрийн намууд бүртгэлээ хэвээр хадгалах, пропорционал системээр суудал авах, нийтийн санхүүжилтийн шалгуурт хүрэх босгыг хангахад чухал юм. Түүнчлэн энэ нь хууль тогтоомжоор босгыг заасан байхад бүх нийтийн санал асуулга дахин санал хураалтад холбоотой байж болно. Гэвч зарим системд хоосон саналын хуудсыг хүчингүй, хүчин төгөлдөр бус гэж үздэг.

532. Дийлэнх улс орнууд сонгуулийн хороод, эсвэл тооллогын ажилтнуудад санал хураалтын тооллогын үеэр саналыг аливаа маргаангүйгээр хүчингүйд тооцох, мэдэгдэх эрхийг олгосон байдаг. Маргаантай саналын эсрэг давж заалдах, сануулж болно. Сонгогчийн эрх зүйн байдал, хувийн мэдээлэлтэй холбоотой бусад хэрэг маргаан

байх нь эргэлзээгүй юм. Энэ тохиолдолд СЗБЭ-ийн дээд шатны байгууллага шийдвэр гаргана.

533. Зарчмын дагуу хүчингүйд тооцох явдал нь зөвхөн тодорхой сонгогчийн хувийн саналтай холбоотой бөгөөд сонгуулийн хороонд хүлээн авсан санал, сонгуулийн дүнгийн мэдэгдэлд нөлөөлөхгүй. Гэвч зарим сонгуулийн хууль тогтоомжийн тогтолцоо хүчингүйд тооцсон саналын дүн өндөр байх нь тодорхой сонгуулийн хороодын нийт санал болон сонгуулийг бүхэлд нь хүчингүйд тооцох боломжийг үүсгэдэг. Тухайлбал: сонгуулийн хороонд авсан хүчинтэй саналын тооноос хүчингүй нь их, саналын талаас илүү нь хүчингүй, саналын гуравны хоёр нь хүчингүй хоосон тохиолдолд дээрх байдалд хүргэнэ.

Тодорхой саналын хороон дээр хүлээн авсан саналыг хүчингүйд тооцох

534. Сонгуулийн хорооны саналыг хүчингүйд тооцох үндэслэлийг дараах 3 бүлэгт ангилан үзэж болно. А. Сонгуулийн хорооны албан хаагчдын алдаа, Б. Процессын алдаа В. Саналын тооллого, протоколд гарсан алдаа мөн тодорхой алдаа Сонгуулийн хорооны албан хаагчдын гаргасан алдаа

535. Үндсэндээ, Сонгуулийн хорооны албан хаагчдын томилгоо хууль бус байх нь хүчингүйд тооцох үндэслэл болдог. Сонгуулийн хорооны албан хаагчдын байдал сонголт хийхэд гаргасан алдаа, санал хураах албан хаагчдын хуульд нийцээгүй үйл ажиллагаа, албан бусаар томилогдсон гишүүд, хуульд заасан хугацааны дараа томилогдсон байдал, зөвшөөрөгдсөн тооноос цөөн байх зэргээс шалтгаалан хууль бус байж болно. Өөр нэг шалтгаан нь эрх олгосноос бусад газар зөвшөөрөөгүй байхад томилсон явдал юм.

536. Колумбид санал хураах албан хаагч нь нэр дэвшигчтэй эхнэр, нөхрийн эсвэл ойр төрлийн холбоотой бол нэр дэвшигчийг сонгосон саналуудыг хүчингүйд тооцдог.

537. Хууль тогтоомжид санал хураах процесст алдаа гаргасны улмаас саналыг хүчингүйд тооцох дараах үндэслэлүүдийг заасан байдаг. Үүнд:

- Сонгуулийн хорооны бүртгэл буруу болсон, буруутгагдсан, өөрчлөгдсөн;
- Саналын хуудас нэр дэвшигчийн нэр, намын эмблемтэй холбоотой алдаатай байсан;
- Санал өгөх эрхтэй сонгогч саналаа өгч чадаагүй;

- Сонгуулийн бүртгэлд бүртгэгдээгүй, хувийн мэдээлэл нь баталгаажигдаагүй хүн саналаа өгсөн;
- Нийлмэл саналыг илрүүлсэн;
- Улс төрийн намын төлөөлөгчийг хяналт тавихыг зөвшөөрөөгүй.

538. Хүчингүйд тооцох бусад үндэслэлүүд:

- сонгогчийг санал өгөхөөс түдгэлзүүлэх, тэдний хүсэл зоригийнх нь эсрэг эсхүл хууль ёсны баталгаагүй санал өгүүлэх зорилготой сонгуулийн хорооны албан хаагчийн албадлагын үйл ажиллагаа;
- санал хураах процессын үеийн сонгуулийн хорооны албан хаагчийн зөрчил;
- нэр дэвшигч, бусад сонгогчдоос сонгогчийн эсрэг гаргасан зөрчил, албадлага, заналхийлэл;
- аливаа нэр дэвшигчийн өмнөөс хийсэн залилан, хээл хахууль, заналхийлэл, зохисгүй нөлөөлөл, айлган сүрдүүлэлт, зөрчил;
- саналаа чөлөөтэй, тайван өгөхөд нь саад хийсэн түгээмэл зөрчил;
- нууц санал хураалтын зарчмын зөрчил;
- сонгуулийн кампанит ажлын хуулиар хориглосон үйлдэл;
- эрх бүхий байгууллагын санхүүгийн саад, албан тушаалаа урвуулан ашигласан үйлдэл, тухайлбал сонгох, сонгогдох эрх чөлөөг хязгаарласан үйлдэл;
- сонгуулийн эрх бүхий байгууллагаас тогтоосон өдөр, цагаас өөр үед санал хураалт явуулсан үйлдэл (давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд);
- үндэслэлгүй шалтгаанаар сонгуулийн хороо оройтож нээгдсэн, эрт хаагдсан, сонгогчдын сонгох эрхийг хассан;
- тогтоосноос өөр газар санал хураалтыг явуулсан, тогтоосноос өөр хүнээс санал хүлээн авсан, ерөнхийдөө ноцтой алдаа гаргасан.

СМШ ихэнх систем сонгуулийн дүнд нөлөөлөхүйц алдаа гаргасан сонгуулийн хорооны хүлээн авсан саналыг хүчингүйд тооцох шаардлагыг хуульчилсан байдаг.

Саналын тооллого, протоколд гарсан алдаа

539. Тодорхой сонгуулийн хорооны саналыг хүчингүйд тооцох даарах үндэслэлүүд байдаг. Үүнд:

- тогтоосон газраас өөр газарт саналын тооллого явуулсан;
- саналын дүнд нөлөөлөх зорилгоор санал тоолж байхад

- сонгуулийн албан хаагчдын эсрэг зөрчил гаргасан;
- сонгуулийн дүнд нөлөөлөх зорилгоор тодорхой нэр дэвшигчид ашигтай эсхүл нэр дэвшигчийг дэвшүүлэхээр саналыг тооцоолоход залилан, алдаа гаргах;
- сонгогчдын тоо, хэрэглэсэн саналын хуудасны тоо хооронд ялгаа гарсан, жишээлбэл тав түүнээс их;
- бүртгэгдсэн сонгогчдын тооноос саналын тоо их гарсан;
- хүчингүйд тооцогдсон санал хүчинтэй саналаас их, эсхүл хэрэглэсэн саналын хуудасны тоо тодорхой сонгуулийн хороонд бүртгэгдсэн сонгогчдын нийт тооноос их болох нь тогтоогдсон;
- Сонгуулийн журамд хамаатай аливаа алдаа гарсан;
- саналын тооны бусад гажуудал, тухайлбал математикийн алдаа эсхүл нийлбэр дүнгийн өөрчлөлт;
- эрх олгогдоогүй хүн бэлтгэсэн, протоколд гарын үсэг зурсан, баталгаажуулсан;
- хориотой бланк хэрэглэсэн;
- сонгуулийн бичиг баримт дутсан, гэмтсэн, устсан;
- сонгуулийн хорооны зарим эсхүл бүх албан хаагчдын гарын үсэг дутуу;
- сонгуулийн баримт бичгийн баглаа, уутанд гар хүрсэн;
- сонгуулийн хорооноос дээд шатны байгууллага руу сонгуулийн баримт бичгийн баглаа, өргөх бичиг, уутыг хүргэхдээ тогтоосон хугацаанаас хожимдож хүргэсэн.

540. Сонгуулийн хорооны саналыг бүхэлд нь хүчингүйд тооцохын үр дагавар маш чухалд тооцогддог. Зарчмын дагуу, ийм тохиолдлууд сонгуулийн хорооны саналд, түүгээр ч барахгүй сонгуулийн процесст бүхэлд нь нөлөөлдөг. Хэд хэдэн сонгуулийн хорооны саналыг хүчингүйд тооцох нь сонгуульд бүхэлд нь нөлөөлөх боломжтой. Саналыг хүчингүйд тооцсоноор хүчингүйд тооцогдсон сонгуулийн хорооны санал ялагчийг өөрчлөх шинэ дүнд нөлөөлж болох байсан ч сонгуулийн эцсийн дүнд хамаарахгүй. СМШ зарим системд, тухайлбал Бангладеш улсад үндэслэлтэй бол сонгуулийн хороонд санал хураалтыг дахин шинээр явуулдаг. Бараг бүх сонгуулийн тогтолцоонд тодорхой сонгуулийн хорооны санал, томилгоог хүчингүйд тооцсон нь сонгуулийн дүн эсхүл сонгуулийн хүчинтэй байдалд нөлөөлөхөөр байвал шинэ санал хууралт эсхүл шинэ сонгуулийг явуулах зарчим туссан байдаг. Ингэхдээ эерэг, сөрөг нөхцлүүдийг нарийвчлан томъёолсон байдаг.

541. Зарим хуулийн тогтолцоо шинэ санал хураалт (тодорхой сонгуулийн хорооны) сонгуулийн үндсэн дүнд нөлөөлөхөөргүй

байвал шинэ сонгууль явуулахгүй гэсэн сөрөг нөхцөлтэй зарчмыг суулгасан байдаг. Харин бусад сонгуулийн тогтолцоонд хүчингүйд тооцогдсон санал хураалт сонгуулийн дүнд нөлөөлөх, түүнийг өөрчлөх боломжтой эсхүл нам хууль зүйн байр сууриа үргэлжлүүлэх эсэхийг шийдэхэд хангалттай тохиолдолд шинэ сонгуулийг явуулах хэрэгтэй гэсэн эерэг зарчмыг суулгасан байдаг.

542. Хэд хэдэн улсад зөвхөн санал нь хүчингүйд тооцогдсон (эсхүл сонгууль явагдаагүй) сонгуулийн хороон дээр санал хураалт буюу хэсэгчилсэн санал хураалтыг шинээр явуулах боломжийг хүлээн зөвшөөрсөн байхад зарим улсад улс даяар шинэ сонгууль заавал явуулах ёстой гэж үздэг.

543. Санал хураалтын нийлбэр дүнг шинээр гаргах үед дахин сонгогдсон нэр дэвшигчдийг баталгаажуулдаг. Харин нэг эсхүл хэд хэдэн сонгуулийн хорооны саналыг хүчингүйд тооцсоноор ялагчаар тогтоогдсон нэр дэвшигчдийг дараа нь баталгаажуулдаг.

б) Сонгуулийг хүчингүйд тооцох

544. Сонгуулийн үйл ажиллагаа, журмын хууль ёсны байдлыг хамгаалахын тулд сонгуулийн тогтолцоонд сонгуулийг хүчингүйд тооцох төрөл бүрийн үндэслэлүүдийг тусгасан байдаг. Нийтийн эрх зүйн бусад салбарт сонгуулийн зөрчил гарсан тохиолдолд сонгуулийн хуулийн заалтыг зөрчил бүрийн үр дагавар ижил биш байдгийг дурдах хэрэгтэй. Үүсэх үр дагаврын зэрэглэлийг тодорхойлоход алдаатай үйл ажиллагаа, буруу үйлдлийн хууль зүйн үр дагаврыг судлах нь чухал.

545. Хэд хэдэн сонгуулийн тогтолцоонд сонгуулийг хуулийн хүрээнд хүчингүйд тооцон мэдэгдэл хийх эрх зарим СМШЭ-д олгогдсон байдаг ч хүчингүйд тооцох үндэслэлүүдийг хуульд тодорхой заасан байдаг. Тухайлбал “факт, гажуудал, алдаа ... сонгуулийн ерөнхий дүнд нөлөөлөх” хэмээн Урагвайн хуульд заасан.

546. Үндсэндээ СМШ зарчмын дагуу сонгуулийн дүнд нөлөөлөх алдаа гарсан тохиолдолд хүчингүйд тооцно. Үүнээс гадна маргааныг үүсгэн гомдол гаргах нь маргаантай шийдвэр, үйл ажиллагааны үр дагаврыг (түр зуурын байсан ч гэсэн) хойшлуулахгүй. Гомдол гаргах хугацаа нэгэнт өнгөрсөн бол зохих шийдвэр, үйл ажиллагаа эцсийнх болно. Түүнчлэн эргэлзээтэй (жишээлбэл Экуадор) эсхүл сонгуулийн хоёр шүүгчийн санал зөрсөн (жишээлбэл Нэгдсэн вант улс) тохиолдолд сонгууль хүчинтэйд тооцогдоно. Эдгээр заалтын

шалтгаан нь хүчин төгөлдөр явагдсан нийтийн үйл ажиллагаа хамгаалагдах ёстой гэж заасан хуулийн үндсэн зарчимд байдаг. Энэ зарчим “хэрэггүй зүйлээр хэрэгтэй зүйлийг сүйтгэж болохгүй” гэсэн афоризмд туссан байдаг бөгөөд хэд хэдэн СМШЭ-үүд сонгуулийн хуультай холбогдуулан шийдвэртээ тусгасан байна (жишээлбэл Коста Рика, Мексик, Испани).

547. Сонгууль хүчингүйд тооцогдсон тухай голдуу СМШЭ зарладаг. Гэхдээ энэ шийдвэр нь СЗБЭ-ийн захиргааны маргаан (Азербайжан, Кroatia, Эстони, Унгар, Киргизстан, Литвани, Турк) эсхүл СМШЭ-ийн хууль зүйн маргааны (Нидерланд) үр дүн юм. СМШЭ-ээс маргааныг хянан шийдвэрлэхэд үүссэн, мэдэгдсэн асуудлаар хязгаарлагдах бөгөөд маргаан, гомдлоос бусад асуудлыг хэлэлцэхгүй байх дүрэмтэй.

548. Сонгуулийн тогтолцоон дахь сонгуулийг хүчингүйд тооцох гурван үндэслэлийг (a) олон янзын сонгуулийн хорооны саналын дүнгээр; (b) нэр дэвшигч, жагсаалтаар нэр дэвшигчийн чадваргүй байдлаас шалтгаалан; (c) Шаардлагатай баталгааг хавсаргаагүй үед гэж ангилж болно.

i) Олон янзын сонгуулийн хорооны саналыг хүчингүй болгосны үр дагавар

549. Эдгээрт саналыг хүчингүйд тооцсоноор сонгуулийн хорооны талаас дээш хувьд нөлөөлөх эсэх, санал хураалтыг хүчингүйд тооцсоноор хүлээн авсан саналын талаас дээш хувьд нөлөөлөх эсэх, эдгээр нь улсын нийт хүчинтэй санал хураалтын гуравны нэгд нөлөөлөх эсэх багтдаг. Зарим улсад хүчингүйд тооцсон санал сонгуулийн хорооны саналын 20 хувьд хүрвэл сонгуулийг бүхэлд нь хүчингүйд тооцдог.

ii) Нэр дэвшигч, жагсаалтаар нэр дэвшигчийн чадваргүй байдлаас шалтгаалах

550. Олон сонгуулийн хуульд нэр дэвшигч эсхүл жагсаалтаар нэр дэвшигдсэн хүн зохих шаардлагыг хангаагүй, эсхүл төлөөллийн луйвар хийж томилогдсон тохиолдолд сонгуулийг хүчингүй болгохоор заасан байдаг. Тэдгээр орнуудад үүнийг сонгуулийг хүчингүйд тооцох үндэслэл гэж заагаагүй ч гэсэн сонгогдсон нэр дэвшигчийг тохирохгүй хэмээн үзсэн тохиолдолд хожим нь эргүүлэн татах үед боломжийг олгодог ганц арга нь мэдэгдэл, баталгаажилтыг хүчингүй болгох юм.

iii) Шаардлагатай баталгааг хавсаргаагүй сонгууль

551. Хэд хэдэн сонгуулийн хууль тогтоомжийн тогтолцоонд сонгуулийг хүчингүй болгох үндэслэлүүдийг заасан байдаг. Үүнд: дүн гарсны дараа зөрчсөн, албадсан үйлдэл хангалттай байгаа, шаардлагатай баталгаагүйгээр сонгууль явагдсан (жишээ нь: Боливи, Панама), санал тооллогыг саатуулах, луйвардах, зөрчих зорилгоор хууран мэхлэлт өргөн хүрээнд явагдсан (жишээ нь: Прагвай), сонгогчийг жинхэнэ хүсэл зоригоо тусгах боломжгүй болгосон зөрчил гарсан (жишээ нь: ОХУ), сонгуулийн дүнд их хэмжээгээр нөлөөлөх гэсэн аливаа этгээдийн сонгуулийг дэмжих, хангах зорилготой авлига, хууль бус ажиллагаа байсан (жишээ нь: Их Британи), сонгуулийн ерөнхий дүнд нөлөөлсөн гэж сонгуулийг хүчингүй болгох үйлдлүүд байсан (жишээ нь: Урагвай).

552. Олон янзын үзэл баримтлалтай холбоотой дээрх тохиолдлууд, тухайлбал “шаардлагатай баталгаа”, “сонгуулийг хүчингүй болгох үйлдэл”, “саналын тооллогод гарсан өргөн хүрээний зөрчил”, “их хэмжээг хамрах” зэрэг нь СМШЭ-д чөлөөтэй, анхааралтай шийдэх эрхийг өгдөггүй ч хуулийн тодорхойгүй үзэл баримтлалыг техник хэрэглэн, гардан үндэслэл бүхий аргаар шийдэхийг шаарддаг. Энэ шалтгаанаар шүүхийн жишгээр хязгаарлахаас гадна СМШЭ өөрийн шийдвэрийг шударга ёсонд нийцсэн болохын үндэслэлийг гаргах хэрэгтэй. Энэ нь нотолгоо болгон хэрэглэхэд хангалттай бус байдаг.

553. Төгсгөлд нь цөөн тооны орнуудын хуульд Ерөнхийлөгчийн эсхүл хууль тогтоох байгууллагын сонгуулийг бүхэлд нь хүчингүйд тооцох нэмэлт үндэслэлүүдийг заасан байдаг. Тухайлбал, зохих байгууллагаас эхлээд тогтоолгүйгээр сонгуулийг явуулсан, тогтоосон өдрөөс өөр өдөр сонгуулийг явуулсан.

в) Нэр дэвшигч зохих шаардлагыг хангаагүйн улмаас санал хураалтыг дахин явуулах

554. Хэрэв сонгогдсон нэр дэвшигч хуулиар тогтоосон зохих шаардлагыг хангахгүй нь мэдэгдсэн тохиолдолд өргөдөл, гомдол гаргагчийн өөр нэг боломжит арга нь нэр дэвшигчийн гэрчилгээ, сонгогдсон тухай мэдэгдэлд дахин санал хураалт явуулах юм. Энэ нөхцөл байдал сонгуулийг хүчингүйд тооцох нь зохих шаардлагыг хангаагүйн улмаас үүсэх хууль зүйн үр дагавар биш байх үед, тодруулбал жагсаалтаар (зарчмын болон бусад) нэр дэвшигчийн зөвхөн нэг нь зохих ёсны бус байх, эсхүл хувь тэнцүүлсэн төлөөллийн тогтолцоог хэрэглэж байх үед үүсдэг. Сүүлчийн тохиолдолд ихэнхдээ

жагсаалтын (намын жагсаалт тодорхой байх тохиолдолд) дараагийн хүнийг сонгодог. Бусад системд бүрэн эсхүл намын сонгууль явагддаг, жишээ нь Тайланд.

7. Шүүхийн шийдвэр, тогтоол тогтвортой байх, нарийн нягт байх зарчим

555. СМШЭ-ийн шударга ёс, ардчилсан байдлыг хангахын тулд СМШ систем бүр шүүхийн шийдвэр, тогтоолд баримтлах ерөнхий зарчмыг процессын хуульд тусгаж, хүндэтгэх нь чухал. Үүний дагуу СМШЭ-үүд өөрсдийн шийдвэр, тогтоол нь талуудын гомдол, хэлэлцсэн асуудлын хувьд тогтвортой байлгах (өөр үр дүн тодорхой байлгах нөхцөл байхгүй тохиолдолд) хэрэгтэй. Шийдвэр нь гаргасан маргаан, гомдлоос бусад асуудлыг хамарч болохгүй.

556. Үүний адилаар зарим СМШЭ-үүд маргаанд хамаарч байгаа мэдэгдэлд авч үзэж буй гомдол, нотолгооны аливаа дутагдлыг нөхөх бүрэн эрхтэй байдгийг тэмдэглэх нь чухал. Гэвч энэ нь СМШЭ энэ үйлдлийг өөрийн санаачлагаар хийж болно гэсэн утгыг илэрхийлдэггүй. Ийм нөхцлүүд сонгуулийн эрхэд хохирол учруулах маргааны аливаа дутагдлыг нөхөж байдаг. СМШЭ жинхэнэ гомдолд багтаагүй мэдэгдлийг хийж болохгүй.

557. Шүүхийн шийдвэр, тогтоолын тогтвортой байдлын зарчим нь шударга ёсонд хүрэхдээ авч үзэлгүй өнгөрөөсөн аливаа холбогдолтой зүйл байхгүй гэдгийг баталгаажуулахын тулд СМШЭ-ийг гомдолд хариу тайлбар өгч буй иргэн, аж ахуйн нэгж, гомдол гаргагчийн дэвшүүлсэн байр суурь нэг бүрийг авч үзэхийг шаарддаг.

БҮЛЭГ 8

БҮЛЭГ 8

Сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх арга

1. Танилцуулга

558. Албан ёсны СМШ тогтолцоонд сонгуулийн маргааны хүрээнд бусад арга зам, механизм бас хамаарч байдаг. Ийм механизмуудад албан бус эсхүл сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх (СМШБЖШ) механизмууд хамаарна. Энэ механизмын гол зорилго нь албан ёсны СМШ системийг орлуулах бус харин албан ёсны систем үнэмшилтэй байдалтай нүүр тулсан нөхцөлд санхүүгийн эсхүл улс төр, институцийн хугацаа, тэдгээрийн шаардлага хангаагүй загвартай холбоотой цаг хугацааны дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэх юм. СМШ механизмын эсрэгээр СМШБЖШ механизмд маргааныг шийдвэрлэхээр нэг болон түүнээс дээш тал санаачилдаг. Үүнийг нэг тал (гомдол, эсхүл хариу тайлбар), 2 тал эсхүл гуравдагч этгээд, агентлаг гаргасан байж болно.

559. СМШБЖШ зарим механизмууд СМШ албан ёсны механизмуудтай хамт байж, тогтмол дэмжлэг үзүүлэх, сайшаах үүрэг гүйцэтгэдэг. Бусад нь СМШ албан ёсны механизмын улс төрийн байдлыг шийдвэрлэх хугацаа, институцын ад hoc зарчим, онцгой эсхүл хэвийн нөхцөл байдалтай байдаг.

560. СМШБЖШ механизмууд хамгийн түгээмэл нэг сайн жишээ бол албан ёсны СМШЭ-д маргаан үүсгэхийн эсрэг эвлэрэх, зуучлах, арбитраар шийдвэрлэх арга юм. Ийм тохиолдолд СМШБЖШ механизмаар дамжуулан маргаанаа шийдвэрлүүлснээр СМШ албан ёсны тогтолцооны сул талыг гарган ирж байгаа бус харин маргааныг шийдвэрлэхэд дэмжих, зардлыг хэмнэх арга зам болж байдаг.

Маргааныг шийдвэрлэх албан ёсны болон албан бус тогтолцоо зэрэгцэн оршиж, бие биеэ дэмжиж байдаг.

561. СМШБЖШ бусад аргууд улс төрийн зөрчил, институцын сул байдлаас шалтгаалан СМШ албан ёсны системд үүссэн хоосон зайг нөхөж байдаг. Ийм СМШБЖШ аргуудыг сонгууль явуулах, сунгах, түүний дүнтэй холбогдон үүссэн ноцтой маргааны үед хэрэглэдэг. Маргааны шийдлийг СМШ системд байдаггүй ad hoc байгууллагын онцгой болон хэвийн зарчимд хариуцуулдаг. Сайн жишээнүүд бол Кени, Зимбабвед 2008, 2009 онд тус тус болсон сонгуулийн маргааны дараа гарсан улс төрийн сонгуулийн зөрчлийг шийдвэрлэх зорилгоор үндэсний эв нэгдлийн засгийн газар байгуулахаар хэлцэл хийн, зуучлалын үйл ажиллагааг явуулсан жишээ байдаг.

2. Сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх аргын хөгжил

562. Сонгуулийн маргааныг энгийн шүүхээс гадуур шийдвэрлэх нь шинэ зүйл бус юм. Дэлхий дээрх нийгмүүд сонгуулийн зөрчил, бусад маргааныг шийдвэрлэх зорилгоор урт хугацааны турш шүүхийн бус, нутгийн, эсхүл албан бус аргыг хэрэглэж ирсэн. Тухайлбал, АНУ-д 1970-аад онд зарим мужид зуучлалаар иргэний эрхийн маргааныг шийдвэрлэх болон хэт бөөгнөрсөн шүүхийн системээс үүссэн маргааны зардалд хандуулахаар СМШБЖШ аргуудыг нэвтрүүлсэн.

563. Шинэ зүйл бол СМШБЖШ аргын өсөлт, тэдгээрийн өргөн хэрэглээ, дэлхий даяар бий болгох, ялангяа, сүүлийн жилүүдэд бий болж буй зөрчилдөөний дараах нийгмүүд юм. СМШБЖШ аргуудыг хэрэглэхийн үр ашиг улс төрийн болон сонгуулийн салбарын нөгөө талд явдаг. Тэдгээрийг тухайлбал, хадгалагдах ёстой маргалдагч талуудын хоорондын харилцаа холбоо, бэхжигдэх ёстой нийгэмлэгийн хамтын ажиллагаа, мөн шаардлагатай зөрчил маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх нөхцөлд нийгэмлэгийн түвшний хүнд асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэглэдэг.

564. Өмнөд Африкт 1990-ээд онд хөдөлмөрийн маргаан, шударга ёсонд хүрэх, үйлчилгээний хүргэлтийн зэрэг маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх том хэмжээний туршилтыг явуулсан. Хамгийн чухал нь 1994 оны анхны ардчилсан байдлаар зохион байгуулагдсан сонгууль. СМШ олон янзын бүтцүүд маргаантай сонгуулийн туршид маргааныг шийдвэрлэх, улс төрийн түгшүүртэй нөхцөл байдлыг намдаахад бий болдог бөгөөд эдгээр бүтцэд нийгэмлэгт суурилсан зөрчлийн удирдлагын бүтэц болон улс төрийн намын харилцаа

холбооны хороод хамаардаг. Зохион байгуулалтын эдгээр бүтцүүд үндэсний, орон нутгийн гэх мэт Засгийн газрын бүхий л шатанд гарсан зөрчлүүдийг шийдвэрлэхээр СМШБЖШ аргуудыг, тухайлбал хэлэлцээр, зуучлал, арбитрын ажиллагааг явуулдаг (579 дахь хэсэг болон Хүснэгт 8.1-ийг үзнэ үү).

Хүснэгт 8.1. South Africa's Independent Electoral Commission conflict management programme

Өмнөд Африкийн Сонгуулийн Бие Даасан Хороо зөрчлийн удирдлагын программыг 1999 онд суулгасан. Энэхүү программ нь зөвхөн сонгуулийн хугацаанд ажиллаж, зөрчлийн удирдлага дээр мэргэжилтнээр ажилладаг. Тухайлбал сонгуулийн өмнөх цөөн долоо хоногийн хугацаанд хуульч, багш, нийгэмлэгийн шашны тэргүүлэгч нар хөлсөөр ажилладаг. Тэд сонгуулийн хуулиар бэлтгэгддэг бөгөөд шаардлагатай тохиолдолд дуудагдаж болно. Мэргэжилтнүүд эвлэрүүлэн зуучлал хийж, эвлэрүүлэн чадвараа ашигладаг. Мөн цалин авч байгаагын үндсэн дээр СЗБЭ-д тайлан гарган өгнө. Тэд зуучлалаа утсаар, талуудад маргааныг сонсгохоор нийтийн сонсголоор, мөн санал болгож буй шийдлээр хийгдэж болно. Програмын үр ашиг, шүүхэд ирсэн маргааны тоогоор баталгаажуулж, ерөнхий сонгуулийн маргааныг багасгадаг. Жишээлбэл, 1999 оны сонгуулиар гарсан 1113 маргаанд айлган сүрдүүлэлт, зөрчлийн улмаас саатсан сонгогчид, нэр дэвшигчид, эсхүл улс төрийн намууд, эсхүл сонгуулийн сурталчилгааны сүйтгэл хамаарсан байна. Ийм маргааны тоо 2000 оны сонгуульд 314, 2004 оны сонгуульд 253-д хүрсэн.

565. СМШБЖШ аргууд ихэнх зөрчлийн дараах орнууд, үүнд Афганистан, Конгогийн Ардчилсан Бүгд Найрамдах Улс, Индонез, Малайз, Мозамбик, Өмнөд Африкт өргөн, үр дүнтэй хэрэглэгдсээр ирсэн. Ийм тохиолдолд шүүхийн шийдвэрийг авч үзэх байгууллагын томилгоо, цэргийн бус зохион байгуулалтын бүрэн эрхийн хүрээнд сонгуулийн маргааныг зохицуулахаар хэлэлцээр болон арбитрын аргыг өргөн хэрэглэдэг. Тэдгээр нь арбитраар шийдвэрлэх, маргагч талуудыг холбосон шийдвэрийг хүргэх бүрэн эрхтэй байдаг. Ийм эвлэрүүлэн зуучлал, арбитрын хороод СЗБЭ-ээс үндэсний, орон нутгийн, хотын захиргааны түвшинд томилогдож, сонгуулийн маргаанг эхэнд дуудагдаж, албан ёсны шүүхийн ачааллыг хөнгөвчлөхөд тусалж байдаг.

566. Гани, Боствана зэрэг Африкт загвар ардчиллыг голдуу ишлэдэг орнууд зөрчлийг үр дүнтэй эвлэрүүлэх, удирдах, шийдэхэд сонгуулийн ил тод, итгэл үнэмшилтэй байдлыг дэмжихэд СЗБЭ-д туслах зорилгоор талууд, хороондын харилцаа холбоо, зохион байгуулагдсан бүтцийн бусад нийгэмлэгийг ашигладаг.

3. СМШ аргын хамт байдаг СМШБЖШ байнгын аргууд

а) СМШБЖШ процессын гол шат

567. Ерөнхийдөө СМШБЖШ аргыг маргааны нэг талын хүсэл зоригоор маргааныг шийдэх, дүгнэхэд хангалттай буюу нэг талын маргааныг шийдэгдсэн гэж үзэхээс өмнө холбогдолтой талууд тохиролцоонд орсон буюу хоёр талын, төрийн захиргааны байгууллагаас бусад гуравдагч этгээдийн оролцоотой хэмээн ангилж болно. Эхний бүлэгт нэхэмжлэлээсээ татгалзах эсхүл хүлээн зөвшөөрөхөөс татгалзах болон зөвшөөрөх эсхүл хүлээн зөвшөөрөх явдал үүсч, хоёр дахь ангилалд хоёр болон түүнээс дээш талууд эвлэрэх эсхүл харилцан буулт хийдэг. Гуравдагч талын оролцоо нь эвлэрүүлэх комисс, эвлэрүүлэн зуучлал, арбитрын оролцоо гэсэн гурван сонголттой. (Хүснэгт 8.2-ыг үзнэ үү).

Хүснэгт 8.2. Зэрэгцээ механизмууд

- i. Нэг талын: өргөдөл эсхүл гомдол гаргагч гаргасан өргөдөл, гомдлоосоо татгалзах эсхүл хариуцагч хүлээн зөвшөөрөх эсхүл буулт хийх
- ii. Хоёр эсхүл олон талын: талууд тохиролцоонд (хүрэх) эсхүл тайван замаар шийдвэрт хүрэх
- iii. Гуравдагч талын оролцоо (шүүхийн тэнцвэрт байдал):
 - Эвлэрэл
 - Зуучлал
 - Арбитрын ажиллагаа

568. Сайн дурынхан болон маргалдагч талууд өөрийн хүслээр СМШБЖШ аргуудыг чөлөөтэй хэрэглэдэг. Хэрэв тэд эвлэрүүлэх ажиллагаа, зуучлал, арбитрын ажиллагаанд орохыг зөвшөөрөхгүй бол эрх бүхий байгууллагын шийдвэр, захирамжаар тэдэнд шийтгэл оногдуулахгүй. СМШБЖШ аргууд нь СМШ аргуудыг орлох нөхцөл байдалтай байж болохгүй, харин энэ хоёр аргууд хамтран бэхжиж байдаг. СМШБЖШ аргыг заасан нөхцөлд ч гэсэн СМШ арга нээлттэй хэвээр байх ёстой.

569. Зарим оронд СМШБЖШ аргыг хэрэглэх боломжийг тодорхой заасан СМШ системийг хуульчилсан байдаг. Зарим тохиолдолд, магадгүй луйвраас (хуулиар тодорхойлсноор) бусад тохиолдолд, хууль ёсны дагуу шийдвэрийг бүрэн гаргаж, хамааралтай талуудад үүрэг хүлээлгэж ч болдог. Ардчилал баттай тогтсон улс орнуудын албан ёсны шүүхийн тогтолцоог багтаасан өөр өөр эрх зүйд хэрэглэдэг СМШБЖШ аргууд зарим бусад хуулийн процессоос урьдчилан талууд хоорондоо шууд тохиролцоонд хүрэхийг дэмждэг шүүхийн өмнөх

шатны тохиролцооноос эхлээд арбитрын тогтолцоо эсхүл шүүхийн процесстой ижил явагддаг загвар шүүх хуралдааныг хамардаг.

570. Сонгуулийн маргааныг өргөдөл, гомдол гаргагч өөрийн гаргасан сонгуулийн өргөдөл, гомдлоос татгалзан СМШЭ-ээс гадуур шийдвэрлэж болдог. Энэхүү татгалзах үйлдэл нь татгалзал эсхүл эрхээсээ татгалзахтай адил хүчинтэй. Хариуцагч буруугаа хүлээж эсхүл хүлээн зөвшөөрснөөр маргааныг шийдвэрлэгдсэн байхад хүргэдэг (Хүснэгт 8.3-ыг үзнэ үү). Заримдаа хуулиар бусад этгээдүүд зөвшөөрсөн байхыг шаарддаг хэдий ч гомдол гаргагч эсхүл хариуцагчийн алины ч хүсэл маргааныг шийдвэрлэгдсэн гэж үзэхэд хангалттай тул эдгээр үйлдлүүд хоёулаа хоёр талын байдаг.

Винчестерлын жишээ: Их Британи

Андрю Эллис

1997 оны Нэгдсэн Вант Улсын ерөнхий сонгуулиар Винчестер дүүргийн нэг гишүүнд тэргүүлж буй хоёр нэр дэвшигч тус бүр 20,000 давсан санал авсан. Тэд хоорондоо хоёр саналын зөрүүтэй байсан. Ялагдсан нэр дэвшигч Gerry Malone болон түүний нам цөөхөн санал алдаатай багтаагүй гэдэгт итгэсэн. Тэрээр сонгуулийн шүүхээр шалгуулахаар сонгуулийн өргөдөл-гомдол гаргасан. Ялсан нэр дэвшигч Mark Oaten болон түүний нам энэ хэрэг хэрхэн шийдэгдэх талаар итгэлгүй байсан бөгөөд хэрэг хамгаалагдана гэж, их зардал гарна гэж мэдэж байсан (Хүснэгт 6.14-ийг үзнэ үү). Түүнчлэн тэрээр шүүхэд хэргийн эсрэг байгаагүй бөгөөд шинэ сонгууль зарласан. Oaten-ий сонгуулийн кампанит ажлын тал Malone-г шаардлагагүй сонгууль явуулахад нөлөөлсөн уур уцаартай ялагдагч гэж үзэж байсан. Дахин сонгуулиар Oaten 20,000 гаруй саналаар Malone-д ялагдсан. Oaten-ы түүний эрх ашгийг хамгаалах хамгийн зүй ёсны улс төрийн шийдвэр зүй ёсны болж эргэсэн.

571. Эвлэрэл бол маргааныг шийдвэрлэхэд туслах гуравдагч этгээд эсхүл агентлаггүйгээр маргалдагч талууд маргааныг тодорхой эсхүл нууцаар аль ч байдлаар тайван замаар тохиролцох юм. Эвлэрэл нь хоёр эсхүл холбоотой бүхий л маргалдагч талын хоёр эсхүл олон талт тохиролцоог шаарддаг.

572. Зуучлал болон эвлэрүүлэх комисс нь талууд хоёулаа маргааныг шийдвэрлэхдээ маргаанд хамааралгүй гуравдагч талыг хэрэглэдгээрээ адил байдаг. Зуучлалд зуучлагч идэвхигүй зуучлагчийн үүднээс үйл ажиллагаа явуулж байхдаа талуудыг ойртуулахыг оролддог. Эвлэрэлд эвлэрүүлэгч – маргалдагчийн эсхүл бүхий л маргалдагч зөвшөөрөхүйц байдалд хүргэхийн тулд маргалдагчдад боломжит шийдлийг санал болгож буй тохиролцооны идэвхитэй оролцогч байдаг. Эвлэрэл хууль ёсоор зохицуулагддаг бол зуучлал тусгай дүрэм, журмын зүйл байдаггүй.

573. Арбитрын оролцоо нь арбитраар маргааныг шийдвэрлүүлэх талуудын тохиролцооноос үүсдэг. Энгийнээр “арбитрын шийдвэр” гэж нэрлэдэг эцсийн шийдвэр эрх зүй эсхүл тэгш байдлын алинд ч үндэслэн гардаг. Маргалдагчдад үүрэг оногдуулж, хуулийг сахиулдаг шүүхийн шийдвэр, тогтоолын шинж чанар дээр арбитрын шийдвэр гардаг тул арбитрын шийдвэр шүүхийн шийдвэртэй адил шинж чанартай байдаг.

574. Арбитраар хэрэг хянан шийдвэрлэх процесс ерөнхийдөө маргалдагч талууд үүнийг урьдчилан зөвшөөрсөн байдаг хэдий ч энэхүү процесс хуулийн процессыг чанд даган мөрдөж явагдана. Эцсийн шийдвэрийг гаргахаас өмнө өөрийгөө хамгаалах эрх, нотлох баримт гарган өгөх, шалгах, хэргийг давтан шалгах зэргийг хамарсан шударга шүүх хуралдаан явуулахыг хуулиар шаарддаг.

575. Зарим улс оронд маргааны төрлөөс хамааран хуулиар тогтоосон институт, агентлаг явуулах арбитрын ажиллагаа ба маргагч талуудын сонгосон хувь хүнээс явуулах арбитрын ажиллагаа гэсэн хоёр аргыг хэрэглэдэг. Институтад суурилсан арбитрын ажиллагааг хуулиар заасан ч гэсэн маргагч талууд арбитр эсхүл жирийн шүүхээр (тухайлбал 2004 онд Индонез, 2005 онд Афганистаны сонгуулийн салбарт ийм тохиолдол гарсан) маргаанаа шийдвэрлүүлэхээ сонгоход чөлөөтэй.

576. Илүү албан бус шинжтэй СМШБЖШ аргууд зүй ёсны сонгуулийг дэмжих оролдлогод томоохон ашиг тус өгөх боломжтой давуу талыг санал болгодог. Эдгээрт дараах давуу талууд хамаарна. Үүнд:

- зүй ёсны сонгуульд хүрэхэд хялбар, хурдан, илүү үр дүнтэй зардалтай;
- маргагч талуудын эргэн тойронд заналхийлдэггүй;
- маргалдагч бүхий л талууд ялах үр дүнд хүрэх боломж;
- СМШ аргуудад үл итгэх асуудлыг үгүй болгох завшаан.

577. Түүнчлэн СМШБЖШ аргуудад зарим сул тал байдаг. Тодруулбал сул маргагчийн ашиг сонирхлыг илүү хүчтэй маргагчийнхтай тэнцвэржүүлэхэд маргагч талуудын хоорондын тэнцвэрт бус хэт их эрх мэдлийн байдалд эдгээр аргыг хэрэглэх нь үр дүнгүй бөгөөд олон талт маргааны нэг тал оролцоогүй тохиолдолд эдгээр аргыг хэрэглэж болдоггүй.

б) СМШБЖШ байнгын аргыг хэрэглэх өргөн туршлагатай улс орнууд

578. СМШБЖШ аргууд хангалттай хөгжөөгүй бөгөөд түүний үр ашиг бага судлагдсан байдаг. Гэвч олон улс орнууд СМШБЖШ аргын зарим хэлбэрийг хэрэглэдэг. Үүнд: орон нутгийн сонгуулийн байгууллагатай холбоотой Афганистан, Камбож (Хүснэгт 8.4-ийг үзнэ үү), Этиопи, Кени, Лесото, Малави, зан заншил болон уламжлалт ёсны тогтолцоон дахь нутгийн эсхүл үндэстэн ястны нийгэмлэгийн орон нутгийн сонгуульд хэрэглэдэг Мексик, Самоа, Өмнөд Африк болон Уганда хамаарна.

Хүснэгт 8.4. AEDR in Cambodia

Denis Truesdell

Камбоджийн албан ёсны СМШ институтад Үндэсний Сонгуулийн Хороо (ҮСХ) болон Үндсэн Хуулийн Шүүх хамаардаг. ҮСХ шүүхийн шийдвэрээр хууль зүйн дагуу унаснаас бусад нийтийн шүүх хурлаар явагдсан бүхий л гомдол, давж заалдах гомдлын шийдвэрийг хариуцдаг. Сонгуулийн маргаанууд сонгуулийн хорооны ажилтнаас эхлээд маргаан бий болсон шатанд, Коммуны Сонгуулийн Хороо (КСХ), Бүсийн Сонгуулийн Хороо (БСХ)-д хаяглагдана. Сонгуулийн гомдолд эдгээр байгууллагаас гаргасан бүхий л шийдвэрийн эсрэг дараагийн дээд шат, ҮСХ-д эцэст нь Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах гомдол гаргаж болно. Цаашлаад сонгуулийн маргаанууд сонгуулийн бүтэц, хүн амын дийлэнх хэсэгт хүрдэггүй шударга ёсны/шүүхийн албан тогтолцооны гадаад байдал, мөн гэмт хэргийн сэжиг, холбогдлын талаар байдаг. Үр дүнд нь Камбоджийн ихэнх иргэд орон нутгийн эрх бүхий байгууллага, тосгоны удирдлага, тосгоны өндөр настнууд, үндэстний цөөнхийн тэргүүнүүд өдөр тутмын маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх албан бус байгууллагыг бий болгоход дуудагддаг. Гэвч энд хүний эрхийн баталгааны хууль зүйн тогтолцоо, маргааныг шийдвэрлэхээр ажиллаж байгаа эдгээр албан бус аргын тодорхой зохицуулалт байдаггүй. Коммуны захиргааны хуулиар коммуны зөвлөхөд иргэдийн дунд маргааныг эвлэрүүлэх эрхийг олгосон байдаг ч эдгээр хүмүүст маргааныг шүүхийн үзэмжээр шийдвэрлэх эрхийг олгодоггүй. Сонгуулийн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх аргуудаар сонгуулийн ихэнх маргааныг шийдвэрлэхээр сонгуулийн журамд заасан байдаг. Бага хэмжээний сонгуулийн гэмт хэргийг шийдвэрлэхэд эдгээр аргыг хэрэглэхээр заасан байдаг ч шүүхээс гадуур зуучлах, эвлэрүүлэх ажиллагааны соёлын уламжлал СМШБЖШ аргуудыг маргааныг шийдвэрлэх хүчтэй хэрэгсэл болгож байдаг. Цаашлаад илүү ноцтой тохиолдлууд сонгуулийн дээд байгууллагаас хянах шаардлагатай үед "эвлэлдэх" хандлагатай байдаг. КСХ нь бүхий л давж заалдах гомдол, хуулийн ихэнх салбарт шаардагддаг албан ёсныхтой адил шүүх хуралдааны процессыг явуулах чадваргүй боловч СМШБЖШ аргуудыг хэрэгжүүлдэг. Эдгээрийг БСХ, ҮСХ явуулдаг. Шийдвэр, тохиролцоонд сэтгэл ханамжгүй байгаа талууд дээд шатанд гомдлоо гаргах боломжтой. Гэсэн хэдий ч энэхүү тогтолцоо арбитрын журмаар гаргасан шийдвэр үр ашиггүй болсон эсхүл нотлох баримтад бус цуурхалд үндэслэсэн доод шатны сонгуулийн ажилтнууд олон тооны гомдлыг хүлээн авахаас татгалздагаас шалтгаалан шүүмжлэлд өртдөг. Шүүмжлэл дээд БСХ эсхүл ҮСХ-ы шатны илүү албан ёсныхтой адил шүүх хуралдааны процесс явагдан, гарсан шүүхийн шийдвэрийг илүүд үзэж байгаа талуудад СМШБЖШ аргуудыг тулгахад болгоомжилдог. Тэдгээрийн хязгаарлалтыг үл харгалзан СМШБЖШ аргууд ихэнх сонгуулийн маргааныг түргэн шуурхай шийдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг бөгөөд маргаан албан ёсны гомдол руу шилжихээс өмнө сонгуулийн байгууллагад хүрэх, зааварчилгаа өгөх, асуултад хариулах, асуудлыг шийдэхэд амар байх зөрчлүүдээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй.

579. Тухайлбал Өмнөд Африк, Лесото улс чөлөөт, шударга, зүй ёсны сонгуулийн зорилгоор сонгуулийн бүхий л маргаанд СЗБЭ болон бүртгэгдсэн намуудын хоорондын зөвлөлдөөн, хэлэлцүүлэгт хэрэгслийн үүднээс үйлчилдэг намын харилцаа холбооны хороодын тогтолцоог институтчилан байгуулсан. Эдгээр хороод үндэсний, аймгийн, орон нутгийн хэмжээнд байгуулагдсан бөгөөд байнгын үйл ажиллагаа явуулдаг. Бүртгэгдсэн улс төрийн нам бүр хороо бүрт хоёр төлөөлөгч томилох эрхтэй. Хороод олон удаа уулзах ба тэдгээрийг бүхий л шатанд нь удирддаг СЗБЭ-ээс хорооны захиргаанд эрх олгодог. Тэд сонгуулийн янз бүрийн маргаан, асуудлыг ялгаж салгах, шийдвэрлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан бөгөөд тэдний зөвлөлгөөн нээлттэй бөгөөд шударга байдаг. Ийм хороодын бүтцийг сонгуулийн маргаан, асуудлыг шийдвэрлэх зорилгоор хуулийн дагуу байгуулдаг. Тэд зөвлөлгөөний, үр дүнтэй арга замыг авч хэрэгжүүлдэг ба улс төрийн намууд, тэдгээрийн нэр дэвшигчдийн дунд зөвшилцөлд хүрэхийн төлөө тэмүүлдэг. Холбоотой байгууллага, агентлагаас хүндэлж, биелүүлдэг хороодын дүгнэлтийг ерөнхийд нь зөвшөөрсөн сонгуулийн янз бүрийн маргаан, асуудлыг шийдвэрлүүлэхээр Өмнөд Африкийн Сонгуулийн Шүүхээс шүүгчийг томилдог.

580. Энэ талаар сонгуулийн салбарт эвлэрэл, зуучлал, арбитрын ажиллагааны хэрэглээнд бага зэрэг бичигдсэн. Гэвч энэ нь сонгуулийн маргаанд СЗБЭ-ээс ийм аргуудыг хэрэглэхэд үр дүнтэй бөгөөд үр ашигтай байх болно. Энэ нь тодруулбал нийтээрээ маргаж байгаа ашиг сонирхол дээр тохиролцоонд хүрэхийг оролдож байгаа СЗБЭ-д том маргаан байхад, улс төрийн намуудын төлөөллийг оруулсан тэдгээр СЗБЭ-үүдэд түгээмэл байдаг. Энэ нь СМШЭ-ийн хүнд, төвөгтэй байдлыг хөнгөвчлөх, сонгуулийн давчуу цагт чухал үүрэг гүйцэтгэх илүү хурдан бөгөөд үр дүнтэй бага зардалтай шийдлийг санал болгодог ач холбогдолтой. Түүнчлэн СЗБ-үүдээс дэвшүүлсэн хуулиар сонгуульд оролцож байгаа, хуулийн бүх зүйл заалтад хяналт тавих эрхийн үнэмлэхтэй бүхий л улс төрийн хүчний төлөөлөгч нараас бүрдсэн ad hoc хорооны зохицуулалтыг заасан байдаг. Эдгээр нь ялангуяа сонгуулийн кампанит ажлын үед зөрчлийг шийдэх, маргааны тоог багасгахад үр дүнтэй байдаг. 2003 оныг Емен, 2006 оны Палестины эрх бүхий байгууллагын жишээг энд дурдаж болно.

581. Олон оронд, мэдэгдсэн алдаа, зөрчлийг засах боломжийг өгөхийн тулд байгууллага, эрх бүхий байгууллагаас өмнө хамгийн түрүүнд гарч ирэх ёстой СЗБ-ийн бүтэц дэх байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрийн эсрэг гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх процессыг эхлүүлэхээс өмнө үүнийг шаарддаг. Зөвхөн ийм шүүх хуралдааны дараа шүүх эсхүл дараагийн шаардлагад хандаж болно.

Захиргааны арга хэмжээний урьдчилсан оролдлого нь захиргааны албан ёсны маргаан биш гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд захиргааны сонгуулийн маргаан биш, харин СМШБЖШ арга гэж авч үзэх нь зүйтэй.

582. Үүнтэй адилаар нам дотроо дотоод маргаанаа шийдвэрлэх дотоод механизмыг улс төрийн намууд суулгасан тохиолдолд энэ нь тэдгээр механизмыг СМШБЖШ механизм гэж үзэхээр техникийн байдлаар батлагдсан байдаг. Энэ нь намын гишүүн өөрийнхөө намын үйл ажиллагааны эсрэг маргахад хуулиар заасан намын дотоод механизм эхлээд явагдаж дууссанаар СМШЭ-д хандана гэсэн үндсэн дүрэм юм. Ийм намын дотоод механизмуудаар дамжин гарсан шийдвэр ихэнхдээ СМШБЖШ аргуудыг хэрэглэж гарсан шийдвэр эцсийн бөгөөд үүрэг хүлээлгэсэн байна гэж үздэг СМШЭ-ийн өмнө маргаан үүсгэдэггүй.

4. Сонгуулийн тусгайлсан зөрчлийг шийдвэрлэх тусгай аргын үүднээс байгуулагдсан СМШЭ-ийн Ad hoc байгууллагууд

а) Үндэсний дотоод шийдлийн үүднээс байгуулагдсан СМШЭ-ийн Ad hoc байгууллагууд

583. СМШЭ-ийн энэ хэлбэрийн үүднээс улсын эрх бүхий байгууллага эсхүл байгууллагууд (үндсэндээ хууль тогтоох байгууллага) сонгуулийн процесстой холбоотой маргааныг шийдвэрлэх тусгайлсан эрх олгосон, шүүхийн шинжтэй түр зуурын ad hoc байгууллагыг томилдог. Энэхүү шийдэл нь сонгуулийн процессын ажиллагаа эсхүл түүний дүнг хүлээн зөвшөөрөхгүй байгаа улс төрийн хүчнүүдийн дунд хэвийн бус, маш ноцтой маргаан гарсан тохиолдолд бий болдог бөгөөд сонгуулийн тусгайлсан маргааныг шийдвэрлэхээр хуульд зааснаас бусад институцын механизмыг байгуулах сонголтыг хийдэг. Холбогдох улс төрийн хүчин эсхүл нийгмийн холбогдох хэсгүүдийн дунд зөвшилцөлд хүрснээр хууль тогтоох байгууллага дараагийн давж заалдах боломж байхгүй байхын эсрэг дүрэм журам эсхүл шинээр гаргасан нэмэлт механизмуудыг хэрэглэн гаргасан тогтоол мөн/эсхүл сонгуулийн маргааны эцсийн шийдвэрээр эрх олгосон ad hoc байгууллагыг гаргадаг.

584. Нэгдсэн улсад 1876 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар ийм нөхцөл байдал явагдсан. Гурван муж улсад гарсан сонгуулийн дүнгийн маргаан (Сонгуулийн Бүлгийн 19 гишүүн сонгуулийн дүнд нөлөөлөхөд хангалтгүй байсан)-наар Нэгдсэн Улсын Үндсэн хуульд заагаагүй, харин сонгуулийн дараа гаргасан хууль тогтоох байгууллагын тогтоолын дагуу ad hoc Сонгуулийн Хороог байгуулсан.

Хороо Бүгд найрамдах намын нэр дэвшигч Rutherford B. Hayes-ийн ашиг сонирхлоор есөөс долоон саналаар шийдэгдсэн, ялангуяа намын баримтлалд нийцүүлэн таван сенатор, Төлөөлөгчийн Танхимын таван гишүүн, Дээд Шүүхийн таван шүүгчээс бүрдсэн. Гурван муж улсад гарсан жинхэнэ дүн өөрчлөгдөж, өөр нэр дэвшигч ялагчаар зарлагдсан.

Нэгдсэн Улс бол 50 муж улсын холбооны Засгийн газарт Үндсэн хуулийн тогтолцоогоор тодорхой олгоогүй эрх мэдлийг шилжүүлсэн холбооны үндсэн хуулийн бүгд найрамдах улс юм. Энэ эрх мэдэлд мужийн болон үндэсний сонгуулийн байгууллага, удирдлага хамаардаг. Нэгдсэн Улсын Үндсэн хуулиар Нэгдсэн Улсын Конгрессын холбооны сонгуулийг тодорхой илэрхийлсэн. Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Сенатын болон төлөөлөгчийн сонгуулийг явуулах цаг, газар, аргыг муж улс бүрийн хууль тогтооох байгууллага тодорхойлно, гэхдээ Конгресс аль ч үед сенаторын сонгосон газрыг үл оролцуулан хууль гаргаж, ийм дүрэм журмыг өөрчилж болно” гэж заасан байдаг. Үндсэн хуулийн бусад хэсэг болон холбооны хэмжээнд батлагдсан сонгуулийн янз бүрийн хууль тогтоомжийн түүх (жнь: 1969 оны Холбооны Маргаантай Сонгуулийн Хууль) зөвхөн муж улсын бус, харин холбооны сонгуулийн маргааныг шийдвэрлэх өргөн хүрээтэй муж улсыг түүнчлэн заасан байдаг. Нэгдсэн Улсад сонгуулийн дүрэм журмын тогтолцоо төвлөрөөгүй учир агуулгын хувьд мужаас муж өөр өөр байдаг. Муж улсууд өөр өөр хууль, дүрэм, эдгээр дүрмээ хэрэгжүүлэх процедурыг зөвхөн суулгах бус, харин эдгээр процедурын ихэнхийг өөрийн орон нутгийн Засгийн газар-ихэвчлэн улсад явуулах нь чөлөөтэй. Энэ нь эдгээр зүйлсийг ашиглах санал хураалтын хэрэгслийн төрөл, саналын хуудасны загвар, ирээгүй болон урьдчилсан санал хураалтын төлөө явуулж байгаа зүйл зэргийн үүднээс хэсэгчлэн шийдсэн улс юм. Ихэнх муж сонгуулийн маргаан шийдвэрлэх хууль, захиргааны бүтцийг суулгасан байдаг, гэхдээ энэ бүтэц нь мужуудад өөр өөр байдаг. Сонгуулийн хууль мужаас мужид өөр өөр байснаараа сонгуулийн маргааны шийдлийг авч үзэж байгаа жишгийн эрх зүй мөн өөр өөр байдаг. Энд сонгуулийн зохион байгуулалтад, тодруулбал хэлэлцэгдэж байгаа сонгууль холбооны удирдлага гэж үзэж байх үед холбооны ашиг сонирхлууд байдаг. 2000 онд Флоридад Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг шийдэх Нэгдсэн Улсын Дээд Шүүхийн шийдвэр энэхүү ашиг сонирхлын жишээ юм. Энэ шийдвэрийн дагуу бүх дахин тооллогыг зогсоосон. Заримдаа Холбооны сонгуулийн маргааныг Дээд Шүүхээс бусад шүүх шийдвэрлэдэг. Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Конгрессын танхим бүр сонгууль, тайлан, өөрийн гишүүдийн Маргааны асуудлаар шүүгч байна” гэж заажээ. Холбооны Сонгуулийн Хууль (ХМСХ)-д үүнтэй адил утгатай

зохицуулалт байдаг. Нэгдсэн Улсын Конгрессын суудлын толоо нэр дэвшигчдийн сонгуультай холбоотой маргааныг нөлөөлсөн танхим шийдвэрлэж болох бөгөөд Захиргааны Танхимын Комисс гомдолтой холбогдуулан шүүх хуралдаан, мөрдөн шалгах ажиллагааг явуулна. Хороо эцсийн шийдвэрийн санал хураалтын дараа Танхимд олж мэдсэн зүйлээ тайлагнана.

585. Жишээ татвал байгуулагдсан институтуудыг нөхцөл байдлаар давж гарсан бөгөөд шүүхийн бус журмаар шийдвэрлэх шийдлийг олох хэрэгцээ энд байсан. Улс төрийн соёл хамгийн сайн байдалтай үед хамгаалагч болон нийгэмд байгуулагдсан институтуудын шийдвэрийг хамгаалах, хүндлэхийг даалгадаг бөгөөд энэ нь ийм нөхцөл хэзээ ч гаргаагүй бол үе үе оршин байгаа систем итгэл аваагүй эсхүл маргааныг найдвартай байдлаар шийдвэрлэх хангалттай чадваргүй байдаг бодит байдлыг илүү дээр болгоно. Гэвч үр дүнг үүсгэж байгаа институтын хор уршиг тооцоолсон шийдлийн ашиг тусаас их байж магадгүй. Маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх иймэрхүү шийдлийг суулгахдаа маш болгоомжтой авч үзэх хэрэгтэй. Ялангуяа энэ нь шүүхийн бус журмаар шийдвэрлэх нь ашиг тустай байж чадна гэсэн найдвараар сонгуулийн байгууллагын маргаан болон сонгуулийн дүнгийн асуудлыг сонгож байгаа өрсөлдөгчид ирээдүйд аливаа алдагдалд хүргэх аюултай жишгийг гаргаж чадах учир болгоомжтой авч үзэх хэрэгтэй.

б) Олон улсын ад нос СМШЭ-ийн бүтэц

586. Кени улсад 2007 оны сонгуулийн дараах зөрчлийн хор уршигт Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга асан Кофи Аннаны дагуу Африкийн Холбоо зөвшилцөлд хүрэх зуучлалыг явуулж, эвслийн Засгийн газрыг байгуулсан. 2009 онд Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэг (ЗАХН) Өмнөд Африкийн Ерөнхийлөгч асан Thabo Mbeki-ийг Зимбабве улсад 2008 оны сонгуулиар үүссэн зөрчлийг эвлэрүүлэн зуучлуулахаар томилсон. Энэхүү процесс тэмцэж байгаа талуудыг эрх мэдэл хуваах хэлэлцээрт гарын үсэг зурах, үндэсний эв нэгдлийн Засгийн газрыг байгуулахад хөтлөн хүргэсэн.

587. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх Үндсэн хуулиас гадуурх арга замын эдгээр хоёр жишээ энх тайвны хэлэлцээрийг явуулах, маргааны бүхий л талуудад үүрэг хүлээлгэх замаар хэлэлцээрт гарын үсэг зурахыг тухайн хоёр парламентуудаас шаардсан байна. Эдгээр хоёр улсад сонгуулийн дараа гарсан зөрчлийн үед хэлэлцээрт хүргэх, зуучлах гадаад хүчин зүйлсийн хэрэглээ болон тэдэнд хууль зүйн

үүрэг ногдуулах зорилгоор парламентаас баталж буй энх тайвны гэрээний зүйлд хүргэх сүүлчийн шийдвэр тэдгээрийн хууль санаачлах эрхийг СМШБЖШ аргын үүднээс олгодог.

Тэмдэглэл

588. СМШ болон СМШБЖШ механизмууд хоёулаа эцсийн үр дүнд итгэл хүлээлгэсэн тохиолдолд ашиг тустай бөгөөд хэрэв гомдол гаргасан тохиолдолд зайлшгүй байдаг. Энэ итгэлийг өргөнөөр гаргаж ирсэн үед ч гэсэн тэдгээр механизмууд улс төрийн хүчин оролцож байгаа сонгуулийн бүхий л процесст нэг хэсэг нь байсаар байдаг. Улс төрчид улс төрийн шийдвэр гаргадаг – мөн зүй ёсны сонгуулийн тогтолцоо эдгээр аргуудыг хэрэглэхийг дэмжих хангалттай тааламжтай сонголт юм.

“Монгол улс дахь сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох нь”
төслийн хүрээнд НДЭХ-өөс орчуулан гаргав.

Энэхүү номыг хэсэгчилсэн болон бүрэн эхээр нь хувилж олшруулахыг
хүсвэл доорхи хаягаар хандан зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Ардчиллын Ордон, өрөө 208, 205 Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар.

Утас: 70135147

Факс: 70135146

Веб: <http://www.wsp.mn>

И-мэйл: womenforsocialprogress@gmail.com

Монгол улс
Улаанбаатар хот, 2011